

---

# MONGOLIA

## Regulation for Food Additives and Contaminants & Residues

---



---

# Contents

---

## 1. Regulation for Food Additives

1.1 Food Additives(MNS CAC 192:2007-ын оронд) .....	4
A Хавсралт. ХҮНСНИЙ нэмэлтийн хэрэглээний Дээд тҮвшинг хоногийн зохистой хэрэглэ эний тоон ҮзҮүлэлтээр илэрхийлэх зөвлөмж .....	10
B Хавсралт. ХҮНСНИЙ АНГИЛЛЫН ТОГТОЛЦОО .....	14
C Хавсралт. Кодексын стандартад хамрагдсан хҮНСНИЙ жагсаалт .....	64

## 2. Regulation for Contaminants & Residues

2.1 ХҮНСНИЙ бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрҮүл ахуйн шалгуур ҮзҮүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ .....	301
2.2 ХҮНСНИЙ бүтээгдэхүүнд агуулагдах бензапирений зөвшөөрөгдөх дээд хэмжээ	319
2.3 ХҮНСНИЙ бүтээгдэхүүнд агуулагдах меламины зөвшөөрөгдөх дээд хэмжээ .....	321
2.4 ХҮНСНИЙ бүтээгдэхүүн дэх хҮнд металлын Үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ .....	323
2.5 Цацрагаар боловсруулсан хҮНСНИЙ бүтээгдэхүүний ерөнхий стандарт .....	331
2.6 <b>ХҮНСНИЙ бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий</b> <b>стандарт</b> .....	334
A Хавсралт. ....	341
B Хавсралт. ....	348
C Хавсралт. ....	349
D.1 Хавсралт. ....	351
2.7 <b>ХҮНСНИЙ бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын</b> <b>ерөнхий стандарт хэмжээг тодорхойлох дээж авах төлөвлөгөө</b> .....	358



# 1 Regulation for Food Additives

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 67.020

Хүнсний нэмэлт	MNS CAC 192 : 2015
Food additives	MNS CAC 192:2007-ын оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 60 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2016 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

### 0 Хамрах хүрээ

#### 0.1 Энэ стандартад хамрагдсан хүнсний нэмэлтүүд

Зөвхөн энэхүү стандартад жагсаасан хүнсний нэмэлтийг тухайн стандартын<sup>1</sup> нөхцөлд нийцүүлэн бүтээгдэхүүнд нэмэхэд тохиромжтой гэж үзнэ. Хүнс хөдөө аж ахуйн Олон улсын байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Хүнсний нэмэлтийн шинжээчдийн хамтарсан хороо (цаашид JECFA гэх)<sup>2</sup> ба Кодексын Олон улсын дугаарлалтын тогтолцооны шалгуур үзүүлэлтээр аюулгүй<sup>3</sup> болох нь тогтоогдсон бөгөөд хоногийн зохистой хэрэглээний хэм хэмжээнд нийцсэн хүнсний нэмэлтийн хэрэглээг л энэхүү стандартад хамруулах асуудлыг авч үзнэ. Энэ стандартад заасан хүнсний нэмэлтийг технологийн зориулалтаар хэрэглэх үндэслэлтэй болно.

#### 0.2 Хүнсний нэмэлтийг хэрэглэж болох бүтээгдэхүүн

Энэхүү стандартаар, Хүнсний эрхзүйн хороо өмнө нь стандартчилсан эсэхээс үл хамааран бүх ангиллын бүтээгдэхүүнд нэмэлт ашиглах нөхцлийг тодорхойлно. Кодексийн стандартчилалд хамрагдсан хүнсний нэмэлтийг Кодексийн бараа бүтээгдэхүүний болон энэхүү стандартад тусгасан нөхцлийг харгалзан хэрэглэнэ. Хүнсний нэмэлтийн ерөнхий стандарт (цаашид GSFA гэх) нь нэмэлтийн талаарх мэдээллийн үндсэн эх сурвалж болно. Кодексийн бараа бүтээгдэхүүний хороо нь нэмэлтийг бүтээгдэхүүнд хэрэглэх технологийн шаардлагыг тухайлсан стандартын дагуу тогтоох, үнэлэх, нотлох үүргийг хүлээнэ.

Стандартад хамрагдаагүй, нэгэн төрлийн бүтээгдэхүүнд хүнсний нэмэлт хэрэглэх нөхцлийг Бараа бүтээгдэхүүний хорооны мэдээлэлд тулгуурлан Кодексийн хүнсний нэмэлтийн хороо тогтоох боломжтой.

<sup>1</sup> Ерөнхий стандартын энэ хэсэгт тодорхой нэг хүнсний нэмэлтийн онцлог мэдээллийг орхигдуулах эсвэл энэ ерөнхий стандартад тухайн нэмэлтийг хэрэглэх талаар төсөл хийгдэж буй талаар нэмэлт мэдээлэл байхгүй бол энэ нь тухайн нэмэлтийг хүнсэнд ашиглах нь аюултай эсвэл тохиромжгүй болохыг илэрхийлэхгүй. Эрхзүйн хорооноос энэ хөл тайлбарыг шинэчлэх шаардлагатай эсэхийг тогтмол шалгаж, ерөнхий стандартад дээрх асуудал тусгагдаж, бүрэн баталгаажсан тохиолдолд хөл тайлбарыг стандартаас хасна.

<sup>2</sup> Энэ стандартад “аюулгүй байдлын бусад шаардлагын дагуу аюулгүй гэж тогтоосон” гэдэг нь хүнсний нэмэлтийн хоногийн зөвшөөрөгдөх хэрэглээний зааврын дагуу ашиглахад хоргүй (тухайлбал тогтоосон түвшинг ашиглах) аюулгүй байдлын асуудалгүй болохыг илэрхийлнэ.

<sup>3</sup> Хоногийн зөвшөөрөгдөх хэрэглээний өнөөгийн байдал, Олон улсын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага ба Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Хүнсний нэмэлтийн шинжээчийн хамтарсан хорооны сүүлийн жилийн үнэлгээ, Олон улсын тоон системийн бүртгэлийн INS дугаар зэрэг хүнсний нэмэлтийн үндсэн үзүүлэлтийн талаарх мэдээллийг англи хэл дээр Олон улсын Хүнс Хөдөө аж ахуйн байгууллагын Хүнсний нэмэлтийн талаарх шинжээчийн нэгдсэн хорооны цахим хуудсаас үзэж болно. <http://www.fao.org/ag/agh/ieega-additives/scarch.html?lang=cn>

Энэ сайт руу хүсэлтээ Англи, Франци, Испани, Араб, Хятад хэлээр илгээж болно. Хүнсний нэмэлтийн талаарх шинжээчийн хамтарсан хорооны тайланг ДЭМБ-ын <http://www.who.int/ipes/food/ieefa/cn> хаягаар үзэж болно.

### **0.3 Нэмэлт хэрэглэхийг хязгаарласан хүнсний бүтээгдэхүүн**

Нэмэлт хэрэглэхэд тохиромжтой бус эсвэл хэрэглээг нь хязгаарлах шаардлагатай бүтээгдэхүүний нэр төрөл эсвэл тухайлсан бүтээгдэхүүнийг энэ стандартаар тодорхойлно.

### **0.4 Хүнсний нэмэлт хэрэглээний Дээд түвшин**

Нэмэлтийн хэрэглээг хоногийн зохистой хэмжээнээс хэтрүүлэхгүй байх нь төрөл бүрийн бүтээгдэхүүнд нэмэх хүнсний нэмэлтийн Дээд түвшинг тогтоох үндсэн зарчим болно.

Энэ стандартад заасан хүнсний нэмэлт, эдгээрийн хэрэглээний зохистой Дээд түвшинг тогтооход Кодексийн хүнсний бүтээгдэхүүний стандартын нэмэлтийн заалтад үндэслэх, эсвэл Төрийн байгууллагын хүсэлтээр хэрэглээний Дээд түвшин нь хоногийн зохистой Дээд хэм хэмжээтэй нийцэж буй эсэхийг тохиромжтой аргын дагуу шалгахад үндэслэнэ.

Энэ чиглэлээр эхний ээлжинд энэ стандартын А хавсралтын материалыг ашиглаж болно. Мөн хүнсний бодит хэрэглээний үзүүлэлтийг ашиглахад тохиромжтой.

## **1 Норматив эшлэл**

Энэ стандартад олон улсын дараах стандартыг эш татсан бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг хэрэглэнэ. Үүнд: *Codex Stan 192-1995, General standard for food additives (1997, 1999, 2001, 2003, 2004, 2005, 2006, 2007, 2008, 2009, 2010, 2011, 2012, 2013, 2014, 2015 онуудад дахин хянасан)*

## **2 Нэр томьёо, тодорхойлолт**

### **2.1**

#### **хүнсний нэмэлт**

хүнсний бүтээгдэхүүн эсвэл түүний бүрэлдэхүүн байдлаар бие даан хэрэглэгдэхгүй, шимт чанар агуулсан эсвэл агуулаагүй бөгөөд технологийн зориулалтаар (мэдрэхүйн шинж чанар хамаарна) үйлдвэрлэл, боловсруулалт, бэлтгэл, савлалт, тээвэрлэлтийн явцад нөлөөлөх, эсвэл тухайлсан үр дүнд хүргэх (шууд болон шууд бусаар), өөрөө эсвэл түүний дагалдах бодис нь хүнсний бүрэлдэхүүн хэсэг болж технологийн үзүүлэлтэд нөлөөлөх бодис

Энэ нь хүнсний шимт чанарыг сайжруулах эсвэл хадгалах зорилгоор хэрэглэдэг бодис болон бохирдуулагчид хамаарахгүй.<sup>4</sup>

### **2.2**

#### **хоногийн зохистой хэрэглээ (ADI)**

JECFA–аас хүний биеийн үндсэн жинг харгалзан тооцсон бөгөөд өдөр бүр амьдралын туршид тогтмол хэрэглэхэд эрүүл мэндэд эрсдэл үзүүлэхгүй байх хүнсний нэмэлтийн хэмжээ<sup>5</sup>

<sup>4</sup> Хүнсний хууль эрх зүйн хорооны лавлах

<sup>5</sup> Хүнсэнд агуулагдах бохирдол, нэмэлтийн аюулгүй байдлыг үнэлэх зарчим, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага,( ДЭМБ Орчны эрүүл ахуйн шалгуур үзүүлэлт № 70) р.111 (1987). Энэ стандартад заасан “эрүүл мэндэд мэдрэгдэх эрсдэлгүй” гэдэг хэллэг нь ашиглаж буй хүнсний нэмэлтийн хэмжээ энэхүү стандартад заасан хэмжээнээс хэтрэхгүй байх тохиолдолд хэрэглэгчийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй болохыг илэрхийлнэ. Энэ стандартын заалт нь хэрэглэгчийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хэмжээгээр нэмэлтийг хэрэглэхийг дэмжихгүй болно

**2.3****хоногийн зохистой хэрэглээ “тодорхой бус”<sup>6</sup>**

бодит үзүүлэлтэд (химийн, биохимийн, хор судлалын болон бусад) тулгуурлан хоруу чанар маш бага болохыг тогтоосон бөгөөд хүссэн үр дүнд хүргэх шаардлагатай түвшин ба хүнсэнд агуулагдах хэмжээ нь хоногийн зохистой хэрэглээнээс хэтрэхгүй бөгөөд JECFA-ийн үзэж буйгаар, хүний эрүүл мэндэд аюул учруулахгүй байх хүнсний нэмэлт

Дээр дурдсан шалтгаан болон JECFA-ийн үнэлгээний үр дүнгээр хоногийн зохистой хэрэглээг тоон үзүүлэлтээр илэрхийлэх шаардлагагүй гэж JECFA үздэг. Дээрх шалгуурт нийцсэн нэмэлтийг 3.3-т дурдсан үйлдвэрлэлийн зохистой дадлын хүрээнд хэрэглэнэ.

**2.4****хэрэглээний Дээд түвшин**

хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний тухайлсан төрөлд хэрэглэхэд үр дүнтэй гэдгийг тогтоосон бөгөөд Хүнсний Эрх зүйн Хорооноос аюулгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн нэмэлтийн хамгийн их агууламж

Үүнийг (кг) хүнсний бүтээгдэхүүнд оногдох (мг) нэмэлтийн хэмжээгээр зонхилон илэрхийлнэ.

Хэрэглээний Дээд түвшин нь зохистой, зөвлөмжийн эсвэл ердийн хэрэглээний түвшинтэй тэр бүр тохирохгүй.

Үйлдвэрлэлийн зохистой дадлын хүрээнд зохистой, зөвлөмжийн эсвэл ердийн хэрэглээний түвшин нь нэмэлтийг хэрэглэх тохиолдол бүрт харилцан адилгүй. Энэ нь нэмэлтийг хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний төрөл, техникийн үзүүлэлт, түүхий эдийн төрөл, хүнс боловсруулах, хадгалах, тээвэрлэх, түгээлтийн явц, жижиглэнгийн худалдаа ба хэрэглэгчийн онцлог зэрэг хүчин зүйлээс хамаарна.

**3 Хүнсний нэмэлт ашиглах ерөнхий зарчмууд**

Энэ стандартад заасан хүнсний нэмэлтийг ашиглахдаа тухайн стандартын 3.1-3.4 дугаар заалтыг баримтлана.

**3.1 Хүнсний нэмэлтийн аюулгүй байдал**

а) JECFA-аас санал болгож буй түвшинд хэрэглэхэд хэрэглэгчийн эрүүл мэндэд эрсдэл учруулахгүйг тодорхой хэмжээгээр нотолсон хүнсний нэмэлтийн хэрэглээг л энэ стандартаар зохицуулна.

б) Энэ стандартад хүнсний нэмэлтийг хамруулахдаа хоногийн зохистой хэрэглээ, JECFA тогтоосон хүнсний нэмэлтийн аюулгүйн үнэлгээ болон хүнсний бүх эх сурвалжаас авах хоногийн хэрэглээг<sup>7</sup> харгалзсан болно. Онцлог бүлгийн хэрэглэгчийн (тухайлбал чихрийн шижин өвчтэй, эмчилгээний эсвэл шингэн хоолны дэглэмтэй өвчтөн гэх мэт) хоол хүнсэнд агуулагдах нэмэлтийн хэмжээг тогтооходоо тухайн хэрэглэгчийн өдөр тутмын нэмэлтийн хэрэглээг харгалзана.

с) Хүнсэнд нэмж буй нэмэлтийн хэмжээ нь хэрэглээний Дээд түвшинд эсвэл түүнээс бага байх, харин доод түвшин нь технологийн үр дүнд хүрэх шаардлагатай нөхцлийг хангасан байна. Нэмэлт хэрэглээний дээд түвшинг А хавсралтад заасан

<sup>6</sup> Энэ стандартын хоногийн зохистой хэрэглээ “хязгааргүй” гэсэн томъёолол нь хоногийн зохистой хэрэглээ “тодорхой бус” гэсэнтэй ижил утга агуулна. Хоногийн зохистой хэрэглээний тохиромжтой үзүүлэлтийг JECFA-ийн үнэлгээгээр тогтооно. Энэ нь хоруу чанарын үзүүлэлтээр бус, харин хүнс боловсруулах зохистой түвшин, эсвэл үйлдвэрлэлийн зохистой дадлыг хангасан нөхцөлд аюулгүй болохыг тогтоосон үнэлгээнд тулгуурлана.

<sup>7</sup> Кодексийн гишүүд нь хэрэглээний дээд түвшинг тогтооход ашиглах мэдээллээр CCFA-г хангах боломжтой. Түүнчлэн, JECFA нь CCFA-ийн хүсэлтээр Кодексын гишүүдийн хүсэлтэд нийцсэн үзүүлэлтийг харгалзан нэмэлтийн хэрэглээний үнэлгээг хийнэ. CCFA нь нэмэлтийн дээд түвшинг тогтооход JECFA-ийн үнэлгээг харгалзана.

## **MNS CAC 192 : 2015**

журмын заалт, Хүнсний эрх зүйн хорооны гишүүдийн хоногийн хэрэглээний үнэлгээ эсвэл Хүнсний эрх зүйн Хүнсний нэмэлтийн хорооноос JECFA-д тавьсан хүсэлтийн дагуу үндэсний хэмжээнд хийсэн хоногийн хэрэглээний хөндлөнгийн үнэлгээ зэрэгт тулгуурлана.

### **3.2 Хүнсний нэмэлт ашиглах үндэслэл**

Хэрэглэгчийн эрүүл мэндэд эрсдэл учруулахгүй, тэднийг төөрөгдөлд оруулахгүй, нэг буюу хэд хэдэн технологийн зориулалтаар ашиглах үндэслэлтэй болохыг Codex-оос тодорхойлсон нөхцөлд л нэмэлтийг бүтээгдэхүүнд нэмнэ. Хүнсний нэмэлт хэрэглэхэд эдийн засгийн болон технологийн хувьд ашигтай байх, мөн доорхи заалтыг (a-d) харгалзана. Үүнд:

- a) Хүнсний шимт чанарыг хадгалах зориулалтаар ашиглах, ингэхдээ (b) заалтын дагуу хүнсний шимт чанарыг зориудаар бууруулахыг зөвтөгсөн, эсвэл хооллолтын дэглэмд нь тухайн хүнс зонхилох байр суурийг эзэлдэггүй байх нөхцлийг харгалзах
- b) Тусгай хүнс хэрэглэх шаардлагатай хүмүүст зориулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хүнсний бүрэлдэхүүн бодисын агууламжийг хадгалах зориулалтаар ашиглах
- c) хүнс болон түүнийг бүрдүүлэгч бодисын байгалийн унаган төрх эсвэл чанар өөрчлөгдөхгүй бөгөөд хэрэглэгчийг төөрөгдөлд оруулахгүй байх нөхцлийг хангасан нөхцөлд бүтээгдэхүүний хадгалалт, тогтворжилт болон мэдрэхүйн үзүүлэлтийг сайжруулах зориулалтаар хэрэглэх
- d) Чанаргүй түүхий эд ашиглах, эрүүл ахуйн шаардлагад нийцээгүйн улмаас үйлдвэрлэлийн явцад гарсан согог гэмтлийг засах, нуух зориулалтаар бус, хүнс үйлдвэрлэх, боловсруулах, бэлтгэх, савлах, тээвэрлэх, хадгалах хугацааг нэмэгдүүлэх зориулалтаар ашиглах.

### **3.3 Үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)<sup>8</sup>**

Хүнсний бүх нэмэлтийг энэхүү стандартад заасны дагуу үйлдвэрлэлийн зохистой дадлын хүрээнд дараах нөхцлийг харгалзан хэрэглэнэ. Үүнд:

- a) Хүнсэнд хэрэглэсэн нэмэлтийн хэмжээг хүссэн үр дүнд хүрэхэд шаардагдах хамгийн бага түвшинд байлгах;
- b) Бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, савлах явцад түүний бүрэлдэхүүн хэсэг болдог хэдий ч, физикийн болон технологийн чанарт нь нөлөө үзүүлдэггүй нэмэлтийн хэмжээг боломжит түвшин хүртэл бууруулах;
- c) Нэмэлт нь хүнсний чанарын зэрэглэлд нийцсэн байх бөгөөд түүнийг бэлтгэх, боловсруулах арга нь хүнсний бүрэлдэхүүнийхтэй нэгэн адил байна.

### **3.4 Хүнсний нэмэлтийн таньц ба цэвэр байдлын техникийн үзүүлэлт**

Энэ стандартад заасны дагуу нэмэлт нь хүнсний чанарын тохиромжтой зэрэглэлд нийцсэн байх бөгөөд түүний таньц ба цэвэр байдал нь Хүнсний эрхзүйн хорооноос<sup>9</sup> зөвлөмж болгосон техникийн үзүүлэлтийг хангасан байна. Харин энэ шаардлага байхгүй нөхцөлд Үндэсний болон Олон улсын байгууллагаас боловсруулсан техникийн үзүүлэлтийг харгалзана. Хүнсний аюулгүй байдлын үүднээс нэмэлт нь техникийн бүх шаардлагыг хангасан (ганц нэг үзүүлэлтээр бус)

<sup>8</sup> Нэмэлт мэдээллийг Хүнсний эрхзүйн хорооноос гаргасан Дүрэм журмын эмхтгэлээс харна. Бараа бүтээгдэхүүний ба Ерөнхий хороодын хоорондын уялдаа – Хүнсний нэмэлт ба бохирдол.

<sup>9</sup> Хүнсний эрхзүйн хороогоор баталсан техникийн үзүүлэлтийн индекс (CAC/MISC 6) болон баталсан огноог <http://www.codexalimentarius.net> сайтаас үзэж болно. JECFA-аас бэлтгэсэн эдгээр техникийн үзүүлэлтийг 2006 онд хэвлэгдсэн “Хүнсний нэмэлтийн техникийн үзүүлэлтийн нэгдсэн жагсаалт” FAO JECFA Monographs No. 1-д тусгасан бөгөөд энэ нь 4 боть болон бусад JECFA Монографд туссан болно. Түүнчлэн уг техникийн үзүүлэлтийг <http://www.fao.org/ag/aqh/jeeqa-additives/scarch.html?lang=cn> сайтаас үзэж болно. Энэ жагсаалтанд амт оруулагч нэмэлтийг тусгаагүй хэдий технологийн зориулалтаар ашигладаг цөөхөн нэмэлтийг тусгасан болно. Энэ нэмэлтийн мэдээллийг Хүнс хөдөө аж ахуйн олон улсын байгууллагын Хүнсний нэмэлтийн шинжээчийн хамтарсан хорооны сайтаас авч болно. <http://www.fao.org/food/food-safety-quality/scientificadvice/jecfa/jecfa-flav/en/>.

бөгөөд Үйлдвэрлэлийн зохистой дадлын хүрээнд үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт болон боловсруулах ажилбар нь хэрэгжсэн нөхцөлд хүнсний аюулгүй байдал, чанарын зэрэглэл хангагдана.

#### **4 Бүтээгдэхүүнд шууд бус хэрэглэх хүнсний нэмэлт**

##### **4.1 Бүтээгдэхүүний бүрэлдэхүүн бодис болон түүхий эдээр дамжуулан хэрэглэх нэмэлт, түүнийг ашиглах нөхцөл**

Нэмэлтийг бүтээгдэхүүнд шууд нэмэхээс гадна түүхий эд болон бүрэлдэхүүн бодистой холих замаар хүнсэнд хэрэглэх боломжтой. Энэ тохиолдолд нэмэлт нь дараах шаардлага хангасан байна. Үүнд:

- а) Энэ стандартын дагуу нэмэлтийг түүхий эд, эсвэл бүрэлдэхүүн бодистой хам байдлаар хэрэглэхэд тохиромжтой байх;
- б) Түүхий эд болон бүрэлдэхүүн бодист агуулагдаж байгаа нэмэлтийн хэмжээ (хүнсний нэмэлтийг оролцуулаад) нь энэ стандартад заасан хэрэглээний Дээд түвшнээс хэтрэхгүй байх;
- в) Энэхүү стандартын нөхцлийг дагуу үйлдвэрлэлийн зохистой ажилбар, эсвэл технологийн зохих нөхцөлд хүнсэнд агуулагдах нэмэлтийн хэмжээ нь түүхий эд болон бүрэлдэхүүн бодисоос ихгүй байна.

##### **4.2 Хүнсний бүтээгдэхүүний бүрэлдэхүүн болон түүхий эдэд нэмэлт ашиглах тусгай нөхцөл**

Түүхий эд эсвэл бүрэлдэхүүн бодис нь зөвхөн хүнс үйлдвэрлэхэд ашиглагдах бол эдгээрт хэрэглэх нэмэлтийн хэмжээ нь энэ стандартын заалтын дагуу дээд түвшний үзүүлэлтээс хэтрэхгүй байна.

##### **4.3 Шууд бус нэмэлт ашиглахад тохиромжгүй хүнс**

Тухайн стандартын хүнсний нэмэлтийн жагсаалтын 1 ба 2 хүснэгтэд тусгагдаагүй бөгөөд түүхий эд ба бүрэлдэхүүн бодистой нэмэлтийг хам хэрэглэхэд тохиромжгүй хүнсэнд дараах бүлгийн бүтээгдэхүүн хамаарна. Үүнд:

- а) угжны сүү, угжны баяжуулсан сүү болон эмчилгээний зориулалтаар хэрэглэх хүүхдийн хүнс -13.1
- б) Нярай болон өсвөр насны хүүхдийн тэжээл -13.2

#### **5 Хүнсний ангиллын тогтолцоо<sup>10</sup>**

Хүнсний ангиллын тогтолцоо нь энэхүү стандартад заасан хүнсний нэмэлтийн хэрэглээг зохицуулах арга хэрэгсэл болно. Хүнсийг ангилах тогтолцоо нь хүнсний бүх бүтээгдэхүүнд хамаарна.

Хүнсний ангиллын тодорхойлолт нь бүтээгдэхүүнийг хууль ёсоор илэрхийлэхгүй, хаяг, шошгололтын зориулалтгүй болно.

Хүнсний ангиллын тогтолцоо нь дараах зарчимд тулгуурлана. Үүнд:

- а) Хүнсний ангиллын тогтолцоо нь шаталсан хэлбэртэй байна. Энэ нь тухайн нэмэлтийг ерөнхий ангиллын хүнсэнд ашиглахыг зөвшөөрсөн бол дэд ангилалынхт өөрөөр заагүй бол мөн ашиглах боломжтой гэсэн ойлголт юм. Үүний нэгэн адил хэрэв нэмэлтийг дэд ангиллын хүнсэнд ашигласан бол улмаар тухайлсан эсвэл дэд ангилалд багтсан бүхий л хүнсэнд ашиглах боломжтойг илтгэнэ.
- б) Хүнсний ангиллын тогтолцоо нь бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах нэмэлтийн тодорхойлолтод үндэслэнэ. Гэхдээ энэ нь өөрөөр заагаагүй нөхцөлд хүчинтэй.

<sup>10</sup> Энэ стандартын В хавсралт



## MNS CAC 192 : 2015

- с) Хүнсний ангиллын тогтолцоо нь нэмэлтийг бүтээгдэхүүнд шууд бус аргаар нэмэх зарчмыг тухайлан харгалзана. Ийм байдлаар хүнсний бүрэлдэхүүн бүрийг ангиллын тогтолцоонд тухайлан заах шаардлагагүй (Тухайлбал, Пицца зэрэг бэлэн хоол нь ижил хэмжээний олон нэмэлтийг нэгэн зэрэг ашиглахыг зөвшөөрдөг). Энэ нөхцөл нь тухайн хүнсэнд зөвшөөрөлгүй нэмэлт ашиглаагүй тохиолдолд хүчинтэй.
- д) Энэ стандартын хүнсний нэмэлтийг боловсруулах, цэгцлэхэд ашиглах мэдээллийг хялбаршуулахад хүнсний ангиллын тогтолцоог ашиглана.

### 6 Стандартын бүтэц

Энэ стандарт нь 3 үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- а) Удиртгал хэсэг
- б) Хавсралт

i - А Хавсралтад хүнсний нэмэлтийн хэрэглээний дээд түвшингийн JECFA болон ADI тоон үзүүлэлтийн зөвлөмжийг тусгасан болно.

ii - В Хавсралт - Стандартын 1-3 дугаар хүснэгтийг боловсруулахад ашигласан хүнсний ангиллын тогтолцооны жагсаалт. Хүнсний ангилал, дэд ангилал бүрийн тодорхойлолтыг тусгасан болно.

iii - С Хавсралт - Хүнсний ангиллын тогтолцоо болон Кодексийн бараа бүтээгдэхүүний стандартын лавлагаа

с) Хүнсний нэмэлтэд тавих шаардлага

i. 1 дүгээр хүснэгтэд хүнсний нэмэлт болон хүнсний нэмэлтийн бүлгийг (үсгийн дарааллаар) JECFA ADI-ийн дугаарлалтаар, нэмэлт хэрэглэхийг зөвшөөрсөн хүнсний ангилал (эсвэл хүнс), мөн хүнс болон хүнсний ангилалд хэрэглэх нэмэлтийн дээд түвшин болон эдгээрийн технологийн зориулалтыг тусгасан болно. Мөн 1 дүгээр хүснэгтэд дугаарлалтгүй ADIs-д хамаарах нэмэлтийн хэрэглээний зөвшөөрөгдөх дээд түвшин нь тодорхой нэмэлтийг багтаасан болно.

ii. 2 дугаар хүснэгт нь 1 дүгээр хүснэгтийн нэгэн ижил мэдээллийг агуулах боловч мэдээллийн жагсаалтыг хүнсний ангиллын дугаараар эрэмбэлсэн болно.

iii. 3 дугаар хүснэгтэд JECFA ADI нөхцлөөр хязгаарлаагүй, тодорхойлоогүй боловч тохиромжтой хэмжээгээр ашиглах болон энэ стандартын 3.3-д тусгасан Үйлдвэрлэлийн зохистой дадлын зарчимд нийцүүлэн хэрэглэх боломжтой хүнсний нэмэлтийг тусгасан болно.

3 дугаар хүснэгтийн хавсралт нь 3 дугаар хүснэгтийн ерөнхий нөхцлөөс хасагдсан хүнсний ангилал ба тухайлсан хүнсний нэр төрлийг багтаасан болно.

1, 2 дугаар хүснэгтийн үзүүлэлт нь 3 дугаар хүснэгтийн хавсралтад заасан хүнсний ангиллын хэрэглээг зохицуулахад чиглэгдэнэ.

Өөрөөр заагаагүй бол, 1 ба 2 дугаар хүснэгтийн хүнсний нэмэлтийн хэрэглээний Дээд түвшин нь эцсийн бүтээгдэхүүнд хамаарна<sup>10</sup>.

1, 2, 3 дугаар хүснэгт нь боловсруулах ажилбарыг дэмжих<sup>11</sup> бодисын талаарх лавлагааг агуулаагүй болно.<sup>11</sup>

<sup>11</sup> Боловсруулах ажилбарыг дэмжих бодис гэдэг нь тоног төхөөрөмж, сав суулга болон дангаар нь хэрэглэхгүй бүрэлдэхүүн бодист хамаарахгүй бөгөөд харин түүхий эд, хүнс болон түүний бүрэлдэхүүнийг боловсруулах явцад тодорхой технологийн

## А Хавсралт

### Хүнсний нэмэлтийн хэрэглээний Дээд түвшинг хоногийн зохистой хэрэглээний тоон үзүүлэлтээр илэрхийлэх зөвлөмж

Энэ хавсралт нь хүнсний нэмэлтийг зөвлөмж байдлаар хэрэглэхэд зориулагдсан болно. Энэ нь хэрэглэгчийн өдөр тутмын хэрэглээний хүнс, ундаанд ашиглах нэмэлтийн дээд түвшин болон физиологийн дээд хязгаарт тулгуурласан болно.

Хавсралт нь нэмэлтийг хэрэглэх нөхцлийг тодорхойлох болон хэрэглэх хэмжээний нийлбэрийг тооцоход ашиглагдахгүй.

#### I. Хүнсний нэмэлт – Хэрэглээний түвшинг тооцох үндсэн зарчим

##### 1 дүгээр зөвлөмж

Урьдчилсан тооцооны аргын дагуу нэмэлтийн түвшин ба хэмжээг тооцоходоо хоногийн зохистой хэрэглээ нь тодорхой бодисын (хүчил болон түүний давс г.м) нэгэн ижил зарчмаар илэрхийлнэ. Бэлдмэл болон нунтаг байдлаар худалдаалагдаж улмаар хэрэглэхийн өмнө сэргээж хэрэглэх зориулалттай хүнсний хувьд нэмэлтийн хэрэглээний түвшинг тогтоох урьдчилсан тооцоог бэлэн бүтээгдэхүүнээр хийнэ.

#### II. Хүнсний нэмэлтийн хэрэглээний аюулгүйн үзүүлэлтийг тооцох - Хоногийн зохистой хэрэглээний тоон үзүүлэлт нь тодорхой бус хүнсний нэмэлт

##### 2 дугаар зөвлөмж

#### Хоногийн зохистой хэрэглээ нь “тодорхой бус” хүнсний нэмэлт

Хоногийн зохистой хэрэглээ нь “тодорхой бус”<sup>12</sup> нэмэлтийг үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-д өөрөөр заагаагүй бол хүнсэнд тухайлсан хязгаар заахгүй хэрэглэнэ. Гэхдээ, хүнсний нэмэлтийн хоногийн зохистой хэрэглээ “тодорхой бус” гэдгийг тухайн нэмэлтийг хязгаарлалтгүй хэрэглэх нь зохистой гэсэн ойлголт бус юм. JECFA ийн ашигладаг энэхүү томъёоллыг тодорхой үзүүлэлт ( хими, биохими, хор судлалын болон бусад )-д тулгуурлан хүссэн үр дүнд хүргэх түвшинд хэрэглэхэд Хорооны үзэж байгаагаар хүний эрүүл мэндэд хор учруулахгүй гэсэн тохиолдолд хэрэглэнэ.

Хэрэв JECFA–ийн тооцоолсноос илүү их хэмжээний нэмэлт, эсвэл олон нэр төрлийн хүнсийг ашиглах бол энэхүү хэрэглээний шинэ үнэлгээнд хамрагдах нөхцлийг хангах талаар JECFA-тай зөвлөлдөх шаардлага гарч болзошгүй. Жишээ нь нэмэлтийг чийгшүүлэгчээр ашигласны дараа түүнийг амтлагч байдлаар дахин хэрэглэх тохиолдол гарснаар харьцангуй их тунгаар хэрэглэх нөхцлийг бүрдүүлэх эрсдэлтэй.

зориулалтаар хэрэглэдэг бодис эсвэл материалд хамаарна. Эдгээр бодисын үлдэц нь эцсийн бүтээгдэхүүнд зайлшгүй тодорхойлогддог болно: Хүнсний эрх зүйн хорооны гарын авлага

<sup>12</sup> Хүнсний нэмэлт, хүнсний бохирдлын аюулгүй байдлыг үнэлэх зарчим. Женев, ДЭМБ, 1987 (Орчны эрүүл мэндийн шалгуур №70), 83х

### **3 дугаар зөвлөмж**

**Тодорхой зориулалтаар хэрэглэдэг, “зохистой” гэж үнэлэгдсэн хүнсний нэмэлт**

JECFA нь ADI-г тогтоох боломжгүй хэдий ч тухайлсан бодисын өвөрмөц хэрэглээг илрүүлэх тохиолдол бий. Энэ тохиолдолд тухайн нэмэлтийг тусгайлан заасан нөхцөлд нийцүүлэн ашиглах зөвшөөрөл олгоно. Бусад тэмдэглэгдсэн тохиолдолд CCFA нь JECFA-д хүсэлт гаргаж, улмаар нэмэлтийг дахин үнэлж, хэрэглээний шинэ мэдээллийг бүрдүүлнэ.

### **III. Хэрэглээний түвшний аюулгүйн үзүүлэлтийн тооцоо –Хоногийн зохистой хэрэглээний тоон үзүүлэлт бүхий хүнсний нэмэлт**

#### **4 дүгээр зөвлөмж**

**Хатуу төлөвтэй хүнс болон ундаанд хэрэглэх нэмэлтийн хоногийн зохистой хэрэглээний хувийг тооцох**

Нэмэлтийг хатуу төлөвтэй хүнс болон ундаанд аль алинд нь ашиглахаар төлөвлөсөн тохиолдолд хоногийн нийт зохистой хэрэглээг дээрхи бүтээгдэхүүний аль алинд нь ашиглах боломжгүй. Иймээс бүтээгдэхүүн тус бүрээр хоногийн зохистой хэрэглээний ноогдлыг тооцох шаардлагатай. Эхний шатанд хатуу, шингэн төлөвтэй хүнс бүрт хоногийн нийт зохистой хэрэглээний тал хувийг ноогдуулах нь тохиромжтой байх талтай. Харин онцгой тохиолдолд нэмэлтийн нийлбэр нь ADI үзүүлэлтээс хэтрэхгүй байхаар эдгээрийн хувийг зохицуулах нь илүү тохиромжтой (Жишээ нь: ХТХ- хатуу төлөвт хүнс, ШТХ-шингэн төлөвт хүнсийг тэмдэглэж байгаа бол  $ХТХ=1/4$  ба  $ШТХ=3/4$ ;  $ХТХ=1/6$  ба  $ШТХ=5/6$ ). Хэрвээ зөвхөн хатуу төлөвт хүнсэнд нэмэлт ашиглах тохиолдолд  $ХТХ=1$ ,  $ШТХ=0$  болох ба эсрэг тохиолдолд  $ХТХ=0$ ,  $ШТХ=1$  болно.

#### **iii (a) Хатуу төлөвтэй хүнсэнд ашиглах нэмэлт (ХТХ)**

#### **5 дугаар зөвлөмж**

**Хэрэглээний түвшин ХТХ х хоногийн зохистой хэрэглээ х 40 –өөс бага**

Хэрэв санал болгож буй нэмэлтийн хэрэглээний түвшин ( $ХТХ \times$ хоногийн зохистой хэрэглээ х 40)-өөс бага үед эдгээр нэмэлтийг хүнсний бүтээгдэхүүнд ерөнхийд нь хэрэглэхэд тохиромжтой гэж үзнэ.

#### **6 дугаар зөвлөмж**

**Хэрэглээний түвшин ХТХ х хоногийн зохистой хэрэглээ х 80 –аас бага**

Хэрэв санал болгож буй нэмэлтийн хэрэглээний түвшин ( $ХТХ \times$  хоногийн зохистой хэрэглээ х 80)–аас бага үед хүнсний нэмэлттэй бүтээгдэхүүний өдөр тутмын хэрэглээ нь хатуу төлөвт хүнсний нийт хэрэглээний хагасаас хэтрэхгүй (ж-нь: 12,5 г/кг бж/хоногт) байх нөхцлийг харгалзана.

**7 дугаар зөвлөмж****Хэрэглээний түвшин (ХТХ х хоногийн зохистой хэрэглээх 160)-аас бага**

Хэрэв санал болгож буй нэмэлтийн хэрэглээний түвшин (ХТХ х хоногийн зохистой хэрэглээ х 160)–аас бага үед хүнсний нэмэлттэй бүтээгдэхүүний өдөр тутмын хэрэглээ нь хатуу төлөвт хүнсний нийт хэрэглээний дөрөвний нэгээс хэтрэхгүй (ж-нь: 6,25 г/кг бж/хоногт) байх нөхцлийг харгалзана.

**8 дугаар зөвлөмж****Хэрэглээний түвшин (ХТХ х хоногийн зохистой хэрэглээ х 320)–оос бага**

Хэрэв санал болгож буй нэмэлтийн хэрэглээний түвшин (ХТХ х хоногийн зохистой хэрэглээ х 320)-оос бага үед хүнсний нэмэлттэй бүтээгдэхүүний өдрийн хэрэглээ нь хатуу төлөвт хүнсний нийт хэрэглээний наймны нэгээс хэтрэхгүй(ж-нь: 3,13 г/кг бж/хоногт) байх нөхцлийг харгалзана.

**9 дүгээр зөвлөмж****Хэрэглээний түвшин (ХТХ х хоногийн зохистой хэрэглээ х 320)–оос их**

Хэрэв санал болгож буй нэмэлтийн хэрэглээний түвшин (ХТХ х хоногийн зохистой хэрэглээ х 320)-оос их үед боломжит бүх хэрэглээнд тулгуурлан тооцоод хоногийн зохистой хэрэглээнээс хэтрэхгүй болохыг баталсан, эсвэл илүү нарийвчлалтай аргад тулгуурлан (ж-нь: хүнсний хэрэглээний судалгаа) тухайн түвшинг хүлээн зөвшөөрөх боломжтойг нотолсон нөхцлийг харгалзана.

**iii (б) Ундааны төрлийн хүнсэнд ашиглах нэмэлт (УТХ)****10 дугаар зөвлөмж****Хэрэглээний түвшин (УТХ х хоногийн зохистой хэрэглээ х 10)-аас ихгүй**

Хэрэв санал болгож буй нэмэлтийн хэрэглээний түвшин (УТХ х хоногийн зохистой хэрэглээ х 10)–аас ихгүй нөхцөлд хүнсний нэмэлт нь ундааны төрлийн хүнсэнд ерөнхийдөө тохиромжтой гэж үзнэ.

**11 дүгээр заавар****хэрэглээний түвшин (УТХ\* хоногийн зохистой хэрэглээ \*20)-оос ихгүй**

Хэрэв санал болгож буй нэмэлтийн хэрэглээний түвшин (УТХ \*хоногийн зохистой хэрэглээ \*20)–оос ихгүй үед нэмэлттэй ундааны өдрийн хэрэглээ нь ундааны төрлийн хүнсний нийт хэрэглээний хагасаас хэтрэхгүй (ж-нь:50мл/кг бж/хоногт) байх нөхцлийг харгалзана.

**12 дугаар заавар****хэрэглээний түвшин (УТХ х хоногийн зохистой хэрэглээ х 40)–өөс ихгүй**

Хэрэв санал болгож буй нэмэлтийн хэрэглээний түвшин (УТХ х хоногийн

## **MNS CAC 192 : 2015**

зөвшөөрөгдөх хэрэглээ х 40)–өөс ихгүй үед нэмэлттэй ундааны өдрийн хэрэглээ нь ундааны төрлийн хүнсний нийт хэрэглээний (ж-нь:25 мл/кг бж/хоногт) дөрөвний нэгээс хэтрэхгүй байх нөхцлийг харгалзана.

### **13 дугаар заавар**

#### **Хэрэглээний түвшин (УТХ х хоногийн зохистой хэрэглээ х 80)–аас ихгүй**

Хэрэв санал болгож буй нэмэлтийн хэрэглээний түвшин (УТХ х хоногийн зохистой хэрэглээ х 80)–аас ихгүй үед нэмэлттэй ундааны өдрийн хэрэглээ нь ундааны төрлийн хүнсний нийт хэрэглээний наймны нэгээс хэтрэхгүй (ж-нь: 12,5 мл/кг бж/хоногт) байх нөхцлийг харгалзана.

### **14 дүгээр заавар**

#### **хэрэглээний түвшин (УТХ х хоногийн зохистой хэрэглээ х 80)-аас их**

Хэрэв санал болгож буй нэмэлтийн хэрэглээний түвшин (УТХ х хоногийн зохистой хэрэглээ х 80)–аас их үед боломжит хэрэглээний тооцоогоор хоногийн зохистой хэрэглээ хэтрээгүй болохыг нотолсон байдлыг харгалзана (хүчтэй согтууруулах ундаа гэх мэт бүтээгдэхүүнд).

## В Хавсралт

## ХҮНСНИЙ АНГИЛЛЫН ТОГТОЛЦОО

## 1 дүгээр хэсэг: Хүнсний ангиллын тогтолцоо

01.0	Сүүн бүтээгдэхүүн ба эдгээртэй ижил төстэй бүтээгдэхүүн, хүнсний ангиллын 02.0-д заасан бүтээгдэхүүн хамаарахгүй	
01.1	Сүү болон сүүнд суурилсан ундаа	
	01.1.1	Сүү болон пахт (ердийн)
		01.1.1.1 Сүү (ердийн)
		01.1.1.2 Пахт (ердийн)
	01.1.2	Сүүнд суурилсан ундаа, амталсан болон исэг сүүн бүтээгдэхүүн (ж-нь: шоколадтай сүү, какао, цохисон өндөгтэй холисон сүү, йогурт, шар сүүний ундаа)
01.2	Исэг болон ходоодны ферментээр эздүүлсэн сүүн бүтээгдэхүүн (ердийн), хүнсний ангиллын 01.1.2 (сүүнд суурилсан ундаа)-д заасан бүтээгдэхүүн хамаарахгүй	
	01.2.1	Исэг сүү (ердийн)
		01.2.1.1 Исэг сүү (ердийн), исгэсний дараа дулааны боловсруулалт хийгээгүй
		01.2.1.2 Исэг сүү (ердийн), исгэсний дараа дулааны боловсруулалт хийсэн
	01.2.2	Ходоодны ферментээр эздүүлсэн сүү (ердийн)
01.3	Өтгөрүүлсэн сүү болон үүнтэй ижил төстэй бүтээгдэхүүн (ердийн)	
	01.3.1	Өтгөрүүлсэн сүү (ердийн)
	01.3.2	Ундаа цайруулагч
01.4	Цөцгийн (ердийн) болон үүнтэй ижил төстэй бүтээгдэхүүн	
	01.4.1	Халааж ариутгасан цөцгий (ердийн)
	01.4.2	Ариутгасан болон хэт өндөр температураар ариутгасан цөцгий, хөөсрүүлсэн цөцгий, тос багатай цөцгий (ердийн)
	01.4.3	Өтгөрүүлсэн цөцгий (ердийн)
	01.4.4	Цөцгийтэй ижил төрлийн бүтээгдэхүүн
01.5	Хатаамал сүү, хатаамал цөцгий болон эдгээртэй ижил төстэй бүтээгдэхүүн (ердийн)	
	01.5.1	Хатаамал сүү, хатаамал цөцгий (ердийн)
	01.5.2	Хатаамал сүү, хатаамал цөцгийтэй ижил төстэй бүтээгдэхүүн
01.6	Бяслаг болон үүнтэй ижил төст бүтээгдэхүүн	
	01.6.1	Хатуу бяслаг
	01.6.2	Зөөлөн бяслаг
		01.6.2.1 Хатуу бяслаг, холтостой
		01.6.2.2 Хатуу бяслагийн холтос
		01.6.2.3 Нунтаг бяслаг (дахин боловсруулдаг тухайлбал, сүмс хийх зориулалттай)
	01.6.3	Шар сүүний бяслаг
	01.6.4	Хайлмал бяслаг
		01.6.4.1 Хайлмал бяслаг (ердийн)
		01.6.4.2 Жимс, ногоо, мах зэргээр амталсан Хайлмал бяслаг
	01.6.5	Бяслагтай төстэй бүтээгдэхүүн
	01.6.6	Шар сүүний уургийн бяслаг
01.7	Сүүнд суурилсан амттан (ж-нь: пудинг, жимс болон бусад амт оруулагч бүхий йогурт)	
01.8	Шар сүү болон шар сүүн бүтээгдэхүүн, шар сүүний бяслаг хамаарахгүй	
	01.8.1	Шингэн төлөвтэй шар сүү ба шар сүүн бүтээгдэхүүн, шар сүүний бяслаг хамаарахгүй
	01.8.2	Хатаамал шар сүү ба шар сүүн бүтээгдэхүүн, шар сүүний бяслаг хамаарахгүй
02.0	Өөх тос ба ургамлын тос, тосны цийдэм	
02.1	Ургамлын шаргаасан тос, шар тос	
	02.1.1	Цөцгийн тос, шаргаасан сүүний тос, шар тос
	02.1.2	Өөх тос, ургамлын тос
	02.1.3	Гахайн өөх ба тос, малын өөхөн тос, загасны тос болон амьтны гаралтай бусад тос
02.2	"Тосон суурьтой ус" төлөвтэй тосон цийдэм	
	02.2.1	Цөцгийн тос
	02.2.2	Тосон түрхлэг, сүүний тосон түрхлэг ба холимог түрхлэг (ж-нь: маргарин, цөцгийн тос болон тэдгээрийн холимог)
02.3	"Усан суурьтай тос" төлөвтэй тосон цийдэм, түүнд суурилсан амтлаг болон холимог бүтээгдэхүүн	
02.4	Тосонд суурилсан амттан, хүнсний ангиллын 01.7-д заасан сүүнд суурилсан амттан	

**MNS CAC 192 : 2015**

		хамаарахгүй
03.0	Хүнсний мөс, жимстэй хөлдөөсөн амттан шербет, сорбет	
04.0	Жимс, хүнсний ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст болон булцуут ногоо, залаат болон буурцагт тариа, зуун наст), далайн ургамал, самар, үр	
	04.1	Жимс
	04.1.1	Шинэ жимс
	04.1.1.1	Боловсруулаагүй шинэ жимс
	04.1.1.2	Гадаргууг боловсруулсан шинэ жимс
	04.1.1.3	Хальсалсан, хэрчсэн шинэ жимс
	04.1.2	Боловсруулсан жимс
	04.1.2.1	Хөлдөөсөн жимс
	04.1.2.2	Хатаасан жимс
	04.1.2.3	Цагаан цуу, ургамлын тос болон давсны уусмалд дарсан жимс
	04.1.2.4	Нөөшилсөн ба шилэнд савласан (халааж ариутгасан) жимс
	04.1.2.5	Жимсний джем, цэлцэгнүүр ба бүржмэл
	04.1.2.6	Хүнсний ангиллын 04.1.2.5-аас бусад жимсэнд суурилсан түрхлэг хэлбэрийн бүтээгдэхүүн (чатни сүмс гэх мэт)
	04.1.2.7	Чихэрлэсэн жимс (цукат)
	04.1.2.8	Жимсний зөөлөн эд, нухаш, жимсэн өнгөлгөө, наргил модны сүү зэрэг жимсний бэлдмэлүүд
	04.1.2.9	Жимсэнд суурилсан амттан, тухайлбал: жимсний амт оруулсан усанд суурилсан амттан
	04.1.2.10	Исгэж нөөшилсөн жимсэн бүтээгдэхүүн
	04.1.2.11	Жигнэмэл гурилан бүтээгдэхүүний шанзны жимс
	04.1.2.12	Чанаж боловсруулсан жимс
	04.2	Хүнсний ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст болон булцуут ногоо, залаат болон буурцагт тариа, зуун наст), далайн ургамал, самар болон үр
	04.2.1	Шинэ ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст болон булцуут ногоо, залаат болон буурцагт тариа, зуун наст), далайн ургамал, самар болон үр
	04.2.1.1	Боловсруулаагүй шинэ ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст болон булцуут ногоо, залаат болон буурцагт (шар буурцаг ороод) тариа, зуун наст), далайн ургамал, самар болон үр
	04.2.1.2	Гадаргууг боловсруулсан шинэ ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст болон булцуут ногоо, залаат болон буурцагт тариа, зуун наст), далайн ургамал, самар болон үр
	04.2.1.3	Хальсалсан, хэрчсэн, жижиглэсэн шинэ ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст болон булцуут ногоо, залаат болон буурцагт тариа, зуун наст), далайн ургамал, самар болон үр
	04.2.2	Боловсруулсан ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст болон булцуут ногоо, залаат болон буурцагт тариа, зуун наст), далайн ургамал, самар болон үр
	04.2.2.1	Хөлдөөсөн ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст болон булцуут ногоо, залаат болон буурцагт тариа, зуун наст), далайн ургамал, самар болон үр
	04.2.2.2	Хатаасан ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст болон булцуут ногоо, залаат болон буурцагт тариа, зуун наст), далайн ургамал, самар болон үр
	04.2.2.3	Цагаан цуу, ургамлын тос, давсны уусмал болон шар буурцгийн сүмсэнд нөөшилсөн ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст болон булцуут ногоо, залаат болон буурцагт тариа, зуун наст), далайн ургамал
	04.2.2.4	Лааз эсвэл шилэнд савласан (халааж аритгасан), эсвэл зориулалтын уутанд савласан ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст болон булцуут ногоо, залаат болон буурцагт тариа (шар буурцаг ороод) тариа, зуун наст), далайн ургамал
	04.2.2.5	Хүнсний ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст болон булцуут ногоо, залаат болон буурцагт тариа, зуун наст), далайн ургамал, самар болон үрийн нухаш, түрхлэг (ж-нь: газрын самрын тос)
	04.2.2.6	Хүнсний ангиллын 04.2.2.5-аас бусад хүнсний ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст болон булцуут ногоо, залаат болон буурцагт тариа, зуун наст), далайн ургамал, самар болон үр, тэдгээрийн зөөлөн эд болон бэлдмэлүүд (ж-нь: ногооны амттан, сүмс, чихэржүүлсэн ногоо)
	04.2.2.7	Хүнсний ангиллын 06.8.6, 06.8.7, 12.9.1, 12.9.2.1 ба 12.9.2.3-ийн

			исгэж нөөшилсөн шар буурцгийн бүтээгдэхүүнээс бусад исгэж нөөшилсөн хүнсний ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст болон булцуут ногоо, залаат болон буурцагт тариа, зуун наст), далайн ургамлын бүтээгдэхүүн
		04.2.2.8	Чанаж, хуурч боловсруулсан ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст болон булцуут ногоо, залаат болон буурцагт тариа, зуун наст), далайн ургамлын бүтээгдэхүүн
05.0	Чихэр, чихрэн бүтээгдэхүүн		
	05.1	Какао болон шоколадан бүтээгдэхүүн, үүнд: дуураймал шоколад, шоколад орлуулагч зэрэг бүтээгдэхүүнийг оруулаад	
		05.1.1	Какао холимог (нунтаг), какао масс
		05.1.2	Какао холимог (сироп)
		05.1.3	Какаоонд суурилсан түрхлэг болон шанз
		05.1.4	Какао болон шоколадан бүтээгдэхүүн
		05.1.5	Дуураймал шоколад, шоколад орлуулагч бүтээгдэхүүн
	05.2	Хатуу, зөөлөн чихэр, самран биетэй чихэр болон хүнсний 05.1, 05.3, 05.4 ангилалд дурдсанаас бусад чихэр, чихрэн бүтээгдэхүүн	
		05.2.1	Хатуу чихэр
		05.2.2	Зөөлөн чихэр
		05.2.3	Самран биетэй чихэр, марципан
	05.3	Бохь	
	05.4	Чимэглэл (ж-нь: амтлаг гурилан бүтээгдэхүүний зориулалтын), өнгөлгөө (жимсний бус), амтлаг сүмс	
06.0	Хүнсний ангиллын 07.0-д заасан бусад залаат, буурцагт үр тариа, үндэст болон булцуут, далдуу модны гол эсвэл зөөлөн эдээс гаргаж авсан тариа, тариан бүтээгдэхүүн		
	06.1	Бүтэн, бяцарсан, хавтгайлсан тариа болон тутрага	
	06.2	Гурил, цардуул (шар буурцгийн нунтаг)	
		06.2.1	Гурил
		06.2.2	Цардуул
	06.3	Өглөөний зуушны зориулалтын үр тариа, хавтгайлсан хошуу тариаг оруулаад	
	06.4	Гоймон, туузан гоймон, түүнтэй ижил төстэй бүтээгдэхүүн (ж-нь: цагаан будааны бэлдэц, цагаан будааны нарийн гоймон, шар буурцагны гоймон, туузан гоймон )	
		06.4.1	Хатаагаагүй гоймон, туузан гоймон болон ижил төстэй бүтээгдэхүүн
		06.4.2	Хатаасан гоймон, туузан гоймон болон ижил төстэй бүтээгдэхүүн
		06.4.3	Урьдчилан боловсруулсан гоймон, туузан гоймон болон ижил төстэй бүтээгдэхүүн
	06.5	Залаат үр тариа болон цардуулд суурилсан амттан (ж-нь: цагаан будааны пудинг, тапиоки пудинг)	
	06.6	Шингэн зуурмаг (ж-нь: загас, шувууны махны бүрмэлд зориулсан)	
	06.7	Боловсруулсан эсвэл урьдчилан чанасан цагаан будааны бүтээгдэхүүн, цагаан будааны бялууг оруулаад (зөвхөн Дорнын уламжлалт төрөл)	
	06.8	Шар буурцагны бүтээгдэхүүн (12.9 ангиллын шар буурцаганд суурилсан амтлагч болон хачирнаас бусад)	
		06.8.1	Шар буурцаганд суурилсан ундаа
		06.8.2	Шар буурцаганд суурилсан ундааны нимгэн хальс
		06.8.3	Шар буурцагны ээдэм (Дүпү)
		06.8.4	Дутуу хатаасан шар буурцагны ээдэм
		06.8.4.1	Өтгөн сүмсэнд жигнэсэн дутуу хатаасан шар буурцагны ээдэм
		06.8.4.2	Их тосонд шарсан, дутуу хатаасан шар буурцагны ээдэм
		06.8.4.3	Хүнсний 06.8.4.1 ба 06.8.4.2 ангиллаас бусад дутуу хатаасан шар буурцагны ээдэм
		06.8.5	Хатаасан шар буурцагны ээдэм (kori tofu)
		06.8.6	Исгэсэн шар буурцаг ( <i>natto</i> , <i>tempe</i> )
		06.8.7	Исгэсэн шар буурцагны ээдэм
		06.8.8	Шар буурцгийн уургийн бусад бүтээгдэхүүн
07.0	Талх, гурилан бүтээгдэхүүн		
	07.1	Талх, өргөн хэрэглээний талхан бүтээгдэхүүн, талхны холимог	
		07.1.1	Талх, хомбоо
		07.1.1.1	Дрожжоор хөөлгөсөн болон тусгай зориулалтын талх
		07.1.1.2	Хүнсний содоор хөөлгөсөн талх
		07.1.2	Крекер, чихэрлэгээс крекерээс бусад
		07.1.3	Бусад өргөн хэрэглээний талхны төрлийн бүтээгдэхүүн (цагираган боов, хавтгай талх, англи маягийн жижиг талх гэх мэт)



**MNS CAC 192 : 2015**

	07.1.4	Шанзтай талх, хатаасан талхны үйрмэг зэрэг талхны төрлийн бүтээгдэхүүн
	07.1.5	Мантуу, шанзтай хомбоо
	07.1.6	Талх болон өргөн хэрэглээний гурилан бүтээгдэхүүний хольц
	07.2	Амтлаг гурилан бүтээгдэхүүнд (чихэрлэг, давслаг, амтлаг) зориулсан хольц
	07.2.1	Бялуу, жигнэмэг, шанзтай боов (ж-нь: жимс болон цөцгийн төрлийн шанзтай)
	07.2.2	Бусад төрлийн амтлаг гурилан бүтээгдэхүүн (ж-нь: цагирган чанамал хөөмөл боов, амтлаг ороомог, бин, жижиг талх)
	07.2.3	Амтлаг гурилан бүтээгдэхүүний хольц (ж-нь: бялуу, шарвин)
08.0	Мах, махан бүтээгдэхүүн, шувууны болон ангийн мах	
	08.1	Шинэ мах, шувууны болон ангийн мах
	08.1.1	Шинэ мах, шувууны болон ангийн мах, бүхэл эсвэл мөчилсөн хэлбэрээр
	08.1.2	Шинэ мах, шувууны болон ангийн мах, жижиглэсэн
	08.2	Боловсруулсан мах, шувууны болон ангийн мах, бүхэл ба мөчилсөн
	08.2.1	Дулааны боловсруулалт хийлгүй боловсруулсан мах, шувууны болон ангийн махан бүтээгдэхүүн, бүхэл ба мөчилсөн хэлбэрээр
	08.2.1.1	Дулааны боловсруулалтгүй, нөөшлөх боловсруулалт хийсэн (давсалсан байж болно) мах, шувууны болон ангийн махан бүтээгдэхүүн, бүхэл ба мөчилсөн хэлбэрээр
	08.2.1.2	Дулааны боловсруулалтгүй нөөшлөх боловсруулалт хийж хатаасан (давсалсан байж болно), мах, шувууны болон ангийн махан бүтээгдэхүүн, бүхэл ба мөчилсөн хэлбэрээр
	08.2.1.3	Ферментийн аргаар боловсруулж, дулааны боловсруулалт хийгээгүй мах, шувууны болон ангийн мах, бүхэл ба мөчилсөн хэлбэрээр
	08.2.2	Дулааны боловсруулалт хийж боловсруулсан мах, шувууны болон ангийн мах, бүхэл ба мөчилсөн хэлбэрээр
	08.2.3	Хөлдөөсөн шувууны болон ангийн мах бүхэл ба жижиглэсэн хэлбэрээр
	08.3	Татаж, боловсруулсан мах, шувууны болон ангийн мах, тэдгээрийн бүтээгдэхүүн
	08.3.1	Татаж, дулааны боловсруулалт хийлгүй боловсруулсан мах, шувууны болон ангийн махан бүтээгдэхүүн
	08.3.1.1	Татаж, дулааны боловсруулалтгүй, нөөшлөх боловсруулалт хийсэн (давсалсан байж болно) мах, шувууны болон ангийн махан бүтээгдэхүүн
	08.3.1.2	Татаж, дулааны боловсруулалтгүй, нөөшлөх боловсруулалт хийсэн хатаасан (давсалсан байж болно) мах, шувууны болон ангийн махан бүтээгдэхүүн
	08.3.1.3	Татаж, ферментийн аргаар боловсруулан, дулааны боловсруулалт хийгээгүй мах, шувууны болон ангийн махан бүтээгдэхүүн
	08.3.2	Татаж, дулааны боловсруулалт хийсэн, боловсруулсан мах, шувуу болон ангийн махан бүтээгдэхүүн
	08.3.3	Татаж, хөлдөөсөн мах, шувуу болон ангийн махан бүтээгдэхүүн
	08.4	Хүнсний бүрхүүл (ж-нь: хиамын бүрхүүл гэдэс)
09.0	Загас, загасан бүтээгдэхүүн болон нялцгай биетэн, хавч хэлбэртэн/сам, өргөст биетэн (echinoderms) гэх мэт бүтээгдэхүүн	
	09.1	Шинэ загас, загасан бүтээгдэхүүн болон нялцгай биетэн, хавч хэлбэртэн/сам, өргөст биетэн (echinoderms) гэх мэт бүтээгдэхүүн
	09.1.1	Шинэ загас
	09.1.2	Шинэ нялцгай биетэн, хавч хэлбэртэн/сам, өргөст биетэн (echinoderms) гэх мэт бүтээгдэхүүн
	09.2	Боловсруулсан загас, загасан бүтээгдэхүүн болон нялцгай биетэн, хавч хэлбэртэн/сам, өргөст биетэн (echinoderms) гэх мэт бүтээгдэхүүн
	09.2.1	Хөлдөөсөн загас, загасны гол мах ба загасан бүтээгдэхүүн болон нялцгай биетэн, хавч хэлбэртэн/сам, өргөст биетэн (echinoderms) гэх мэт бүтээгдэхүүн
	09.2.2	Хөлдөөсөн, бүрмэл загас, загасны гол мах ба загасан бүтээгдэхүүн нялцгай биетэн, хавч хэлбэртэн/сам, өргөст биетэн (echinoderms) гэх мэт бүтээгдэхүүн
	09.2.3	Татаж, амтлан хөлдөөсөн загас, загасан бүтээгдэхүүн болон нялцгай биетэн, хавч хэлбэртэн/сам, өргөст биетэн (echinoderms) гэх мэт бүтээгдэхүүн
	09.2.4	Чанаж эсвэл шарж болгосон загас, загасан бүтээгдэхүүн болон нялцгай биетэн, хавч хэлбэртэн/сам, өргөст биетэн (echinoderms) гэх мэт бүтээгдэхүүн
	09.2.4.1	Чанаж болгосон загас, загасан бүтээгдэхүүн
	09.2.4.2	Чанаж болгосон нялцгай биетэн, хавч хэлбэртэн/сам, өргөст биетэн (echinoderms) гэх мэт бүтээгдэхүүн
	09.2.4.3	Шарж болгосон загас, загасан бүтээгдэхүүн нялцгай биетэн, хавч хэлбэртэн/сам, өргөст биетэн (echinoderms) гэх мэт бүтээгдэхүүн
	09.2.5	Утсан, хатаасан, даршилсан болон давсалсан загас, загасан бүтээгдэхүүн нялцгай биетэн, хавч хэлбэртэн/сам, өргөст биетэн (echinoderms) гэх мэт бүтээгдэхүүн
	09.3	Хагас нөөшилсөн загас, загасан бүтээгдэхүүн нялцгай биетэн, хавч хэлбэртэн/сам, өргөст биетэн (echinoderms) гэх мэт
	09.3.1	Амтлагч уусмалд дарсан болон/эсхүл цэлцэгнүүрт царцаасан загас, загасан бүтээгдэхүүн нялцгай биетэн, хавч хэлбэртэн/сам, өргөст биетэн (echinoderms) гэх мэт бүтээгдэхүүн
	09.3.2	Цуужуулсан болон давсны уусмалд даршилсан загас, загасан бүтээгдэхүүн нялцгай биетэн, хавч хэлбэртэн/сам, өргөст биетэн (echinoderms) гэх мэт

			бүтээгдэхүүн
	09.3.3		Хулд (яргай) загасыг орлуулагч, түрс, загасны түрс төрлийн бүтээгдэхүүн
	09.3.4		Хүнсний ангиллын 09.3.1-09.3.3-д дурдсанаас бусад хагас нөөшилсөн загас, загасан бүтээгдэхүүн нялцгай биетэн, хавч хэлбэртэн/сам, өргөст биетэн (echinoderms) гэх мэт бүтээгдэхүүн
	09.4		Гүйцэт нөөшилсөн болон лаазалсан, ферментжүүлсэн загас, загасан бүтээгдэхүүн нялцгай биетэн, хавч хэлбэртэн/сам, өргөст биетэн (echinoderms) гэх мэт бүтээгдэхүүн
10.0	Өндөг, өндгөн бүтээгдэхүүн		
	10.1		Шинэ өндөг
	10.2		Өндгөн бүтээгдэхүүн
	10.2.1		Шингэн байдалтай өндгөөр хийсэн бүтээгдэхүүн
	10.2.2		Хөлдөөсөн өндгөн бүтээгдэхүүн
	10.2.3		Хатаасан болон дулаанаар боловсруулсан өндгөн бүтээгдэхүүн
	10.3		Шүлтээр боловсруулсан, давсалсан, лаазалсан зэрэг нөөшилсөн өндөг
	10.4		Өндгөнд суурилсан амттан (ж-нь: чанамал крем буюу тослог зуурмаг)
11.0	Чихэрлэг амт оруулагч, зөгийн бал ороод		
	11.1		Цэвэршүүлсэн болон түүхий элсэн чихэр
	11.1.1		Цагаан элсэн чихэр, хуурай декстроз, декстозын моногидрат, фруктоз
	11.1.2		Элсэн чихрийн нунтаг, декстозын нунтаг
	11.1.3		Чийгийн агууламж ихтэй (soft) цагаан болон бор элсэн чихэр, глюкозын сироп, хатаасан глюкозын сироп, чихрийн нишингийн түүхий элсэн чихэр
	11.1.3.1		Чихрийн үйлдвэрлэлд ашиглах хатаасан глюкозын сироп
	11.1.3.2		Чихрийн үйлдвэрлэлд ашиглах глюкозын сироп
	11.1.4		Лактоз
	11.1.5		Тарималжуулсан эсвэл тээрэмдсэн цагаан элсэн чихэр
	11.2		Хүнсний ангиллын 11.1.3-д дурдсанаас бусад бор элсэн чихэр
	11.3		Элсэн чихрийн уусмал ба сироп, түүнчлэн (бүрэн бус) инвертийн сахар, меласс болон бурам, хүнсний ангиллын 11.1.3-д дурдсанаас бусад бүтээгдэхүүн
	11.4		Бусад элсэн чихэр болон сироп (ж-нь: ксилоз, агч модны сироп, өнгөлгөөний элсэн чихэр)
	11.5		Зөгийн бал
	11.6		Савласан чихэрлэг амт оруулагч, өндөр идэвхитэй чихэрлэг амт оруулагчийг оруулаад
12.0	Давс, халуун ногоо, шөл, сүмс, салат болон уурагт бүтээгдэхүүн		
	12.1		Давс болон давс орлуулагч
	12.1.1		Давс
	12.1.2		Давс орлуулагч
	12.2		Амтлагч ургамал, халуун ногоо, амтлагч, ба ааг, амт үнэрийг нэмэгдүүлэгч (ж-нь: бэлэн гоймонгийн амтлагч)
	12.2.1		Амтлагч ургамал болон халуун ногоо (ааг амттан)
	12.2.2		Амтлагч ба амт үнэрийг нэмэгдүүлэгч
	12.3		Цагаан цуу
	12.4		Гич
	12.5		Шөл болон мах, ногоотой шөл
	12.5.1		Хэрэглэхэд бэлэн нөөшилсөн, шилэнд савласан, хөлдөөсөн шөл болон мах, ногоотой шөл
	12.5.2		Шөл болон мах, ногоотой шөлний холимог
	12.6		Сүмс, түүнтэй төстэй бүтээгдэхүүн
	12.6.1		Цийдмэгжүүлсэн сүмс болон дүрлэг (ж-нь: майонез, салат амтлагч, сонгинын дүрлэг)
	12.6.2		Цийдмэгжүүлээгүй сүмс (ж-нь: кетчуп, цөцгийн сүмс, бяслат сүмс, махан хүрэн сүмс)
	12.6.3		Сүмс болон махан сүмсний холимог
	12.6.4		Тунгалаг сүмс (ж-нь: загасны сүмс)
	12.7		Хүнсний ангиллын 04.2.2.5 ба 05.1.3-д дурдсан какао болон самарт суурилсан бүтээгдэхүүнээс бусад салат (ж-нь: гоймон, төмсний салат) болон сэндвичийн түрхлэг
	12.8		Хөрөнгө, түүний төрлийн бүтээгдэхүүн
	12.9		Шар буурцагт суурилсан амтлагч ба ааг, амт үнэрийг нэмэгдүүлэгч
	12.9.1		Исгэсэн шар буурцагны нухаш (мисо)
	12.9.2		Шар буурцагны сүмс
	12.9.2.1		Исгэсэн шар буурцагны сүмс
	12.9.2.2		Исгээгүй шар буурцагны сүмс
	12.9.2.3		Шар буурцагны бусад сүмс
	12.10		Шар буурцагнаас өөр бүтээгдэхүүнээс гаргаж авсан уургат бүтээгдэхүүн
13.0	Тухайлсан зориулалттай хүнсний бүтээгдэхүүн		
	13.1		Нярай болон хүүхдийн нэмэлт тэжээл, нярай хүүхдийн эмчилгээний зориулалтын тэжээл
	13.1.1		Угжны сүү
	13.1.2		Хүүхдийн нэмэлт тэжээл
	13.1.3		Нярай хүүхдийн эмчилгээний зориулалтын тэжээл
	13.2		Нярай болон өсвөр насны хүүхдийн тэжээл
	13.3		Эмчилгээний тусгай зориулалттай сувиллын хүнс (хүнсний ангиллын 13.1-д дурдсан бүтээгдэхүүнээс бусад)
	13.4		Тураах, жин бууруулах сувиллын бүтээгдэхүүн
	13.5		Сувиллын хүнс (ж-нь: сувиллын зориулалтаар хэрэглэх нэмэлт хүнс), хүнсний ангиллын 13.1-13.4 болон 13.6-д дурдсанаас бусад
	13.6		Хүнсний нэмэлт бэлдмэл

**MNS CAC 192 : 2015**

14.0	Сүүн бүтээгдэхүүнээс бусад ундаа	
14.1	Спиртгүй (зөөлөн) ундаа	
14.1.1	Ус	
14.1.1.1	Байгалийн эрдэст ус болон байгалийн бусад эх үүсвэрийн ус	
14.1.1.2	Савласан болон хийжүүлсэн ус	
14.1.2	Жимс, ногооны шүүс	
14.1.2.1	Жимсний шүүс	
14.1.2.2	Ногооны шүүс	
14.1.2.3	Жимсний өтгөрүүлсэн шүүс	
14.1.2.4	Ногооны өтгөрүүлсэн шүүс	
14.1.3	Жимс, ногооны нектар	
14.1.3.1	Жимсний нектар	
14.1.3.2	Ногооны нектар	
14.1.3.3	Жимсний өтгөрүүлсэн нектар	
14.1.3.4	Ногооны өтгөрүүлсэн нектар	
14.1.4	Усанд суурилсан амтат ундаа, "спортын", "хүч тамирын", "электролитын" болон бусад тусгай зориулалтын ундаа	
14.1.4.1	Хийжүүлсэн, усанд суурилсан амтат ундаа	
14.1.4.2	Хийжүүлээгүй, усанд суурилсан амтат ундаа	
14.1.4.3	Усанд суурилсан амтат ундааны концентрат (хатуу эсвэл шингэн)	
14.1.5	Какаоноос бусад кофе, кофе орлогч цай, ургамлын ханд, бусад үр тарианы халуун ундаа	
14.2	Спиртлэг ундаа, спиртгүй болон бага спирттэй ундаа	
14.2.1	Шар айраг, соёолжийн ундаа	
14.2.2	Алим, лийрийн ундаа (спирттэй)	
14.2.3	Усан үзмийн дарс	
14.2.3.1	Усан үзмийн нэрмэл дарс	
14.2.3.2	Усан үзмийн оргилуун болон хөөсрөлт багатай дарс	
14.2.3.3	Усан үзмийн хатуу дарс, ликёр, чихэрлэг дарс	
14.2.4	Дарс (усан үзмийнхээс бусад)	
14.2.5	Зөгийн балны спиртлэг ундаа	
14.2.6	Нэрж бэлтгэсэн, 15 %-аас дээш спиртлэгтэй дарс	
14.2.7	Анхилуун үнэртэй спиртлэг ундаа (шар айраг, дарс ба сэрүүцүүлэгч спиртлэг ундаа, спиртлэг багатай сэрүүцүүлэгч ундаа)	
15.0	Амтат бэлэн зууш	
15.1	Хөнгөн зууш-төмс, үр тариа, гурил, цардуулд суурилсан (үндэст, булцуут, буурцагт ургамлын)	
15.2	Боловсруулсан самар, бүрмэл буюу өнгөлсөн самар, самрын холимог (ж-нь: хатаасан жимстэй)	
15.3	Хөнгөн зууш-загасанд суурилсан	
16.0	Бэлэн болгосон хүнс	

## 2 дугаар хэсэг: Хүнсний ангиллын тодорхойлолт

### 01.0 Хүнсний ангиллын 02.0-д зааснаас бусад сүүн бүтээгдэхүүн болон түүнтэй ижил төрлийн бүтээгдэхүүн:

Энд саалийн мал (саалийн үнээ, хонь, ямаа, сарлагийн үнээний)-ын сүүгээр хийсэн бүх төрлийн сүүн бүтээгдэхүүн хамаарна. Энэ ангиллын “ердийн” гэдэгт холбогдох стандартад өөрөөр заагаагүй бол амтлагч болон жимс, ногоо зэрэг сүүний гаралтай бус бүрэлдэхүүн, хольц агуулаагүй бүтээгдэхүүн хамаарна. Сүүний тосыг ургамлынхаар хэсэгчлэн болон бүрэн орлуулсан бүтээгдэхүүнийг сүүн бүтээгдэхүүнтэй ижил төстэй гэж үзнэ.

#### 01.1 Сүү болон сүүнд суурилсан ундаа:

Тосгүй, хагас тостой, бага тостой болон хэвийн сүүнд суурилсан ердийн болон амтлагчтай бүх төрлийн шингэн төлөвтэй сүүн бүтээгдэхүүн хамаарна.

##### 01.1.1 Сүү болон пахт (ердийн):

Зөвхөн ердийн шингэн төлөвтэй бүтээгдэхүүн хамаарна. Зөвхөн сүүний хольцтой сэргээсэн ердийн сүү хамаарна.

###### 01.1.1.1 Сүү ердийн):

Саалийн малаас (саалийн үнээ, хонь, ямаа, сарлагийн үнээ) саадаг шингэн төлөвтэй сүү. Сүүнд халааж ариутгах, ариутгах эсвэл хэт өндөр температураар ариутгах<sup>13</sup> зэрэг дулааны боловсруулалтыг зонхилон хийнэ. Энд тосгүй, хагас тостой, бага тостой болон хэвийн сүү хамаарна.

###### 01.1.1.2 Пахт (ердийн):

Пахт нь цөцгийн тос үйлдвэрлэх (исгэсэн эсвэл исгээгүй сүү, цөцгийг цохих) технологи ажилбарын үед үүсдэг тос агуулаагүй шингэн бүтээгдэхүүн. Түүнчлэн сүүнхүчлийн болон үнэр үүсгэгч бактерийн үйлчлэлээр тосгүй сүүг исгэх эсвэл халаасан сүүнд бактерийн цэвэр өсгөвөр нэмэх (пахтын хөрөнгө)<sup>14</sup> замаар пахтыг тус тусгарган авч болно. Пахтыг халааж ариутгах эсвэл ариутгаж болно.

##### 01.1.2 Сүүнд суурилсан ундаа, амталсан болон исгэсэн (шоколадтай сүү, какао, өндгөнд суурилсан сүү эсвэл йогуртын ундаа, шар сүүний ундаа):

Сүүнд суурилсан бөгөөд шууд хэрэглэх зориулалттай, амт, үнэр оруулсан ундаа, эдгээрийн холимог ундаа хамаарна. Энд какаоны холимог хамаарахгүй (05.1.1 ангиллын какао-сахарын холимог). Жишээлбэл: халуун шоколад, шоколад соёолжийн ундаа, гүзээлзгэний амт бүхий йогурт, сүүний хүчлийн бактериар исгэсэн ундаа болон ласси (сүүн хүчлийн аргаар исгэсэн сүүний ээдмийг хөөсрүүлж, сахар, сахар орлуулагчтай хольсон шингэн бүтээгдэхүүн)

### 01.2 Исгэсэн болон эздүүлсэн сүүн бүтээгдэхүүн (ердийн), хүнсний ангиллын 01.1.2 сүүнд суурилсан ундаа хамаарахгүй:

<sup>13</sup> Хүнсний хими, H.D. behtz & W. groseh, Springer-Verlag, Heidelberg, 1987, p.389.

<sup>14</sup> Ibid., 392.

## **MNS CAS 192 : 2015**

Тосгүй, хагас тостой сүү, тос багатай сүү, хэвийн сүүнд суурилсан ердийн бүх бүтээгдэхүүнд хамаарна. Амталсан бүтээгдэхүүн нь 01.1.2 (ундаа), 01.7 (амттан) ангилалд хамаарна.

### 01.2.1 Исэг сүү (ердийн):

Исгэсэн, хүчиллэг болон хөрөнгөлсөн бүхий л ердийн шингэн бүтээгдэхүүнд хамаарна. Амт, өнгө оруулагч агуулаагүй ердийн иогуртыг дулаанаар боловсруулсан эсэхийг нь харгалзан 01.2.1 дэд ангиллаас харж болно.

#### 01.2.1.1 Исэг сүү (ердийн), исгэсний дараа дулааны боловсруулалт хийгээгүй:

Иогурттай төстэй, шингэн болон шингэн бус ердийн бүтээгдэхүүн.<sup>15</sup>

#### 01.2.1.2 Исэг сүү (ердийн) исгэсний дараа дулааны боловсруулалт хийсэн:

01.2.1.1 ангиллын бүтээгдэхүүнтэй ижил, зөвхөн тэдгээрийг исгэсний дараа дулаанаар (ариутгах, халааж ариутгах гэх мэт) боловсруулсан байна.

### 01.2.2 Сүү эздүүлэгч ферментээр боловсруулсан (ердийн) сүү:

Сүү эздүүлэгч ферментийн үйлчлэлээр боловсруулсан ердийн сүү. Үүнд эздүүлсэн сүү хамаарна. Амталж эздүүлсэн сүүн бүтээгдэхүүн 01.7 ангилалд хамаарна.

## 01.3 Өтгөрүүлсэн сүү болон ижил төрлийн бүтээгдэхүүн (ердийн):

Ердийн болон амталж өтгөрүүлсэн, өтгөрүүлж ариутгасан сүү болон эдгээртэй ижил төстэй бүтээгдэхүүн хамаарна. Тосгүй, хагас тостой, бага тостой сүү болон хэвийн сүүнд суурилсан, өтгөрүүлсэн тосгүй сүү ба ургамлын тосны холимог, өтгөрүүлсэн чихэртэй сүү ба ургамлын тосны холимог хамаарна.

### 01.3.1. Өтгөрүүлсэн сүү (ердийн):

Сүүний усыг хэсэгчлэн ялгах аргаар ширгээж, шаардлагатай үед элсэн чихэр нэмэх замаар өтгөрүүлсэн сүү. Өтгөрүүлж ариутгасан сүүний хувьд усыг ууршуулах, ингэхдээ дулааны үйлчлэлийг<sup>16</sup> хам байдлаар ашиглана. Усыг хэсэгчлэн ялгасан, өтгөрүүлсэн, амталж өтгөрүүлж ариутгасан сүү болон кноа (үнээ эсвэл одос үнээний сүүг буцалгах замаар өтгөрүүлсэн сүү) хамаарна.

### 01.3.2. Ундаа цайруулагч

Кофе, цай зэрэг ундаанд ашигладаг бөгөөд сүүний уураг, лактоз эсвэл ургамлын уургийн агууламжтай, ургамлын тос-усан эмульс төлөвтэй сүү эсвэл цөцгийнд хамаарна.

## 01.4 Цөцгий (ердийн) болон ижил төрлийн бүтээгдэхүүн:

<sup>15</sup> Исэг сүүн бүтээгдэхүүний кодекс стандарт (Codex Stan 243-2003)-д зааснаар худалдаж буй орны үндэсний хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд сэргээх, дахин боловсруулах зорилгоор тогтворжуулагч болон өтгөрүүлэгчээс бусад хүнсний нэмэлтийг ердийн исэг сүүнд ашиглахыг хориглоно.

<sup>16</sup> Ширгээсэн сүүний кодекс стандарт (Codex Stan 281-1971).

Цөцгий нь сүүтэй харьцуулбал тос агууламж өндөртэй шингэн бүтээгдэхүүн юм. Ердийн бүх төрлийн шингэн, өтгөн, өтгөвтөр төлөвтэй цөцгий болон түүнтэй ижил төрлийн бүтээгдэхүүнд хамаарна. Амталсан цөцгий нь 01.1.2 (ундаа) болон 01.7 (амттан) ангилалд хамаарна.

#### 01.4.1 Халааж ариутгасан цөцгий (ердийн):

Халааж ариутгасан цөцгий болон халааж ариутгасан сүүгээр хийсэн цөцгийнд хамаарна. Сүүний цөцгий болон ургамлын гаралтай тостой хам бүтээгдэхүүн хамаарна.

#### 01.4.2 Ариутгасан болон хэт өндөр температураар ариутгасан цөцгий, хөөсрүүлсэн цөцгий, тос багатай цөцгий (ердийн):

Тосны агууламжаас үл хамааран халааж ариутгах горимоос илүү өндөр температурт ариутгасан бүх төрлийн цөцгийнд хамаарна. Мөн тосыг нь багасган халааж ариутгасан бөгөөд хөөсрүүлсэн эсвэл хөөсрүүлэх зориулалттай цөцгий хамаарна. Ариутгасан цөцгийг савласны дараа дулаанаар боловсруулсан байна. Хэт өндөр температурын ариутгал болон ультрапастеризаци хийх цөцгийнд тохиромжтой бөгөөд үргэлжилсэн ажиллагаагаар дулааны боловсруулалт хийж (хэт өндөр температур, ультра пастеризаци), ариун нөхцөлд савлана. Цөцгийг мөн өндөр даралтын нөхцөлд ( хөөсрүүлсэн цөцгий ) савлаж болно<sup>17</sup>.

Хөөсрүүлсэн цөцгий, өтгөн цөцгий, ариутгаж хөөсрүүлсэн цөцгий болон хөөсрүүлсэн цөцгийтэй төстэй сүүн крем ба шанзанд хамаарна. Сүүний тосыг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь бусад тосоор орлуулсан цөцгий эсвэл шанз нь 01.4.4 (цөцгийний ижил төрөл) дэд ангилалд хамаарна.

#### 0.1.4.3 Зөөхий (ердийн):

Сүү эздүүлэх ферментийн үйлчлэлээр өтгөрсөн, зуурамхай цөцгий хамаарна. Мөн зөөхийнд хамаарна (01.1.12-д пахтны хэсэгт зааснаар цөцгийг сүүнхүчлийн бактерийн үйлчлэлээр исгэсэн).<sup>18</sup>

#### 01.4.4 Цөцгийтэй ижил төстэй бүтээгдэхүүн:

Ундаа цайруулагчаас (01.3.2)-өөр зориулалтаас ашигладаг, ургамлын тос-усан эмульс болон нунтаг төлөвтэй цөцгий орлуулагч. Энд уусамхай бөгөөд хөөсрүүлсэн цөцгийний шанз болон зөөхий орлуулагч хамаарна.

#### 01.5 Хатаамал сүү, хатаамал цөцгий болон ижил төстэй хатаасан бүтээгдэхүүн (ердийн):

Энд ердийн хатаасан сүү, хатаасан цөцгий, эдгээрийн холимог болон тэдгээртэй ижил бүтээгдэхүүн хамаарна. Мөн тосгүй сүү, хагас тостой сүү, бага тостой сүү, хэвийн сүүнд суурилсан бүтээгдэхүүн хамаарна.

#### 01.5.1 Хатаасан сүү, хатаасан цөцгий (ердийн):

Сүү болон цөцгийний усыг хэсэгчлэн ялгаж, нунтаг хэлбэрээр

<sup>17</sup> Зөөхий ба бэлэн болгосон зөөхийн кодекс стандарт (Codex Stan 288-1976).

<sup>18</sup> Хүнсний хими, H.D.Belitz & W.Grosch, Springer-Verlag, Heidelberg, 1987, p.393.

## MNS CAC 192 : 2015

Үйлдвэрлэсэн сүүн бүтээгдэхүүн.<sup>19</sup> Энд казейн ба казейнат хамаарна.<sup>20</sup>

### 01.5.2 Хатаамал сүү, хатаамал цөцгийтэй ижил төстэй бүтээгдэхүүн:

Ундаа цайруулагч (01.3.2)-аас өөр зориулалтаар ашигладаг, эмульс суурьтай хатаасан бүтээгдэхүүн. Тухайлбал, тосгүй сүүний холимог, хатаасан цөцгий болон ургамлын тосны хатаасан холимогийг орлох бүтээгдэхүүн.

### 01.6 Бяслал болон үүнтэй ижил төстэй бүтээгдэхүүн:

Бяслал болон үүнтэй төстэй бүтээгдэхүүн нь сүүний уургийн бүтцэд тос, ус агуулсан байна. Бяслалтай сүмс (12.6.2), зууш (15.1) болон бяслал агуулсан нийлмэл бүтээгдэхүүн зэрэг нь (бяслал нэмэлттэй гоймон 16.0) өөр ангилалд хамаарна.

#### 01.6.1 Зөөлөн бяслал

Үйлдвэрлэсний дараа шууд хэрэглэх боломжтой, зөөлөн болон шинэ бяслал хамаарна.<sup>21</sup> Тухайлбал, коттеж (зөөлөн, бойжилтгүй, ээдмийн бяслал), цөцгийтэй коттеж бяслал (цөцгийгээр амталсан коттеж),<sup>22</sup> цөцгийт бяслал (rahmfrischkase, хатаагаагүй, зөөлөн түрхдэг бяслал)<sup>23</sup>, моцарелла, скаморца бяслал болон *панер* бяслал (нимбэг эсвэл нимбэгний шүүснээс авсан хүчил эсвэл шар сүүний хүчил зэргээр сүүний уургийг ээдүүлж, ээдмийг ургамал хоолтны хоолны жоронд тухайлбал гамбургер г.м хэрэглэх).

Зөөлөн бүх төрлийн бяслал болон эдгээрийн холтос (моцарелла зэрэг холтостой бяслал) хамрагдана. Зонхилох бүтээгдэхүүн ердийн бөгөөд зарим коттеж болон цөцгийт бяслал нь жимс, мах, хүнсний ногооны амт, үнэр оруулагчтай байж болно. Харин өндөр тостой цөцгий агуулсан хатуу бяслал хамаарахгүй.

#### 01.6.2 Хатуу бяслал:

Үйлдвэрлэсэн даруйд шууд хэрэглэхгүй бөгөөд тухайлсан температур-хугацаанд бойжуулах явцад биохимийн болон физикийн өвөрмөц шинж чанартай болсон бүтээгдэхүүн. Хөгцтэй бяслалны хувьд бойжилтын явцад түүний дотор болон гадаргууд хөгц үүссэн байна. Бойжилттой бяслал нь зөөлөн (жишээ нь: камемберт), хатуувтар (жишээ нь: эдам, гауда), хатуу (жишээ нь: чеддар) эсвэл хэт хатуу байж болно. Түүнчлэн зөөлөнгөөс хагас хатуу төлөвтэй, цагаанаас шаравтар өнгөтэй, нягт бүтэцтэй, холтосгүй бөгөөд хэрэглэгчдэд түгээх хүртэл давсны уусмалд хадгалдаг шорвог бяслал хамаарна.<sup>24</sup>

##### 01.6.2.1 Хатуу холтостой бяслал:

Хатуу бяслал (хөгцтэй бяслал хамаарна) болон түүний холтос хамаарах бөгөөд үүнтэй уялдан хэрчсэн, зүссэн, үрсэн, хавтгайлсан хэсгүүд мөн хамаарна. Тухайлбал, хатуу бяслалт блу бяслал, бри, гауда, хаварти, швейцар бяслал хамаарна.

<sup>19</sup> Хатаамал сүү ба хатаамал цөцгийн стандарт (CodexStan 207-1999).

<sup>20</sup> Хүнсний казейн ба түүний бүтээгдэхүүний стандарт (CodexStan 290-1995).

<sup>21</sup> Бяслалны стандарт (CodexStan 283-1978).

<sup>22</sup> Коттежийн стандарт (CodexStan 273-1968).

<sup>23</sup> Цөцгийтэй бяслалны (Rahmfrischkase) стандарт (CodexStan 275-1973).

<sup>24</sup> Шорвог бяслалны бүлэг стандарт (CodexStan 208-1999).

01.6.2.2 Хатуу бяслагны холтос:

Энд зөвхөн бяслагны холтос хамаарна. Бяслагны гадаргуу хэсэг буюу холтосны бүрэлдэхүүн бодис нь эхэн үедээ бяслагны дотор хэсгийнхтэй ижил байх бөгөөд улмаар давсны уусмалаар боловсруулах, бойжуулах явцад хатаж өөрчлөгдсөн байна.<sup>25</sup>

01.6.2.3 Нунтаг бяслаг (ж-нь: давтан боловсруулалтад орж сүмс хийх зориулалттай):

Төрөл бүрийн боловсруулсан болон хайлмал бяслагийг хатаах замаар бэлтгэсэн бүтээгдэхүүн. Үрмэл, жижиглэсэн бяслаг (01.6.2.1 бяслагийн төрөл зүйл, 01.6.4 хайлмал бяслаг) хамаарахгүй. Энэ төрлийн бүтээгдэхүүнийг сүү, устай хам байдлаар боловсруулж сүмс эсвэл хоолонд нэмэх (тухайлбал: чанасан гоймон, сүү, цөцгийн тосны хамт бяслагтай гоймон бэлтгэх) зориулалттай болно. Мөн тоосруулан хатаасан бяслаг хамаарна.

01.6.3 Шар сүүний бяслаг:

Шар сүүнд сүү, цөцгий, сүүний гаралтай бодис нэмэх, эсвэл нэмэлгүй өтгөрүүлж улмаар хэвлэх аргаар бэлтгэсэн хатуу болон хагас-хатуу төлөвтэй бүтээгдэхүүн хамаарна.<sup>26</sup> Бүтэн бяслаг, түүний холтос хамаарна. Шар сүүний уургийн бяслагнаас (01.6.6) ялгаатай.

01.6.4 Хайлмал бяслаг:

Бяслагийг цийдмэгжүүлэх, хайлуулах аргаар бэлтгэдэг, хадгалах хугацаа урттай бүтээгдэхүүн. Бяслаг, сүүний тос, сүүний уураг, хуурай сүү болон усыг янз бүрийн хэмжээгээр хольж улмаар цийдмэгжүүлэн, халаасан бүтээгдэхүүн хамаарна. Бүтээгдэхүүнд үнэр, амт оруулагч бодис, жимс, ногоо болон мах зэрэг нэмэлт ашигласан байж болно. Бүтээгдэхүүн нь түрхэж болохуйц эсвэл жижиглэсэн, хэрчсэн байж болно.<sup>27</sup>

01.6.4.1 Хайлмал бяслаг (ердийн):

Нэмэлт амт, үнэр оруулагч бодис, жимс, ногоо болон мах агуулаагүй хайлмал бяслаг. Тухайлбал: Америк бяслаг, рекуесон.

01.6.4.2 Жимс, ногоо, мах зэргээр амталсан хайлмал бяслаг:

Нэмэлт амт, үнэр оруулагч бодис, жимс, ногоо болон мах нэмсэн хайлмал бяслаг. Тухайлбал: ногоотой бяслаг, чинжүүтэй бяслаг, дарстай чеддар бяслаг, бөөрөнхий бяслаг (самар, халуун ногоо, ургамлаар бүрсэн бяслаг).

01.6.5 Бяслагтай төстэй бүтээгдэхүүн:

<sup>25</sup> Бяслагны холтос нь хальсан бүрхүүлээс ялгаатай. Хальс (1) нь байгалийн болон синтетик гаралтай байх бөгөөд энэ нь бяслаг бойжих явцад харьцангуй чийглэгийг тохируулж, бичил биетнээс хамгаална. Мөн хальс (2) нь чийг үл нэвтрүүлэх лав, парафин, пластик материалаар хийгдэх ба энэ нь бойжилтын дараах бичил биетэн, физик гэмтлээс хамгаалахаас гадна бяслагны гадаад байдалд нөлөөлнө (ж-нь: гадаргууг өнгөлөх).

<sup>26</sup> Шар сүүний бяслагны стандарт (Codex Stan 284-1971).

<sup>27</sup> Хүнсний хими, H.D. Belitz & W. Grosch, Springer-Verlag, Heidelberg, 1987, pp. 400,.



## **MNS CAS 192 : 2015**

Гадаад байдлаараа бяслагтай ижил боловч сүүний тосыг өөр тосоор хэсэгчлэн болон бүрэн сольсон байна. Энд бяслаг, бяслагийн холимог, бяслагийн нунтаг зэргийг дууриалгаж хийсэн бүтээгдэхүүн хамаарна.

### 01.6.6 Шар сүүний уургийн бяслаг:

Шар сүүний бүрэлдэхүүнээс ялгасан уургийн агууламжтай бүтээгдэхүүн. Энэ бүтээгдэхүүнийг хийхэд шар сүүний уургийг тунадасжуулан ялгана. Ж-нь: рикотта бяслаг. Шар сүүний бяслагнаас (01.6.3) ялгаатай.

### 01.7 Сүүнд суурилсан амттан (пудинг, жимс болон бусад амтлагчтай йогурт):

Шууд хэрэглэх зориулалттай, амт оруулсан сүүний гаралтай амттан болон түүний холимог бүтээгдэхүүнд хамаарна. Мөн хөлдөөсөн сүүн амттан, шинэлэг бүтээгдэхүүн, сүүн гаралтай шанз багтана. Мөн исгэлтийн дараа дулаанаар боловсруулсан, боловсруулаагүй амтлаг йогурт (сүү ба сүүн бүтээгдэхүүний исгэж, үнэр амт оруулах нэмэлт (жишээ нь: жимс, какао, кофе) нэмсэн сүүн бүтээгдэхүүн<sup>28</sup>) хамаарна. Мөн бусад бүтээгдэхүүн: зайрмаг (хэвийн сүү, тос багатай сүүн бүтээгдэхүүн, зөөхий эсвэл цөцгийн тос, сахар, ургамлын тос, өндгөн бүтээгдэхүүн, жимс, какао эсвэл кофе агуулсан хөлдөөсөн амттан), хөлдөөсөн сүү (хэвийн эсвэл тос багатай, эсвэл тосгүй сүүгээр хийсэн зайрмагтай төстэй бүтээгдэхүүн), цэлцэгнүүр сүү, амт оруулсан хөлдөөсөн йогурт, цөцгийтэй амтлаг ээдэм (сүүг уураг задлагч ферментээр боловсруулж, амт оруулах замаар хийдэг бөгөөд чихэрлэг амттай суурь кремтэй төстэй амттан), шанзгүй хатуу чихэр (наргил модны самар эсвэл шоколад нэмж сахартай чанасан сүү), бор сахар болон цөцгийн тосонд суурилсан пудинг болон шоколадтай мусс энэ ангилалд багтана. Өтгөрүүлсэн сүү буюу кноа (үнээ эсвэл одос үхрийн сүүг буцалгаж өтгөрүүлсэн), эсвэл shhena (бүлээсгэсэн үхэр эсвэл одос үхрийн сүүнд сүүний, нимбэгний, алимны хүчил нэмж эздүүлсэн), сахар болон нийлэг чихэрлэг амт оруулагч ба бусад бүрэлдэхүүн (ж-нь: matda (цэвэр буудайн гурил), амт, өнгө оруулагч (ж-нь: pedaburfee, сүүний бялуу, gulab jamun, rasgulla, rasmalai, basundi) агуулсан сүүнд суурилсан, уламжлалт аргаар бэлтгэдэг амттан энэ ангилалд хамаарна. Эдгээр бүтээгдэхүүн нь хүнсний 03.0 ангилал (хүнсний мөс, щербет, сорбет)-ийн бүтээгдэхүүнээс ялгаатай бөгөөд сүүнд суурилсан бүтээгдэхүүнд 01.7-д харин усанд суурилсан, сүү агуулаагүй бүтээгдэхүүн 03.0-ийн ангилалд хамаарна.

### 01.8 Шар сүү болон шар сүүн бүтээгдэхүүн, шар сүүний бяслаг хамаарахгүй:

Шар сүүнд суурилсан шингэн болон нунтаг хэлбэрийн төрөл бүрийн бүтээгдэхүүн хамаарна.

#### 01.8.1 Шингэн төлөвтэй шар сүү ба шар сүүн бүтээгдэхүүн, шар сүүний бяслаг хамаарахгүй:

Шар сүү нь бяслаг, казейн болон эдгээртэй төстэй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх явцад сүү, зөөхий, тосгүй сүү, пахт зэргийг сүү эздүүлэх ферментээр эздүүлэхэд ялгардаг шингэн. Исгэлэн шар сүү нь сүү, цөцгий, тосгүй сүү эсвэл пахтыг эздүүлэх үед ялгардаг, хүчлийн аргаар үйлдвэрлэдэг бяслагны үйлдвэрлэлээс зонхилон гардаг бүтээгдэхүүн.<sup>29</sup>

<sup>28</sup> Исэг идээний стандарт (Codex Stan 243-2003).

<sup>29</sup> Нунтаг шар сүүний стандарт (Codex Stan 289-1995).

01.8.2 Хатаамал шар сүү ба шар сүүн бүтээгдэхүүн, шар сүүний бяслалт хамаарахгүй:

Шар сүү эсвэл исгэлэн шар сүүг тоосруулагчтай эсвэл бултай хатаагчаар хатаах замаар хатаасан шар сүүг бэлтгэх бөгөөд энэ ажилбарын явцад сүүний тосны агууламж багасна.

02.0 Тос ба шингэн төлөвтэй тос, тосны цийдэм:

Ургамал, амьтан, далайн гаралтай бүтээгдэхүүн эсвэл тэдгээрийн хольцоос гаргаж авсан тосонд суурилсан бүх бүтээгдэхүүн хамаарна.

02.1 Шаргаасан ба шингэн төлөвтэй тос:

Хүнсний тос ба шингэн төлөвтэй тос нь ургамал, амьтан эсвэл далайн гаралтай бүтээгдэхүүнээс гаргаж авсан тосны хүчлийн триглицеридээс бүтэх бүтээгдэхүүн болно.<sup>30</sup>

02.1.1 Сүүний шаргаасан тос, шар тос:

Сүүний тослог бүтээгдэхүүн - сүүний шаргаасан тос, шар тосыг зөвхөн сүү болон сүүн бүтээгдэхүүнээс ялгах бөгөөд ус болон тосгүй хуурай бодисыг бүрэн ялгах замаар үйлдвэрлэдэг. Ги нь зөвхөн сүү, зөөхий болон цөцгийн тосноос ус болон тосгүй хуурай бодисыг бүрэн ялгах аргаар бэлтгэдэг бөгөөд энэ нь өөрийн өвөрмөц амт болон бүтэцтэй юм.<sup>31</sup>

02.1.2 Ургамлын тос ба өөх:

Хүнсний ургамлаас хүнсний тос, өөх тосыг ялгана. Бүтээгдэхүүн нь нэг төрлийн ургамлаас гаргаж авсан эсвэл шарах, чанах болон салат хийх зорилгоор холимог байдлаар хэрэглэж эсвэл худалдаж болно.<sup>32</sup> Цэвэршүүлсэн ургамлын тосыг тосны унаган найрлагыг өөрчлөхгүйгээр механик аргыг (шахах, хөөх) халаах ажиллагаатай хослуулан гаргаж авна. Цэвэршүүлсэн ургамлын тосыг дахин боловсруулалгүй шууд хэрэглэнэ. Хүйтэн аргаар шахсан тосыг халаалгүйгээр шахах аргаар гаргана.<sup>30, 33</sup> Жишээ нь: чидун жимсний цэвэршүүлсэн тос, хөвөнгийн ургамлын тос, газрын самрын тос, vanaspati хамаарна.

02.1.3 Гахайн өөх ба тос, загасны тос болон бусад амьтны гаралтай өөх тос:

Амьтны гаралтай бүх өөх тос нь хүнсэнд хэрэглэх шаардлага хангасан байх ёстой бөгөөд нядалгааны үед эрүүл байсан амьтнаас гаргаж авна. Гахайн тосыг түүний эдээс ялгана. Үхрийн тосыг шинэ үхрийн тосны эд, хэвлийн хөндийн, гэдэс дотор, бөөр, зүрхний гадар өөх, бусад гэмтээгүй эдээс ялгана. Нядалгааны үед авдаг шинэ өөхийг "killingfat" үхмэл өөх гэнэ. Үхрийн сайн чанарын тос (premierejus болон тослог бүтээгдэхүүн)-ыг гаргаж авахдаа үхмэл өөх болон сонгож авсан гадар (хэрчсэн өөх) өөхийг нам температурт (50-55) °C халаах замаар гарган авна. Үхрийн өөхийг шаргааж (60-65) °C, цэвэрлэж гаргаж авсан, үхрийн тосны

<sup>30</sup> Тухайлсан стандартгүй, хүнсний тос, ургамлын тосны стандарт (CodexStan 19-1981).

<sup>31</sup> Сүүний тосны стандарт (CodexStan 280-1973).

<sup>32</sup> Хүнсний хими, H.D.Belitz&W.Grosch, Springer-Verlag, Heidelberg, 1987, pp.472-476.

<sup>33</sup> Чидун жимсний тос, чидун жимсний цэвэршүүлээгүй тосны стандарт (CodexStan 33-1981); Нэрлэсэн ургамлын тос (CodexStan 210-1999).

## **MNS CAS 192 : 2015**

ердийн үнэр, амттай тосыг *secunda* тос гэнэ. Шаргаасан гахайн тос гэж гахайн эд болон яснаас гаргаж авсан тосыг хэлнэ. Хүнсний тос (урсамтгай)-ыг үхэр эсвэл хонины тослог эд (салгаж авсан гадар өөх болон бусад жижиг хэсгүүдээс бусад), булчин, яснаас гаргаж авна. Загасны тосыг май загас, сардин, килька, хар хайган загаснаас<sup>34</sup>, <sup>35</sup> гаргана. Мөн бага зэрэг өөхийг нь авсан гахай эсвэл үхрийн өөх тосны эд энэ ангилалд хамаарна.

### 02.2 “Тосон суурьтай ус” төрлийн тосон цийдэм:

Тосонд суурилсан сүү, сүүний десертний дууриамал бүтээгдэхүүнээс бусад эмульсэн бүтээгдэхүүн хамаарна.

#### 02.2.1 Цөцгийн тос:

Цөцгийн тос гэдэгт зөвхөн сүү болон сүүн бүтээгдэхүүнээс ялгасан, “Тосон суурьтай ус” төлөвтэй цийдмээс бүтэх тослог бүтээгдэхүүн хамаарна.<sup>36</sup>

#### 02.2.2 Тосон түрхлэг, сүүний тосон түрхлэг ба холимог түрхлэг (Маргарин, цөцгийн тос болон тэдгээрийн холимог)

Тосон түрхлэг (усан суурьтай, хүнсний хатуу болон шингэн тостой цийдэм), сүүний тосон түрхлэг (сүүний Тосон суурьтай ус төлөвтэй цийдэм) болон холимог түрхлэг (сүүний тосны агууламж ихтэй тосон түрхлэг) энэ ангилалд багтана.<sup>37</sup> Жишээлбэл, маргарин (түрхлэг эсвэл хүнсний хатуу болон шингэн тосоор хийдэг “Усан суурьтай тос” төлөвтэй цийдэм); цөцгийн тосноос гаргаж авсан бүтээгдэхүүн (цөцгийн тос “орлуулагч”, ургамлын тостой хольсон цөцгийн тосон түрхлэг)<sup>38</sup>; цөцгийн тос болон маргарины холимог ба минарин ( “Тосон суурьтай ус” төлөвтэй цийдэм түрхлэг бөгөөд ус, сүү хүнсний хатуу болон шингэн тосоор хийдэг) зэрэг бүтээгдэхүүн хамаарна. Түүнчлэн, тос багатай цөцгийн тос, маргарин болон эдгээрийн холимог (жишээлбэл, тос агууламжийн  $\frac{3}{4}$  нь цөцгийн тос,  $\frac{1}{4}$  нь маргарин, эсвэл  $\frac{3}{4}$  нь цөцгийн тос болон маргарины холимог) бүтээгдэхүүн хамаарна.

### 02.3 “Усан суурьтай тос” хэлбэрийн тосон цийдэм, тосны цийдэмд суурилсан амтат болон холимог бүтээгдэхүүн:

Тосонд суурилсан бөгөөд сүүнд суурилсан хүнстэй ижил төстэй бүтээгдэхүүн хамаарна. Энд десерт хамаарахгүй. Эдгээр бүтээгдэхүүнийг бүрдүүлж буй тосыг сүүний тосноос бусад (жишээ нь: ургамлын тос, өөх) өөх тосоор үйлдвэрлэнэ. Тухайлбал: сүү орлуулагч (тослоггүй хатаасан сүүн дээр ургамлын өөх тос (нарбил модны самрын тос, сафлорын тос, эрдэншишийн тос)<sup>14</sup> нэмэх замаар бэлтгэсэн өөх тос орлуулагчтай сүү), сүүний бус цохимол зөөхий, сүүний бус шанз, ургамлын крем хамаарна. Майонез хүнсний ангиллын 12.6.1 бүлэгт хамаарна.

### 02.4 Хүнсний ангиллын 01.7 дурдсан сүүнд суурилсан амттанаас бусад тослог амттан:

Хүнсний ангиллын 01.7-д заасан сүүнд суурилсан амтантай ижил төстэй

<sup>34</sup> Хүнсний хими, H.D.Belitz & W.Grosch, Springer-Verlag. Heidelberg, 1987, pp.472-476.

<sup>35</sup> Тухайлсан амьтны өөх тос (CodexStan 211-1999).

<sup>36</sup> Цөцгийн тосны стандарт (CodexStan 279-1971).

<sup>37</sup> Хүнсний өөх тосон түрхлэгний стандарт (CodexStan 253-2006); Өөх тосон түрхлэг ба холимог түрхлэгний стандарт (CodexStan 256-2006).

<sup>38</sup> Хүнсний хими, H.D.Belitz & W.Grosch, Springer-Verlag. Heidelberg, 1987, p 395.

тосонд суурилсан бүтээгдэхүүн хамаарна. Хэрэглээнд бэлэн төрөл бүрийн бүтээгдэхүүн тэдгээрийн хольц хамаарна. Мөн десертийн сүүн бус шанз хамаарна. Тухайлбал, ургамлын тос бүхий зайрмагтай төстэй бүтээгдэхүүн

03.0 Тослог мөхөөлдөс ба мөстэй амттан, зайрмаг (щербет, сорбет):

Энэ ангилалд усанд суурилсан хөлдөөсөн амттан, жимсний сорбет зэрэг чихэр боовон бүтээгдэхүүн “Итали” загварын болон амт оруулсан мөс хамаарна. Үндсэн түүхий эд нь сүүнээс гаралтай амттаныг хүнсний ангиллын 01.7-д хамруулна.

04.0 Жимс, ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст болон булцуут ногоо, залаат буурцагт тариа, зуун наст), далайн ургамал, самар, үр:

Үндсэн ангилал нь 2 дэд ангилалд хуваагдана. Үүнд: 04.1 (жимс) болон 04.2 (хүнсний ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст, булцуут, буурцагт ургамал, зуун наст), далайн ургамал, самар, үр). Энэхүү 2 дэд ангиллыг шинэ, боловсруулсан гэсэн 2 хэсэгт хуваана.

04.1 Жимс:

Бүхий л шинэ (04.1.1) болон боловсруулсан (04.1.2) бүтээгдэхүүн хамаарна.

04.1.1 Шинэ жимс:

Шинэ жимс нь ихэвчлэн нэмэлтгүй байна. Гэхдээ хэрэглэгчдэд зориулан өнгөлсөн, хальсалсан, зүссэн байдлаар бэлтгэсэн жимс нь нэмэлт агуулж болно.

04.1.1.1 Боловсруулаагүй шинэ жимс:

Хураан авсан шинэхэн жимс.

04.1.1.2 Гадаргууг боловсруулсан шинэ жимс:

Зарим нэг шинэ жимсний шинэлэг байдал, чанарыг хамгаалах зорилгоор гадаргууг нь лав, өнгөлгөө болон бусад нэмэлтээр боловсруулдаг. Тухайлбал: алим, жүрж, хасарваань, лонган хамаарна.

04.1.1.3 Хальсалсан, хэрчсэн шинэ жимс:

Хэрэглэгчдэд шинэ жимсийг хальсалсан, зүссэн байдлаар нийлүүлж болно. Ж-нь: жимсний салат. Энд шинээр хэрчсэн, хавтгайлсан (нэвс) наргил модны самар хамаарна.

04.1.2 Боловсруулсан жимс:

Гадаргууг боловсруулсан, зүссэн, хальсалсан зэргээс бусад боловсруулалт хийсэн бүхий л төрлийн жимс хамаарна.

04.1.2.1 Хөлдөөсөн жимс:

## **MNS CAS 192 : 2015**

Хөлдөөхийн өмнө түр зуурын дулаанаар боловсруулсан эсвэл боловсруулаагүй жимс. Бүтээгдэхүүнийг шүүс болон чихрийн сиропонд хөлдөөсөн байж болно.<sup>39</sup> Тухайлбал хөлдөөсөн салат, гүзээлзгэнэ хамаарна.

### 04.1.2.2 Хатаасан жимс:

Бичил биетэн үржихээс сэргийлэн хатааж, усны агууламжийг бууруулсан жимс хамаарна.<sup>39</sup> Жимсний шингэн нухшийг хатааж бэлтгэсэн жимсний хальсны хатаамж (жимсний ороомог) хамаарна. Тухайлбал, зүсч хатаасан алим, үзэм, хэрчсэн, хавтгайлсан наргил модны самар болон хар чавга хамаарна.

### 04.1.2.3 Цагаан цуу, ургамлын тос болон давсны уусмалд дарсан жимс:

Дарсан чавга, манго, ногоон нимбэг, тошлой болон тарвасны хальс хамаарна. Уламжлалт аргаар дарсан зарим жимсэн бүтээгдэхүүн ("нөөшлөх боловсруулалт хийсэн", "нөөшилсөн")-ийг "чихэржүүлсэн"<sup>40</sup> гэж нэрлэдэг. Гэхдээ эдгээр нь 04.1.2.7 ангиллын (ж-нь:хатаасан, чихрээр өнгөлсөн жимс) чихэржүүлсэн бүтээгдэхүүнд хамаарахгүй.

### 04.1.2.4 Нөөшилсөн ба шилэнд савласан (халааж ариутгасан) жимс:

Шинэхэн жимсийг цэвэрлэж, жимсний өөрийн шүүстэй эсвэл элсэн чихрийн сироптой (чихэр орлуулагчийн сироп ч байж болно) лааз эсвэл шилэнд савлан, ариутгаж эсвэл халаан ариутгаж нөөшилсөн бүтээгдэхүүн.<sup>39</sup> Зориулалтын уутанд савлаж боловсруулсан бүтээгдэхүүн хамаарна. Тухайлбал: лаазанд савлаж нөөшилсөн жимсний салат, шилэнд нөөшилсөн алимны шүүс.

### 04.1.2.5 Жимсний джем, цэлцэгнүүр ба бүржмэл:

Жимсний джем нь өтгөн, түрхлэг хэлбэрийн бүтээгдэхүүн юм. Джемийг бүхэл эсвэл хэрчсэн жимс, жимсний зөөлөн эд эсвэл нухшийг жимсний шүүс болон өтгөрүүлсэн шүүстэй, шүүсгүй байдлаар чанаж бэлтгэнэ. Өтгөрүүлэх зорилгоор элсэн чихэр, пектин болон хэрчсэн жимс нэмж болно. Цэлцэгнүүрийг джемтэй адил аргаар бэлтгэх бөгөөд түрхлэг хэлбэрийн бүтээгдэхүүн бөгөөд илүү жигд бүтэцтэй, жимсний хэсэг агуулдаггүй ялгаатай. Бүржмэл нь өтгөн, түрхлэг хэлбэрийн жимсний суспенз бөгөөд бүхэл жимс, жимсний нухаш (ихэвчлэн цитрусын жимс)-ыг элсэн чихэртэй хамт өтгөн болтол чанаж бэлтгэнэ. Пектин, хэрчсэн жимс, жимсний хальс нэмж болно.<sup>39, 41</sup>

Түүнчлэн тэжээллэг чанар агуулаагүй, өндөр идэвхтэй чихэрлэг амт оруулагч агуулсан ижил төстэй сувиллын бүтээгдэхүүн хамаарна. Тухайлбал, жүржийн бүржмэл, усан үзмийн цэлцэгнүүр, гүзээлзгэний джем.

### 04.1.2.6 Хүнсний ангиллын 04.1.2.5-аас бусад жимсэнд суурилсан түрхлэг хэлбэрийн бүтээгдэхүүн (ж-нь: чатни):

Жимсэнд суурилсан түрхлэг хэлбэрийн бүхий л бүтээгдэхүүн тухайлбал алимны тос, нимбэгний ээдэм зэрэг хамаарна. Түүнчлэн манго болон үзэмний чатни зэрэг жимсэн амтлагч хамаарна.

<sup>39</sup> Хүнсний хими, H.D.Belitz & W.Grosch, Springer-Verlag, Heidelberg, 1987, p 613-617.

<sup>40</sup> Ази хүнс, Шинжлэх ухаан технологи, C.Y.W.Ang, K.S.Ltu, & Y.-W.Huang, Eds., Бүлэг 10, Жимсэн бүтээгдэхүүн, J.X.Shi & B.S.Luh, Technomic Publishingn Co., Lancaster PA 1999, p 290.

<sup>41</sup> Джем, цэлцэгнүүр ба мармелад, (CodexStan 196-2009).

04.1.2.7 Чихэрлэсэн жимс (цукат):

Өнгөлсөн жимс (элсэн чихрийн уусмалаар боловсруулж, хатаасан жимс), чихэржүүлсэн жимс (хатааж, элсэн чихрийн уусмалд дүрж гадаргууг нь бүрж чихэр байдалтай болгосон жимс), талстжуулсан жимс (хатааж өнгөлсөн жимсийг мөсжүүлэн эсвэл элсэн чихрээр бүрж хатаан бэлтгэсэн жимс) хамаарна.<sup>39</sup> Тухайлбал интоорын коктейль (*maraschino*), чихэржүүлсэн цитрусын хальс, чихэржүүлсэн нимбэг (ж-нь: баярын жимсний бялуунд ашигладаг) болон итали гаралтай амтлагч чихэржүүлсэн гич (*mostarda difrutta*).

04.1.2.8 Жимсний зөөлөн эд, нухаш, жимсэн өнгөлгөө, наргил модны сүү зэрэг жимсний бэлдмэлүүд:

Жимсний зөөлөн эдийг ихэвчлэн хүнсэнд шууд ашиглахгүй. Энэ нь зөөлөн уураар халааж боловсруулсан, нөөшлөх бодисын нэмэлттэй, нэмэлтгүй шинэ жимс. Жимсний шингэн нухшийг (манго, хар чавганы шингэн нухаш) ижил аргаар үйлдвэрлэх бөгөөд илүү нягт бүтэцтэй, нарийн ширхэгтэй бөгөөд ихэвчлэн гурилан бүтээгдэхүүний шанз байдлаар ашиглах боловч үүгээр хэрэглээг хязгаарлахгүй. Жимсний сүмсийг (ж-нь: ханборгоцой, гүзээлзгэний сүмс) жимсний зөөлөн эдийг чихэрлэг амт оруулагчтай эсвэл амт оруулагчгүй чанаж бэлтгэх бөгөөд жимсний хэсгийг агуулсан байж болно. Жимсний сүмсийг амтлаг гурилан бүтээгдэхүүн болон зайрмагт чимэглэл байдлаар ашиглаж болно. Жимсний сироп (ж-нь: нэрсний сироп) нь илүү шингэн бүтэцтэй жимсний сүмс юм. Түүнийг бялуун бүтээгдэхүүнд чимэглэл байдлаар ашиглаж болно.<sup>39</sup> Жимсний бус чимэглэл (элсэн чихэр болон шоколаданд суурилсан бүтээгдэхүүн) нь 05.4 болон элсэн чихрийн сироп (агчийн сироп) 11.4 ангилалд тус тус хамаарна. Наргил модны шинэхэн цөмийг бүхлээр дэвтээж эсвэл нунтаглан наргил модныустай, усгүй эсвэл нэмэлт устай байдлаар ихэнхи үл уусах эслэг болон бусад үлдэцээс ялгах замаар наргил модны сүү болон тосыг бэлтгэнэ.

Наргил модны самрын сүү, тосыг ариутгах, халааж ариутгах болон хэт өндөр температурын үйлчлэлээр (УНТ) боловсруулна. Мөн наргил модны самрын сүү, тосыг өтгөрүүлсэн эсвэл тосгүй сүү (“хөнгөн”) хэлбэрээр үйлдвэрлэнэ.<sup>42</sup> Тухайлбал энэхүү дэд ангилалд уламжлалт бүтээгдэхүүн болох өтгөрүүлсэн тамаринд (65 %-иас багагүй уусдаг бодис агуулсан тамаринд жимсний охь), тамарин жимсний нунтаг (тапиока цардуултай хольсон тамаринд жимсний нухаш) тамаринд тоффи чихэр (тамаринд жимсний зөөлөн эд, элсэн чихэр, хуурай сүү, үл исэлдүүлэгч, амт оруулагч, тогтворжуулагч, нөөшлөх бодис), жимсний хомбоо (жимс (манго, ханборгоцой, гуава)-ний зөөлөн эд, элсэн чихэр, амт оруулагч, нөөшлөх бодисын хольцын хатаасан бэлдэц) хамаарна.

04.1.2.9 Жимсэнд суурилсан амттан, тухайлбал: жимсний амт оруулсан усанд суурилсан амттан хамаарна:

Хүнсэнд хэрэглэхэд бэлэн бүтээгдэхүүн, тэдгээрийн хольц хамаарна. Мөн жимсний амттай желатин, *route gruze*, *frutgrod* төрлийн жимс, жимсний компот, *nata de coco*, *mitsumame* (агарын цэлцэгнүүр байдалтай желатинтай төстэй, жимсний хэсэг болон сироптой бүтээгдэхүүн) нэрийн бүтээгдэхүүн хамаарна.

Энэ ангилалд жимстэй бялуун бүтээгдэхүүн (07.2.1, 07.2.2), жимсний амт оруулсан хүнсний мөс (03.0) эсвэл жимстэй хөлдөөсөн сүүн бүтээгдэхүүн (01.7) хамаарахгүй.

<sup>42</sup> Коконат бүтээгдэхүүн - Коконатын сүү болон Коконатын крем (CodexStan 240-2003).

## **MNS CAS 192 : 2015**

### 04.1.2.10 Исгэж нөөшилсөн жимсэн бүтээгдэхүүн:

Давстай орчинд сүүн хүчлийн исэлтээр нөөшилсөн бүтээгдэхүүн хамаарна.  
Тухайлбал: исгэж нөөшилсөн чавга.

### 04.1.2.11 Жигнэмэл гурилан бүтээгдэхүүний шанзны жимс:

Хүнсэнд хэрэглэхэд бэлэн бүтээгдэхүүн, тэдгээрийн хольц хамаарна. Мөн шингэн нухашнаас (04.1.2.8) бусад бүх төрлийн шанз хамаарна. Энэ шанз нь ихэвчлэн бүтэн жимс эсвэл жимсний хэсгийг агуулна. Тухайлбал: бялууны интоор, хошуу тарианы жигнэмгийн үзэм гэх мэт.

### 04.1.2.12 Чанаж боловсруулсан жимс:

Чанасан, жигнэсэн, уураар боловсруулсан, хуурсан, өнгөлсөн эсвэл өнгөлөөгүй байдлаар хэрэглэгчдэд нийлүүлэх жимс. Тухайлбал, жигнэсэн алим, алимны хуурсан хэрчим, жигнэсэн тоор (чихэрлэг зуурмагаар өнгөлөн жигнэсэн тоор).

### 04.2 Хүнсний ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст, булцуут ногоо, залаат буурцагт тариа, зуун наст), далайн ургамал болон самар, үр:

Бүхий л шинэ (04.2.1) болон боловсруулсан (04.2.2) бүтээгдэхүүн хамаарна.

#### 04.2.1 Шинэ ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст, булцуут ногоо, залаат буурцагт тариа, зуун наст) оруулаад, далайн ургамал, самар болон үр:

Шинэ ногоо нь ихэвчлэн нэмэлтгүй байна. Гэвч хэрэглэгчдэд зориулан бүрсэн, хальсалсан, хэрчсэн шинэ ногоо нь нэмэлттэй байж болно.

#### 04.2.1.1 Боловсруулаагүй шинэ ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст, булцуут ногоо, залаат буурцагт тариа, зуун наст) оруулаад, далайн ургамал, самар болон үр:

Шинэ ургацын ногоо

#### 04.2.1.2 Гадаргууг боловсруулсан шинэ ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст, булцуут ногоо, залаат буурцагт тариа, зуун наст) оруулаад, далайн ургамал болон самар, үр:

Шинэ ногооны гадаргууг гадны нөлөөллөөс хамгаалах, шинэлэг байдал, чанарыг хадгалах зорилгоор бүрхүүл эсвэл бусад хүнсний нэмэлтийг ашиглаж болно. Тухайлбал: авакадо, өргөст хэмх, ногоон чинжүү болон хясаа самар хамаарна.

#### 04.2.1.3 Хальсалсан, хэрчсэн, жижиглэсэн шинэ ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст, булцуут ногоо, залаат буурцагт тариа, зуун наст) оруулаад, далайн ургамал болон самар, үр:

Хэрэглэгчид ахуйн нөхцөлд боловсруулж ашиглахад зориулсан шинэ ногоо тухайлбал, хальсалсан төмс (ж-нь: төмсний хольц бэлтгэх).

#### 04.2.2 Боловсруулсан ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст, булцуут ногоо, залаат буурцагт тариа, зуун наст) оруулаад, далайн ургамал болон самар, үр:

Хальсалсан, хэрчсэн, гадаргуугийн боловсруулалтаас бусад бүхий л төрлийн боловсруулалт хийсэн шинэ ногоо хамаарна.

04.2.2.1 Хөлдөөсөн ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст, булцуут ногоо, залаат буурцагт тариа, зуун наст), далайн ургамал болон самар, үр:

Түр зуурын дулаанаар боловсруулан хөлдөөсөн шинэ ногоо.<sup>43</sup> Тухайлбал түргэн хөлдөөсөн эрдэнэшиш, түргэн хөлдөөсөн Франц шарсан төмс, түргэн хөлдөөсөн вандуй болон түргэн хөлдөөж бүхлээр нь боловсруулсан лооль хамаарна.

04.2.2.2 Хатаасан ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст, булцуут ногоо, залаат буурцагт тариа, зуун наст), далайн ургамал болон самар, үр:

Чухал шимт бодист нөлөөлөхгүйгээр чийглэгийн хэмжээг бичил биетэн үржих эгзэгтэй хэмжээнээс бага түвшин хүртэл бууруулсан бүтээгдэхүүн хамаарна. Энэ бүтээгдэхүүнийг чийглэн дэвтээж эсвэл дэвтээхгүйгээр хэрэглэж болно. Үүнд шүүсийг нь хатаах замаар бэлтгэсэн лооль, хүрэн манжин зэрэг ногооны нунтаг хамаарна.<sup>31</sup> Тухайлбал төмсний хатаасан нэвс, хатаасан сэвэг зарам мөн уламжлалт аргаар хатаасан далайн хүрэн замаг (*kelp; kombu*), амт оруулагчтай далайн хүрэн замаг (*shio-kombu*), хатаасан далайн ургамал (*tororo-kombu*), хатаасан хулууны зүсэм (*kampyo*), хатаасан улаан замаг (*nori*), хатаасан далайн ургамал *laminariales* (*wakame*) хамаарна.

04.2.2.3 Цагаан цуу, ургамлын тос, давсны уусмал болон шар буурцгийн сүмсэнд нөөшилсөн ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст, булцуут ногоо, залаат буурцагт тариа, зуун наст) болон далайн ургамал:

Исгэж нөөшилсөн шар буурцагас бусад хүнсний ногоог давсны уусмалаар боловсруулж бэлтгэсэн бүтээгдэхүүн. Исгэж нөөшилсөн бүтээгдэхүүн нь 04.2.2.7 ангилалд хамаарна. Исгэж нөөшилсөн шар буурцагны бүтээгдэхүүн 06.8.6, 06.8.7, 12.9.1, 12.9.2.1 ба 12.9.2.3 ангилалд хамаарна. Тухайлбал, дарсан байцаа, өргөст хэмх, чидун жимс, сонгино, тосонд боловсруулсан мөөг, цууны хүчлээр боловсруулсан артишокын зүрх, *achar, picalilli* төрлийн дарсан ногоо хамаарна.

Мөн уламжлалт аргаар боловсруулсан *tsukemono*–цагаан будааны хивэгтэй дарсан ногоо (*nuka-zuke*), *koji*- төрлийн дарсан ногоо (*koji-zuke*), цагаан будааны архины шааранд дарсан ногоо (*kasu-zuke*), мисонд дарсан ногоо (*miso-zuke*), шар буурцгийн шүүсэнд дарсан ногоо (*shoyu-zuke*), цагаан цуунд дарсан ногоо (*su-zuke*) болон давсны уусмалд дарсан ногоо (*shio-zuke*) тус тус хамаарна. Түүнчлэн дарсан цагаан гаа, сармис, чинжүү орно.

04.2.2.4 Лааз эсвэл шилэнд савласан (халааж ариутгасан) эсвэл зориулалтын уутанд савласан ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст, булцуут ногоо, залаат буурцагт тариа, зуун наст) ба далайн ургамал:

Шинэ ногоог цэвэрлэж, түр зуурын дулаанаар боловсруулж, шингэн бүхий (ж-нь: давсны уусмал, ус, тос, сүмс) лааз, шилэнд савлаж, ариутгаж, халаан ариутгаж бүрэн нөөшилсөн бүтээгдэхүүн.<sup>43</sup> Тухайлбал, лаазанд нөөшилсөн туулайн бөөр, лаазанд нөөшилсөн туулайн бөөрний нухаш, шилэнд нөөшилсөн аспарагус, нөөшилж, боловсруулсан ягаан буурцаг, лаазалсан лоолийн нухаш (хүчил багатай) болон лаазанд нөөшилсөн лооль (хэрчсэн, бүтэн, талласан).

<sup>43</sup> Хүнсний хими, Н.Д.Белитз & В.Гросш, Springer-Verlag, Heidelberg, 1987, p 572-576.



## MNS CAS 192 : 2015

04.2.2.5 Хүнсний ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст, булцуут ногоо, залаат буурцагт тариа, зуун наст), далайн ургамал, самар болон үрийн нухаш, түрхлэг (ж-нь: газрын самрын тос):

Урьдчилан дулаанаар боловсруулсан (ж-нь: уураар боловсруулсан) ногооны концентрацаар бэлтгэсэн суспензийг ногооны шингэн нухаш гэнэ. Энэ бүтээгдэхүүнийг савлахын тулд шүүж болно. Шингэн нухаш нь нухаштай (04.2.2.6)<sup>43, 44</sup> харьцуулбал үл уусах хэсгийг бага агуулна. Жишээ нь: лоолийн нухаш, газрын самрын тос (газрын самар дээр самрын тос нэмж хуурч, бутлах замаар түрхлэг нухшийг бэлтгэнэ), бусад самрын тос (хушны самрын тос) болон хулууны тос хамаарна.

04.2.2.6 Хүнсний ангиллын 04.2.2.5-аас бусад хүнсний ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст, булцуут ногоо, залаат буурцагт тариа, зуун наст), далайн ургамал, самар болон үр, тэдгээрийн зөөлөн эд болон бэлдмэлүүд (ж-нь: ногооны амттан, сүмс, чихэржүүлсэн ногоо):

Ногооны нухаш болон зөөлөн эдийг шингэн нухшийн (04.2.2.5) адилаар бэлтгэнэ. Гэхдээ нухаш болон зөөлөн эд нь үл уусах хэсэг ихээр агуулах бөгөөд ихэвчлэн бусад хүнсний бүтээгдэхүүнд орц байдлаар (ж-нь: сүмс) ашиглана. Тухайлбал: төмс, улаан луувангийн зөөлөн эд, зуун настын сироп, салса ногооны хольц (ж-нь: жижиглэсэн лооль, сонгино, чинжүү, халуун ногоо, ургамал), чихэрлэг улаан буурцгийн нухаш (ap), чихэрлэг кофений буурцгийн нухаш (шанз), лоолийн нухаш, лоолийн зөөлөн эд, лоолийн сүмс, талстжуулсан цагаан гаа, буурцагт суурилсан ногооны амттан (*namagashi*) хамаарна.

04.2.2.7 Хүнсний ангиллын 06.8.6, 06.8.7, 12.9.1, 12.9.2.1 ба 12.9.2.3-ийн исгэж нөөшилсөн шар буурцгийн бүтээгдэхүүнээс бусад исгэж нөөшилсөн хүнсний ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст, булцуут ногоо, залаат буурцагт тариа, зуун наст), далайн ургамлын бүтээгдэхүүн:

Исгэж нөөшилсөн хүнсний ногоо нь дармал бүтээгдэхүүний нэг төрөл бөгөөд сүүнхүчлийн бактерийн үйлчлэлээр боловсруулагдах бөгөөд ихэвчлэн давсыг<sup>43</sup> хамт ашиглана. Уламжлалт аргаар ногоог исгэж нөөшлөхийн тулд тасалгааны температурт агаараар хатааж, бичил биетэн үржих боломж олгоно. Үүний дараа давс (сүүний хүчил үүсгэхийн тулд), халуун ба амтлагч ногоо<sup>45</sup> нэмж хүчилтөрөгчгүй байдлаар битүүмжлэнэ. Жишээ нь: улаан чинжүүний нухаш, исгэж нөөшилсөн ногоо (04.2.2.3 ангиллаас бусад зарим *tsukemono*), *кимчи* (исгэж боловсруулсан хятад байцаа, ногооны бэлдэц), *sauerkraut* (исгэж нөөшилсөн байцаа) хамаарна. Хүнсний ангиллын 06.8.6 шар буурцгийн исгэж нөөшилсөн бүтээгдэхүүн (ж-нь: *natto*, *tempe*), 06.8.7 (исгэж нөөшилсөн шар буурцагны аарц), 12.9.1 (исгэж нөөшилсөн шар буурцагны нухаш ж-нь: *miso*), 12.9.2.1 (исгэж нөөшилсөн шар буурцагны сүмс), болон 12.9.2.3 (бусад шар буурцагны сүмс 12.10) энд хамаарахгүй.

04.2.2.8 Чанаж, хуурч боловсруулсан ногоо (мөөг, мөөгөн бүтээгдэхүүн, үндэст, булцуут ногоо, залаат буурцагт тариа, зууннаст), далайн ургамал:

Хэрэглэгчдэд зориулан чанах, уураар боловсруулах, жигнэх, шарах зэргээр боловсруулж савласан, савлаагүй ногоо. Тухайлбал: жигнэсэн буурцаг, урьдчилан шарсан төмс, шарсан окра, шар буурцагны сүмсэнд чанасан ногоо (*tsukudani*).

05.0 Чихэр, чихэрлэг бүтээгдэхүүн:

<sup>44</sup> Улаан лоолийн нухашны стандарт (Codex Stan 57-1981)

<sup>45</sup> Ази хүнс, Шинжлэх ухаан технологи, C.Y.W.Ang, K.S.Ltu, & Y.-W.Huang, Eds., Бүлэг 11, Ногооны бүтээгдэхүүн, Wang, Technomic Publishing Co., Lancaster PA 1999, p 320-323.

Бүх какао ба шоколадан бүтээгдэхүүн (05.1), какао (05.2) агуулсан, агуулаагүй бусад чихэр, чихэрлэг бүтээгдэхүүн, бохь (05.3), чимэглэл болон өнгөлгөө (05.4) эсвэл энэ дэд ангиллалд нийцэх бүтээгдэхүүний хослолоор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн.

#### 05.1 Какао ба шоколадан бүтээгдэхүүн, үүнд дуураймал шоколад, шоколад орлуулагч зэрэг бүтээгдэхүүнийг оруулаад

Энэ ангиллыг стандартчилсан эсвэл стандартчилаагүй какао, шоколаданд суурилсан бүтээгдэхүүний төрлийг агуулсан дэд ангилалд хуваана.

##### 05.1.1 Какао холимог (нунтаг), какао масс :

Бусад шоколадан бүтээгдэхүүн эсвэл какаонд суурилсан ундааны үйлдвэрлэлд ашиглах төрөл бүрийн бүтээгдэхүүн хамаарна. Ихэнх какаоны төрлийн бүтээгдэхүүнийг цэвэрлэж, хальснаас нь салгасан какао буурцагнаас гаргаж авдаг. Какао буурцгийг механик аргаар бутлаж какао массыг гаргана. Шоколадан бүтээгдэхүүний нэр төрлөөс хамаарч какаоны буурцаг болон массыг шүлтээр боловсруулан зөөлөн, амт чанартай болгоно. Какао тоосонцор нунтаг нь какао буурцгийг шигших, үр хөврөлийг ялгах явцад үүсэх бүтээгдэхүүн юм. Какао масс эсвэл нухшийг шахах (шахдас ялгах хамаарна), хавтгайлж какао шахмал үүсгэх замаар тосны агууламжийг бууруулан какао нунтгийг үйлдвэрлэнэ. Какао шахмалыг буталж, тээрэмдэн какао нунтгийг үйлдвэрлэнэ. Какао нухаш гэдэг нь хуурч, хатааж, буталж тээрэмдсэн какао буурцагаар үйлдвэрлэсэн нэгэн жигд урсамтгай төлөв байдалтай бүтээгдэхүүн юм. Какао-элсэн чихрийн хольц нь зөвхөн какао нунтаг болон элсэн чихрээс бүрдэнэ. Ундаанд зориулсан шоколадны нунтгийг какао нухаш эсвэл амт оруулагч (ванилин)<sup>46, 47</sup> нэмсэн какао нунтаг болон элсэн чихрээр хийнэ. Жишээ нь: нунтаг шоколадан ундаа; өглөөний цайны какао, какао тоосонцор нунтаг (нарийн), буурцаг, масс, шахмал; шоколадан ундаа, какао холимог (халуун ундаа бэлтгэх нунтаг), какао-элсэн чихрийн хольц; элсэн чихэр-какаоны чихэр хийх хуурай хольц хамаарна. Бэлэн бүтээгдэхүүн какао нухаш, шоколадан сүүн бүтээгдэхүүн 01.1.2, ихэнх шоколадан бэлэн бүтээгдэхүүн 05.1.4 ангилалд хамаарна.

##### 05.1.2 Какао холимог (сироп):

Какао нухшанд амилаза фермент нэмэх замаар энэ бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ. Фермент нь какаоны сироп хатуурах, тунадасжих, какаоны цардуул задрахаас урьдчилан сэргийлнэ. Үүнд шоколадны сүү эсвэл халуун шоколад бэлтгэхэд ашиглах шоколадны сироп хамаарна.<sup>47</sup> Шоколадны сироп нь 05.4 ангиллын зөөлөн чихрийн сүмснээс (зайрмагт зориулсан) ялгаатай.

##### 05.1.3 Какаонд суурилсан түрхлэг болон шанз:

Талхны түрхлэг эсвэл жигнэмэг, бялуун бүтээгдэхүүний шанзаар хэрэглэх нухшан түрхлэгт зориулан какаог жор орцын бусад хэсэг (ихэвчлэн тосонд суурилсан)-тэй хольсон бүтээгдэхүүн. Үүнд какао тос,<sup>48</sup> бон бон чихэр болон шоколадны шанз, шоколадан зөөлөн жигнэмгийн шанз болон самартай шоколадад суурилсан талхны түрхлэг (*Nutella* төрлийн бүтээгдэхүүн) хамаарна.

<sup>46</sup> Нунтаг какао (какао) болон какао ба сахарын хуурай хольц, (CodexStan 105-1981), Какао (какао) масс (какао/шоколадны ликёр) какао таблет, (CodexStan 141-1981)

<sup>47</sup> Хүнсний хими, H.D.Belitz & W.Grosch, Springer-Verlag, Heidelberg, 1987, p 708-711.

<sup>48</sup> Какаоны масло, (CodexStan 86-1981).

05.1.4 Какао болон шоколадан бүтээгдэхүүн:

Шоколадыг какао буурцаг, масс, шахмал, нунтаг, нухаш болон үндсэн орц (самар)-оор үйлдвэрлэх ба элсэн чихэр, какао тос, үнэр амт оруулагч бодисын нэмэлттэй эсвэл нэмэлтгүй байж болно.<sup>47</sup> Энэ ангилал нь Шоколад ба шоколадан бүтээгдэхүүн (CodexStan 87-1981)-ий стандартад тодорхойлсноор шоколад, стандартын шаардлага хангасан шоколад болон шоколадаар бүрсэн самар, жимс (ж-нь:үзэм) зэрэг бусад бүтээгдэхүүн агуулсан чихэр, чихэрлэг бүтээгдэхүүнд хамаарна. Энэ ангилалд хүнсний ангиллын 05.2-ын хүрээнд багтах аливаа чихэр, чихэрлэг бүтээгдэхүүний зөвхөн шоколадны хэсэг хамаарна. Жишээ нь: бон бон чихэр, какао тостой чихэр, чихрэн бүтээгдэхүүн (какао тос, хуурай сүү ба элсэн чихрийн холимог), цагаан шоколад, шоколадны хавтан (ж-нь: жигнэмэл гурилан бүтээгдэхүүнд зориулсан), сүүтэй шоколад, тосон шоколад, амтлаг шоколад, гашуун шоколад, өнгөлгөөний шоколад, элсэн чихэрт суурилсан “бүрхүүл”-тэй эсвэл өнгийн чимэглэлтэй шоколад, шанзтай шоколад (төв болон гадаргуугийн өнгөлгөө нь ялгаатай шоколад, харин 07.2.1 ба 07.2.2 ангиллын чихэр, чихрэн болон талх, гурилан бүтээгдэхүүн хамаарахгүй) болон бусад хүнсний бүтээгдэхүүний жор орц бүхий шоколад.<sup>49</sup> Энэ ангилалд йогурт, тариа ба зөгийн балаар бүрсэн самар (15.2) хамаарахгүй.

5.1.5 Дуураймал шоколад, шоколад орлуулагч бүтээгдэхүүн:

Какао суурьтай эсвэл суурьгүй боловч мэдрэхүйн эрхтний үзүүлэлтээр шоколадтай ижил шинж чанартай, 5 %-иас их ургамлын тос агуулсан (какао тосноос бусад), *Шоколад, шоколадан бүтээгдэхүүн (CODEXSTAN 87-1981)*-ийн стандартын хамрах хүрээнд ороогүй, *carob* чипс, какаоонд суурилсан бүтээгдэхүүн хамаарна. Эдгээр шоколадтай төстэй бүтээгдэхүүн нь үндсэн орцоор нэмэлт бүтээгдэхүүн агуулж болох ба шанзтай чихэр, чихрэн бүтээгдэхүүн байж болно. Жишээ нь: холимог шоколад, өнгө амт оруулсан холимог шоколад, холимог шоколадны өнгөлгөө, дуураймал шоколадаар бүрсэн самар ба жимс (ж-нь: үзэм). Энэ ангилалд хүнсний ангиллын 05.2-ын хүрээнд багтах аливаа чихэр, чихрэн бүтээгдэхүүний зөвхөн шоколадтай төстэй хэсэг хамаарна.

05.2 Хатуу, зөөлөн чихэр, самран биетэй чихэр болон хүнсний ангиллын 05.1, 05.3, 05.4-д дурдсанаас бусад чихэр, чихрэн бүтээгдэхүүн:

Элсэн чихэр болон түүнтэй төстэй сувиллын сахар орлуулагч агуулсан какаотой эсвэл какаогүй бүх төрлийн бүтээгдэхүүн хамаарна. Хатуу чихэр (05.2.1), зөөлөн чихэр (05.2.2) болон самран биетэй чихэр ба марципан (05.2.3) хамаарна.

05.2.1 Хатуу чихэр:

Ус болон элсэн чихрээр (ердийн сироп) хийсэн өнгө, амт оруулагчтай, чөмөгтэй, чөмөггүй, тэдгээрийн сувиллын орлуулагч агуулсан, какаотой, какаогүй бүтээгдэхүүн хамаарна. Пастила, цул (ороомог, хэлбэртэй, амтлаг чөмөгтэй чихэр)<sup>50</sup> чихэр хамаарна. Энэ төрлийн бүтээгдэхүүнийг 05.1.4 ба 05.1.5 ангиллын шоколадан бүтээгдэхүүнд шанз болгон ашиглаж болно.

<sup>49</sup> Шоколад ба шоколадан бүтээгдэхүүн (CodexStan 87-1981).

<sup>50</sup> Хүнсний хими, Н.Д.Белитц & В.Гросх, Springer-Verlag, Heidelberg, 1987, p 634-636

05.2.2 Зөөлөн чихэр:

Зөөлөн, зажлууртай, карамел төрөл (элсэн чихрийн уусмал, тос, амт, үнэр оруулагч агуулсан) болон тэдгээрийн сувиллын орлуулагч, какао болон сүүний орцтой, орцгүй бүтээгдэхүүн (ж-нь: toffee болон шоколадан амттай карамел), цэлцэн биетэй (ж-нь: үрлэн чихэр, элсэн чихрээр өнгөлгөөтэй жимсний цэлцэгнүүр, желатинаар хийсэн, пектин, амт, үнэр оруулагчтай чихэр) чихэр ба тэдгээрийн ижил төстэй бүтээгдэхүүн, лакриц хамаарна. Түүнчлэн *teheniaa* халва болон уламжлалт чихэрлэг бүтээгдэхүүн болох амтлаг буурцган цэлцэн (*yokan*), агар цэлцэн *mitstumame* энэ ангилалд багтана. Энэ төрлийн бүтээгдэхүүнийг 05.1.4 ба 05.1.5 ангиллын шоколадан бүтээгдэхүүнд шанз болгон ашиглаж болно.

05.2.3 Самран биетэй чихэр, марципан:

Самран биетэй чихэр нь хуурч, буталсан самар, элсэн чихэр, какао болон эдгээрийг орлуулах бүтээгдэхүүнээс бүрдэх ба шууд эсвэл 05.1.4 ба 05.1.5 ангиллын шоколадан бүтээгдэхүүнд шанз болгон ашиглаж болно. Марципан нь бүйлсний нухаш, элсэн чихэр болон тэдгээрийг орлуулах бүтээгдэхүүнээс бүрдэх ба шууд хэрэглэх зорилгоор өнгө оруулж хэлбэржүүлсэн эсвэл 05.1.4 ба 05.1.5 ангиллын шоколадан бүтээгдэхүүнд шанз болгон ашиглаж болно.<sup>50</sup>

05.3 Бохь:

Байгалийн болон синтетик гаралтай бохины суурь түүхий эдэд суурилсан амт оруулагч, чихэрлэг бодис (тэжээллэг, тэжээллэг бус), үнэр оруулагч бодис болон бусад нэмэлтийг ашиглан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ.<sup>50</sup> Үүнд зажлах, амны хөндий ариутгах бохь хамаарна.

05.4 Чимэглэл (ж-нь: амтлаг гурилан бүтээгдэхүүний зориулалтын), өнгөлгөө (жимсний бус), амтлаг сүмс:

Бялуу, жигнэмэг, талх, жигнэмэл гурилан бүтээгдэхүүн болон тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнийг чихрийн уусмалаар өнгөлж царцаасан, шууд хэрэглэх бүтээгдэхүүн хамаарна. Түүнчлэн жигнэмэл гурилан бүтээгдэхүүний элсэн чихэр болон шоколаданд суурилсан өнгөлгөө хамаарна. Чихэрлэг сүмс болон чимэглэлийн жишээнд зайрмагны дээрх ирисэн сүмс багтана. Чихэрлэг сүмс нь 11.4 ангиллын сироп (ж-нь: агч, карамел, амт оруулагч зэрэг амтлаг гурилан бүтээгдэхүүн болон мөсөнд зориулсан уусмал)-оос ялгаатай. Жимсэнд суурилсан чимэглэл 04.1.2.8 ангилалд, шоколадны сүмс 05.1.2 ангилалд тус тус хамаарна.

6.0 Хүнсний ангиллын 07.0-д дурдсанаас бусад залаат, буурцагт үр тариа болон үндэст, булцуут, далдуу модны гол эсвэл зөөлөн эдээс гаргаж авсан тариа, тариан бүтээгдэхүүн:

Боловсруулаагүй (06.1) болон бүхий л төрлийн боловсруулалт хийсэн үр тариа, үр тариан гаралтай бүтээгдэхүүн.

06.1 Бүтэн, бяцарсан, хавтгайлсан тариа болон тутрага:

Бүтэн, хальсалсан, боловсруулаагүй үр, залаат тариа хамаарна. Жишээ нь: арвай, эрдэнэ шиш, зөрөг цэцэг (пивоны зориулалтын), хошуу тариа, тутрага (баяжуулсан, түргэн болох, хальстай боловсруулсан), сорго, шар буурцаг, буудай хамаарна.

## **MNS CAC 192 : 2015**

### **06.2 Гурил, цардуул (шар буурцагны нунтаг зэрэг):**

Үр тариа, үндэст, булцуут, залаат, буурцагт ургамал, дал модны зөөлөн эдийн тээрэмдэлтээр үүсэх худалдаанд гаргах эсвэл бүтээгдэхүүний (ж-нь: талх, гурилан бүтээгдэхүүн) жор орцын хэсэг нь болох үндсэн бүтээгдэхүүн

#### **06.2.1 Гурил:**

Үр, залаат тариа болон булцуут таримал (ж-нь: cassava) болон дал модны зөөлөн эд зэргийг тээрэмдэж гурил үйлдвэрлэнэ. Энд талх, гурилан бүтээгдэхүүний зуурмагийн гурил, талх, жигнэмэг, гоймон, туузан гоймонгийн гурил, холимог гурил (гурилан бүтээгдэхүүний жорын холимгоос ялгаатай, өөр өөр тарианы гурилыг механикаар хольсон гурил (гурил болон 07.1.6 ангиллын (ердийн гурилан бүтээгдэхүүний хольц), 07.2.3 ангиллын (амтлаг бүтээгдэхүүний хольц) жорын дагуу бусад түүхий эдийн хуурай хольц) хамаарна. Тухайлбал: хатуу буудайн гурил, исгэгчтэй гурил, баяжуулсан гурил, хурдан уусах гурил, эрдэнэшишийн гурил, эрдэнэшишийн бүтээгдэхүүн, хивэг, *farina* гурил, хуурсан шар буурцагны гурил (*kinako*), *konjac* гурил (цэлцэнгийн нунтаг, *konnyaku-ko*), *maida* (шигшсэн буудайн гурил) ба саго гурил хамаарна.

#### **06.2.2 Цардуул:**

Тодорхой зарим төрлийн ургамал (жишээ нь: залаат болон буурцагт үр тариа, эрдэнэшиш, буудай, тутрага, шош, вандуй) болон булцуут (ж-нь: төмс, тапиока) зэрэг ургамалд мөхлөг хэлбэрээр агуулагдах глюкозын полимерийг цардуул гэнэ. Полимер нь альфа-D-глюкозын бүлгийн холбооноос бүрдэнэ. Түүхий эдийн онцлогоос хамаарч цардуулыг ялгах арга өөр өөр байна.

### **06.3 Өглөөний зуушны зориулалтын үр тариа, хавтгайлсан хошуу тариаг оруулаад:**

Үр тарианы гаралтай, шууд хэрэглэх, хурдан болох өглөөний халуун зууш. Жишээ нь: мюсли үр тарианы төрлийн өглөөний зууш, хурдан болцтой хошуу тарианы зууш, *farina* төрөл, эрдэнэшишийн нэвс, буудай, тутрагын хөвсийрүүлсэн бүтээгдэхүүн, үрийн холимог (жишээ нь: цагаан будаа, буудай, эрдэнэшиш) өглөөний зууш, шар буурцаг-хивгээр бэлтгэсэн өглөөний зууш, үрийн гурил болон нунтгийг экструдерээр боловсруулсан өглөөний зууш төрлийн бүтээгдэхүүн хамаарна.

### **06.4 Гоймон, туузан гоймон, түүнтэй ижил төстэй бүтээгдэхүүн (жишээ нь: цагаан будааны бэлдэц, цагаан будааны нарийн гоймон, шар буурцагны гоймон, туузан гоймон):**

Хатаасан гоймон болон туузан гоймонд аливаа нэмэлт хийх шаардлагыг харгалзан энэ ангилалд өөрчлөлт оруулсан.<sup>51</sup> Бүх төрлийн гоймон болон туузан гоймон, түүнтэй ижил бүтээгдэхүүн хамаарна.

#### **06.4.1 Хатаагаагүй гоймон, туузан гоймон болон ижил төстэй бүтээгдэхүүн:**

Боловсруулаагүй (ж-нь: халаах, чанах, уураар боловсруулах, жигнэх, цавуужуулах эсвэл хөлдөөх ажиллагаа хийгээгүй) бөгөөд хатаагаагүй бүтээгдэхүүн хамаарна. Эдгээр бүтээгдэхүүнийг боловсруулалтын дараа богино хугацаанд хэрэглэх шаардлагатай. Жишээ нь: чанаагүй гоймон, ороомогт зориулсан хальс, хятад банш-*wontons*, *shuo mai*.

#### **06.4.2 Хатаасан гоймон, туузан гоймон болон ижил төстэй бүтээгдэхүүн :**

<sup>51</sup> ALINORM 03/12, 55-р зүйл

Боловсруулаагүй (ж-нь: халаах, чанах, уураар боловсруулах, жигнэх, урьдчилан цавуужуулах эсвэл хөлдөөх ажиллагаа хийгээгүй), хатаасан бүтээгдэхүүн хамаарна. Тухайлбал: шпагетти, буурцагны, тутрагын нарийн гоймон, хөндий гоймон, тутрагын туузан гоймон хамаарна.

#### 06.4.3 Урьдчилан боловсруулсан гоймон, туузан гоймон болон ижил төстэй бүтээгдэхүүн:

Боловсруулсан (ж-нь: халаах, чанах, уураар боловсруулах, жигнэх, урьдчилан цавуужуулах эсвэл хөлдөөх ажиллагаа хийсэн) бүтээгдэхүүн хамаарна. Эдгээр бүтээгдэхүүн хэрэглэгчдэд шууд худалдаалах (ж-нь: халааж хэрэглэх зориулалттай, урьдчилан боловсруулж хөргөсөн итали банш-*gnocchi*) эсвэл цардуул агуулсан бэлэн хүнс (ж-нь: шпагетти, хөндий болон туузан гоймон гоймон агуулсан, хөлдөөсөн оройн үндсэн хоолны зориулалтаар халааж хэрэглэх бүтээгдэхүүн; лаазалсан шпагетти ба бөөрөнхий махтай зууш) байж болно. Түүнчлэн хэрэглэгчдэд худалдаалахын өмнө урьдчилан цавуужуулан, халааж, хатаасан бэлэн гоймон (*sokuseki-men*; ж-нь: урьдчилан боловсруулсан рамен, удон, цагаан будааны туузан гоймон).

#### 06.5 Залаат үр тариа болон цардуулд суурилсан амттан (жишээ нь: цагаан будааны пудинг, тапиоки пудинг):

Үндсэн бүрэлдэхүүн нь залаат тариа, цардуул эсвэл үр болох амттан хамаарна. Түүнчлэн амттанд зориулсан залаат тариа, цардуулд суурилсан шанз хамаарна. Жишээ нь: цагаан будааны пудинг, хүүхдийн будааны пудинг, тапиока пудинг, цагаан будааны гурилын банш (*dango*), дрожжоор исгэсэн буудайн гурилын зуурмагаар жигнэж бэлтгэсэн амттан (*misipan*), цардууллаг пудингд суурилсан амттан (*namagashi*).

#### 06.6 Шингэн зуурмаг (жишээ нь: загас, шувууны махны бүрмэлд зориулсан):

Загас, шувууны махыг бүрэхэд зориулан хавтгайлсан эсвэл буталсан үрийг бусад орцын хэсгүүдтэй (ж-нь: өндөг, ус, сүү) хольсон бүтээгдэхүүн. Бүтээгдэхүүнийг ихэвчлэн залаат тариа эсвэл үрийн хуурай хольц байдлаар борлуулна. Тухайлбал: *tempura* зуурмаг. Зуурмаг нь (ж-нь: талхны) 07.1.4 ангилалд, бусад хольц нь (ж-нь: талх эсвэл бялууны) 07.1.6 ба 07.2.3 ангилалд тус тус хамаарна.

#### 06.7 Боловсруулсан эсвэл урьдчилан чанасан тутрагны бүтээгдэхүүн, цагаан будааны бялууг оруулаад (зөвхөн Дорнын уламжлалт төрөл):

Тутрагыг дэвтээж, хатааж, уураар боловсруулж, нухаж, бялууны хэлбэрт оруулсан (ж-нь: Японы *mochi*, Солонгосын *teuck*)<sup>52</sup> бүтээгдэхүүн. Тутрагын үрээр хийх шаржигнуур зуушийг мөн “цагаан будааны бялуу” гэх бөгөөд 15.1 ангилалд, амттаны төрлийн цагаан будааны бялуу 06.5 ангилалд тус тус хамаарна. Хүнсний 06.7 ангилалд нөөшилсөн, хөргөсөн эсвэл хөлдөөсөн, урьдчилан чанах зэргээр боловсруулсан, баяжуулсан, зориулалтын уутанд савлан борлуулж буй цагаан будаан бүтээгдэхүүн хамаарна.

Энэ нь зөвхөн бүтэн, хальсалсан, боловсруулаагүй залаат тариа, үрийг хамардгаар 06.1 ангиллаас (Бүтэн, бяцарсан эсвэл хавтгайлсан тариа, тутрагыг оруулсан) ялгаатай.

<sup>52</sup> Ази хүнс: Шинжлэх ухаан технологи, C.Y.W.Ang, K.S.Ltu, & Y.-W.Huang, Eds., Бүлэг 1, Тутрагын бүтээгдэхүүн, B.S.Luh, Technomic Publishing Co., Lancaster PA 1999, p 16.

## **MNS CAC 192 : 2015**

### 06.08 Шар буурцагны бүтээгдэхүүн (12.9 ангиллын шар буурцганд суурилсан амтлагч болон хачирнаас бусад):

Хатаасан, чанасан, хуурсан эсвэл исгэсэн шар буурцагны болон шар буурцагны ээдмээр хийсэн бүтээгдэхүүн хамаарна.

#### 06.8.1 Шар буурцганд суурилсан ундаа

Хатаасан шар буурцгийг усанд дэвтээж, нухшилж, чанаж ба шахаж бэлтгэсэн эсвэл шар буурцагны гурил, шар буурцагны концентрат, шар буурцагны изолятаас бэлтгэсэн бүтээгдэхүүн. Зарим улс энэ ангилалд шар буурцагны сүүг хамааруулдаг. Шар буурцганд суурилсан ундааг шууд эсвэл 06.8.2 ангилал (шар буурцганд суурилсан ундаагаар хийсэн нимгэн хальс), 06.8.3 ангилал (шар буурцгийн ээдэм (дүпү)), 06.8.4 ангилал (дутуу хатаасан дүпү) ба 06.8.5 ангилал (хатаасан дүпү -*kori tofu*)-д заасан шар буурцагны бүтээгдэхүүн хийхэд ашиглаж болно.<sup>53, 54, 55</sup> Түүнчлэн, сэргээж хэрэглэх шар буурцагны ундааны нунтаг бэлдмэл, эсвэл хэрэглэгч ахуйн нөхцөлд гэрийн зөөлөн дүпү хийх ээдүүлэгч бүхий бэлдмэл хамаарна.<sup>53,56</sup>

#### 06.8.2 Шар буурцганд суурилсан ундааны нимгэн хальс:

Шар буурцганд суурилсан ундааны чаналгын явцад гадаргуу дээр үүсэх хальсан хэсгийг хатааж бэлтгэсэн бүтээгдэхүүн. Шөл болон бусад чанаж бэлтгэх хүнсэнд хэрэглэхийн өмнө их тосонд шарах эсвэл усанд хийж зөөлрүүлнэ. Түүнчлэн *fuzhu* эсвэл *yuba*<sup>56, 57, 58</sup> гэж нэрлэдэг.

#### 06.8.3 Шар буурцагны ээдэм (дүпү)

Хатаасан шар буурцгийг усанд дэвтээж, нухшилж, шахаж бэлтгэсэн шар буурцагны ундааг ээдүүлэгчээр боловсруулж, хэвлэж шар буурцагны ээдэм (дүпү)-ийг бэлтгэнэ. Дүпү нь янз бүрийн бүтэцтэй (ж-нь: зөөлөн, хагас хатуу ба хатуу) байна.<sup>53, 54</sup>

#### 06.8.4 Дутуу хатаасан шар буурцагны ээдэм:

Шар буурцагны ээдмийг хэвлэх явцад чийглэгийг бууруулах боловч бүрэн хатаахгүй (06.8.5 ангиллыг харах). Дутуу хатаасан шар буурцагны ээдэм ихэнхидээ 62 %-ийн ус агуулах бөгөөд зажлууртай байна.<sup>53</sup>

##### 06.8.4.1 Өтгөн сүмсэнд жигнэсэн дутуу хатаасан шар буурцагны ээдэм:

Өтгөн сүмсэнд (ж-нь: мисо сүмс) чанасан (жигнэсэн) хэсэгчилэн дутуу хатаасан шар буурцагны ээдэм. Хэсэгчилэн дутуу хатаасан шар буурцагны ээдэм нь сүмсийг шингээснээр өөрийн анхны төлөв байдалдаа ордог.<sup>53</sup>

##### 06.8.4.2 Их тосонд шарсан, дутуу хатаасан шар буурцагны ээдэм:

<sup>53</sup> The Joy of Japanese Cooking, K. Takahashi, Shufunomoto Col., Ltd., Japan, 1996, pp. 17-18 and 123-131.

<sup>54</sup> Taste of Japan, D. Richie, Kodansha International, Tokyo, Japan, 1992, pp. 34-35.

<sup>55</sup> Ibid., pp.141-153.

<sup>56</sup> World Food Japan, Lonely Planet, 2002, p. 35.

<sup>57</sup> Taste of Japan, D. Richie, Kodansha International, Tokyo, Japan, 1992, pp. 168-169.

<sup>58</sup> The Joy of Japanese Cooking, K. Takahashi, Shufunomoto Col., Ltd., Japan, 1996, p. 31.

Их тосонд шарсан, дутуу хатаасан шар буурцагны ээдэм. Шууд эсвэл хуурсны дараа боловсруулж (ж-нь: сүмсэнд жигнэх) хэрэглэнэ.<sup>53, 59</sup>

#### 06.8.4.3 Хүнсний 06.8.4.1 ба 06.8.4.2 ангиллаас бусад дутуу хатаасан шар буурцагны ээдэм

Өтгөн сүмсэнд (ж-нь: мисо сүмс) жигнэх эсвэл их тосонд шарахаас бусад аргаар бэлтгэсэн дутуу хатаасан шар буурцагны ээдэм. Грилдсэн, нухшилсан эсвэл жор орцын дагуу хольц нэмсэн бүтээгдэхүүн (ж-нь: хавтгай эсвэл эзлэхүүнтэй бүтээгдэхүүн хийхэд зориулсан) байна.<sup>53</sup>

#### 06.8.5 Хатаасан шар буурцагны ээдэм (*kori tofu*)

Шар буурцагны ээдмийг хөлдөөх, хатаах ажиллагаагаар болон хадгалалтын явцад чийгийг бүрэн зайлуулсан бүтээгдэхүүн. Энэ бүтээгдэхүүнийг ус эсвэл сүмсээр сэргээж эсвэл хоолтой хамт шууд хэрэглэж болно. Түүнчлэн их тосонд шарах эсвэл сүмсэнд зөөлөн галаар жигнэж хэрэглэж болно.<sup>53</sup>

#### 06.8.6 Исгэсэн шар буурцаг (ж-нь: *natto, tempe*)

Шар буурцгийг тодорхой мөөгөнцөр эсвэл бактериар (хөрөнгө) исгэж, жигнэж бэлтгэсэн бүтээгдэхүүн. Зөөлөрсөн, бүхэл буурцаг нь өвөрмөц үнэр, амттай болно. Үүнд: *dou chi* (Хятад), *natto* (Япон), *tempe* (Индонез) бүтээгдэхүүн хамаарна.

#### 06.8.7 Исгэсэн шар буурцагны ээдэм

Исэлтийн явцад шар буурцагны ээдмийг эзлэхүүнтэй хэлбэрт оруулах аргаар энэ бүтээгдэхүүнийг бэлтгэнэ. Энэ бүтээгдэхүүн нь зөөлөн бүтэцтэй, тодорхой үнэртэй, улаан, эсвэл цагаан шаргал, саарал ногоон өнгөтэй байна.

#### 06.8.8 Шар буурцагны уургийн бусад бүтээгдэхүүн

Шар буурцагны бусад бүтээгдэхүүнд ихэвчлэн шар буурцагны уургийг экструдерээр боловсруулсан, нэгэн бүтэцтэй болгосон, өтгөрүүлсэн эсвэл ялгасан бүтээгдэхүүн хамаарна.

#### 07.0 Талх, гурилан бүтээгдэхүүн:

Талх, өргөн хэрэглээний талхны төрлийн бүтээгдэхүүн (07.1), чихэрлэг, давслаг, амтлаг гурилан бүтээгдэхүүн (07.2) гэсэн ангиллыг хамрана.

#### 07.1 Талх, өргөн хэрэглээний талхны төрлийн бүтээгдэхүүн, тэдгээрийн хольц:

Бүх төрлийн чихэрлэг бус талхан бүтээгдэхүүн, талхны төрлийн бүтээгдэхүүн хамаарна.

#### 07.1.1 Талх, хомбоо:

<sup>59</sup> Ази хүнс, Шинжлэх ухаан технологи, C.Y.W.Ang, K.S.Ltu, & Y.-W.Huang, Eds., Chapter 4: Дорны шар буурцгийн хүнс, K.S. Liu, Technomic Publishing Co., Lancaster PA 1999, pp. 162-163.



## **MNS CAS 192 : 2015**

Дрожжоор хөөлгөсөн болон тусгай зориулалтын талх, хүнсний содоор хөөлгөсөн талх хамаарна.

### 07.1.1.1 Дрожжоор хөөлгөсөн болон тусгай зориулалтын талх:

Бүх төрлийн чихэрлэг бус талхан бүтээгдэхүүн, талхны төрлийн бүтээгдэхүүн хамаарна. Тухайлбал: цагаан талх, хөх тарианы талх, хөх тарианы бүхэл үрийн хар талх (*pumpernickel*), үзэмтэй талх, буудайн бүхэл үрийн талх, соёолжийн талх, франц маягийн талх (*pain courant francais*), гамбургерийн хомбоо, буудайн бүхэл үрийн хомбоо, сүүтэй хомбоо гэх мэт хамаарна.

### 07.1.1.2 Хүнсний содоор хөөлгөсөн талх:

Содоор хөөлгөсөн талх хамаарна.

### 07.1.2 Крекер, чихэрлэг крекерээс бусад:

Ихэвчлэн чихэрлэг бус зуурмагаар хийсэн нимгэн, бутрамтгай өрмөнцөрийг “крекер” гэнэ. Зууш байдлаар хэрэглэх амт оруулсан крекер (ж-нь: бяслагны амттай) 15.1 ангилалд хамаарна. Жишээ нь: содтой крекер, хөх тарианы крекер, гамбир төрлийн крекер (*matzohs*).

### 07.1.3 Бусад өргөн хэрэглээний талхан бүтээгдэхүүн (жишээ нь: цагираган боов, гамбир, англи маягийн жижиг талх гэх мэт):

Эрдэнэшишийн талх, жигнэмэг зэрэг бусад бүх төрлийн өргөн хэрэглээний талхан бүтээгдэхүүн хамаарна. Энэ ангилалын “жигнэмэг” гэдэг нь дрожди, хүнсний содоор исгэсэн жижиг бялуун бүтээгдэхүүн. Энд 07.2.1 ангилалын “cookie” эсвэл “чихэрлэг крекер” гэж нэрлэх Англи маягийн “жигнэмэг”-т хамаарахгүй.

### 07.1.4 Шанзтай талх, хатаасан талхны үйрмэг зэрэг талхны төрлийн бүтээгдэхүүн:

Шарсан, хайрсан талхны жижиг хэсэг (*croutons*), шанзтай талх, шанзны холимог, болон зоиулалтаар бэлтгэсэн зуурмаг (жишээ нь: жигнэмгийн зориулалтын) зэрэг талханд суурилсан бүтээгдэхүүн хамаарна. Талхны бэлдэц холимог 07.2.6 ангилалд хамаарна.

### 07.1.5 Мантуу, шанзтай хомбоо:

Уламжлалт дорнын аргаар буудайн эсвэл цагаан будааны гурилыг исгэж, уураар жигнэж болгосон бүтээгдэхүүн. Бүтээгдэхүүнийг шанзтай эсвэл шанзгүй хийж болно. Хятадад шанзгүй бүтээгдэхүүнийг жигнэсэн талх (мантуу), шанзтайг мантуун бууз гэнэ. Мөн давхар ороосон олон хэлбэртэйгээр (*huajuan*) бэлтгэж болно.<sup>60</sup> Жишээ нь: махтай, джем болон бусад төрлийн (*manjuu*) шанзтай банш болон мантуун бууз.

### 07.1.6 Талх болон өргөн хэрэглээний гурилан бүтээгдэхүүний хольц:

<sup>60</sup> Ази хүнс, Шинжлэх ухаан технологи, C.Y.W.Ang, K.S.Ltu, & Y.-W.Huang, Eds., Бүлэг 4, Буудайн бүтээгдэхүүн; 2.Талх, Бялуу, Cookie, зуурмаг, банш, S.Hung, Technomic Publishing Co., Lancaster PA 1999, p 72-73.

07.1.1-07.1.5 ангиллын талхан бүтээгдэхүүний зуурмаг бэлтгэхэд шингэн хэсэг (жишээ нь: ус, сүү, ургамлын тос, цөцгийн тос, өндөг) нэмж бэлтгэх жор орцын бүхий л хуурай хольц хамаарна. Тухайлбал: Франц талхны хольц, нимгэн талхны хольц, Итали төрлийн талх (*panettone*)-ны хольц, Итали төрлийн хавтгай талх (*ciabatta*)-ны хольц болон бусад. Амтлаг гурилан бүтээгдэхүүний (жишээ нь: бялуу, жигнэмэг, шарвин) хольц 07.2.3 ангилалд хамаарна.

## 7.2 Амтлаг гурилан бүтээгдэхүүнд (чихэрлэг, давслаг, амтлаг) зориулсан хольц:

Шууд хэрэглэх дэд бүлгийн (07.2.1 ба 07.2.2) бүтээгдэхүүн, амтлаг гурилан бүтээгдэхүүн бэлтгэхэд зориулсан хольц (07.2.3) хамаарна.

### 07.2.1 Бялуу, жигнэмэг, шанзтай боов (жишээ нь: жимс болон цөцгийн төрлийн шанзтай):

Энэ ангиллын “чихэрлэг крекер”, “чихэрлэг жигнэмэг” нь амттан байдлаар хэрэглэх жигнэмэл гурилан бүтээгдэхүүний төрөлд хамаарна. Тухайлбал: цөцгийн тостой бялуу, бяслагтай бялуу, жимсэн шанзтай үр тарианы хомбоо, Япон төрлийн бялуу (*kasutera*), чийглэг бялуу, (цардууллаг төрлийн амттан (Япон төрлийн амттан *namagashi*)), барууны бялуу, сарны бялуу, хөвсгөр бялуу, жимсний шанзтай жигнэмэг (алимны жигнэмэг), хошуу тарианы жигнэмэг, элсэн чихэртэй жигнэмэг, Англи маягийн “*biscuits*” (*cookies* эсвэл чихэрлэг крекер) хамаарна.

### 07.2.2 Бусад төрлийн амтлаг гурилан бүтээгдэхүүн (цагираган чанамал хөөмөл боов-пончик, амтлаг ороомог, хомбоо, торхтой бялуу):

Амттан байдлаар эсвэл өглөөний цайнд хэрэглэх бүх төрлийн бүтээгдэхүүн хамаарна. Тухайлбал: шарвин, өрмөнцөр, чихэрлэг шанзтай боов (*anpan*), Дани маягийн амттан, зайрмагны өрмөнцөр буюу аяга, гурилан амттан, хүйтэн амттан- *trifles*

### 07.2.3 Амтлаг гурилан бүтээгдэхүүний хольц (жишээ нь: бялуу, шарвин):

Амтлаг гурилан бүтээгдэхүүний зуурмаг бэлтгэхэд шингэн хэсэг (жишээ нь: ус, сүү, ургамлын тос, цөцгийн тос, өндөг) нэмж бэлтгэх жор орцын бүхий л хуурай хольц хамаарна. Тухайлбал: бялууны хольц, гурилан амттаны хольц, шарвингийн хольц, шанзтай боовны хольц, өрмөнцөрийн хольц хамаарна. Зориулалтаар бэлтгэсэн зуурмаг 07.1.4 ангилалд хамаарна. Өргөн хэрэглээний талхны төрлийн бүтээгдэхүүний зуурмаг (жишээ нь: талхны) 07.1.6 ангилалд хамаарна.

## 08.0 Мах, махан бүтээгдэхүүн, шувууны болон ангийн мах:

Энэ ангилалд шинэ (08.1) болон боловсруулсан (08.2,08.3) жижиглэсэн, мөчилсөн эсвэл татсан бүх төрлийн мах, шувууны болон ангийн махан бүтээгдэхүүн хамаарна.

### 08.1 Шинэ мах, шувуу болон ангийн мах

Шинэ бүтээгдэхүүн ихэнх тохиолдолд нэмэлтгүй байдаг. Гэхдээ, зарим тохиолдолд нэмэлт хийдэг. Жишээ нь: шинэ, мөчилсөн махны гадаргууд өнгөтэй баталгаажуулалтын тамга дардаг ба өнгө нь Хүнсний ангиллын тогтолцоонд “тамгалах, тэмдэглэх эсвэл барааны худалдааны тэмдэгтэй болгох”-д зориулсан тэмдэглэгээг заадаг. Түүнчлэн,

## **MNS CAC 192 : 2015**

хэрэглэгчид зориулан зах зээлд гаргахын өмнө махан бүтээгдэхүүнийг гялгар түрхэц эсвэл халуун ногооны түрхлэг (гялалзсан гадаргуутай гахайн утсан мах эсвэл шорлогонд зориулж бэлдсэн тахианы мах) зэргээр өнгөлж болдог. Хүнсний ангиллын системд “түрхэц, түрхлэг (гадаргуугийн боловсруулалт)” гэсэн утга агуулна. *Perse* тэмдэглээтэй өнгөлгөө нь хүнсний ангиллын 04.1.2.8 (жимсэнд суурилсан түрхэц, жишээ нь гахайн утсан мах) болон 12.2 (халуун ногооны түрхлэг)-д тус тус хамаарна.

### 08.1.1 Шинэ мах, шувууны болон ангийн мах, бүхэл эсвэл мөчилсөн хэлбэрээр

Боловсруулаагүй түүхий мах, шувуу болон ангийн махны мөч, бүхэл хэсгүүд хамаарна. Тухайлбал: үхэр, гахай, гахайн махны мөч, үхрийн шинэ цус, шинэ бүтэн тахиа болон тахианы мөч, шинэ үхрийн махны хэсэг (жишээ нь: стейк), үхрийн дотор эрхтэн (жишээ нь: зүрх, бөөр), шинэ гүзээ, гахайн цавчсан хавирга хамаарна.

### 08.1.2 Шинэ мах, шувууны болон ангийн мах, хэсэглэсэн татаж бэлтгэсэн:

Боловсруулаагүй татсан мах эсвэл яснаас нь механикаар салгасан мах, шувуу болон ангийн мах хамаарна. Тухайлбал: үхрийн шинэ махан таташ (гамбургерийн); боэрвурс (Өмнөд Африкийн хиам); өглөөний зуушны зайдас; махан таташ (жижиглэсэн мах); логаниза зайдас (шинэ бэлтгэсэн); шинэ бөөрөнхий мах; яснаас нь механикаар салгасан шувууны махны жижиглэсэн хэсэг (гадаргууг боловсруулсан, боловсруулаагүй); ба шинэ зайдас (жишээ нь: үхрийн махан, Итали маягийн болон гахайн махан).

### 08.2 Боловсруулсан мах, шувууны болон ангийн мах, бүхэл ба мөчилсөн хэлбэрээр:

Дулааны боловсруулалт хийгээгүй, (08.2.1), дулааны боловсруулалт хийсэн (08.3.2) төрөл бүрийн боловсруулалт бүхий мөчилсөн мах хамаарна.

#### 08.2.1 Дулааны боловсруулалт хийгээгүй, боловсруулсан мах, шувууны болон ангийн махан бүтээгдэхүүн, бүхэл ба мөчилсөн хэлбэрээр:

Махны шинэлэг байдлыг хадгалах, уртасгах хэд хэдэн аргыг (ж-нь: давслах, хатаах, даршлах) энэ ангилалд хамааруулж тайлбарлана.

##### 08.2.1.1 Дулааны боловсруулалт хийгээгүй, боловсруулсан (давсалсан) мах, шувууны болон ангийн махан бүтээгдэхүүн, бүхэл ба мөчилсөн хэлбэрээр:

Хоолны давс ашиглан бүтээгдэхүүнийг давслана. Махны гадаргууг давсаар шууд үрж давслах аргаар хуурай давсалсан (хуурай нөөшилсөн) бүтээгдэхүүнийг бэлтгэнэ. Махыг давсны уусмалд сойх замаар нойтон аргаар давсалж бэлтгэнэ. Тарих аргаар давсалсан бүтээгдэхүүнийг давсны уусмалыг маханд шахах замаар давсална. Давсалж боловсруулах ажиллагааг мөн нэмэлт ашиглах замаар гүйцэтгэж болно. Энд утсан бүтээгдэхүүн хамаарна.<sup>61</sup> Тухайлбал: гахайн утсан мах (давсалсан, хуурай аргаар давсалсан, нойтон аргаар давсалсан, тарих аргаар давсалсан); гахайн утсан цорой; үхрийн давсалсан мах; үхрийн амталсан мах; болон дорнын уламжлалт бусад аргаар давсалсан бүтээгдэхүүн: мисонд даршилсан мах, (miso-zuke), koji-zuke мах (koji-zuke), шар буурцгийн сүмсэнд дарсан мах (shoyu-zuke) хамаарна.

<sup>61</sup> Food Chemistry, H.-D. Belitz & W. Grosch, Springer-Verlag, Heidelberg, 1987, pp. 439-445.

8.2.1.2 Дулааны боловсруулалт хийгээгүй, боловсруулж (давсалсан), хатаасан мах, шувууны болон ангийн махан бүтээгдэхүүн, бүхэл ба мөчилсөн хэлбэрээр:

Мөчилсөн махыг 08.2.1.1 ангилалд заасны дагуу давсаар боловсруулж дараа нь хатаасан эсвэл зөвхөн хатаасан байж болно. Хатаалтыг халуун агаараар эсвэл вакуум аргаар гүйцэтгэнэ.<sup>61</sup> Энэ ангилалд гахайн давсалж хатаасан мах, усгүйжүүлсэн мах, нурууны шанзалсан мах, Ибери гахайн утсан мах, проскуитто маягийн гахайн утсан мах хамаарна.

08.2.1.3 Ферментийн аргаар боловсруулсан, дулааны боловсруулалт хийгээгүй мах, шувууны болон ангийн мах, бүхэл ба мөчилсөн хэлбэрээр:

Ферментийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүн нь давстай орчинд сүүн хүчлийн бактерийн нөлөөгөөр даршилсан бүтээгдэхүүний төрөл. Жишээ нь: лаазалсан үхрийн мах, даршилсан (исгэсэн) гахайн шийр.

08.2.2 Дулаанаар боловсруулсан мах, шувууны болон ангийн мах, бүхэл ба мөчилсөн хэлбэрээр:

Чанасан (давсалж чанасан, болон хатааж чанасан), дулаанаар боловсруулж (ариутган), лаазалсан махан бүтээгдэхүүн хамаарна. Тухайлбал: гахайн давсалж чанасан гуя; гахайн давсалж чанасан хаа, тахианы лаазалсан мах, шар буурцгийн сүмсэнд (tsukudani) чанасан махны хэсгүүд хамаарна.

08.2.3 Хөлдөөсөн мах, шувууны болон ангийн мах, бүхэл ба мөчилсөн хэлбэрээр:

Түүхийгээр болон боловсруулж, хөлдөөсөн махны хэсгүүд хамаарна. Тухайлбал: хөлдөөсөн бүтэн тахиа, тахианы мөч, үхрийн гуяны мах хамаарна.

08.3 Татсан мах, шувууны болон ангийн мах, тэдгээрийн бүтээгдэхүүн:

Дулаанаар ариутгаагүй (08.3.1), дулаанаар ариутгасан (08.3.2) төрөл бүрийн боловсруулалт бүхий бүтээгдэхүүн хамаарна.

08.3.1 Дулааны боловсруулалт хийгээгүй, татаж боловсруулсан мах, шувууны болон ангийн махан бүтээгдэхүүн:

Татсан эсвэл механик аргаар яснаас нь салгасан махны шинэлэг байдлыг хадгалах, уртасгах хэд хэдэн аргыг (ж-нь: нөөшлөх, давслах, хатаах, даршлах) энэ ангилалд тайлбарлана.

08.3.1.1 Татсан, боловсруулсан (давсалсан) ба дулааны боловсруулалт хийгээгүй мах, шувууны болон ангийн махан бүтээгдэхүүн:

Хоолны давс ашиглан бүтээгдэхүүнийг давслана. Махны гадаргууг давсаар шууд үрж давслах аргаар хуурай давсалсан (хуурай нөөшилсөн) бүтээгдэхүүнийг бэлтгэнэ. Махыг давсны уусмалд сойх замаар нойтон аргаар давсалж бэлтгэнэ.

Тарих аргаар давсалсан бүтээгдэхүүнийг давсны уусмалыг маханд шахах замаар давсална. Давсалж боловсруулах ажиллагааг мөн нэмэлт ашиглах замаар гүйцэтгэж болно. Энд утсан бүтээгдэхүүн хамаарна.<sup>61</sup>

Тухайлбал: чоризо зайдасны хэд хэдэн төрөл (халуун ногоотой гахайн махан зайдас), салями төрлийн бүтээгдэхүүн, салчичон (Испани аргаар хийсэн гахайн махан зуны хиам), точино (шинэ, давсалж боловсруулсан зайдас), Америк маягийн салями болон утсан зайдас хамаарна.

## **MNS САС 192 : 2015**

### 08.3.1.2 Татаж, дулаанаар боловсруулалгүй, нөөшлөх боловсруулалт (давсалсан) хийсэн ба хатаасан мах, шувууны болон ангийн махан бүтээгдэхүүн:

Татсан эсвэл яснаас нь механик аргаар салгасан бүтээгдэхүүнийг 08.3.1.1 ангилалд заасны дагуу давсалж, дараа нь хатаасан эсвэл зөвхөн хатаасан байж болно. Хатаалтыг халуун агаараар эсвэл вакуум аргаар гүйцэтгэнэ.<sup>61</sup>

Энэ ангилалд пастурма (Турк гаралтай бөгөөд халуун ногоо ихтэй, давсалж агаарт хатаасан үхрийн мах), хатаасан хиам, давсалж хатаасан хиам, үхрийн амталж хатаасан мах, хятад зайдас (уламжлалт аргаар давсалж боловсруулсан, утсан гахайн зайдас), собрасада (Газрын дундад тэнгисийн орнуудаас гаралтай хиам) хамаарна.

### 08.3.1.3 Татсан бөгөөд Ферментийн аргаар боловсруулсан, дулааны боловсруулалт хийгээгүй мах, шувууны болон ангийн махан бүтээгдэхүүн:

Ферментийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүн нь давстай орчинд сүүн хүчлийн бактерийн нөлөөгөөр даршилсан бүтээгдэхүүний төрөл. Зарим төрлийн хиамыг ийм аргаар бэлтгэж болно.

### 08.3.2 Татаж, дулааны боловсруулалт хийсэн, мах, шувуу болон ангийн махан бүтээгдэхүүн:

Татаж, чанасан (давсалж чанасан, болон хатааж чанасан), дулаанаар боловсруулж (ариутган) лаазалсан бүтээгдэхүүн хамаарна. Тухайлбал, урдчилан хайрсан үхрийн махан котлет; шувууны элгэн нухаш; царцмаг; давсалсан мах; шар буурцгийн сүмсэнд чанасан мах; үхрийн давсалж, лаазалсан мах; зуушны мах; махан нухамш; болгосон котлет; салями төрлийн чанамал бүтээгдэхүүн; болгосон бөөрөнхий мах; Страсбургийн хиам; өглөөний зуушны зайдас; түүхий зайдас; базмаг багтана.

### 08.3.3 Татаж, хөлдөөсөн мах, шувууны болон ангийн махан бүтээгдэхүүн:

Татсан эсвэл яснаас нь механик аргаар салгасан, түүхийгээр, хагас эсвэл бүрэн болгож хөлдөөсөн мах хамаарна. Тухайлбал: хөлдөөсөн котлет, эвдсэн, бүрсэн тахианы мөч хамаарна.

### 08.4 Хүнсний бүрхүүл (хиамны гадна хальс):

Коллаген, целлюлоз болон хүнсний зориулалтын нийлэг материалаас гадна амьтны гаралтай (гахай, хонины өлөн гэдэс) эх үүсвэрээс бэлтгэсэн, хиамын таташ агуулах бүрхүүл.<sup>61</sup>

### 09.0 Загас, загасан бүтээгдэхүүн, нялцгай биетэн, хавч, далайн од:

Энэ ангиллыг шинэ загас (09.1) болон төрөл бүрийн аргаар боловсруулсан загасан бүтээгдэхүүн (09.2-09.4) гэсэн дэд ангилалд хуваана. Энэ ангилалд усны сээр нуруутан (загас, далайн сүүн тэжээлтэн (халим), сээр нуруугүйтэн (далайн мөгөөрс), түүнчлэн нялцгай биетэн (зөөлөн биетэн ба дун), хавч хэлбэртэн (сам хорхой, наймаалж, хавч), далайн од (далайн зараа, далайн өргөст хэмх) хамаарна. Загасан бүтээгдэхүүнийг халуун ногоо болон бусад түрхлэгээр бүрж боловсруулан хэрэглэгчдэд хүргэж болно. (ж-нь: загасны бүрж хөлдөөсөн гол мах). Хүнсний ангиллын системд “түрхэц, түрхлэг (гадаргуугийн боловсруулалт)” гэнэ.

09.1 Шинэ загас, загасан бүтээгдэхүүн, нялцгай биетэн, хавч, далайн од:

“Шинэ” гэж далай, нуур болон бусад усан эх үүсвэрээс олборлосон загасыг муудаж, чанар нь буурахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хөргөсөн, мөсөнд хадгалсан, хөлдөөсөн зэргээс өөр боловсруулалт хийгээгүй загас, загасан бүтээгдэхүүнийг нэрлэнэ.<sup>62</sup>

09.1.1 Шинэ загас:

Халимны шинэ мах, сагамхай, яргай, хулд загас болон шинэ загасны түрс хамаарна.

09.1.2 Шинэ нялцгай биетэн, хавч, далайн од:

Шинэ сам хорхой, нялцгай биетэн, хавч хэлбэртнүүд (том жижиг хавч), дун зэрэг хамаарна.

09.2 Боловсруулсан загас, загасан бүтээгдэхүүн, нялцгай биетэн, хавч, далайн од:

Энэ ангилалд хөлдөөсөн, цаашид боловсруулах зориулалттай, түүнчлэн, утсан, хатаасан, даршилсан, давсалсан зэргээр боловсруулж шууд хэрэглэхэд бэлэн болсон бүтээгдэхүүн хамаарна.

09.2.1 Хөлдөөсөн загас, загасны гол мах ба загасан бүтээгдэхүүн, нялцгай биетэн, хавч, далайн од:

Цаашид боловсруулахаар шинээр нь болон хагас болгож, тэнгис эсвэл газар дээр хөлдөөсөн буюу гүн хөлдөөсөн загас. Жишээ нь: хөлдөөсөн, гүн хөлдөөсөн нялцгай биетэн, сагамхайн гол мах, хавч, энгийн загас, алгана, хек, том хавч, загасан таташ, том сам хорхой, сам хорхой; загасны хөлдөөсөн түрс; хөлдөөсөн загасан нухаш (сурими); хөлдөөсөн халимны мах хамаарна.

09.2.2 Хөлдөөсөн бүрмэл загас, загасны гол мах ба загасан бүтээгдэхүүн, нялцгай биетэн, хавч, далайн од:

Загас болон загасны хэсгүүдийг өндөг, талхны үртэс, эсвэл шингэн зуурмагаар бүрж бэлтгэсэн боловсруулаагүй бүтээгдэхүүн хамаарна. Тухайлбал: талхны үйрмэгээр эсвэл шингэн зуурмагаар бүрж, хөлдөөсөн сам хорхой; талхны үйрмэгээр эсвэл шингэн зуурмагаар бүрж, хөлдөөсөн эсвэл түргэн хөлдөөсөн загасны гол мах, загасны хэрчим ба саваа (загасан шагшуурга) хамаарна.<sup>63</sup>

9.2.3 Татаж, тослог сүмсээр амтлан хөлдөөсөн загасан бүтээгдэхүүн, нялцгай биетэн, хавч, далайн од:

Тослог сүмстэй, дулааны боловсруулалт хийгээгүй загасан таташ.

09.2.4 Чанаж эсвэл шарж болгосон загас, загасан бүтээгдэхүүн, нялцгай биетэн, хавч, далайн од:

<sup>62</sup> Lbid., p 464-468

<sup>63</sup> Түргэн хөлдөөсөн загасан шагшуурга, загасны хэрчим, загасны гол мах – Үйрмэг талх ба шингэн зуурмагаар бүрсэн (Codex Stan 166 – 1989).

## **MNS CAC 192 : 2015**

Доор дурдсан дэд ангилалд багтах бүх төрлийн хэрэглэхэд бэлэн боловсруулсан бүтээгдэхүүн хамаарна.

### 09.2.4.1 Дулааны боловсруулалт хийсэн загас, загасан бүтээгдэхүүн:

Дулааны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүнд шарахаас (09.2.4.3-аас үзэх) бусад жигнэх, чанах гэх мэт бүхий л аргаар болгосон бүтээгдэхүүн хамаарна. Загас нь бүтэн, хэсэглэсэн эсвэл татсан байж болно. Тухайлбал: загасны зайдас; шар буурцгийн сүмсэнд чанаж болгосон загасан бүтээгдэхүүн (tsukudani); боловсруулсан загасны нухшаар хийсэн бүтээгдэхүүн (kataboko); хавчны амттай загасны нухашаар хийсэн бүтээгдэхүүн (kanikama); загасны чанасан түрс; загасны болгосон нухаш; загасны нухшаар хийсэн зайдас (chikuwa); болгосон загас ба том хавчны нухаш (загасны нухшаар хийсэн адил төстэй бүтээгдэхүүн). Загасны нухашны бусад төрөл (Уламжлалт)-ийг 09.03.4 ангилалд багтаасан.

### 09.2.4.2 Чанаж болгосон нялцгай биетэн, хавч, далайн од:

Шарахаас (09.2.4.3-ыг үз) бусад жигнэх, чанах гэх мэт аргаар боловсруулсан бүтээгдэхүүн хамаарна. Тухайлбал: боловсруулсан сам хорхойны төрөл зүйл (хүрэн сам хорхой, чанасан сам хорхой, нялцгай биетэн ба том хавч) хамаарна.

### 09.2.4.3 Шарж болгосон загас, загасан бүтээгдэхүүн, нялцгай биетэн, хавч, далайн од:

Хэрэглэхэд бэлэн бүтээгдэхүүнийг загас, загасны хэсгийг өндөг ба талхны үйрмэг эсвэл зуурмагаар бүрж эсвэл бүрэхгүй шарах, жигнэх, хагас шарах, шорлог хийх зэргээр боловсруулан, сүмс эсвэл тостой, тосгүйгээр савлаж эсвэл лаазалж бэлтгэнэ.<sup>53</sup> Тухайлбал: шарж, хэрэглэхэд бэлэн болгосон сурими, шарсан кальмар, зөөлөн хуягтай, шарсан хавч хамаарна.

### 09.2.5 Утсан, хатаасан, даршилсан болон давсалсан загас, загасан бүтээгдэхүүн, нялцгай биетэн, хавч, далайн од:

Шинээр нь гүн хөлдөөсөн, хөлдөөсөн загасыг давсалж, эсвэл давслалгүйгээр шууд эсвэл чанасны дараа, үртэсний утаагаар утаж хатаах замаар утсан загасыг бэлтгэнэ. Загасыг нарны гэрэлд болон тусгай төхөөрөмжид шууд эсвэл чанасны дараа хатааж хатаасан загасыг бэлтгэнэ; загасыг хатаахын өмнө давсалж болно. Давсаар үрэх буюу давсны уусмалд сойж загасыг давсална.

Энэхүү ажилбар нь 09.3 ангиллын амталсан ба даршилсан загас бэлтгэхээс ялгаатай. Нөөшлөх загасыг давсалж, утна<sup>62</sup>. Жишээ нь: давсалсан харалзай загас, сам хорхой, сельд; утсан голавль, арваалж, наймаалж; утсан загас, хатаасан, утсан сагамхай төрлийн загас; давсалсан эсвэл утсан загасны нухаш, түрс; давсалж боловсруулсан, утсан хар сагамхай, сельд, баяргай загас; хатаасан дун, хатаасан хар амар загас (katsuobush), чанаж хатаасан загас (niboshi) хамаарна.

### 09.3 Хагас нөөшилсөн загас, загасан бүтээгдэхүүн, нялцгай биетэн, хавч, далайн од:

Дарсан, даршилсан мөн хагас болгосон бөгөөд хадгалалтын хугацаа богинотой бүтээгдэхүүн хамаарна.

### 09.3.1 Цуужуулж дарсан болон цэлцэгнүүрт царцаасан загас, загасан бүтээгдэхүүн, нялцгай биетэн, хавч, далайн од:

Давс, халуун ногоо нэмсэн, эсвэл нэмээгүй цагаан цуу, дарсанд сойж боловсруулсан бүтээгдэхүүнийг цуужуулж дарсан гэнэ. Ийм бүтээгдэхүүнийг лааз, шилэн саванд савлах бөгөөд хадгалалтын хугацаа богинотой байдаг. Загасан дээр цуу эсвэл дарс, давс, нөөшлөгчид нэмж чанах буюу жигнэх замаар зөөлрүүлэн, үүссэн шөлөнд нь царцаах аргаар цэлцэгнүүр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг. Жишээ нь: загасны гол махан ороомог (цуужуулсан май загасны төрөл), желе байдалтай далайн могой загас (аварга загасны төрөл зүйл), загасны цэлцэгнүүр хамаарна.<sup>62</sup>

#### 09.3.2 Даршилсан, давсалсан загас, загасан бүтээгдэхүүн, нялцгай биетэн, хавч, далайн од:

Зарим тохиолдолд даршилсан бүтээгдэхүүнийг дарсан бүтээгдэхүүний нэг хэлбэр гэж үздэг. Загасыг давс, цагаан цуу эсвэл спиртлэг (жишээ нь: дарс) уусмалаар боловсруулсан тохиолдолд даршилсан бүтээгдэхүүн болно.<sup>62</sup>

Жишээ нь: янз бүрийн уламжлалт аргаар даршилсан бүтээгдэхүүн: цагаан будааны мөөгөнцрөөр даршилсан загас (koji-zuke), сакений шүүгдэстэй даршилсан загас (kasu-zuke), мисотой даршилсан загас (miso-zuke), шар буурцгийн сүмсэнд даршилсан загас (shoyu-zuke), цагаан цуунд даршилсан загас (su-zuke), даршилсан халимны мах, даршилсан май загас болон шпрот хамаарна.

#### 09.3.3 Хулд (яргай) загасыг орлуулагч, түрс, загасны түрс төрлийн бүтээгдэхүүн:

Түрсийг угааж, давслаад, өнгө нь тунгалагжтал сойж боловсруулдаг. Бэлэн болсон түрсийг шилэн болон бусад тохиромжтой саванд савлана. Caviar нь зөвхөн хилмийн төрлийнхний (жишээ нь: белуга) түрсийг нэрлэх нэр болно. Caviar түрс орлуулагчийг далай, цэнгэг усны янз бүрийн загасны (жишээ нь: сагамхай ба май загас) түрсийг давслах, халуун ногоогоор амтлах, будах, нөөшлөгч бодис нэмэх зэргээр боловсруулж бэлтгэнэ.<sup>62</sup> Жишээ нь: давсалсан яргай загасны түрс (sujiko), боловсруулж давсалсан яргай загасны түрс (ikega), сагамхай загасны түрс (tarako) болон lumpfish caviar хамаарна. Түрсийг пастерчилж болно. Энэ тохиолдолд бүрэн нөөшилсөн бүтээгдэхүүн болох учир 09.4 ангилалд хамаарна. Хөлдөөсөн, боловсруулсан, утсан түрс нь 09.2.1, 09.2.4.1 болон 09.2.5 ангилалд тус тус хамаарна. Шинэ загасны түрс 09.1.1 ангилалд хамаарна.

#### 09.3.4 Хүнсний ангиллын 09.3.1-09.3.3-д дурдсанаас бусад хагас нөөшилсөн загас, загасан бүтээгдэхүүн, нялцгай биетэн, хавч, далайн од:

Энд загас эсвэл сам хорхойн нухаш болон дорно дахины уламжлалт аргаар бэлтгэсэн загасны нухаш багтана. Дорны уламжлалт загасны нухшийг шинэ загас эсвэл загасны сүмсний үйлдвэрлэлийн үлдэгдлийг буудайн гурил, хивэг, тутрага, шар буурцагтай хамт хольж үйлдвэрлэнэ.<sup>64</sup> Энэ бүтээгдэхүүнийг цаашид исгэж болно. Боловсруулсан загас эсвэл сам хорхойн нухаш (сурими төрлийн бүтээгдэхүүн) нь 09.2.4.1 болон 09.2.4.2 ангилалд хамаарна.

#### 09.4 Лаазалсан, ферментийн аргаар боловсруулсан зэрэг бүрэн нөөшилсөн загас, загасан бүтээгдэхүүн, нялцгай биетэн, хавч, далайн од

Пастеризаци хийж эсвэл халуун уураар боловсруулж, ариун чанарыг хадгалах зорилгоор агаар орохгүй саванд савлаж битүүмжлэн, хадгалах хугацааг

<sup>64</sup> Ази хүнс: Шинжлэх ухаан, технологи, C.Y.W. Ang, K.S. Liu, & Y.-W. Huang, Eds., Бүлэг 9: Дорнын уламжлалт далайн хүнс, Y.-W. Huang & C.-Y. Huang, Technomic Publishing Co., Lancaster PA 1999, p. 264.



## **MNS CAC 192 : 2015**

нь уртасгасан бүтээгдэхүүн. Бүтээгдэхүүнийг өөрийн шүүсэнд нь эсвэл тос, сүмс нэмж савлаж болно.<sup>62</sup>

Энэ ангилалд бүрэн боловсруулсан бүтээгдэхүүн (09.2.4 ангиллыг үзэх) хамаарахгүй. Энэ ангилалд: нөөшилсөн туна загас, нальхан хорхой, хавч, загасны түрс, сардин, шанзалсан загасны махан бөөрөнцөг, сурими (дулаанаар пастерчилсан) бүтээгдэхүүн хамаарна.

### 10.0 Өндөг, өндгөн бүтээгдэхүүн:

Хальстай шинэ өндөг (10.1), шинэ өндгийг орлуулагч бүтээгдэхүүн (10.2) болон бусад өндгөн бүтээгдэхүүн (10.3,10.4) хамаарна.

#### 10.1 Шинэ өндөг:

Хальстай шинэ өндгийг ямар нэгэн нэмэлтгүй хэмээн тооцдог. Гэвч өндөгний гадаргуугийн өнгө нь засалт, будалт, тамгалалт зэргээс хамаарч өөрчлөгдөж болно. Хүнсний ангиллын тогтолцооны тэмдэглэгээ нь бүтээгдэхүүний гадаргууг засаж, будаж, брэндэд хамааруулан өөрчилснийг илэрхийлнэ.

#### 10.2 Өндгөн бүтээгдэхүүн:

Шинэ өндгийг орлуулан хоолны орц эсвэл хүнс (омлетт) байдлаар хэрэглэж болох бүтээгдэхүүн. Эдгээр бүтээгдэхүүнийг шинэ өндгөөр дараах байдлаар бэлтгэнэ. Үүнд: 1/бүтэн өндгийг хольж хутгаад, шүүх, 2/ өндөгний цагаан ба шар хэсгийг ялгаж, дараа нь тус тусад нь хутгаж, шүүх. Цэвэрлэсэн бүтэн өндөгнөөс цагаан эсвэл шар хэсгийг салгаж шингэн, хөлдөөсөн, хатаасан өндгийг дор өгүүлсний дагуу үйлдвэрлэнэ.<sup>65</sup>

##### 10.2.1 Өндөгний шингэнээр хийсэн бүтээгдэхүүн:

Цэвэрлэсэн бүтэн өндөг, өндөгний шар, цагаан хэсгийг пастерчилж, химийн аргаар (жишээ нь: давс нэмэх замаар) нөөшилсөн бүтээгдэхүүн.

##### 10.2.2. Хөлдөөсөн өндгөн бүтээгдэхүүн:

Цэвэрлэсэн бүтэн өндөг, өндөгний шар, цагаан хэсгийг пастерчилж хөлдөөсөн бүтээгдэхүүн.

##### 10.2.3 Хатаасан болон дулаанаар өтгөрүүлсэн өндгөн бүтээгдэхүүн:

Цэвэрлэсэн бүтэн өндөг, өндөгний цагаан, шар хэсгээс сахарыг ялгаж дараа нь пастерчилж хатаасан бүтээгдэхүүн.

### 10.3 Нөөшилсөн өндөг, шүлтээр боловсруулсан, давсалсан, лаазалсан өндөг:

Уламжлалт аргаар боловсруулсан давсалсан галууны өндөг (Hueidan), шүлтээр боловсруулсан “мянган жилийн настай өндөг” (pidan) хамаарна.<sup>66</sup>

<sup>65</sup> Хүнсний хими, Н.-D. Belitz & W. Grosch, Springer-Verlag, Heidelberg, 1987, pp. 411-414.

<sup>66</sup> Ази хүнс: Шинжлэх ухаан, технологи, C.Y.W. Ang, K.S. Liu, & Y.-W. Huang, Eds., Бүлэг 8: Уламжлалт шувуу болон өндгөн бүтээгдэхүүн, T.C. Chen, Technomic Publishing Co., Lancaster PA 1999, pp. 240- 244.

10.4 Өндгөнд суурилсан амттан (жишээ нь:зуурмаг):

Хуурай хольцоос бэлтгэсэн, хэрэглэхэд бэлэн бүтээгдэхүүн хамаарна. Жишээ нь: бяслагтай бялуу болон өндөгний зуурмаг. Мөн жигнэмэг, бялуун бүтээгдэхүүний шанз хамаарна.(жишээ нь: кексний шанз).

11.0 Чихэрлэг амт оруулагч, зөгийн бал ороод:

Стандартчилсан элсэн чихэр (11.1), стандарчлаагүй бүтээгдэхүүн (ж-нь:11.2, 11.3, 11.4, 11.6) болон байгалийн гаралтай чихэрлэг амттан (11.5-зөгийн бал) хамаарна.

11.1 Цэвэршүүлсэн болон түүхий элсэн чихэр:

Тэжээллэг чанартай чихэрлэг амт оруулагч, тухайлбал 11.1.1-11.1.5 дэд ангилалд хамаарах бүрэн болон дутуу цэвэршүүлсэн сахароз (чихрийн хүрэн манжин, чихрийн нишингээс гарган авсан), глюкоз (цардуулаас гарган авсан) эсвэл фруктоз

11.1.1 Цагаан элсэн чихэр, хуурай декстроз, декстрозын моногидрат, фруктоз:

99.7 <sup>0</sup>Z-ээс багагүй эргэлтийн өнцөгтэй, цэвэршүүлж, талстжуулсан сахарозыг цагаан элсэн чихэр гэнэ. Усгүй талстжуулсан, цэвэршүүлж талстжуулсан D-глюкозыг хуурай декстроз гэнэ. Нэг молекул устай талсжсан, цэвэршүүлж, талстжуулсан D-глюкозыг декстрозын моногидрат гэнэ. Цэвэршүүлж, талстжуулсан D-фруктозыг фруктоз гэнэ.<sup>67</sup>

11.1.2 Элсэн чихрийн нунтаг, декстрозын нунтаг:

Бөөгнөрөхөөс сэргийлсэн бодистой, бодисгүй, нарийн ширхэгтэй нунтагласан цагаан элсэн чихрийг элсэн чихрийн нунтаг (*өөрөөр icing sugar ч гэж нэрлэнэ*) гэнэ. Бөөгнөрөхөөс сэргийлсэн бодистой, бодисгүй, нарийн ширхэгтэй болгон нунтагласан хуурай декстроз, декстрозын моногидрат эсвэл эдгээрийн хольцыг декстрозын нунтаг (*өөрөөр icing декстроз ч гэж нэрлэнэ*) гэнэ.<sup>67</sup>

11.1.3 Чийгийн агууламж ихтэй (soft) цагаан болон бор элсэн чихэр, глюкозын сироп, хатаасан глюкозын сироп, чихрийн нишингийн түүхий элсэн чихэр:

Цагаан өнгөтэй, чийгтэй, нарийн ширхэгтэй нунтагласан элсэн чихрийг чийгийн агууламж ихтэй цагаан элсэн чихэр гэнэ. Цайвраас бараан бор өнгөтэй, чийгтэй, нарийн ширхэгтэй нунтагласан элсэн чихрийг чийгийн агууламж ихтэй бор элсэн чихэр гэнэ. Цардуул эсвэл инулинээс гарган авсан тэжээллэг чанартай цэвэршүүлсэн сахаридын концентрацитай усан уусмалыг глюкозын сироп гэнэ.<sup>68</sup>

Чийгийг бүрэн зайлуулсан глюкозын сиропыг хатаасан глюкозын сироп гэнэ. Дутуу цэвэршүүлсэн чихрийн нишингийн шүүсийг дутуу цэвэршүүлж, талстжуулан гарган авсан сахарозыг чихрийн нишингийн түүхий элсэн чихэр хэлнэ.<sup>67</sup>

11.1.3.1 Чихрийн үйлдвэрлэлд ашиглах хатаасан глюкозын сироп:

<sup>67</sup> Элсэн чихэр (CodexStan 212-1999).

<sup>68</sup> Хүнсний хими, Н.-D. Belitz & W. Grosch, Springer-Verlag, Heidelberg, 1987, p. 631-633.

## **MNS CAC 192 : 2015**

Хүнсний ангиллын 05.2-д заасан чихрэн бүтээгдэхүүн (жишээ нь: хатуу эсвэл зөөлөн чихэр) үйлдвэрлэлд ашиглах 11.1.3-д заасан хатаасан глюкозын сироп

### 11.1.3.2 Чихрийн үйлдвэрлэлд ашиглах глюкозын сироп:

Хүнсний ангиллын 05.2-д заасан чихрэн бүтээгдэхүүн (жишээ нь: хатуу эсвэл зөөлөн чихэр) үйлдвэрлэлд ашиглах 11.1.3-д заасан глюкозын сироп

### 11.1.4 Лактоз:

Шар сүүнээс гаргаж авсан, ердийн сүүний бүрэлдэхүүн хэсэг. Энэ нь усгүй эсвэл нэг молекул талсжуулсан устай, мөн эдгээрийн холимог хэлбэрээр байж болно.<sup>67</sup>

### 11.1.5 Тарималжуулсан эсвэл тээрэмдсэн цагаан элсэн чихэр:

99.7<sup>0</sup>Z–ээс багагүй эргэлтийн өнцөгтэй, цэвэршүүлж, талстжуулсан сахароз

### 11.2 Хүнсний ангиллын 11.1.3-д дурдсанаас бусад бор элсэн чихэр:

Том ширхэгтэй, хүрэн эсвэл шаргал өнгөтэй элсэн чихэр хамаарна. Жишээ нь: *Demerara* маягийн элсэн чихэр

### 11.3 Элсэн чихрийн үүсмал ба сироп, түүнчлэн (бүрэн бүс) инвертийн элсэн чихэр, меласс болон бурам, хүнсний ангиллын 11.1.3-д дурдсанаас бусад бүтээгдэхүүн

Элсэн чихрийг цэвэршүүлэх ажиллагааны явцад үүсэх дайвар бүтээгдэхүүн (бурам, меласс), инвертийн сахар (сахарозын гидролизоор үүсэх ижил хэмжээний глюкоз, фруктозын хольц),<sup>68</sup> фруктозын агууламж ихтэй эрдэнэшишийн болон инулины сироп, эрдэнэшишийн элсэн чихэр зэрэг бусад чихэр амт оруулагч хамаарна.

### 11.4 Бусад элсэн чихэр болон сироп (жишээ нь: ксилоз, агч модны сироп, өнгөлгөөний элсэн чихэр):

Бүх төрлийн хүнсний сироп (жишээ нь: агч модны сироп), амтлаг гурилан бүтээгдэхүүний сироп, мөс (карамелийн сироп, амтлагч сироп), өнгөлгөө чимэглэлийн элсэн чихэр (жишээ нь: жигнэмгийн зориулалтын элсэн чихрийн өнгөт талст) хамаарна.

### 11.5 Зөгийн бал:

Ургамлын шүүс эсвэл цэцгийн балыг ажилчин зөгий боловсруулан гаргах байгалийн гаралтай чихэрлэг амттай нэгдлийг зөгийн бал гэнэ. Ажилчин зөгий ургамлын шүүс эсвэл цэцгийн балыг зөгийн өөрийн өвөрмөц бодистой нийлүүлэн зөгийн сархиагт боловсрон болц гүйцэх хүртэл хадгална.<sup>69</sup> Жишээ нь: зэрлэг цэцгийн бал болон хошоонгорын бал хамаарна.

### 11.6 Савласан чихэрлэг амт оруулагч, өндөр идэвхитэй чихэрлэг амт оруулагчийг оруулаад:

<sup>69</sup> Хүнсний хими, Н.-D. Belitz & W. Grosch, Springer-Verlag, Heidelberg, 1987, p. 636. Зөгийн бал (CodexStan 12-1981).

Өндөр идэвхитэй чихэрлэг амт оруулагч (ж-нь: *acesulfame potassium*) болон бусад нэмэлт агуулсан эсвэл нүүрс ус зэрэг тэжээллэг чанартай нэгдэл агуулсан *polyols* (ж-нь: сорбитол) бэлдмэл бүтээгдэхүүн хамаарна. Энэ бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нунтаг, хатуу (ж-нь: шахмал, шоо дөрвөлжин хэлбэртэй) эсвэл шингэн байдлаар борлуулна.

#### 12.0 Давс, халуун ногоо, шөл, сүмс, салат болон уурагт бүтээгдэхүүн:

Энэ ангилалд өргөн хүрээний бүтээгдэхүүн хамаарна. Үүнд: хүнсний үнэр, амтыг нэмэгдүүлэх (12.1-давс, давс орлуулагч; 12.2-амтлагч ургамал, халуун ногоо, ааг, амт үнэрийг нэмэгдүүлэгч (ж-нь: бэлэн гоймонгийн амтлагч); 12.3-цагаан цуу; ба 12.4-гич), боловсруулж бэлтгэсэн хүнс (12.5-шөл ба мах, ногоотой шөл, 12.6-сүмс ба түүнтэй төстэй бүтээгдэхүүн, 12.7-салат (ж-нь: гоймонгийн салат, төмсний салат), болон 04.2.2.5, 05.1.3 ангиллын какао ба самранд суурилсан түрхлэгнээс бусад сэндвичний түрхлэг)), шар буурцаг болон бусад эх үүсвэрээс (ж-нь: сүү, залаат тариа, ногоо) гарган авсан уургийн гаралтай бүтээгдэхүүн (12.9-шар буурцагт суурилсан амтлагч ба ааг, амт үнэрийг нэмэгдүүлэгч; (12.10-шар буурцагнаас бусад эх үүсвэрээс гаралтай уурагт бүтээгдэхүүн) хамаарна.

#### 12.1 Давс, давс орлуулагч:

Хүнсний амтлахад ашиглах давс (12.1.1) болон давс орлуулагч (12.1.2) хамаарна.

##### 12.1.1 Давс:

Үндсэн хэсэг нь натрийн хлорид. Хүнсний давс, иоджуулсан давс, фторжуулж иоджуулсан давс, нарийн ширхэгтэй нунтаг байдлаар талстжуулсан давс хамаарна.

##### 12.1.2 Давс орлуулагч:

Давсны оронд ашиглах, натрийн агууламжийг бууруулсан амтлагчийг давс орлуулагч гэнэ.

#### 12.2 Амтлагч ургамал, халуун ногоо, ааг, амт үнэрийг нэмэгдүүлэгчид (жишээ нь: бэлэн гоймонгийн амтлагч):

Хүнсний амт, үнэрийг нэмэгдүүлэх зорилгоор ашиглах бүтээгдэхүүн.

##### 12.2.1 Амтлагч ургамал болон халуун ногоо:

Ургамлыг хатаах, нунтаглах аргаар амтлагч ургамал ба халуун ногоог бэлтгэхээс гадна бүхэл байдлаар хэрэглэнэ. Амтлагч ургамалын жишээнд базилик, орегано, ганга хамаарна. Халуун ногооны жишээнд гоньд ба гоньдны үр хамаарна. Түүнчлэн халуун ногоо нь нунтаг холимог эсвэл нухаш хэлбэртэй байж болно. Халуун ногооны нунтаг холимогийн жишээнд чили амтлагч, чили нухаш, карри нухаш, карри сүмс болон мах, загасны гадаргууг амтлахад ашиглах хуурай амтлагч хамаарна.

##### 12.2.2 Амтлагч ба ааг, амт үнэрийг нэмэгдүүлэгч:

## **MNS CAC 192 : 2015**

Мах зөөлрүүлэгч, сонгинотой давс, сармистай давс, уламжлалт аргаар бэлтгэсэн холимог амтлагч (*dashi*), цагаан будааг цацаж амтлагч (ж-нь: хатааж хавтгайлсан далайн ургамлын үр, гүнжидийн үр ба бусад амтлагч агуулсан *furikake*), ба гоймон амтлагч хамаарна. Хүнсний “ааг, амт үнэрийг нэмэгдүүлэгч” ангилалд амтлагч сүмс (ж-нь: кетчуп, майонез, гич) болон чанаж боловсруулсан, нөөшилсөн амтлагчууд хамаарахгүй.

### **12.3 Цагаан цуу:**

Тохиромжтой эх үүсвэрийн (ж-нь: дарс, алимны дарс) этилийн спиртийг исгэх аргаар гарган авсан шингэн бүтээгдэхүүн. Жишээ нь: алимны дарсны, дарсны, соёолжны, үр тарианы, спиртийн, үзэмний ба жимсний (дарс) цагаан цуу.<sup>70</sup>

### **12.4 Гич:**

Буталсан, ихэвчлэн тосыг нь ялгасан гичний үрийг ус, цагаан цуу, давс, ургамлын тос болон бусад халуун ногоотой хольж, цэвэршүүлсэн ааг, амт үнэр нэмэгдүүлэгч суспенз. Жишээ нь: Франц маягийн буюу *Dijon* гич, “халуун” гич (хальстай үрээр бэлтгэсэн).<sup>71</sup>

### **12.5 Шөл болон мах, ногоотой шөл:**

Хэрэглэхэд бэлэн шөл тэдгээрийн хольц хамаарна. Бэлэн бүтээгдэхүүн нь усанд суурилсан (жишээ нь: тунгалаг, махтай шөл-*consommé*), цөцгийнд суурилсан (жишээ нь: *далайн ургамал, ногоотой шөл- chowder*) байж болно.

#### **12.5.1 Хэрэглэхэд бэлэн нөөшилсөн, шилэнд савласан, хөлдөөсөн шөл болон мах, ногоотой шөл:**

Хүнсний ногоо, мах эсвэл загастай, нэмэлтээр бусад хольц (ж-нь: ногоо, мах, гоймон) ашигласан эсвэл ашиглаагүй ус эсвэл сүүнд суурилсан бүтээгдэхүүн. Жишээ нь: бульон, мах, ногоотой шөл, тунгалаг шөл, ус болон цөцгийнд сүүнд суурилсан шөл, далайн ургамал, ногоотой шөл, Франц маягийн зутан шөл.

#### **12.5.2 Шөл болон мах, ногоотой шөлний холимог:**

Бусад орцын (ж-нь: ногоо, мах, гоймон) нэмэлттэй, нэмэлтгүй, ус эсвэл сүүгээр шингэлж хэрэглэх өтгөрүүлсэн шөл. Жишээ нь: нунтаг болон шахмал бульон, нунтаг болон өтгөрүүлсэн шөл (ж-нь: *mentsuyu*), шахмал болон нунтаг бүтээгдэхүүн хамаарна.

### **12.6 Сүмс, түүнтэй төстэй бүтээгдэхүүн:**

Хэрэглэхэд бэлэн сүмс, хоол бэлтгэх явцад гарах өөрийнх нь шүүс ашигласан сүмс (*gravies*), салат амтлагч (*dressings*) болон хэрэглэхийн өмнө сэргээж ашиглах хольц. Хэрэглэхэд бэлэн бүтээгдэхүүн нь цийдмэгжүүлсэн (12.6.1), цийдмэгжүүлээгүй (12.6.2), тэдгээрийн хольц (12.6.3) гэсэн дэд ангилалд хуваагдана.

#### **12.6.1 Цийдмэгжүүлсэн сүмс болон дүрлэг (жишээ нь: майонез, салат амтлагч, сонгинын дүрлэг):**

<sup>70</sup> Хүнсний хими, Н.-D. Belitz & W. Grosch, Springer-Verlag, Heidelberg, 1987, pp. 719-720.

<sup>71</sup> Ibid., p. 718.

Ус болон ургамал, амьтны гаралтай тосны цийдмийн хэсэг болох сүмс, хоол бэлтгэх явцад гарах өөрийнх нь шүүс ашигласан сүмс (*gravies*), салат амтлагч (*dressings*) болон дүрлэг. Жишээ нь: салат амтлагч (Франц, Итали, Грек, тосгоны төрлийн), амьтны гаралтай тосонд суурилсан сэндвичний түрхлэг (ж-нь: гичтэй майонез), салатны цөцгий, тосон сүмс ба зуушны дүрлэг (ж-нь: гахайн утсан махан ба *чеддар* дүрлэг, сонгины дүрлэг) хамаарна.

#### 12.6.2 Цийдмэгжүүлээгүй сүмс (жишээ нь: кетчуп, цөцгийн сүмс, бяслагт сүмс, хүрэн сүмс):

Ус, наргил модны сүү болон сүүнд суурилсан сүмс, хоол бэлтгэх явцад гарах өөрийнх нь шүүс ашигласан сүмс (*gravies*) болон салат амтлагч хамаарна. Жишээ нь: шорлогны сүмс, лоолийн кетчуп, бяслагны сүмс, *Worcestershire* сүмс (*tonkatsu* сүмс), чили сүмс, чихэрлэг болон исгэлэн дүрлэг сүмс, цагаан (цөцгийнд суурилсан) сүмс (сүү эсвэл цөцгийн, бага зэргийн амьтны гаралтай тос (ж-нь: цөцгийн тос) гурил нэмсэн, амтлагчтай эсвэл амтлагчгүй).

#### 12.6.3 Сүмс болон махан сүмний холимог:

Ихэвчлэн нунтаг байдалтай, өтгөрүүлсэн ус, сүү, ургамлын тос болон бусад шингэнтэй хольж бэлтгэх сүмс. Жишээ нь: бяслагны сүмний холимог, голланд сүмс, салат амтлагч (ж-нь: Итали эсвэл тосгоны төрлийн).

#### 12.6.4 Тунгалаг сүмс (жишээ нь: загасны сүмс):

Шингэн, цийдмэгжүүлээгүй, усанд суурилсан байж болох тунгалаг сүмс. Энэ сүмсийг хоол бэлтгэх явцад гарах өөрийнх нь шүүс ашигласан сүмс гэхээс (шарсан үхрийн махыг амтлах) илүүтэй хүнсний ааг, амт, үнэр нэмэгдүүлэгч байдлаар голчлон хэрэглэнэ. Жишээ нь: хясааны сүмс, Тай загасны сүмс (*nam pla*).

#### 12.7 Хүнсний ангиллын 04.2.2.5 ба 05.1.3-д дурдсан какао болон самарт суурилсан түрхлэгээс бусад салат (ж-нь: гоймон, төмсний салат) болон сэндвичний түрхлэг:

Бэлтгэсэн салат, сүүнд суурилсан сэндвичний түрхлэг, стандартчилагдаагүй майонез төст сэндвичний түрхлэг, байцааны салатны амтлагч хамаарна.

#### 12.8 Хөрөнгө, түүний төрлийн бүтээгдэхүүн:

Талхан бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ашиглах талхны дрожжи, исгэгч. Энд согтууруулах ундааны уламжлалт үйлдвэрлэлд ашиглах бүтээгдэхүүн *koji* (*A.oryzae* мөөгөнцрөөр соёолуулсан тутрага эсвэл буудай) хамаарна.

#### 12.9 Шар буурцагт суурилсан амтлагч ба ааг, амт үнэрийг нэмэгдүүлэгч:

Шар буурцаг болон амтлагч ба ааг, амт үнэр нэмэгдүүлэгчээр ашиглах бусад бүтээгдэхүүнээс бэлтгэх исгэсэн шар буурцагны нухаш, шар буурцагны сүмс зэрэг бүтээгдэхүүн.

#### 12.9.1 Исгэсэн шар буурцагны нухаш (жишээ нь: мисо):

Шар буурцаг, давс, ус болон бусад жор орцын бүтээгдэхүүн ашиглан исгэж гарган авсан бүтээгдэхүүн. Энэ ангиллын бүтээгдэхүүнийг шөл, халуун ногоо,

## **MNS CAS 192 : 2015**

салат амтлагч байдлаар хэрэглэнэ.<sup>53,72</sup> Жишээ нь: *dou jiang* (Хятад), *doenjang* (Солонгос), *miso* (Япон).

### 12.9.2 Шар буурцагны сүмс:

Исгэсэн, исгээгүй (ж-нь: гидролиз) шар буурцаг хийсэн эсвэл хүнсний ногооны уургийн гидролизоор гарган авсан шингэн амтлагч.

#### 12.9.2.1 Исгэсэн шар буурцгийн сүмс:

Шар буурцаг, залаат үр тариа, давс ба усыг исгэж гарган авсан цийдмэгжүүлээгүй, тунгалаг цуу.

#### 12.9.2.2 Исгээгүй шар буурцгийн сүмс:

Тосгүйжүүлж, хүчлээр задалсан (ж-нь: давсны хүчлээр), саармагжуулсан (ж-нь: натрийн карбонатаар), шүүсэн шар буурцаг зэрэг ургамлын уургаас гарган авсан бүтээгдэхүүнийг исгээгүй буюу нэрээгүй шар буурцагны сүмс гэнэ.<sup>73</sup>

#### 12.9.2.3 Шар буурцагны бусад сүмс:

Исгэсэн эсвэл исгээгүй шар буурцагны сүмсийг элсэн чихэртэй, элсэн чихэргүй, чихэржих урвал явагдсан эсвэл явагдаагүй цийдмэгжүүлээгүй сүмс.

### 12.10 Шар буурцагнаас бусад бүтээгдэхүүнээс гарган авсан уурагт бүтээгдэхүүн:

Сүү, үр тариа, ногооны уурагтай ижил төстэй бүтээгдэхүүн эсвэл мах, загас сүү орлуулагч хамаарна. Жишээ нь: ногооны уурагтай ижил төстэй бүтээгдэхүүн, *fu* (хатаасан (жигнэсэн), эсвэл чийгтэй байдлаар худалдаалах, хоолны хольц (ж-нь: мисо шөл зэрэг) байдлаар хэрэглэх, цавуулаг (ногооны уураг) ба гурилын холимог), уурагт мах болон загас орлуулагч.

## 13.0 Тусгай зориулалттай хүнсний бүтээгдэхүүн

Тухайн хүний физик, физиологийн онцлог, өвчин ба зовиур зэргийн эмчилгээний онцлог, шаардлагад нийцүүлэн тусгайлан боловсруулсан сувиллын хүнс. Энэ төрлийн хүнсний бүтэц, найрлага нь ердийн ижил төрлийн хүнсний найрлагаас ялгаатай байх ёстой.<sup>74</sup> Энэ 13.0 ангилалд дурдсанаас бусад сувиллын хүнсийг тухайн стандартаас үзэж болно.<sup>75</sup>

### 13.1 Нярай болон бага насны хүүхдэд зориулсан эхийн сүү орлуулагч, нэмэгдэл тэжээл, нярай хүүхдийн эмчилгээний тусгай зориулалтын тэжээл

13.1.1, 13.1.2 болон 13.1.3 ангилалд хамаарах нярай болон бага насны хүүхдэд зориулсан хүнс.

#### 13.1.1 Нярайн эхийн сүү орлуулагч:

Нэмэлт тэжээл хэрэглэх хүртэл нярайн эхний саруудад зайлшгүй

<sup>72</sup> K.S. Liu, op.cit. 173-181

<sup>73</sup> Ibid., pp.181-187.

<sup>74</sup> *General Standard for Labelling of and Claims for Prepackaged Foods for Special Dietary Use* (CodexStan 146-1985).

<sup>75</sup> For example, diet soda is found in 14.1.4.1, and low-joule jam is found in 04.1.2.5.

шаардлагатай тэжээлийг өгөх цорын ганц эх үүсвэр болох нярайн (12 сараас ихгүй сартай) эхийн сүү орлуулагч. Бүтээгдэхүүн нь шууд хэрэглэх шингэн эсвэл сэргээж хэрэглэх нунтаг байдалтай байна. Хүнсний ангиллын 13.1.3-д зааснаас өөр бүтээгдэхүүнд гидролизод оруулсан уураг эсвэл амин хүчил болон сүүнд суурилсан бүтээгдэхүүн хамаарна.

#### 13.1.2 Бага насны хүүхдийн нэмэгдэл тэжээл:

Нярай (6 хүртэл сартай) болон бага насны (1-3 настай) хүүхдийн шингэнийг нөхөхөд зориулсан хүнс.<sup>76</sup> Эдгээр бүтээгдэхүүн нь шууд хэрэглэх шингэн эсвэл устай хольж сэргээж хэрэглэх нунтаг байдалтай байж болно. Хүнсний ангиллын 13.1.3-д зааснаас өөр бүтээгдэхүүнд шар буурцганд суурилсан гидролизод оруулсан уураг эсвэл амин хүчил, сүүнд суурилсан бүтээгдэхүүн байж болно.

#### 13.1.3 Нярай хүүхдийн эмчилгээний зориулалтын тэжээл:

Нярайн сувиллын зориулалтаар эмчийн хяналтан дор хэрэглэх тусгай аргаар боловсруулсан зориулалтын хүнс. Эдгээр бүтээгдэхүүн нь эхийн сүү орлуулагч ердийн эсвэл ижил төстэй бэлдмэлийг боловсруулан шингээх чадвар сул, доголдолтой эсвэл эмчийн тодорхойлсноор хоол хүнсээр авч байгаа уураг нь шаардлагатай хэмжээнд хүрэхгүй, бусад хүнс болон нэмэлт тэжээлээр эсвэл эдгээрийг хослуулан хязгаарлагдмал байдлаар хэрэглэх нярайд зориулсан тэжээл.<sup>77</sup>

#### 13.2 Нярай болон өсвөр насны хүүхдийн тэжээл:

6 түүнээс дээш сартай нярай хүүхэд ердийн хүнсэнд дасан зохицоход зориулсан хүнс. Эдгээр бүтээгдэхүүн нь шууд хэрэглэх эсвэл ус, сүү болон бусад тохиромжтой шингэнээр сэргээн ашиглах нунтаг хэлбэртэй байж болно.<sup>78</sup> Эдгээр хүнсэнд нярайн эхийн сүү орлуулагч (13.1.1), хүүхдийн нэмэгдэл тэжээл (13.1.2), эмчилгээний тусгай зориулалтын тэжээл (13.1.3) хамаарахгүй.<sup>79</sup> Энэ ангилалд: залаат тариа-, жимс-, ногоо-, маханд суурилсан “нярайн хүнс”, “мөлхөө хүүхдийн хүнс”, “өсвөр насны хүүхдийн хүнс”, *lactea* гурил, хүүхдэд зориулсан жигнэмэг, хатаасан талх хамаарна.

#### 13.3 Эмчилгээний тусгай зориулалтын сувиллын хүнс (хүнсний ангиллын 13.1-д дурдсан бүтээгдэхүүнээс бусад):

Өвчтний сувиллын зориулалтаар эмчийн хяналтан дор хэрэглэх, тусгай аргаар боловсруулсан, тусгай зориулалтын сувиллын хүнс. Эдгээр бүтээгдэхүүн нь ердийн хүнсийг боловсруулан шингээх чадвар сул, доголдолтой эсвэл эмчийн тодорхойлсноор хоол хүнсээр авч байгаа уураг нь шаардлагатай хэмжээнд хүрэхгүй, бусад хүнс болон нэмэлт тэжээлээр эсвэл эдгээрийг хослуулан хязгаарлагдмал байдлаар хэрэглэх өвчтөнд зориулсан тэжээл.<sup>77</sup>

#### 13.4 Түраах, жин бууруулах сувиллын бүтээгдэхүүн:

Шууд хэрэглэх эсвэл хэрэглэх заавар бүхий өдрийн хэрэгцээт хоол,

<sup>76</sup> Standard for Follow-Up Formula (CodexStan 156-1987).

<sup>77</sup> Standard for the Labelling of and Claims for Foods for Special Medical Purposes (CodexStan 180-1991).

<sup>78</sup> Standard for Processed Cereal-Based Foods for Infants and Children (CodexStan 74-1981).

<sup>79</sup> Standard for Canned Baby Foods (CodexStan 073-1981).



## **MNS CAC 192 : 2015**

хүнсний бүгдийг эсвэл зарим хэсгийг орлох бэлдмэл хамаарна.<sup>80</sup> Энд элсэн чихэр болон тосны агууламж багатай, элсэн чихэр, тос агуулаагүй эсвэл сахар ба тос орлуулагч ашигласан илчлэг багатай бүтээгдэхүүн хамаарна.

### **13.5 Сувиллын хүнс (жишээ нь: сувиллын зориулалтаар хэрэглэх нэмэлт хүнс), ХҮНСНИЙ ангиллын 13.1-13.4 болон 13.6-д дурдсанаас бусад:**

Тэжээллэг чанар өндөртэй, шингэн эсвэл хатуу байдалтай (ж-нь: уургийн шахмал), хувь хүний хоол хүнсний тэнцвэрт байдлыг хангах нэмэлт тэжээл байдлаар хэрэглэнэ. Энэ бүтээгдэхүүнийг жин хасах эсвэл эмчилгээний зориулалтаар ашиглахгүй.

### **13.6 Хүнсний нэмэлт бэлдмэл:**

Капсул, шахмал, нунтаг, уусмал зэрэг нэгж тун хэлбэртэй, үндэсний эрх зүйн зохицуулалтаар хүнс гэж тооцох аминдэм, эрдсийн бэлдмэл хамаарна.<sup>81</sup>

### **14.0 Сүүн бүтээгдэхүүнээс бусад ундаа:**

Энэ ангилал спирт агуулаагүй (14.1) ба спиртлэг (14.2) ундаа гэсэн дэд ангилалд хуваагдана. Сүүнд суурилсан ундаа 01.1.2 ангилалд хамаарна.

### **14.1 Спиртгүй (“зөөлөн”) ундаа:**

Энэ ангилалд ус болон хийжүүлсэн ус (14.1.1), жимс, ногооны шүүс (14.1.2), жимс, ногооны нектар (14.1.3), усанд суурилсан амтат хийжүүлсэн эсвэл хийжүүлээгүй ундаа (14.1.4), кофе, цай зэрэг усанд суурилсан нэрсэн эсвэл хандалсан ундаа (14.1.5) хамаарна.

#### **14.1.1 Ус:**

Хийжүүлсэн, хийжүүлээгүй байгалийн ус (14.1.1.1) болон бусад савласан ус (14.1.1.2) хамаарна.

#### **4.1.1.1 Байгалийн эрдэст ус болон байгалийн бусад эх үүсвэрийн ус:**

Байгалийн эх үүсвэрээс нь шууд авч савласан, тодорхой төрлийн эрдэс давсуудыг харьцангуй ихээр, харин бусад элемент, бүрэлдэхүүн хэсгийг маш бага хэмжээгээр агуулсан ус хамаарна. Байгалийн эрдэст ус нь хийтэй (эх үүсвэрээс байгалийн нүүрсхүчлийн хийтэй), хийжүүлсэн (өөр эх үүсвэрийн нүүрсхүчлийн хийг нэмсэн), хийг багасгасан (ердийн температур, даралттай орчинд нүүрсхүчлийн хий нь аяндаа ялгарахгүйгээр эх үүсвэрийн усанд байх нүүрсхүчлийн хийнээс бага агууламжтай болгосон), эсвэл баяжуулсан (эх үүсвэрээс байгалийн нүүрсхүчлийн хийтэй) ба хийжүүлээгүй (нүүрсхүчлийн хийгүй) байж болно.<sup>82</sup>

#### **14.1.1.2 Савласан болон хийжүүлсэн ус:**

<sup>80</sup> Standard for Formula Foods for Use in Weight Control Diets (CodexStan 181-1991) and Standard for Formula Foods for use in Very Low Energy Diets for Weight Reduction (CodexStan 203-1995).

<sup>81</sup> Guidelines for Vitamin and Mineral Food Supplements (CAC/GL 55-2005).

<sup>82</sup> Байгалийн эрдэст ус, (CodexStan 108-1981).

Нүүрсхүчлийн хийгээр хийжүүлэх, шүүх, ариутгаж халдваргүйжүүлэх болон бусад аргаар боловсруулсан, байгалийн уснаас бусад ус хамаарна. Эдгээр усанд эрдэс давсууд нэмж болно. Амт оруулагчтай хийжүүлсэн эсвэл хийжүүлээгүй ус 14.1.4 ангилалд хамаарна. Энэ ангилалд савласан ус, эрдэсжүүлсэн эсвэл эрдэсгүй савласан ус, цэвэршүүлсэн ус, “Seltzer” ус (хийжүүлсэн ус), Сода ус, оргилуун ус хамаарна.

#### 14.1.2 Жимс, ногооны шүүс:

Энэ ангилал зөвхөн жимс, ногооны шүүсэнд хамаарна. Жимс, ногооны шүүсээр хийсэн ундаа хүнсний 14.1.4.2 ангилалд хамаарна. Жимс, ногооны холимог шүүс бүрэлдэхүүнээсээ хамаарч өөр өөр ангилалд (жишээ нь: жимсний шүүс (14.1.2.1) ногооны шүүс (14.1.2.3)) хамаарна.

##### 14.1.2.1 Жимсний шүүс:

Жимсний шүүс нь бүрэн болцтой, шинэ, эрүүл жимсний идэж болох хэсгээс эсвэл тохирох арга хэрэгсэл ашиглан зөв хадгалсан жимс эсвэл шинэ жимснээс шахсан, исгээгүй боловч исгэж болох шингэн. Шинэ жимсэнд агуулагдах шүүсний физик, хими, мэдрэхүйн болон тэжээллэг чанарын үзүүлэлтийг хадгалахуйц тохиромжтой аргыг сонгож шүүсийг бэлтгэнэ. Шүүс нь тунгалаг эсвэл булингартай, мөн ижил төрлийн жимснээс физикийн тохиромжтой аргаар гарган авсан үнэрт болон амт оруулагч дэгдэмхий нэгдлээр сэлбэсэн (тухайн жимсэн дэх хэвийн түвшинд нь хүргэх) байж болно. Ижил төрлийн жимсний зөөлөн эдийг нэмж болно. Нэг төрлийн жимснээс нэг төрлийн шүүс гаргаж авна. Холимог шүүсийг хоёр ба түүнээс олон төрлийн жимсний шүүс, нухшийг холих замаар гаргана. Шинэ жимсийг шууд механик аргаар шахах, өтгөрүүлсэн шүүсийг усаар шингэлэх (14.1.2.3 ангилал), эсвэл зарим тохиолдолд бүхэл жимсийг усаар хандлах (жишээ нь: хатаасан хар чавганаас шүүс гаргах) аргаар жимсний шүүсийг бэлтгэнэ.<sup>83</sup> Энэ ангилалд жүрж, алим, үхрийн нүд, нимбэг, мангоны шүүс, кокосын ус хамаарна.

##### 14.1.2.2 Ногооны шүүс:

Ногооны шүүс нь нэг эсвэл хэд хэдэн төрлийн шинэ, эрүүл ногоо эсвэл зөвхөн физикийн аргаар нөөшилсөн ногоог механикаар шахах, үрэх, няцлах зэрэг аргаар боловсруулж бэлтгэсэн, исгээгүй боловч исгэх боломжтой, шууд ууж хэрэглэх шингэн хүнс. Шүүс нь тунгалаг, булингартай, зөөлөн эдтэй байж болно.

Эдгээр нь өтгөрүүлсэн, усаар шингэрүүлсэн байж болно. Шүүс нь нэг төрлийн ногооны (ж-нь: луувангийн) эсвэл холимог ногооны (ж-нь: лууван ба цоохор майлзын шүүс) байж болно.

##### 14.1.2.3 Жимсний өтгөрүүлсэн шүүс:

Жимсний өтгөрүүлсэн шүүс нь хүнсний 14.1.2.1 ангиллын шаардлагыг хангасан, жимсний шүүснээс Vrix-ийн түвшинг нэмэгдүүлэн 50 %-аас (энэ хэмжээ нь ижил төрлийн жимснээс бэлтгэсэн сэргээсэн шүүсэнд тогтоосон үзүүлэлт) дээш болтол усыг нь физик аргаар ялгах замаар бэлтгэсэн бүтээгдэхүүн.

Өтгөрүүлсэн шүүсний үйлдвэрлэлд тохиромжтой боловсруулалт хийх шаардлагатай, түүнчлэн өтгөрүүлэх ажиллагааг зөөлөн эдийг усанд нэвчүүлэх

<sup>83</sup> Жимсний шүүс ба нектар, (CodexStan 247-2005).

## **MNS CAC 192 : 2015**

ажиллагаатай хамт буюу жимсний усанд уусах хэсгийг шүүсийг өтгөрөхөөс өмнө нэмэх замаар гүйцэтгэж болно. Ижил төрлийн жимснээс физикийн тохиромжтой аргаар гарган авсан үнэрт болон амт оруулагч дэгдэмхий нэгдлээр сэлбэсэн (тухайн жимсэн дэх хэвийн түвшинд нь хүргэх) байж болно.<sup>83</sup> Шингэн, сироп, хөлдөөсөн байдлаар худалдаалдаг бөгөөд түүн дээр ус нэмж холиод шууд ууж хэрэглэхэд бэлэн шүүс болгоно. Тухайлбал: жүржийн өтгөрүүлж хөлдөөсөн шүүс, нимбэгний өтгөрүүлсэн шүүс.

### **14.1.2.4 Ногооны өтгөрүүлсэн шүүс:**

Ногооны шүүснээс усыг нь физик аргаар ялгасан бүтээгдэхүүн. Шингэн, сироп, хөлдөөсөн байдлаар худалдаалдаг бөгөөд түүн дээр ус нэмж холиод шууд ууж хэрэглэхэд бэлэн шүүс болгоно. Луувангийн өтгөрүүлсэн шүүс хамаарна.

### **14.1.3 Жимс, ногооны нектар:**

Жимс, ногооны нектар нь нухаш, шүүс, эсвэл тэдгээрийн өтгөрүүлсэн хэлбэрийг ус болон элсэн чихэр, зөгийн бал, сироп, чихэрлэг амт оруулагчтай хольж үйлдвэрлэсэн ундаа.<sup>83</sup> Жимс-ногооны нектарын холимгийг тэдгээрийг бүрдүүлж буй хольцын дагуу нэрлэнэ (жимсний нектар (14.1.3.1) ба ногооны нектар (14.1.3.2)).

#### **14.1.3.1 Жимсний нектар:**

Жимсний нектар нь жимсний шүүс, өтгөрүүлсэн шүүс, нухаш, өтгөрүүлсэн нухаш, эсвэл тэдгээрийн холимог дээр элсэн чихэр, зөгийн бал, сироп, чихэрлэг амт оруулагчтай ус эсвэл зөвхөн цэвэр ус нэмэх замаар бэлтгэсэн, исгээгүй боловч исгэх боломжтой бүтээгдэхүүн юм. Ижил төрлийн жимснээс тохиромжтой физик аргаар гарган авсан амт, үнэр оруулагч дэгдэмхий бодис болон зөөлөн эдийг нэмж болно. Нэг эсвэл холимог жимсний нектар байж болно.<sup>83</sup> Тухайлбал: лийрийн нектар, тоорын нектар.

#### **14.1.3.2 Ногооны нектар:**

Ногооны шүүс, өтгөрүүлсэн шүүс, эсвэл тэдгээрийн холимог дээр элсэн чихэр, зөгийн бал, сироп, чихэрлэг амт оруулагчтай ус эсвэл зөвхөн цэвэр ус нэмэх замаар бэлтгэсэн бүтээгдэхүүн. Нэг эсвэл холимог ногооны нектар байж болно.

#### **14.1.3.3 Жимсний өтгөрүүлсэн нектар:**

Жимсний нектар эсвэл түүнийг бэлтгэх анхдагч материалын усыг физик аргаар ялгах замаар бэлтгэнэ.<sup>83</sup> Шингэн, сироп, хөлдөөсөн хэлбэрээр борлуулах бөгөөд ус нэмж холиод шууд ууж хэрэглэхэд бэлэн ундаа болгоно. Жишээ нь: лийрийн өтгөрүүлсэн нектар, тоорын өтгөрүүлсэн нектар.

#### **14.1.3.4 Ногооны өтгөрүүлсэн нектар:**

Ногооны нектарын усыг физик аргаар ялгах замаар бэлтгэнэ. Шингэн, сироп, хөлдөөсөн хэлбэрээр борлуулах бөгөөд ус нэмж холиод шууд ууж хэрэглэхэд бэлэн ундаа болгоно.

#### 14.1.4 Усанд суурилсан амтат ундаа, “спортын”, “хүч тамирын”, “электролитын” болон бусад тусгай зориулалтын ундаа:

Хийжүүлсэн, хийжүүлээгүй төрөл бүрийн ундаа, тэдгээрийн концентрат. Энд жимс, ногооны шүүсэнд суурилсан бүтээгдэхүүн хамаарна.<sup>84</sup> Мөн кофе, цай, ургамалд суурилсан ундаа хамаарна.

##### 14.1.4.1 Хийжүүлсэн, усанд суурилсан амтат ундаа:

Тэжээллэг, тэжээллэг бус эсвэл маш хүчтэй чихэрлэг амт оруулагч болон зөвшөөрөгдөх бусад хүнсний нэмэлт бүхий хийжүүлсэн, амтат ундаа хамаарна. Энд gaseosa (усанд суурилсан хийжүүлсэн, чихэрлэг амт болон үнэр оруулагчтай ундаа), кола зэрэг содын төрлийн ундаа, чинжүү төрлийн, үндэст шар айраг, нимбэг-лайм, цитрусын төрлийн жимсний, сувиллын/хөнгөн болон ердийн ундаа хамаарна. Эдгээр ундаа нь тунгалаг, булингартай, жимсний жижиг хэсэгтэй байж болно. Энд “энергийн” буюу хүч тамирын ундаа хэмээн нэрлэгддэг хийжүүлсэн, шимт бодис болон бусад нэгдэл (ж-нь: кофеин, таурин, карнитин)-ээр баялаг ундаа хамаарна.

##### 14.1.4.2 Хийжүүлээгүй, усанд суурилсан амтат ундаа:

Усанд суурилсан хийжүүлээгүй амтат ундаа, жимс ба ногооны шүүсэнд суурилсан ундаа (ж-нь: бүйлсний, гоньдын үрний, наргил модны самрын, хүн орхоодойн), жимсний амттай ундаа (ж-нь: нимбэгний ундаа, амтат жүржний ундаа), хулууны ундаа (цитрусын төрлийн жимсэнд суурилсан ундаа), Испани маягаар хийсэн ундаа (caripe groselha), сүүнхүчлийн ундаа, шууд ууж хэрэглэхэд бэлэн сүүтэй, сүүгүй кофе ба цай, ургамалд суурилсан ундаа (ж-нь: мөстэй цай, жимсний амттай мөстэй цай, лаазанд савласан хүйтэн капучино ундаа) болон электролит агуулсан “спортын” ундаа хамаарна. Энэ төрлийн ундаа тунгалаг эсвэл жимсний жижиг хэсэгтэй, элсэн чихрээр амталсан, амтлаагүй эсвэл тэжээллэг бус, маш хүчтэй чихэрлэг амт оруулагчтай байж болно. Энд “энергийн” буюу хүч тамирын ундаа хэмээн нэрлэгддэг хийжүүлээгүй, шимт бодис болон бусад нэгдэл (ж-нь: кофеин, таурин, карнитин)-ээр баялаг ундаа хамаарна.

##### 4.1.4.3 Усанд суурилсан амтат ундааны концентрат (хатуу эсвэл шингэн)

Ус эсвэл хийжүүлсэн ус нэмэх замаар усанд суурилсан хийжүүлсэн, хийжүүлээгүй спиртгүй ундаа бэлтгэхэд зориулсан нунтаг, сироп, шингэн, хөлдөөсөн концентрат хамаарна. Тухайлбал: гуурст сироп (кола сироп), зөөлөн ундаанд зориулсан жимсний шүүс, мөн нимбэгний ундаа, мөстэй цайны холимогт зориулсан хөлдөөсөн эсвэл нунтаг концентрат хамаарна.

#### 14.1.5 Какаоноос бусад, кофе, кофе орлогч, цай, ургамлын ханд, бусад үр тарианы халуун ундаа:

Шууд ууж хэрэглэхэд бэлэн ундаа (ж-нь: лаазалсан) болон тэдгээрийн хольц, концентрат. Жишээ нь: цикорид суурилсан халуун ундаа (postum), цагаан будааны цай, mate цай (Өмнөд Америкт ургадаг ургамлын цай), халуун кофе, цайнд зориулсан хольц (жишээ нь: түргэн уусдаг кофе, капучиногийн нунтаг), кофены үйлдвэрлэлд ашиглах боловсруулсан кофены

<sup>84</sup> Жимс, ногооны шүүс, хүнсний 14.1.2.1, 14.1.2.2 ангиллын.

## **MNS CAC 192 : 2015**

буурцаг хамаарна. Шууд ууж хэрэглэхэд бэлэн какао 01.1.2, какаоны хольц 05.1.1 ангилалд хамаарна.

### 14.2 Спиртлэг ундаа, спиртгүй болон бага спирттэй ундаа:

Спирт агуулаагүй болон спиртийн агууламж багатай ундаатай ижил төрлийн бүтээгдэхүүн нь спиртлэг ундааны ангилалд хамаарна.

#### 14.2.1 Шар айраг, соёолжийн ундаа:

Соёолсон арвай (соёолж), зөрөг цэцэг, дрожжи, ус ашиглан исгэж үйлдвэрлэсэн спиртлэг ундаа. Жишээ нь: тунгалаг шар айраг, бараан шар айраг, Weiss, Lager, Oudbruin шар айраг, Obergariges Einfachbier, тунгалаг, савласан шар айраг, соёолжийн ликер, портер, слоут, арвайн дарс хамаарна.<sup>85</sup>

#### 14.2.2 Алим, лийрийн ундаа (спирттэй):

Алим (cider), лийрийн (perry) дарс хамаарна. Мөн алимны дарс (оргилуун дарсны шилэнд савласан) хамаарна.<sup>86</sup>

#### 14.2.3 Усан үзмийн дарс:

Няцалсан эсвэл бүхэл шинэ усан үзэм болон усан үзмийн шинэхэн шахсан шүүсийг бүрэн болон хагас исгэж бэлтгэсэн спиртлэг ундаа.<sup>87</sup>

##### 14.2.3.1 Усан үзмийн нэрмэл дарс:

20 °C температурт 0,4 г/100мл (4000 мг/кг)-ээс ихгүй нүүрсхүчлийн хий агуулсан усан үзмийн дарс (цагаан, улаан, ягаан, улаавтар, хуурай эсвэл чихэрлэг).

##### 14.2.3.2 Усан үзмийн оргилуун болон хөөсрөлт багатай дарс:

Битүү шилэн лонх эсвэл битүү танканд исгэхэд үүссэн нүүрсхүчлийн хий бүхий усан үзмийн дарс. Энд нүүрсхүчлийн хийг гаднаас зориудаар бүрэн болон хагас нэмж хийжүүлсэн дарс хамаарна. Ж-нь: "Spumante", "Coldduck" дарс.<sup>88</sup>

##### 14.2.3.3 Усан үзмийн хатуу дарс, ликёр, чихэрлэг дарс:

Усан үзмийн дарсыг (i) сахарын өндөр агууламжтай усан үзмийн шинэ шахсан шүүсийг исгэх, (ii) усан үзмийн өтгөрүүлсэн шүүсийг дарстай холих, (iii) исгэсэн шүүсийг спирттэй холих аргаар үйлдвэрлэж болно. Жишээ нь: усан үзмийн чихэрлэг дарс.<sup>86</sup>

#### 14.2.4 Дарс (усан үзмийнхээс бусад):

Усан үзмээс бусад жимсний тухайлбал алим, лийр<sup>88</sup> болон үр тариа (тутрага буюу цагаан будаа) зэрэг хөдөө аж ахуйн бусад түүхий эдээр бэлтгэсэн

<sup>85</sup> Хүнсний хими, H.D.Belitz&W.Grosch, Springer-Verlag.Heidelberg,1987, p 644.

<sup>86</sup> Lbid., p 669-679.

<sup>87</sup> Lbid., p 654, OIV-Ocnological дадлын олон улсын код

<sup>88</sup> Усан үзмийн дарс 14.2.3; алимны болон лийрийн дарс 14.2.2 ангилалд хамаарна.

дарс. Эдгээр дарс нь ердийн эсвэл оргилуун байж болно. Жишээ нь: цагаан будааны дарс (саке), жимсний оргилуун болон ердийн дарс.

#### 14.2.5 Зөгийн балны спиртлэг ундаа:

Исгэсэн зөгийн бал, соёолж ба халуун ногоо эсвэл зөвхөн зөгийн балнаас үйлдвэрлэсэн спиртлэг ликер. Энд зөгийн балны дарс хамаарна.<sup>86</sup>

#### 14.2.6 Нэрж бэлтгэсэн, 15 %-аас дээш спиртлэгтэй ундаа:

Үр тариа (ж-нь: эрдэнэшиш, арвай, хөх тариа, буудай), булцуут ногоо (ж-нь: төмс), жимс (ж-нь: усан үзэм, жимсгэнэ) эсвэл чихрийн нишингээс нэрсэн, 15 %-аас их спирт агуулсан бүх төрлийн спиртлэг ундаа хамаарна. Тухайлбал: aperitifs, брэнди (нэрсэн дарс), cordials, liqueurs (цийдмэгжүүлсэн ликер), Bagaceira belha (Португалийн grappa); Bagaceira-bagazo (усан үзмийн шахдас-хальс, үр, иш шилбэ агуулна)-наас нэрсэн), eau de vie (брэнди), джин, grappa (дарс үйлдвэрлэлийн шахдаснаас нэрсэн Итали брэнди), магс (алим эсвэл усан үзмийн шахдаснаас нэрсэн брэнди), Korn (Герман аргаар нэрсэн үр тарианы спирт (schnapps), ихэвчлэн хөх тарианы (Roggen), зарим тохиолдолд буудайн (Weizen), хосолмол (Getreide); Kornbrannt, Kornbrantwein гэсэн шошготой байна),<sup>89</sup> mistela (мөн mistelle (Франц) болон jерopico (Өмнөд Африк) гэж нэрлэдэг; усан үзмийн спиртээр баяжуулсан усан үзмийн исгээгүй шүүс), ouzo (гоньдын үрний амттай Грек спиртлэг ундаа), ром, tsikodia (Критээс гаралтай усан үзмийн шахдсаар хийсэн спирт), tsipouro (Грекийн тодорхой мужаас гаралтай усан үзмийн шахдсаар хийсэн спирт), wienbrand ("Burnt дарс" гэж нэрлэдэг бөгөөд Hugo Asbach, Rudesheim, Герман-ийн зохион бүтээсэн усан үзмийн брэнди,<sup>90</sup> cachaca (чихрийн нишингийн исгэсэн шүүснээс нэрсэн Бразил ликер),<sup>91</sup> tequila, виски, цагаан архи<sup>86, 91, 92</sup> хамаарна.

#### 14.2.7 Анхилуун үнэртэй спиртлэг ундаа (шар айраг, дарс ба сэрүүцүүлэгч спиртлэг ундаа, спиртлэг багатай сэрүүцүүлэгч ундаа):

Стандартчилагдаагүй бүхий л спиртлэг ундаа хамаарна. Эдгээр бүтээгдэхүүний ихэнх нь 15 %-иас бага спирт агуулах боловч зарим уламжлалт бүтээгдэхүүн 24 %-иас их спирт агуулж болно. Тухайлбал: анхилуун үнэрт дарс, алим болон лийрийн дарс; aperitif дарс; americano; batidas (cachaca, жимсний шүүс, эсвэл наргил модны самрын сүүгээр хийсэн ундаа, зарим тохиолдолд элсэн чихэртэй өтгөрүүлсэн сүү ашигладаг);<sup>90</sup> гашуун сода, гашуун vino; clarea (мөн clary эсвэл clary гэж болно; зөгийн бал, цагаан дарс ба халуун ногооны холимог; энэ нь улаан дарсаар хийдэг hipposcras-ийн төрөлтэй төстэй); jurubeba спиртлэг ундаа (Хойд Бразил болон Өмнөд Америкийн бусад хэсэгт ургадаг *Solanum paniculatum* ургамлаар хийдэг спиртлэг ундаа); negus (портвейн, элсэн чихэр, нимбэг болон халуун ногоо бүхий халуун ундаа буюу сангрия); sod, soft, and sodet; vermouthe; zurra (Өмнөд Испанид тоор эсвэл нектараар хийдэг сангрия; халуун ба хүйтэн дарс, элсэн чихэр, нимбэг, амтат жүрж эсвэл халуун ногоогоор бэлтгэдэг халуун амтат дарсны Испани нэршил); amazake (цагаан будааг *A.oryzae* мөөгөнцрөөр исгэж бэлтгэсэн, чихэрлэг амттай, спирт багатай (1 %-аас бага спирттэй) ундаа; mirin (*shoochuu* (спиртлэг ундаа), цагаан будаа болон *A.oryzae*-н холимгоор бэлтгэдэг чихэрлэг амттай, спиртлэг (<10% спирттэй) ундаа); "malternatives," болон шууд хэрэглэхэд бэлэн коктейл (ликёр, дарс, охь, жимс болон ургамлын хандны холимог бөгөөд шууд ууж хэрэглэхэд бэлэн байдлаар худалддаг) хамаарна. Сэрүүцүүлэгч төрлийн ундаа нь шар айраг, соёолжны ундаа, дарс эсвэл спиртлэг ундаа, жимсний шүүс ба сода ус (хийжүүлсэн бол) зэргээс бүрдэнэ.<sup>86, 91, 93</sup>

#### 15.0 Амтат бэлэн зууш:

<sup>89</sup> The Wordsworth Dictionary of Drink, N. Halley, Wordsworth Ltd., Hertfordshire, England, 1996.

Insight Guide: Rio de Janeiro, APA Publications, GmbH & Co., Verlag KG, Singapore, 2000, p. 241.

<sup>90</sup> Insight Guide: Rio de Janeiro, APA Publications, GmbH & Co., Verlag KG, Singapore, 2000, p. 241.

<sup>91</sup> OIV Lexique de la Vigne.

<sup>92</sup> Glossary of Portuguese Terms at: [www.bar-do-binho.com/help.htm](http://www.bar-do-binho.com/help.htm) -ийг үз.

<sup>93</sup> Alexis Lichinne's *New Encyclopedia of Wine and Spirits*, 3rd Ed. See also: [rain-tree.com/jurubeba.htm](http://rain-tree.com/jurubeba.htm), [www.florilegium.org/files/BEVERAGES/Clarea-d-Agua-art.html](http://www.florilegium.org/files/BEVERAGES/Clarea-d-Agua-art.html), and [wine.about.com/food/wine/library/types/bl\\_sangria.htm](http://wine.about.com/food/wine/library/types/bl_sangria.htm).

## **MNS CAC 192 : 2015**

Бүх төрлийн амтат хөнгөн зууш.

### 15.1 Хөнгөн зууш-төмс, үр тариа, гурил, цардуулд суурилсан (үндэст, булцуут, бүүрцагт ургамлын):

Чихэрлэг бус энгийн крекер (07.1.2 ангилал)-ээс бусад амт оруулагчтай эсвэл оруулагчгүй бүх төрлийн амтат хөнгөн зууш. Тухайлбал: төмсний чипс, попкорн, мушгиж сүлжиж хэвлэсэн жижиг талх (pretzel), цагаан будааны крекер (senbei), өвөрмөц амтат крекер (жишээ нь: бяслагаар амталсан крекер), bhujia (namkeen, гурил, эрдэнэшиш, төмс, давс, хатаасан жимс, газрын самар, халуун ногоо, хүнсний будаг, амт оруулагч болон антиоксидантын хольцоор хийсэн), parads (дэвтээсэн цагаан будааны гурил эсвэл хар шош (black gram, Энэтхэгт ургадаг), cowpea шошны гурилыг давс, халуун ногоотой хольж бөөрөнхий, хавтгай хэлбэрт оруулж бэлтгэсэн бүтээгдэхүүн) хамаарна.

### 15.2 Боловсруулсан самар, бүрмэл буюу өнгөлсөн самар, самрын холимог (жишээ нь: хатаасан жимстэй):

Хальстай эсвэл хальсгүйгээр нь хатааж шарах, шарах, цууны хүчилд дарах, чанах зэргээр боловсруулсан, давсалсан эсвэл давслаагүй бүтэн самрын бүх төрөл. Йогурт, залаат үр тариа, зөгийн балаар бүрсэн самар, хатаасан жимс-самар-залаат үр тарианы зууш (trail хольц) энд хамаарна. Шоколадаар бүрсэн самар 05.1.4, харин шоколад орлуулагчаар бүрсэн самар 05.1.5 ангилалд тус тус хамаарна.

### 15.3 Хөнгөн зууш-загасанд суурилсан:

Загас, загасан бүтээгдэхүүн эсвэл загасны амт оруулагчтай крекер хамаарна. Хөнгөн зууш байдлаар хэрэглэж болох *per se* хатаасан загасыг хүнсний 09.2.5 ангилалд, хатаасан махан зуушийг (ж-нь: үхрийн амталж хатаасан мах, махны концентрат) 08.3.1.2 ангилалд хамруулна.

### 16.0 Бэлэн болгосон хүнс:

Хүнсний бусад ангилалд (01-15) хамаарахгүй энэ ангиллын бүтээгдэхүүнийг тохиолдол бүрт өөр өөр авч үзэх хэрэгтэй. Олон бүрэлдэхүүнтэй (ж-нь: мах, сүмс, үр тариа, бяслаг, хүнсний ногоо) хольцыг бэлэн болгосон хүнс гэнэ. Бүрэлдэхүүн хэсгүүд нь хүнсний бусад ангилалд хамаарна. Хэрэглэгчид бэлэн болгосон хүнсэнд харьцангуй бага боловсруулалт (халаах, гэсгээх, дэвтээх) хийж хэрэглэдэг.

Энэ ангиллын хүнсэнд нэмэлтийг зөвхөн шаардлагатай тохиолдолд хэрэглэнэ. Үүнд:

(i) худалдаанд бэлэн хэлбэрээр гаргаж буй хүнсийг бэлтгэх технологийн ажилбарт хэрэгтэй бол; эсвэл

(ii) хэрэглээний түвшинд буюу бүрэлдэхүүн тус бүрээс нийлүүлж буй нэмэлт нь бүтээгдэхүүнд агуулагдах нийт нэмэлтийн хэрэглээний түвшингээс хэтэрсэн үед технологийн ажиллагаанд зайлшгүй шаардлагатай тохиолдолд.

## С Хавсралт

## Кодексын стандартад хамрагдсан хүнсний жагсаалт

## ( Хүнсний Нэмэлтийн Ерөнхий Стандартад заасан хүнсний ангиллаар)

## Стандартын дугаараар эрэмбэлсэн С хавсралт

Стандартын дугаар	Стандартын нэр	Хүнсний ангилал
003-1981	Нөөшилсөн яргай (хулд) загас	09.4
012-1981	Зөгийн бал	11.5
013-1981	Нөөшилсөн лооль	04.2.2.4
017-1981	Нөөшилсөн алимны нухаш	04.1.2.4
019-1981	Бусад стандартад ороогүй хүнсний амьтны ба ургамлын тос (Ерөнхий стандарт)	02.1
033-1981	Цэвэр ба цэвэршүүлсэн чидун жимсний тос, цэвэршүүлсэн, чидун, жимсний шахдасны тос, чидун жимсний тос болон чидун жимсний шахдасны тос	02.1.2
036-1981	Түргэн хөлдөөсөн Фин загас, дотрыг нь цэвэрлэсэн ба цэвэрлээгүй	09.2.1
037-1981	Лаазалсан сам хорхой ба том сам хорхой	09.4
038-1981	Хүнсний мөөг, мөөгөн бүтээгдэхүүн (бэлдмэл, хатаасан бэлдмэл эсвэл ханд)	04.2.2.6
038-1981	Хүнсний мөөг, мөөгөн бүтээгдэхүүн (хүнсний мөөг)	04.2.1.1
038-1981	Хүнсний мөөг, мөөгөн бүтээгдэхүүн (исгэж нөөшилсөн)	04.2.2.7
038-1981	Хүнсний мөөг, мөөгөн бүтээгдэхүүн (мөөгөн бүтээгдэхүүн)	04.2.2
038-1981	Хүнсний мөөг, мөөгөн бүтээгдэхүүн (хөлдөөж хатаасан нунтаг болон үйрмэг байдалтай мөөг)	04.2.2.2
038-1981	Хүнсний мөөг, мөөгөн бүтээгдэхүүн (түргэн хөлдөөсөн)	04.2.2.1
038-1981	Хүнсний мөөг, мөөгөн бүтээгдэхүүн (давсалсан, цагаан цуу эсвэл ургамлын тосонд дарсан)	04.2.2.3
038-1981	Хүнсний мөөг, мөөгөн бүтээгдэхүүн (ариутгасан)	04.2.2.4
039-1981	Хатаасан хүнсний мөөг	04.2.2.2
040R-1981	Шинэ мөөг. "Chanterelle" (бүс нутгийн стандарт)	04.2.1.1
041-1981	Түргэн хөлдөөсөн вандуй	04.2.2.1
042-1981	Нөөшилсөн ханборгоцой	04.1.2.4
052-1981	Түргэн хөлдөөсөн гүзээлзгэнэ	04.1.2.1
053-1981	Натрийн агууламж багатай сувиллын хүнсний бүтээгдэхүүн, давс орлуулагчийг оруулаад (давс орлуулагч)	12.1.2
053-1981	Натрийн агууламж багатай сувиллын хүнсний бүтээгдэхүүн, давс орлуулагчийг оруулаад	13.0
057-1981	Боловсруулсан лоолийн концентрат (лаазалсан өтгөн нухаш)	04.2.2.4
057-1981	Боловсруулсан лоолийн концентрат (шингэн нухаш-пюре)	04.2.2.5
057-1981	Боловсруулсан лоолийн концентрат (өтгөн нухаш-паста)	04.2.2.6
060-1981	Нөөшилсөн бөөрөлзгөнө	04.1.2.4
062-1987	Нөөшилсөн гүзээлзгэнэ	04.1.2.4
066-1981	Хүнсний зориулалтаар боловсруулж савласан чидун жимс	04.2.2.3
067-1981	Үзэм	04.1.2.2
069-1981	Түргэн хөлдөөсөн бөөрөлзгөнө	04.1.2.1
070-1981	Ус ба тостой лаазалсан туна болон пеламида загас	09.4
072-1981	Нярайн тэжээл, нярайд зориулсан сувиллын тусгай зориулалтын тэжээл (нярайн тэжээл)	13.1.1
072-1981	Нярайн тэжээл, нярайд зориулсан сувиллын тусгай зориулалтын тэжээл (нярайд зориулсан сувиллын тусгай зориулалтын тэжээл)	13.1.3
073-1981	Нярайн нөөш хүнс	13.2
074-1981	Нярай хүүхэд ба хүүхдэд зориулсан боловсруулсан үр тарианд суурилсан тэжээл	13.2
075-1981	Түргэн хөлдөөсөн тоор	04.1.2.1
076-1981	Түргэн хөлдөөсөн аньс	04.1.2.1
077-1981	Түргэн хөлдөөсөн бууцай	04.2.2.1
078-1981	Нөөшилсөн жимсний коктейль	04.1.2.4



## MNS CAC 192 : 2015

086-1981	Какао цөцгийн тос	05.1.3
087-2003	Шоколад, шоколадан бүтээгдэхүүн	05.1.4
088-1981	Үхрийн давсалж, нөөшилсөн мах	08.3.2
089-1981	Зуушны мах	08.3.2
090-1981	Нөөшилсөн хавчны мах	09.4
092-1981	Түргэн хөлдөөсөн сам хорхой ба том сам хорхой	09.2.1
094-1981	Сардин ба сардины төрлийн загасны лаазалсан бүтээгдэхүүн	09.4
095-1981	Түргэн хөлдөөсөн хавч (том хавч)	09.2.1
096-1981	Гахайн давсалж чанасан гуя	08.2.2
097-1981	Гахайн давсалж чанасан хаа	08.2.2
098-1981	Давсалж чанасан махан таташ	08.3.2
099-1981	Халуун орны жимсний нөөшилсөн салат	04.1.2.4
103-1981	Түргэн хөлдөөсөн нэрс	04.1.2.1
105-1981	Нунтаг какао, какао ба элсэн чихрийн холимог	05.1.1
108-1981	Байгалийн цэвэр ус	14.1.1.1
110-1981	Түргэн хөлдөөсөн броколь байцаа	04.2.2.1
111-1981	Түргэн хөлдөөсөн цэцэгт байцаа	04.2.2.1
112-1981	Түргэн хөлдөөсөн Брюссель байцаа	04.2.2.1
113-1981	Түргэн хөлдөөсөн ногоон, цайвар шар шош	04.2.2.1
114-1981	Түргэн хөлдөөсөн Франц шарсан төмс	04.2.2.1
115-1981	Дарсан өргөст хэмх (өргөст хэмхийн дармал)	04.2.2.3
117-1981	Шөл ба тунгалаг шөл	12.5
118-1981	Цавуулгийн харшилтай хүнд зориулсан сувиллын тусгай хүнс	13.3
119-1981	Нөөшилсөн Фин загас	09.4
130-1981	Чангаанз (хатаасан гүйлс)	04.1.2.2
131-1981	Хальслаагүй хясаа самар	04.2.1.1
141-1983	Какао, какао масс, шингэн шоколад, какао бялуу	05.1.1
143-1985	Финик жимс (Далдуу модны өнгөлсөн жимс)	04.1.1.2
143-1985	Финик жимс (Далдуу модны шинэ жимс)	04.1.1.1
145-1985	Нөөшилсөн туулайн бөөр ба нөөшилсөн туулайн бөөрийн шингэн нухаш	04.2.2.4
150-1985	Хүнсний давс	12.1.1
151-1985	Гари буюу цагаан гаа	04.2.2.7
152-1985	Буудайн гурил	06.2.1
153-1985	Эрдэнэшиш	06.1
154-1985	Бүхэл эрдэнэшишийн хүнс	06.2.1
155-1985	Үр хөврөлийг ялгасан эрдэнэшишийн хүнс ба эрдэнэшишийн үйрмэг	06.2.1
156-1987	Нэмэлт тэжээл	13.1.2
160-1987	Манго чатни	04.1.2.6
163-1987	Буудайн уургийн бүтээгдэхүүн, цавуулгийг оруулаад	12.10
165-1989	Хэвлэж түргэн хөлдөөсөн загасны ясгүй мах, загасны махан таташ, загасны ясгүй мах ба загасны махан таташны холимог	09.2.1
166-1989	Түргэн хөлдөөсөн загасан шагшуурга /хуруу хэлбэрийн/, загасны хэрчим, загасны гол мах – Үйрмэг талх ба шингэн зуурмагаар бүрсэн	09.2.2
167-1989	Давсалсан болон давсалж хатаасан Гадидай төрлийн загас	09.2.5
169-1989	Бүхэл болон хальсалсан бог тариа	06.1
170-1989	Бог будааны гурил	06.2.1
171-1989	Зарим зүйлийн буурцагт ургамал	04.2.1.1
172-1989	Сорго	06.1
173-1989	Соргоны гурил	06.2.1
174-1989	Ургамлын гаралтай уурагт бүтээгдэхүүн	12.10
175-1989	Шар буурцгийн уургийн бүтээгдэхүүн	12.9.1.3
176-1989	Хүнсний Cassava ургамлын гурил	06.2.1
177-1991	Жижиглэн хатаасан наргил модны самар	04.1.2.2
178-1991	Хатуу буудайн хүүхдийн будаа, хатуу буудайн гурил	06.2.1
181-1991	Биеийн жин зохицуулах үйлчилгээтэй хүнсний бэлдмэл	13.4
182-1993	Хан боргоцой	04.1.1.1
183-1993	Папаяя	04.1.1.1
184-1993	Манго	04.1.1.1

185-1993	Норал-мексикийн кактус	04.2.1.1
186-1993	Өргөст лийр ( <i>Prickly pear</i> )	04.2.1.1
187-1993	Карамбола жимс ( <i>Carambola</i> )	04.1.1.1
188-1993	Нялх эрдэнэ шиш	04.2.1.1
189-1993	Аварга загасны сэвээний хатаамал	09.2.5
190-1995	Загасны түргэн хөлдөөсөн цул мах	09.2.1
191-1995	Түргэн хөлдөөсөн түүхий кальмар	09.2.1
196-1995	Litchi-личи жимс	04.1.1.1
197-1995	Авокадо	04.2.1.1
198-1995	Тутрага	06.1
199-1995	Буудай ба хатуу буудай	06.1
200-1995	Газрын самар	04.2.1.1
201-1995	Хошуу тариа	06.1
202-1995	Кус-кус-Хойд Африкийн хатуу буудайн хүүхдийн будаагаар хийсэн хүнс	06.1
203-1995	Тураах үйлчилгээтэй маш бага илчлэгтэй хүнсний бэлдмэл	13.4
204-1997	Mangosteens-халуун орны чихэрлэг жимс	04.1.1.1
205-1997	Гадил	04.1.1.1
207-1999	Хатаамал /хуурай/ сүү ба цөцгий	01.5.1
210-1999	Нэрлэсэн ургамлын тос	02.1.2
211-1999	Амьтны гаралтай өөх тос	02.1.3
212-1999	Элсэн чихэр (глюкозын сироп, хуурай глюкоз, чийгийн агууламж ихтэй цагаан болон бор элсэн чихэр, нишингийн түүхий элсэн чихэр)	11.1.3
212-1999	Элсэн чихэр (лактоз)	11.1.4
212-1999	Элсэн чихэр (тарималжуулсан болон тээрэмдсэн цагаан элсэн чихэр)	11.1.5
212-1999	Элсэн чихэр (элсэн чихрийн болон декстрозын нунтаг)	11.1.2
212-1999	Элсэн чихэр (цагаан элсэн чихэр, хуурай декстроз, декстрозын моногидрат, фруктоз)	11.1.1
213-1999	Limes- нэг зүйл нимбэг	04.1.1.1
214-1999	Pumelos ( <i>Citrus grand</i> ) Цитрусын төрлийн жимс	04.1.1.1
215-1999	Гуава-халуун орны цайвар шар өнгөтэй жимс	04.1.1.1
216-1999	Chayotes- гуаны төрлийн халуун орны жимс	04.1.1.1
217-1999	Mexican Limes-нэг зүйл нимбэг	04.1.1.1
218-1999	Цагаан гаа	04.2.1.1
219-1999	Грейпфрут ( <i>Citrus paradisi</i> )	04.1.1.1
220-1999	Longans-Өмнөд Азиас гаралтай жимс	04.1.1.1
221-2001	Бяслаг (шинэ бяслаг, боловсроогүй бяслаг зэрэг)	01.6.1
222-2001	Далай ба цэнгэг усны загас, хавч хэлбэртэн болон нальхан хорхойн крекер	09.2.5
223-2001	Кимчи	04.2.2.7
224-2001	Tannia- халуун орны жимс	04.2.1.1
225-2001	Хэрээ нүдэн (аспарагус)	04.2.1.1
226-2001	Тошлой	04.1.1.1
227-2001	Шилэнд савласан ундны ус (байгалийн эрдэсжүүлсэн ус буюу рашаанаас бусад)	14.1.1.2
236-2003	Чанаж, давсалж хатаасан далайн жараахай	09.2.5
237-2003	Pitahaya кактус төрлийн жимс	04.1.1.1
238-2003	Чихэрлэг Cassava	04.2.1.1
240-2003	Кокосын шингэн бүтээгдэхүүн (кокосын сүү болон цөцгий)	04.1.2.8
241-2003	Нөөшилсөн хулсны нахиа	04.2.2.4
242-2003	Нөөшилсөн яст жимс	04.1.2.4
243-2003	Исгэлэн сүүн бүтээгдэхүүн (амтлаг)	01.7
243-2003	Исгэлэн сүүн бүтээгдэхүүн (ердийн)	01.2.1
243-2003	Исгэлэн сүүн бүтээгдэхүүн (дулаанаар боловсруулсан, ердийн)	01.2.1.2
243-2003	Исгэлэн сүүн бүтээгдэхүүн (дулаанаар боловсруулаагүй, ердийн)	01.2.1.1
243-2003	Исгэлэн сүүн бүтээгдэхүүн (исгэсэн сүүнд суурилсан ундаа, ердийн эсвэл амт оруулсан, дулаанаар боловсруулсан эсвэл боловсруулаагүй)	01.1.2
244-2004	Давсалсан Атлантын май загас ба давсалсан шпрот	09.2.5
245-2004	Бэрсүүт жүрж	04.1.1.1

## MNS CAC 192 : 2015

246-2005	Rambutan жимс	04.1.1.1
247-2005	Жимсний шүүс ба нектар (жимсний шүүс)	14.1.2.1
247-2005	Жимсний шүүс ба нектар (жимсний өтгөрүүлсэн шүүс)	14.1.2.3
247-2005	Жимсний шүүс ба нектар (жимсний нектар)	14.1.3.1
247-2005	Жимсний шүүс ба нектарууд (жимсний өтгөрүүлсэн нектар)	14.1.3.3
249-2006	Бэлэн гоймон	06.4.3
250-2006	Өтгөрүүлсэн тослог багатай сүү болон ургамлын тосны холимог	01.3.2
251-2006	Өтгөрүүлсэн чихэртэй сүү болон ургамлын тосны холимог, нунтаг	01.3.2
252-2006	Өтгөрүүлсэн чихэртэй сүү ба ургамлын тосны холимог	01.3.2
253-2006	Сүүний тосон түрхлэг (масло)	02.2.2
254-2007	Лаазалсан цитрусын жимс	04.1.2.4
255-2007	Шууд хэрэглэх усан үзэм	04.1.1.1
256-2007	Өөхөн түрхлэг ба холимог түрхлэг	02.2.2
257R-2007	Техенатай (Гүнжидийн үрнээс гаргаж авсан бүтээгдэхүүн) хольсон чик буурцаг (бүс нутгийн стандарт)	04.2.2.4
258R-2007	Лаазалсан фава буурцаг (бүс нутгийн стандарт)	04.2.2.4
259R-2007	Техена (бүс нутгийн стандарт)	04.2.2.6
260-2007	Дарсан жимс ба ногоо (дарсан жимс)	04.1.2.3
260-2007	Дарсан жимс ба ногоо (исгэсэн жимс)	04.1.2.10
260-2007	Дарсан жимс ба ногоо (дарсан ногоо)	04.2.2.3
260-2007	Дарсан жимс ба ногоо (исгэсэн ногоо)	04.2.2.7
262-2007	Моцарелла бяслаг	01.6.1
263-1966	Чеддар бяслаг	01.6.2.1
264-1996	Данбо	01.6.2.1
265-1966	Эдам бяслаг	01.6.2.1
266-1966	Гауда бяслаг	01.6.2.1
267-1966	Гаварти бяслаг	01.6.2.1
268-1966	Самсю бяслаг	01.6.2.1
269-1967	Эмментааль бяслаг	01.6.2.1
270-1968	Тилситер бяслаг	01.6.2.1
271-1968	Гэгээн–Павел бяслаг	01.6.2.1
272-1968	Проволоне бяслаг	01.6.2.1
273-1968	Коттеж бяслаг	01.6.1
274-1969	Коломиерс бяслаг	01.6.2.1
275-1973	Цөцгийтэй бяслаг (Rahmfrischkдse)	01.6.1
276-1973	Камемберт бяслаг	01.6.2.1
277-1973	Бри бяслаг	01.6.2.1
278-1978	Дээд зэргийн хатуу, үрмэл бяслаг	01.6.2.1
279-1971	Цөцгийн тос	02.2.1
280-1973	Тослог сүүн бүтээгдэхүүн	02.1.1
281-1971	Өтгөрүүлсэн сүү	01.3.1
282-1971	Өтгөрүүлсэн чихэртэй сүү	01.3.1
283-1978	Бяслаг (хатуу, хөгцтэй хатуу)	01.6.2.1
283-1978	Бяслаг (шинэ бяслаг, зөөлөн)–CodexStan 221-2001-аас үзэх	01.6.1
284-1971	Шарсүүний бяслаг (шар сүүний бяслаг)	01.6.3
284-1971	Шар сүүний бяслаг (шар сүүний уургаар хийсэн бяслаг)	01.6.6
288-1976	Цөцгий ба боловсруулсан цөцгий (зөөхий, исгэлэн цөцгий)	01.4.3
288-1976	Цөцгий ба боловсруулсан цөцгий (сэргээсэн цөцгий, холимог цөцгий, дахин савласан шингэн цөцгий)	01.4.1
288-1976	Цөцгий ба боловсруулсан цөцгий (хөөсрүүлсэн цөцгий, өндөр даралтаар савлаж хөөсрүүлсэн цөцгий)	01.4.2
289-1995	Хатаасан шар сүү	01.8.2
290-1995	Хүнсний казеин	01.5.1
291-2010	Хилэм загасны түрс	09.3.3
292-2008	Түүхий ба амьд хоёр хавтаст хясаа (түүхий, хөлдөөсөн)	09.1.2
292-2008	Түүхий ба амьд хоёр хавтаст хясаа (түүхий, халуун ногоотой хясаа)	09.1.2
292-2008	Түүхий ба амьд хоёр талт хясаа бүхий нялцгай биетэн (түүхий, хөлдөөсөн)	09.2.1
293-2008	Улаан лооль	04.2.1.1

294R-2009	Гүчүжан (бүс нутгийн стандарт)	04.2.2.7
296-2009	Жимсний джем, цэлцэгнүүр ба бүржмэл	04.1.2.5
297-2009	Лаазалсан ногооны холимог	04.2.2.4
298R-2009	Исгэсэн шар буурцгийн өтгөн нухаш (бүс нутгийн стандарт)	12.9.1
299-2010	Алим	04.1.1.1
300-2010	Гашуун cassava	04.2.1.1
301R-2011	Хүнсний саго гурил (бүс нутгийн стандарт)	06.2.1
302-2011	Загасны сүмс	12.6.4
303-2011	Tree Tomatoes- өндөг хэлбэртэй жимсний төрлийн ургамал	04.2.1.1
304R-2011	Кулантро Цеоте (Culantro Coyote) (бүс нутгийн стандарт) (урт кориандер)	04.2.1.1
305R-2011	Лукума (Lucuma) (бүс нутгийн стандарт) (Перу Улсад өндөр уулын бүсэд ургадаг жимс)	04.1.1.1
306R-2011	Чили сүмс (бүс нутгийн стандарт)	12.6.2
307-2011	Чили чинжүү	04.2.1.1
308R-2011	Харисса (Harissa) (бүс нутгийн стандарт) (Тунис үндэсний улаан чинжүүний нухаш)	04.2.2.6
309R-2011	Техена халва (бүс нутгийн стандарт)	05.2.2
310-2013	Анар	04.2.1.1
311-2013	Утсан загас, утлаганы амт оруулсан загас, ба утаж хатаасан загас	09.2.5
312-2013	Тэнгисийн амьд хясаа ба шууд хэрэглэхээр эсвэл цаашид боловсруулахаар хөргөсөн буюу хөлдөөсөн тэнгисийн түүхий хясаа (хөлдөөсөн)	09.1.2
315-2014	Шинэ болон түргэн хөлдөөсөн хавтаст дун	09.2.1
313R-2013	Темпе (бүс нутгийн стандарт)	06.8.6
314R-2013	Финик жимсний өтгөн нухаш (бүс нутгийн стандарт)	04.1.2.8
315-2014	Шинэ болон түргэн хөлдөөсөн хавтаст дун	09.1.2
315-2014	Шинэ ба түргэн хөлдөөсөн түүхий хясаан бүтээгдэхүүн (хөлдөөсөн)	09.2.1
316-2014	Passion жимс	04.1.1.1
317-2014	Дуриан	04.1.1.1
318-2014	Окра	04.1.1.1
319-2015	Лаазалсан жимсний холимог	04.1.2.4
320-2015	Түргэн хөлдөөсөн хүнсний ногоо	04.2.2.1
321-2015	Хүн орхоодойтой бүтээгдэхүүн (хатаамал хүн орхоодой, уураар хатаасан хүн орхоодой, хүн орхоодойн нунтаг ханд, уураар хандалсан хүн орхоодойн нунтаг)	04.2.2.2
321-2015	Хүн орхоодойтой бүтээгдэхүүн (хүн орхоодойн ханд, уураар хандалсан хүн орхоодой)	04.2.2.6

## С Хавсралт – Кодексийн стандартын нэрээр эрэмбэлсэн жагсаалт

(Англи хэлний цагаан толгойн үсгийн дарааллаар)

Стандартын дугаар	Стандартын нэрээр (Англи)	Стандартын нэр (Монгол)	Хүнсний ангилал
299-2010	Apples	Алим	04.1.1.1
240-2003	Aqueous Coconut Products (coconut milk and coconut cream)	Кокосын шингэн бүтээгдэхүүн (кокосын сүү болон цөцгий)	04.1.2.8
225-2001	Asparagus	Хэрээ нүдэн (аспарагус)	04.2.1.1
197-1995	Avocado	Авокадо	04.2.1.1
188-1993	Baby corn	Нялх эрдэнэ шиш	04.2.1.1
205-1997	Bananas	Гадил жимс	04.1.1.1
300-2010	Bitter cassava	Гашуун кассава (өвлийн амтат гуа)	04.2.1.1
250-2006	Blend of Evaporated Skimmed Milk and Vegetable Fat	Өтгөрүүлсэн тос багатай сүү болон ургамлын тосны холимог	01.3.2
251-2006	Blend of Skimmed Milk and Vegetable Fat in Powdered Form	Өтгөрүүлсэн чихэртэй сүү болон ургамлын тосны холимог, нунтаг хэлбэртэй	01.3.2
252-2006	Blend of Sweetened Condensed Milk and Vegetable Fat	Өтгөрүүлсэн чихэртэй сүү ба ургамлын тосны холимог	01.3.2
236-2003	Boiled Dried Salted Anchovies	Чанаж, давсалж хатаасан далайн жараахай	09.2.5
227-2001	Bottled/Packaged Drinking Waters (other than natural mineral water)	Шилэнд савласан ундны ус (байгалийн эрдэсжүүлсэн ус буюу рашаанаас бусад)	14.1.1.2
117-1981	Bouillon and Consommés	Шөл ба тунгалаг шөл	12.5
277-1973	Brie	Бри бяслаг	01.6.2.1
279-1971	Butter	Цөцгийн тос	02.2.1
276-1973	Camembert	Камемберт бяслаг	01.6.2.1
017-1981	Canned Applesauce	Нөөшилсөн алимны сүмс	04.1.2.4
013-1981	Canned Baby Foods	Нөөшилсөн улаан лооль	04.2.2.4
241-2003	Canned Bamboo Shoots	Нөөшилсөн хулсны нахиа	04.2.2.4
145-1985	Canned Chestnuts and Canned Chestnut Puree	Нөөшилсөн туулайн бөөр ба нөөшилсөн туулайн бөөрийн нухаш	04.2.2.4
088-1981	Canned Corned Beef	Үхрийн давсалсан мах	08.3.2
090-1981	Canned Crab Meat	Нөөшилсөн хавчны мах	09.4
119-1981	Canned Finfish	Нөөшилсөн Фин загас	09.4
258R-2007	Canned Foul Medames (Regional Standard)	Лаазалсан фава буурцаг (бүс нутгийн стандарт)	04.2.2.4
078-1981	Canned Fruit Cocktail	Нөөшилсөн жимсний коктейль	04.1.2.4
257R-2007	Canned Humus with Tehena (Regional Standard)	Техенатай (Гүнжидийн үрнээс гаргаж авсан бүтээгдэхүүн) хольсон чик буурцаг (бүс нутгийн стандарт)	04.2.2.4
042-1981	Canned Pineapple	Нөөшилсөн хан боргоцой	04.1.2.4
060-1981	Canned Raspberries	Нөөшилсөн бөөрөлзгөнө	04.1.2.4
003-1981	Canned Salmon	Нөөшилсөн яргай (хулд) загас	09.4
094-1981	Canned Sardines and Sardine-Type Products Canned Shrimps or Prawns	Сардин ба сардины төрлийн загасны лаазалсан бүтээгдэхүүн	09.4
037-1981	Canned Shrimps or Prawns	Лаазалсан сам хорхой ба том сам хорхой	09.4
242-2003	Canned Stone Fruits	Нөөшилсөн ястай жимс	04.1.2.4

062-1987	Canned Strawberries	Нөөшилсөн гүзээлзгэнэ	04.1.2.4
099-1981	Canned Tropical Fruit Salad	Халуун орны жимсний (тропик) нөөшилсөн салат	04.1.2.4
070-1981	Canned Tuna and Bonito	Ус ба тостой лаазалсан туна болон пеламида загас	09.4
226-2001	Cape Gooseberry	Тошлой	04.1.1.1
187-1993	Carambola	Карамбола жимс	04.1.1.1
254-2007	Certain Canned Citrus Fruits	Лаазалсан цитрусын жимс	04.1.2.4
319-2015	Certain Canned Fruits	Лаазалсан жимсний холимог	04.1.2.4
297-2009	Certain Canned Vegetables	Лаазалсан ногооны холимог	04.2.2.4
171-1989	Certain Pulses	Зарим зүйлийн буурцагт ургамлын үр	04.2.1.1
216-1999	Chayotes	Чаотис (Chayotes)	04.1.1.1
263-1966	Cheddar	Чеддар бяслаг	01.6.2.1
283-1978	Cheese (ripened, including mould ripened)	Бяслаг (хатуу, хөгцтэй хатуу)	01.6.2.1
283-1978	Cheese (unripened, including fresh cheese) – See also CODEX STAN 221-2001	Бяслаг (шинэ бяслаг, зөөлөн)-CodexStan 221-2001-аасүзэх	01.6.1
208-1999	Cheeses in Brine	Бяслаг, давсны уусмалд сойсон	01.6.2.1
307-2011	Chilli Peppers	Улаан чинжүү	04.2.1.1
306R-2011	Chilli Sauce (Regional Standard)	Улаан чинжүүний сүмс (бүс нутгийн стандарт)	12.6.2
087-2003	Chocolate and Chocolate Products	Шоколад болон шоколадан бүтээгдэхүүн	05.1.4
141-1983	Cocoa (Cacao) Mass (Cocoa/Chocolate Liquor) and Cocoa Cake	Какаоны холимог (нунтаг), нарийн боовны зориулалттай шахмал какао	05.1.1
086-1981	Cocoa Butters	Какаотой цөцгийн тос	05.1.3
105-1981	Cocoa Powders (Cocoa) and Dry Mixtures of Cocoa and Sugar	Нунтаг какао, какао ба элсэн чихрийн нунтаг холимог	05.1.1
098-1981	Cooked Cured Chopped Meat	Болгож нөөшилсөн жижиглэсэн мах	08.3.2
096-1981	Cooked Cured Ham	Чанаж утсан гахайн мах	08.2.2
097-1981	Cooked Cured Pork Shoulder	Болгож нөөшилсөн гахайн хааны мах	08.2.2
273-1968	Cottage Cheese	Коттеж бяслаг	01.6.1
274-1969	Coulommiers	Коломиерс бяслаг	01.6.2.1
202-1995	Couscous	Кускус	06.1
222-2001	Crackers from Marine and Freshwater Fish, Crustaceans and Molluscan Shellfish	Далай ба цэнгэг усны загас, хавч хэлбэртэн болон нальхан хорхойн крекер	09.2.5
288-1976	Cream and Prepared Creams (fermented cream, acidified cream)	Цөцгий ба боловсруулсан цөцгий (зөөхий, исгэлэн цөцгий)	01.4.3
288-1976	Cream and Prepared Creams (reconstituted cream, recombined cream, prepackaged liquid cream)	Цөцгий ба боловсруулсан цөцгий (сэргээсэн цөцгий, дахин боловсруулсан цөцгий, савласан шингэн цөцгий)	01.4.1
288-1976	Cream and Prepared Creams (whipping cream, cream packaged under pressure, whipped cream)	Цөцгий ба боловсруулсан цөцгий (хөөсрүүлсэн цөцгий, өндөр даралтаар савлаж хөөсрүүлсэн цөцгий)	01.4.2
275-1973	Cream Cheese (Rahmfrischkäse)	Цөцгийтэй бяслаг (Rahmfrischkäse)	01.6.1
304R-2011	Culantro Coyote (Regional Standard)	Кулантро Цеоте (Culantro Coyote) (бүс нутгийн стандарт) (урт кориандер)	04.2.1.1
253-2006	Dairy Fat Spreads	Сүүний тосон түрхлэг	02.2.2
264-1966	Danbo	Данбо	01.6.2.1
314R-2013	Date Paste (Regional Standard)	Нандин чавганы нухаш (бүс нутгийн стандарт)	04.1.2.8
143-1985	Dates (coated)	Финик жимс (Далдуу модны жимс) (өнгөлсөн)	04.1.1.2

**MNS CAC 192 : 2015**

143-1985	Dates (fresh)	Финик жимс (Далдуу модны жимс) (шинэ)	04.1.1.1
155-1985	Degermed Maize (Corn) Meal and Maize (Corn) Grits	Үр хөврөлгүй эрдэнэшишийн хоол хүнс ба эрдэнэшишийн бэлэн хоол (грит)	06.2.1
130-1981	Dried Apricots	Хатаамал чангаанз (гүйлс)	04.1.2.2
039-1981	Dried Edible Fungi	Хатаасан хүнсний мөөг	04.2.2.2
189-1993	Dried Shark Fins	Аварга загасны сэрвээний хатаамал	
317-2014	Durian	Дуриан	04.1.1.1
178-1991	Durum Wheat Semolina and Durum Wheat Flour	Жижиг үрийн хатуу буудай ба хатуу буудайн гурил	06.2.1
265-1966	Edam	Эдам бяслаг	01.6.2.1
290-1995	Edible Casein Products	Хүнсний казеин	01.5.1
176-1989	Edible Cassava Flour	Хүнсний "Cassava" гурил	06.2.1
019-1981	Edible Fats and Oils Not Covered by Individual Standards (General Standard)	Бусад стандартад ороогүй хүнсний өөх ба тос (Ерөнхий стандарт)	02.1
038-1981	Edible Fungi and Fungi Products (concentrate, dried concentrate or extract)	Хүнсний мөөг ба мөөгөн бүтээгдэхүүн (бэлдмэл, хатаасан бэлдмэл эсвэл ханд)	04.2.2.6
038-1981	Edible Fungi and Fungi Products (edible fungi)	Хүнсний мөөг ба мөөгөн бүтээгдэхүүн (хүнсний мөөг)	04.2.1.1
038-1981	Edible Fungi and Fungi Products (fermented)	Хүнсний мөөг ба мөөгөн бүтээгдэхүүн (исгэсэн)	04.2.2.7
038-1981	Edible Fungi and Fungi Products (fungus products)	Хүнсний мөөг ба мөөгөн бүтээгдэхүүн (мөөгөн бүтээгдэхүүн)	04.2.2
038-1981	Edible Fungi and Fungi Products (incl. freeze dried, fungus grits and fungus powder)	Хүнсний мөөг ба мөөгөн бүтээгдэхүүн (жижиглэсэн болон нунтаг байдалтай хөлдөөж хатаасан мөөг)	04.2.2.2
038-1981	Edible Fungi and Fungi Products (quick frozen)	Хүнсний мөөг ба мөөгөн бүтээгдэхүүн (түргэн хөлдөөсөн)	04.2.2.1
038-1981	Edible Fungi and Fungi Products (salted, pickled or in vegetable oil)	Хүнсний мөөг ба мөөгөн бүтээгдэхүүн (давсалсан, дарсан эсвэл Ургамлын тосонд дарсан)	04.2.2.3
038-1981	Edible Fungi and Fungi Products (sterilized)	Хүнсний мөөг ба мөөгөн бүтээгдэхүүн (ариутгасан)	04.2.2.4
301R-2011	Edible Sago Flour (Regional Standard)	Хүнсний саго гурил	06.2.1
269-1967	Emmental vaporated milks	Эмменталь бяслаг	01.6.2.1
281-1971	Evaporated milks	Өтгөрүүлсэн сүү	01.3.1
278-1978	Extra Hard Grating Cheese	Дээд заргийн хатуу, үрмэл бяслаг	01.6.2.1
256-2007	Fat Spreads and Blended Spreads	Өөхөн түрхлэг ба холимог түрхлэг	02.2.2
243-2003	Fermented milks (drinks based on fermented milk, plain or flavoured, heat treated or not heat treated)	Исгэлэн сүүн бүтээгдэхүүн (исгэсэн сүүнд суурилсан ундаа, ердийн эсвэл амт оруулсан, дулаанаар боловсруулсан эсвэл боловсруулаагүй)	01.1.2
243-2003	Fermented Milks (flavoured, heat treated and non-heat treated)	Исгэлэн сүүн бүтээгдэхүүн (амтлаг)	01.7
243-2003	Fermented Milks (plain)	Исгэлэн сүүн бүтээгдэхүүн (ердийн)	01.2.1
243-2003	Fermented Milks (plain, heat treated)	Исгэлэн сүүн бүтээгдэхүүн (дулаанаар боловсруулсан, ердийн)	01.2.1.2
243-2003	Fermented Milks (plain, non-heat treated)	Исгэлэн сүүн бүтээгдэхүүн (дулаанаар боловсруулаагүй, ердийн)	01.2.1.1
298R-2009	Fermented Soybean Paste (Regional Standard)	Исгэсэн шар буурцгийн нухаш	12.9.1
302-2011	Fish Sauce	Загасны сүмс	12.6.4
156-1987	Follow-Up Formula	Нэмэгдэл хоол тэжээл	13.1.2

150-1985	Food Grade Salt	Хүнсний давс	12.1.1
118-1981	Foods for Special Dietary Use for Persons Intolerant to Gluten	Цавуулаг иддэггүй хүнд зориулсан сувиллын тусгай хүнс	13.3
203-1995	Formula Foods for Use in Very Low Energy Diets for Weight Reduction	Биеийн жин бууруулах үйлчилгээтэй маш бага илчлэгтэй хүнсний бүтээгдэхүүн	13.4
181-1991	Formula Foods for Use in Weight Control Diets	Биеийн жин зохицуулах үйлчилгээтэй холимог бүтээгдэхүүн	13.4
315-2014	Fresh and Quick Frozen Raw Scallop Products (fresh)	Шинэ ба түргэн хөлдөөсөн түүхий хясаан бүтээгдэхүүн (шинэ)	09.1.2
315-2014	Fresh and Quick Frozen Raw Scallop Products (frozen)	Шинэ ба түргэн хөлдөөсөн түүхий хясаан бүтээгдэхүүн (хөлдөөсөн)	09.2.1
040R-1981	Fresh Fungus "Chanterelle" (Regional Standard)	Шинэ мөөг. Хантерелли (бүс нутгийн стандарт)	04.2.1.1
247-2005	Fruit Juices and Nectars (concentrates for fruit juice)	Жимсний шүүс ба нектар (жимсний өтгөрүүлсэн шүүс)	14.1.2.3
247-2005	Fruit Juices and Nectars (concentrates for fruit nectars)	Жимсний шүүс ба нектарууд (жимсний өтгөрүүлсэн нектар)	14.1.3.3
247-2005	Fruit Juices and Nectars (fruit juices)	Жимсний шүүс ба нектар (жимсний шүүс)	14.1.2.1
247-2005	Fruit Juices and Nectars (fruit nectars)	Жимсний шүүс ба нектар (жимсний нектар)	14.1.3.1
151-1985	Gari	Гари буюу цагаан гаа	04.2.2.7
218-1999	Ginger	Цагаан гаа	04.2.1.1
321-2015	Ginseng Products (Dried Ginseng, Dried Steamed Ginseng, Ginseng Extract in Powdered Form, Steamed Ginseng Extract in Powdered Form)	Хүн орхоодойтой бүтээгдэхүүн (хатаамал хүн орхоодой, уураар хатаасан хүн орхоодой, хүн орхоодойн нунтаг ханд, уураар хандалсан хүн орхоодойн нунтаг)	04.2.2.2
321-2015	Ginseng Products (Ginseng Extract, Steamed Ginseng Extract)	Хүн орхоодойтой бүтээгдэхүүн (хүн орхоодойн ханд, уураар хандалсан хүн орхоодой/ жигнэсэн хүн орхоодойн ханд)	04.2.2.6
294R-2009	Gochujang (Regional Standard)	Гүчүжан (бүс нутгийн стандарт)	04.2.2.7
266-1966	Gouda	Гауда бяслаг	01.6.2.1
219-1999	Grapefruits ( <i>Citrus paradisi</i> )	Грейпфрут ( <i>Citrus paradisi</i> )	04.1.1.1
177-1991	Grated Desiccated Coconut	Жижиглэн /хэрчиж/ усгүйжүүлсэн наргил модны самар	04.1.2.2
215-1999	Guavas	Гуава	04.1.1.1
309R-2011	Halwa Tehenia (Regional Standard)	Техена халва (бүс нутгийн стандарт)	05.2.2
308R-2011	Harissa (Regional Standard)	Харисса (Harissa) (бүс нутгийн стандарт) (Тунис үндэсний улаан чинжүүний нухаш)	04.2.2.6
267-1966	Havarti	Гаварти бяслаг	01.6.2.1
012-1981	Honey	Зөгийн бал	11.5
072-1981	Infant Formula and Formula for Special Dietary Purposes Intended for Infants (infant formula)	Нярайн тэжээл, нярайд зориулсан сувиллын тусгай зориулалтын тэжээл	13.1.1
072-1981	Infant formula and Formula for Special Dietary Purposes Intended for Infants (formula for special dietary purposes intended for infants)	Нярайн тэжээл, нярайд зориулсан сувиллын тусгай зориулалтын тэжээл (нярайд зориулсан сувиллын тусгай зориулалтын тэжээл)	13.1.3
249-2006	Instant Noodles	Бэлэн гоймон	06.4.3
296-2009	Jams, Jellies and Marmalades	Жимсний чанамал (джем), цэлцэгнүүр ба мармелад	04.1.2.5
223-2001	Kimchi	Кимчи	04.2.2.7
213-1999	Limes	Лим /нэг зүйл нимбэг/	04.1.1.1
196-1995	Litchi	Личи	04.1.1.1



## MNS CAC 192 : 2015

312-2013	Live Abalone and Raw Fresh Chilled or Frozen Abalone for Direct Consumption or for Further Processing (fresh)	Тэнгисийн амьд хясаа ба шууд хэрэглэхээр эсвэл цаашид боловсруулахаар хөргөсөн буюу хөлдөөсөн тэнгисийн түүхий хясаа (шинэ)	09.1.2
312-2013	Live Abalone and Raw Fresh Chilled or Frozen Abalone for Direct Consumption or for Further Processing (frozen)	Тэнгисийн амьд хясаа ба шууд хэрэглэхээр эсвэл цаашид боловсруулахаар хөргөсөн буюу хөлдөөсөн тэнгисийн түүхий хясаа (хөлдөөсөн)	09.2.1
220-1999	Longans	Евфории (Longans)	04.1.1.1
305R-2011	Lucuma (Regional Standard)	Лукума (Lucuma) (бүс нутгийн стандарт) (Перу Улсад өндөр уулын бүсэд ургадаг жимс)	04.1.1.1
089-1981	Luncheon Meat	Зуушны мах	08.3.2
153-1985	Maize (Corn)	Эрдэнэшиш	06.1
184-1993	Mango	Манго (амра)	04.1.1.1
160-1987	Mango Chutney	Хатаасан манго жимс	04.1.2.6
204-1997	Mangosteens	Мангуст	04.1.1.1
217-1999	Mexican Limes	Мексик лим	04.1.1.1
207-1999	Milk Powders and Cream Powders	Хатаамал /хуурай/ сүү ба цөцгий	01.5.1
280-1973	Milkfat Products	Тослог сүүн бүтээгдэхүүн	02.1.1
262-2007	Mozzarella	Моцарелла бяслаг	01.6.1
211-1999	Named Animal Fats	Амьтны гаралтай өөх тос	02.1.3
210-1999	Named Vegetable Oils	Ургамлын тос	02.1.2
108-1981	Natural Mineral Waters	Байгалийн цэвэр ус	14.1.1.1
185-1993	Nopal	Нопал	04.2.1.1
201-1995	Oats	Овьёосны үр	06.1
318-2014	Okra	Окра	0.4.2.1.1
033-1981	Olive Oil, Virgin and Refined, and Refined Olive Pomace Oil, Olive Oils and Olive Pomace Oils	Цэвэр ба цэвэршүүлсэн чидун жимсний тос, цэвэршүүлсэн чидун жимсний шахдасны тос, чидун жимсний тос болон чидун жимсний шахдасны тос	02.1.2
245-2004	Oranges	Бэрсүүт жүрж	04.1.1.1
183-1993	Papaya	Папайя	04.1.1.1
316-2014	Passion Fruit	Passion жимс	04.1.1.1
200-1995	Peanuts	Газрын самар	04.2.1.1
170-1989	Pearl Millet Flour	Бог будааны гурил	06.2.1
115-1981	Pickled Cucumbers (Cucumber Pickles)	Давсалж дарсан өргөст хэмх	04.2.2.3
260-2007	Pickled Fruits and Vegetables (fermented fruits)	Дарсан жимс ба ногоо (исгэсэн жимс)	04.1.2.10
260-2007	Pickled Fruits and Vegetables (fermented vegetables)	Дарсан жимс ба ногоо (исгэсэн ногоо)	04.2.2.7
260-2007	Pickled Fruits and Vegetables (pickled fruits)	Дарсан жимс ба ногоо (дарсан жимс)	04.1.2.3
260-2007	Pickled Fruits and Vegetables (pickled vegetables)	Дарсан жимс ба ногоо (дарсан ногоо)	04.2.2.3
182-1993	Pineapple	Хан боргоцой	04.1.1.1
237-2003	Pitahayas	Питахаус жимс	04.1.1.1
310-2013	Pomegranate	Анар	04.2.1.1
013-1981	Preserved Tomatoes	Нөөшилсөн улаан лооль	04.2.2.4
186-1993	Prickly pear	Өргөст лийр (хэдмэн)	04.2.1.1
074-1981	Processed Cereal-Based Foods for Infants and Children	Нярай хүүхэд ба хүүхдэд зориулсан үр тариагаар хийсэн хоол тэжээл	13.2

057-1981	Processed Tomato Concentrates (canned tomato paste)	Өтгөрүүлж боловсруулсан улаан лооль (лаазалсан нухаш)	04.2.2.4
057-1981	Processed Tomato Concentrates (tomato paste)	Өтгөрүүлж боловсруулсан улаан лооль (нухаш)	04.2.2.6
057-1981	Processed Tomato Concentrates (tomato puree)	Өтгөрүүлж боловсруулсан улаан лоолийн нухаш	04.2.2.5
272-1968	Provolone	Проволоне бяслаг	01.6.2.1
214-1999	Pumelos ( <i>Citrus grand</i> )	Пампельмус ( <i>Citrus grand</i> )	04.1.1.1
076-1981	Quick Frozen Bilberries	Түргэн хөлдөөсөн аньс	04.1.2.1
165-1989	Quick Frozen Blocks of Fish Fillets, Minced Fish Flesh and Mixtures of Fillets and Minced Fish Flesh	Хэвлэж түргэн хөлдөөсөн загасны ясгүй мах, загасны махан таташ, загасны ясгүй мах ба загасны махан таташны холимог	09.2.1
103-1981	Quick Frozen Blueberries	Түргэн хөлдөөсөн нэрс	04.1.2.1
110-1981	Quick Frozen Broccoli	Түргэн хөлдөөсөн цэцэгт байцаа	04.2.2.1
112-1981	Quick Frozen Brussels Sprouts	Түргэн хөлдөөсөн Брюсселийн байцаа	04.2.2.1
111-1981	Quick Frozen Cauliflower	Түргэн хөлдөөсөн өнгөт байцаа	04.2.2.1
190-1995	Quick Frozen Fish Fillets	Түргэн хөлдөөсөн загасны цул мах	09.2.1
166-1989	Quick Frozen Fish Sticks (Fish Fingers), Fish Portions and Fish Fillets – Breaded and in Batter	Түргэн хөлдөөсөн загасан шагшуурга /хуруу хэлбэрийн/, загасны хэрчим, загасны гол мах – Үйрмэг талх ба шингэн зуурмагаар бүрсэн	09.2.2
114-1981	Quick Frozen French-Fried Potatoes	Түргэн хөлдөөсөн шарсан төмс (Франц)	04.2.2.1
113-1981	Quick Frozen Green Beans and Wax Beans	Түргэн хөлдөөсөн ногоон ба давирхайлаг шош	04.2.2.1
095-1981	Quick Frozen Lobsters	Түргэн хөлдөөсөн хавч (том хавч)	09.2.1
075-1981	Quick Frozen Peaches	Түргэн хөлдөөсөн тоор	04.1.2.1
041-1981	Quick Frozen Peas	Түргэн хөлдөөсөн вандуй	04.2.2.1
069-1981	Quick Frozen Raspberries	Түргэн хөлдөөсөн бөөрөлзгөнө	04.1.2.1
191-1995	Quick Frozen Raw Squid	Түргэн хөлдөөсөн түүхий кальмар	09.2.1
092-1981	Quick Frozen Shrimps or Prawns	Түргэн хөлдөөсөн сам хорхой ба том сам хорхой	09.2.1
077-1981	Quick Frozen Spinach	Түргэн хөлдөөсөн бууцай	04.2.2.1
052-1981	Quick Frozen Strawberries	Түргэн хөлдөөсөн гүзээлзгэнэ	04.1.2.1
320-2015	Quick Frozen Vegetables	Түргэн хөлдөөсөн хүнсний ногоо	04.2.2.1
036-1981	Quick-Frozen Finfish, Uneviscerated and Eviscerated	Түргэн хөлдөөсөн Фин загас, дотрыг нь цэвэрлэсэн ба цэвэрлээгүй	09.2.1
067-1981	Raisins	Үзэм	04.1.2.2
246-2005	Rambutan	Рамбутан жимс	04.1.1.1
292-2008	Raw and Live Bivalve Molluscs (live)	Түүхий ба амьд хоёр талт хясаа бүхий нялцгай биетэн (амьд)	09.1.2
292-2008	Raw and Live Bivalve Molluscs (raw, chilled shucked)	Түүхий ба амьд хоёр талт хясаа бүхий нялцгай биетэн (түүхий, халуун ногоотой хясаа)	09.1.2
292-2008	Raw and Live Bivalve Molluscs (raw, frozen)	Түүхий ба амьд хоёр талт хясаа бүхий нялцгай биетэн (түүхий, хөлдөөсөн)	09.2.1
198-1995	Rice	Тутрага (цагаан будаа)	06.1
271-1968	Saint Paulin	Гэгээн-Павел бяслаг	01.6.2.1
244-2004	Salted Atlantic Herring and Salted Sprat	Давсалсан Атлантын май загас ба давсалсан шпрот	09.2.5
167-1989	Salted Fish and Dried Salted Fish of the Gadidae Family of Fishes	Давсалсан болон давсалж хатаасан Гадидай төрлийн загас	09.2.5
268-1966	Samsøe	Самсю бяслаг	01.6.2.1

## MNS CAC 192 : 2015

311-2013	Smoke Fish, Smoke-Flavoured Fish and Smoke-Dried Fish	Утсан загас, утлаганы амт оруулсан загас, ба утаж хатаасан загас	09.2.5
173-1989	Sorghum Flour	Соргоны гурил	06.2.1
172-1989	Sorghum Grains	Сорго	06.1
175-1989	Soy Protein Products	Шар буурцгийн уургийн бүтээгдэхүүн	06.8.8
053-1981	Special Dietary Foods with Low-Sodium Content, including salt substitutes (salt substitutes)	Натри багатай сувиллын хүнсний бүтээгдэхүүн, давс орлуулагч бүхий (давс орлуулагч)	12.1.2
053-1981	Special Dietary Foods with Low-Sodium Content, including salt substitutes (special dietary foods with low sodium content)	Натри багатай сувиллын хүнсний бүтээгдэхүүн, давс орлуулагч бүхий	13.0
291-2010	Sturgeon caviar	Хилэм загасны түрс	09.3.3
212-1999	Sugars (glucose syrup, dried glucose, soft white sugar, brown sugar, raw cane sugar)	Элсэн чихэр (глюкозын өтгөрүүлсэн шүүс, хуурай глюкоз, зөөлөн цагаан чихэр, цэвэршүүлээгүй чихэр, чихрийн нишинг)	11.1.3
212-1999	Sugars (lactose)	Элсэн чихэр (лактоза)	11.1.4
212-1999	Sugars (plantation or white mill sugar)	Элсэн чихэр (талбайн болон тээрэмдсэн элсэн чихэр)	11.1.5
212-1999	Sugars (powdered sugar and powdered dextrose)	Элсэн чихэр (сахарын пудр болон нунтаг декстроз)	11.1.2
- 4) БНХАУ-ын ЭМЯ, Үйлдвэрлэл, Мэдээллийн Технологийн Яам, Хөдөө Аж Ахуйн Яам, Худалдаа аж үйлдвэрийн удирдах газар, Чанарын хяналт, шалгалт, хорио цээрийн ерөнхий газрын 2008 оны 25 тоот мэдэгдэл
- 5) ОХУ-ын Ерөнхий эрүүл ахуйч эмчийн 2008 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 56 дугаар тогтоол

### 3 Тодорхойлолт

#### 3.1

#### меламин

цагаан өнгийн талст, азотлог нэгдэл, химийн томьёо -  $C_3H_6N_6$ , олон улсын нэршил - 1,3,5 триазин, 2,4,6 триамин

### 4 Техникийн шаардлага

Эхийн сүү орлуулагч, хүүхдийн тэжээл ба эдгээрээс бусад хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах меламины зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь дараах хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

Хүснэгт – Эхийн сүү орлуулагч, хүүхдийн тэжээл ба эхийн сүү орлуулагч, хүүхдийн тэжээлээс бусад хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах меламины зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Д/д	Бүтээгдэхүүний төрөл	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, мг/кг*
1	Эхийн сүү орлуулагч, хүүхдийн тэжээл	0,5
2	Эхийн сүү орлуулагч, хүүхдийн тэжээлээс бусад хүнсний бүтээгдэхүүн	2,0

ТАЙЛБАР: \* мг/кг нь ppm (ppm-part per million буюу 10<sup>-6</sup>)-тэй ижил

## **5 Шалгаж, хүлээн авах**

Меламины хэмжээг ферменттэй холбох дархлалын урвал (ELISA)-ын болон өндөр мэдрэмжит шингэний хроматографи (HPLC)-ийн аргаар тодорхойлно.

**ТӨГСӨВ.**

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 67.040

Хүнсний бүтээгдэхүүн дэх хүнд металлын үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	MNS 4504:2008
Maximum residue limit of heavy metals in food products	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2008 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 32 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт 2009 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

### 1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах хүнд металлын үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтооход хамаарна.

### 2 Норматив ишлэл

Энэ стандартад Монгол улсын болон олон улсын дараах стандартыг иш татсан бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас иш татаж хэрэглэнэ. Үүнд:

- 1) MNS 1-2:2006, Монгол улсын стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм
- 2) MNS CAC 4504:97, Хүнсний бүтээгдэхүүн дэх хүнд металлын зөвшөөрөгдөх хэмжээ. Техникийн шаардлага
- 3) MNS CAC 193:2007, Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандарт

### 3 Нэр томьёо, тодорхойлолт

#### 3.1

##### бохирдуулагчийн дээд түвшин

хүнсний бүтээгдэхүүнд байвал зохих бохирдуулагч бодисын дээд хэмжээ

#### 3.2

##### бохирдуулагчийн зөвлөмж түвшин

хүнсний бүтээгдэхүүнийг гадаад худалдаанд нийлүүлэхэд баримтлахаар тогтоосон хүнсэнд байх бохирдуулагч бодисын дээд хэмжээ

### 4 Ерөнхий шаардлага

#### 4.1 Нийт кадми

Олон улсын нэр: Cadmium

## MNS 4504:2008

Химийн тэмдэг: Cd

Хүний биеийн жинд 7 хоногт авч болох дундаж тун: 0,007 мг/кг  
1 дүгээр хүснэгт-Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах  
кадьмийн үлдэгдлийн хэмжээ

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, мг/кг
1	Байцааны овгийн хүнсний ногоо /байцаа, цэцэгт байцаа, хятад байцаа гэх мэт/	0,05
2	Булцуут хүнсний ногоо /сонгино, сармис/	0,05
3	Үр жимс ногоо /өргөст хэмх, улаан лооль, чинжүү, тарвас, хулуу, хүнсний мөөг гэх мэт/	0,05
4	Навчит хүнсний ногоо /хүрэн манжингийн навч, эрдэнэ шиш, шанцайн ургамал/	0,2
5	Үрт хүнсний ногоо /шош, вандуй, шар буурцаг гэх мэт/	0,1
6	Төмс	0,1
7	Вандуйн овгийн зарим хүнсний ногоо /шар буурцагнаас бусад/	0,1
8	Үндэс, ба үндэс үрт хүнсний ногоо /төмснөөс бусад/	0,1
9	Ишт болон бутархаг хүнсний ногоо /гишүүнэ гэх мэт/	0,1
10	Үр тариа /буданаас бусад/	0,1
11	Цагаан будаа	0,4
12	Улаан буудай	0,2
13	Далайн хос хавтаст нялаахай /хясаа, цацагт нялаахайнаас бусад/	2,0
14	Цефалоподууд /наймаалж, кальмар, каракатиц гэх мэт/	2,0
15	Байгалийн эрдэсжүүлсэн ус	0,003
16	Хоолны давс	0,5

1-Р ТАЙЛБАР: Кадьми нь хүний үйл ажиллагааны нөлөөгөөр агаар, ус, хөрсөнд үүсдэг ховор элемент юм. Бохирдлын гол эх үүсвэр нь кадьми агуулсан бүтээгдэхүүний хэрэглээ болон кадьми агуулсан хог хаягдал зэрэг болно. Хөрсөнд кадьмийн агуулга ихэссэнээр ургамал тэр хэмжээгээр кадьмийг өөртөө шингээх бөгөөд энэ нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээс хүн ам, хүрээлэн буй орчин кадьмийн бохирдолд өртөх явдлыг ихэсгэдэг. Далайн нялцгай биетэн, жижиг загас, мөөг нь кадьмийн байгалийн хуримтлуулагчид юм. Сээр нуруутан амьтад болон адууны бөөр, элгэнд кадьми ихээр хуримтлагддаг бөгөөд эдгээр бүтээгдэхүүнийг байнга хэрэглэснээр кадьмийн нөлөөлөлд өртөх магадлал өндөр байна.

### 4.2 Нийт мөнгөн ус

Олон улсын нэр: Меркури

Химийн тэмдэг: Hg

Хүний биеийн жинд 7 хоногт авч болох дундаж тун: 0,005 мг/кг

2 дугаар хүснэгт-Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах  
нийт мөнгөн усны үлдэгдлийн хэмжээ

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
1	Байгалийн эрдэсжүүлсэн ус	0,001 мг/л
2	Хоолны давс	0,1 мг/кг

2-Р ТАЙЛБАР: Зарим төрлийн хүнсний бүтээгдэхүүн байгаль дээр элемент мөнгөн усыг өөртөө агуулсан байдаг. Үйлдвэрийн хог хаягдал болон бусад мөнгөн усны хэрэглээний улмаас гадаад орчинд мөнгөн усны түвшин ихэсч бохирдолд өртдөг. Хуурай газрын амьтан, ургамалд метил мөнгөн ус ба нийт мөнгөн усны түвшин маш бага байдаг. Харин мөнгөн усаар бохирдсон усны загасанд метил мөнгөн усны агууламж өндөр байдаг.

### 4.3 Метил мөнгөн ус

Олон улсын нэр: Methylmercury

Химийн тэмдэг: CH<sub>3</sub>Hg

Хүний биеийн жинд 7 хоногт авч болох дундаж тун: 0,0016 мг/кг

3 дугаар хүснэгт-Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах метил мөнгөн усны үлдэгдлийн хэмжээ

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Зөвлөмж хэмжээ, мг/кг
1	Загас /махчин загаснаас бусад/	0,5
2	Махчин загас /аварга загас, цурхай, туна/	1,0

3-Р ТАЙЛБАР: Байгальд тархсан металл мөнгөн усны уур нь уусмал хэлбэрт шилжиж, борооны усаар дамжин 1-2 долоо хоногийн дараа хөрс, усанд тунадас болон бууж, улмаар нуур цөөрөм, гол мөрний усны ёроолын лаг шаварт хуримтлагдана. Энэхүү хуримтлагдсан мөнгөн ус нь усны бичил биетэн болон нэг эст амьтны биед шимэгдэн, биологийн процессийн дүнд метил мөнгөн ус болон хувирч улмаар тэдгээрээр хооллодог том загасны биед метил мөнгөн усны агууламж ихэсч, хуримтлагддаг байна. Метил мөнгөн ус агуулсан том загасыг хоол хүнсэндээ хэрэглэснээр хүн ба амьтан мөнгөн усны хордлогод өртөнө. Метил мөнгөн ус нь хоол хүнсийг чанаж боловсруулалт хийх үед устаж үгүй болдоггүй бөгөөд энэ нь хурц, архаг хордлого үүсэх нэг шалтгаан болдог. Метил мөнгөн усны агууламж их үед хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд зэрэг эрсдэл өндөртэй хүмүүс хордлогод илүү өртөнө.

### 4.4 Нийт хүнцэл

Олон улсын нэр: Arsenic

Химийн тэмдэг: As

Хүний биеийн жинд 7 хоногт авч болох дундаж тун: 0,015 мг/кг

4 дүгээр хүснэгт-Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах хүнцлийн үлдэгдлийн хэмжээ

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, мг/кг
1	Өөх тос	0,1
2	Маргарин	0,1
3	Минарин	0,1
4	Гахайн өөх	0,1
5	Чидун жимсний тос (боловсруулсан )	0,1
6	Чидун жимсний тос (боловсруулаагүй)	0,1
7	Ургамлын тос (цэвэр)	0,1
8	Ургамлын тос (хүнсний)	0,1
9	Байгалийн эрдэсжүүлсэн ус	0,01
10	Хоолны давс	0,5

4-Р ТАЙЛБАР: Хүнцэл нь байгальд эрдэс бодисын найрлаганд агуулагддаг бөгөөд галт уулын дэлбэрэлт, хад чулууны өгөршилтөөс байгальд бий болдог. Түүнчлэн пестицид, эмийн бодисын хэрэглээ, чулуун нүүрсний шаталт, хүдэр боловсруулах үйлдвэрлэл зэрэг хүний үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд ихээхэн хэмжээгээр ялгардаг. Хүнцэл хүнсэнд органик ба органик биш хэлбэрээр их хэмжээтэйгээр агуулагддаг. Ялангуяа далай тэнгисийн орчинд органик хэлбэр нь өндөр түвшрүүлэгтэйгээр агуулагддаг. Тухайлбал, далайн замаг, загас, хясаа, хавч хэлбэртэн нялцгай биетэнд нойтон жинд 50 мг/кг хүртэлх хэмжээтэйгээр хүнцэл агуулагддаг. Цэнгэг ус болон хуурай газар дээр харьцангуй бага бөгөөд үр тариа, гэрийн тэжээмэл амьтанд 0.1-20 мкг/кг хэмжээтэйгээр агуулагддаг. Хүнцэл их хэмжээгээр агуулдаг бүтээгдэхүүн нь будаа, мөөг, хүнцэлээр бохирдсон загасаар хооллосон гэрийн тэжээвэр шувуу зэрэг болно. Хүнцлийн хамгийн хортой хэлбэр нь 3 болон 5 валенттай органик бус хэлбэрүүд бөгөөд эдгээр нь хавдар үүсгэдэг химийн бодисын ангилалд хамаардаг.

## 4.5 Нийт хар тугалга

Олон улсын нэр: Lead

Химийн тэмдэг: Pb

Хүний биеийн жинд 7 хоногт авч болох дундаж тун: 0,025 мг/кг

## 5 дугаар хүснэгт-Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах хар тугалганы үлдэгдлийн хэмжээ

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, мг/кг
1	Халуун орны төрөл бүрийн жимс / далдуу модны жимс, чидун жимс, инжир гэх мэт хальстай нь идэж болдог жимснүүд/	0,1
2	Халуун орны төрөл бүрийн жимс /хальстай нь идэж болдоггүй гадил, киви, манго, хан боргоцой гэх мэт жимснүүд/	0,1
3	Жимс жимсгэнэ /усан үзэм, гүзээлзгэнэ/	0,2
4	Нимбэгний төрлийн жимсүүд	0,1
5	Голдоо үртэй шүүслэг жимс /алим, анар, лийр/	0,1
6	Ястай жимс /гүйлс, интоор, тоор, чавга/	0,1
7	Байцааны овгийн хүнсний ногоо /байцаа, цэцэгт байцаа, хятад байцаа гэх мэт/	0,3
8	Булцуут хүнсний ногоо /сонгино, сармис гэх мэт/	0,1
9	Үр жимст хүнсний ногоо (хулуу ) Өргөст /хэмх,улаан лооль, чинжүү, тарвас, хулуу, хүнсний мөөг гэх мэт/	0,1
10	Үр жимст хүнсний ногоо / хулуу, мөөгнөөс бусад/	0,1
11	Навчит ногоо /шош, вандуй, шар буурцаг гэх мэт/	0,3
12	Үрт ургамал	0,2
13	Буурцаг	0,2
14	Үндэс, ба үндэс үрт хүнсний ногоо /төмснөөс бусад/	0,1
15	Нөөшилсөн жимсний коктейль	1,0
16	Нөөшилсөн усан үзэм	1,0
17	Нөөшилсөн амтат жүрж	1,0
18	Нөөшилсөн манго	1,0
19	Нөөшилсөн хан боргоцой	1,0
20	Нөөшилсөн бөөрөлзгөнө	1,0
21	Нөөшилсөн гүзээлзгэнэ	1,0
22	Нөөшилсөн халуун орны жимсний салат	1,0
23	Жимсний чанамал цэлцэгнүүр	1,0
24	Хатаасан манго	1,0
25	Савласан чидун жимс	1,0
26	Нөөшилсөн хэрээ нүдэн	1,0
27	Нөөшилсөн лууван	1,0
28	Нөөшилсөн ногоон шош, давирхайлаг шош	1,0
29	Нөөшилсөн ногоон вандуй	1,0
30	Нөөшилсөн мөөг	1,0
31	Нөөшилсөн дал модны жимс	1,0
32	Нөөшилсөн чихэрлэг эрдэнэ шиш	1,0
33	Нөөшилсөн улаан лооль	1,0
34	Даршилсан өргөст хэмх	1,0
35	Өтгөрүүлж боловсруулсан улаан лооль	1,5
36	Жимсний шүүснүүд	0,05
37	Үр тариа/ сагагаас бусад/	0,2
38	Нөөшилсөн туулайн бөөр ба туулайн бөөрний нухаш	1,0
39	Бод мал, хонь, гахайн мах	0,1
40	Шувууны мах	0,1
41	Үхрийн дотор махан дайвар бүтээгдэхүүн	0,5
42	Гахайн дотор махан дайвар бүтээгдэхүүн	0,5

43	Шувууны дотор махан дайвар бүтээгдэхүүн	0,5
44	Амьтны гаралтай өөх тос	0,1
45	Гахайны хайлуулсан тос	0,1
46	Загас	0,3
47	Маргарин	0,1
48	Минарин	0,1
49	Чидун жимсний тос, боловсруулсан	0,1
50	Чидун жимсний тос, боловсруулаагүй	0,1
51	Чидун жимс, үлдэгдэл тос	0,1
52	Тэжээвэр шувууны өөх	0,1
53	Ургамлын тос, боловсруулаагүй	0,1
54	Ургамлын тос, боловсруулсан	0,1
55	Сүү	0,02
56	Сүүн бүтээгдэхүүн	0,02
57	Байгалийн эрдэсжүүлсэн ус	0,01
58	Хүүхдийн тэжээл	0,02
59	Хоолны давс	2,0
60	Дарс	0,2

5-Р ТАЙЛБАР: Байгаль дахь хар тугалгын гол эх үүсвэр нь уулын чулуулаг бөгөөд түүнд 0,8-2000 мкг/кг хар тугалга агуулагддаг. Хар тугалга нь бие махбодийн амин чухал ферментүүийн найрлага дахь уургийн SH бүлэгтэй нэгдэж, тэдгээрийг идэвхгүйжүүлдэг. Мөн хоол, хүнсний бүтээгдэхүүнийг хар тугалга агуулсан паалан, шавар, цагаан тугалга, хуванцар саванд хадгалсан тохиолдолд хар тугалгаар хүнс бохирдоно.

#### 4.6 Нийт цагаан тугалга

Олон улсын нэр: Tin

Химийн тэмдэг: Sn

Хүний биеийн жинд 7 хоногт авч болох дундаж тун: 14 мг/кг

#### 6 дугаар хүснэгт-Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах цагаан тугалганы үлдэгдлийн хэмжээ

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, мг/кг
1	Нөөшилсөн хоол хүнс /ундаанаас бусад/	250,0
2	Лаазтай ундаа	150,0
3	Нөөшилсөн жимсний коктейль	250,0
4	Нөөшилсөн усан үзэм	250,0
5	Нөөшилсөн амтат жүрж	250,0
6	Нөөшилсөн манго	250,0
7	Нөөшилсөн хан боргоцой	250,0
8	Нөөшилсөн бөөрөлзгөнө	250,0
9	Нөөшилсөн гүзээлзгэнэ	250,0
10	Нөөшилсөн халуун орны жимсний салат	250,0
11	Жимсний чанамал цэлцэгнүүр	250,0
12	Хатаасан манго	250,0
13	Савласан чидун жимс	250,0
14	Нөөшилсөн аспарагус	250,0
15	Нөөшилсөн лууван	250,0
16	Нөөшилсөн ногоо болон давирхайлаг шош	250,0
17	Нөөшилсөн ногоон вандуй	250,0
18	Нөөшилсөн гүйцэд боловсорсон вандуй	250,0
19	Нөөшилсөн мөөг	250,0
20	Нөөшилсөн дал модны жимс	250,0
21	Нөөшилсөн чихэрлэг эрдэнэ шиш	250,0
22	Нөөшилсөн улаан лооль	250,0
23	Даршилсан өргөст хэмх	250,0

## MNS 4504:2008

24	Боловсруулж өтгөрүүлсэн улаан лооль	250,0
25	Нөөшилсөн туулайн бөөр ба тулайн бөөрний нухаш	250,0
26	Болгож, нөөшилсөн, татсан мах /лаазтай бүтээгдэхүүнүүд/	250,0
27	Болгож нөөшилсөн, татсан мах /Бусад төрлийн савтай бүтээгдэхүүнүүд/	50,0
28	Болгож нөөшилсөн утсан мах /Бусад төрлийн савтай бүтээгдэхүүнүүд/	50,0
29	Болгож нөөшилсөн утсан мах /лаазтай бүтээгдэхүүн/	250,0
30	Болгож нөөшилсөн гахайн мах /Бусад төрлийн савтай бүтээгдэхүүнүүд/	50,0
31	Болгож нөөшилсөн гахайн мах /лаазтай бүтээгдэхүүн/	250,0
32	Үхрийн давсалсан мах /бусад төрлийн савтай бүтээгдэхүүнүүд/	50,0
33	Үхрийн давсалсан мах /лаазтай бүтээгдэхүүн/	250,0
34	Зуушны мах /лаазтай бүтээгдэхүүн/	250,0
35	Зуушны мах /бусад төрлийн савтай бүтээгдэхүүнүүд/	50,0

6-Р ТАЙЛБАР: Байгаль орчин цагаан тугалгаар бохирдох нь харьцангуй бага байдаг. Цагаан тугалгыг гол төлөв цагаан тугалган сав хийхэд ашигладаг. Нөөшилсөн хүнсэнд их хэмжээтэй агуулагддагаас хүн хордох эх үүсвэр болдог

### 4.7 Нийт зэс

Олон улсын нэр: Copper

Химийн тэмдэг: Cu

### 7 дугаар хүснэгт-Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах зэсийн үлдэгдлийн хэмжээ

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, мг/кг
1	Цагаан элсэн чихэр	1,0
2	Нунтаг элсэн чихэр	2,0
3	Зөөлөн элсэн чихэр	10,0
4	Усгүйжүүлсэн декстроз	2,0
5	Моногидратжуулсан декстроз	2,0
6	Хуурай глюкозын сироп	5,0
7	Глюкозын сироп	5,0
8	Лактоз	2,0
9	Фруктоз	2,0
10	Какаоны тос	4,0
11	Шоколад	15,0
12	Чихэргүй шоколад	30,0
13	Какаоны нунтаг	30,0
14	Жүржийн шүүс	5,0
15	Нимбэгний шүүс	5,0
16	Улаан лоолийн шүүс	5,0
17	Гүйлс тоор лийрийн гектар	5,0
18	Шар буурцгийн тос	0,1
19	Газрын самрын тос	4,0
20	Хөвөнгийн үрийн тос	0,1
21	Наран цэцгийн үрийн тос	0,4
22	Гахайн хайлуулсан өөхөн тос.	0,4
23	Үхрийн хайлуулсан өөхөн тос.	0,4
24	Маргарин	0,1
25	Минарин	0,1

7-Р ТАЙЛБАР: Хүний бие организмд зэс илүүдвэл судас гэмтэж, салст бүрхэвч цочрох, элэг бөөр гэмтэх, төв мэдрэлийн тогтолцоо цочрох зэрэг эмгэг илэрнэ. Элэг өндөгний шар, навчит хүнсний ногоо зэрэг нь зэсийг их хэмжээгээр агуулна.



#### 4.8 Нийт төмөр

Олон улсын нэр: Iron  
Химийн тэмдэг: Fe

#### 8 дугаар хүснэгт-Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах төмрийн үлдэгдлийн хэмжээ

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, мг/кг
1	Какаоны тос	2,0
2	Жүржийн шүүс	5,0
3	Нимбэгний шүүс	15,0
4	Улаан лоолийн шүүс	15,0
5	Гүйлс тоор лийрийн гектар	15,0
6	Шар буурцгийн тос	1,5
7	Газрын самрын тос	5,0
8	Хөвөнгийн үрийн тос	1,5
9	Наран цэцгийн үрийн тоос	5,0
10	Гахайн хайлуулсан өөхөн тос.	1,5
11	Үхрийн хайлуулсан өөхөн тос.	1,5
12	Маргарин	1,5
13	Минарин	1,5

8-Р ТАЙЛБАР: Төмөр нь маш өргөн тархсан элемент юм. Тэдгээр нь малын дайвар бүтээгдэхүүн мах, өндөг, шош, жимс жимсгэнэ, хүнсний ногоонд тохиолдоно. Гэвч зөвхөн махан бүтээгдэхүүнд, элэг (2000 мг/100 г), өндөгний шар нь төмрийг хүний бие организмд амархан шингээнэ.

#### 4.9 Нийт цайр

Олон улсын нэр: Zinc  
Химийн тэмдэг: Zn

#### 9 дүгээр хүснэгт-Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах цайрын үлдэгдлийн хэмжээ

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, мг/кг
1	Жүржийн шүүс	5,0
2	Нимбэгний шүүс	5,0
3	Алимны шүүс	5,0
4	Улаан лоолийн шүүс	5,0
5	Усан үзмийн шүүс	5,0
6	Хан боргоцойн шүүс	5,0
7	Хан боргоцойн өтгөрүүлсэн шүүс	5,0
8	Хадны шүүс	5,0
9	Гүйлс тоор лийрийн нектар	5,0

9-Р ТАЙЛБАР: Цайр нь бичил элементэд хамаарагдах бөгөөд 200 орчим ферментийн найрлагад ордог. Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдаж буй цайр нь ихэвчлэн байгалийн гаралтай байдаг. Хэрэв хоол ундны зүйл нь шингэн, хүчиллэг орчинтой (кисель, квас, шар айраг, компот, даршилсан, давсалсан ногоо, ундаа г.м) бол цайрыг өөртөө ихээр уусгана.

**ТӨГСӨВ.**

**А Хавсралт  
(мэдээллийн)**

**Ном зүй**

- 1 John H. Duffus ""Heavy metals" a meaningless term? (IUPAC Technical Report)" Pure and Applied Chemistry, 2002, Vol. 74, pp. 793-807.
- 2 A Dictionary of Chemistry. Oxford University Press, 2000. Oxford Reference Online.Oxford University Press.
- 3 Lane TW, Morel FM (2000). "A biological function for cadmium in marine diatoms". Proc. Natl. Acad. Sci. U.S.A. 97 (9): 4627–31.
- 4 Lane TW, Saito MA, George GN, Pickering IJ, Prince RC, Morel FM (2005). "Biochemistry: a cadmium enzyme from a marine diatom". Nature 435 (7038): 42.
- 5 International Union of Pure and Applied Chemistry. "Chemical element". Compendium of Chemical Terminology Internet edition
- 6 [www.codexalimentarius.net](http://www.codexalimentarius.net)

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 67.020

Цацрагаар боловсруулсан хүнсний бүтээгдэхүүний ерөнхий стандарт	MNS CAS 106:2007
Codex general standard for irradiated foods	CAS 106-1983 (1-2003 нэмэлт өөрчлөлт оруулсан )

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2007 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 37 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандартыг 2007 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

Энэ стандартын бүх шаардлагыг заавал мөрдөнө.

### 1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуйн болон тээвэрлэлтийн эрхзүйн стандартыг баримтлан, ион цацраг туяагаар боловсруулсан хүнсний бүтээгдэхүүнд хамаарна.

Харин хяналтад ашигладаг хэмжилтийн багаж төхөөрөмжөөс дамжих цацрагийн тунд өртсөн хүнсний бүтээгдэхүүнд хамаарахгүй.

### 2 Боловсруулалтад тавих ерөнхий шаардлага

#### 2.1 Цацрагийн үүсгүүр

Иончлогч цацрагийн дараах төрлийг ашиглана. Үүнд:

2.1.1 цацраг идэвхт  $^{60}\text{Co}$ , эсвэл  $^{137}\text{Cs}$  бодисын гамма туяа

2.1.2 5 MeV буюу түүнээс доош энергийн түвшинд ажилладаг үүсгүүрээс үүссэн рентген туяа

2.1.3 10 MeV ба түүнээс доош энергийн түвшинд ажилладаг үүсгүүрээс үүссэн электрон цацраг

#### 2.2 Шингэсэн / шингэлтийн/ тунгийн хэмжээ

Цацрагаар боловсруулсан ямар ч хүнсний бүтээгдэхүүнд шингэсэн хамгийн бага тун нь технологийн зорилгоо бүрэн хангахад хүрэлцэхүйц, шингэсэн хамгийн их тун нь хэрэглэгчийн эрүүл ахуй, аюулгүй байдалд аюул учруулахааргүй, бүтцийн нэгдмэл байдал, үйл ажиллагааны шинж чанар эсвэл мэдрэмтгий байдалд сөргөөр нөлөөлөхгүй хэмжээнд байна.

Технологийн тодорхой зорилгод хүрэхээс бусад тохиолдолд туяагаар шарж боловсруулсан хүнсний бүтээгдэхүүнд шингэсэн цацрагийн тунгийн хэмжээ 10 кГу –аас хэтрэхгүй байна.<sup>1</sup>

#### 2.3 Боловсруулалт хийх төхөөрөмж, түүнд тавих хяналт

2.3.1 Тухайн улсын эрх бүхий байгууллагаас энэ зорилгоор ашиглах зөвшөөрөлтэй, албан ёсны бүртгэлтэй төхөөрөмж дээр хүнсийг цацрагаар боловсруулна.

<sup>1</sup> Шарлагын өндөр тун: 10 кГу-аас их тунгаар шарсан цацрагаар боловсруулсан хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй. ДХХААБ/ОУАЭА/ДЭМБ-ын хамтарсан комиссын судалгааны багийн илтгэл, техникийн тайлан 890, ДЭМБ, Женев ба Цацрагаар боловсруулсан хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал ба шимт чанар. ДЭМБ, Женев, 1994 ба Цацрагаар боловсруулсан хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй. ДХХААБ/ОУАЭА/ДЭМБ-ын хамтарсан Шинжээчдийн Хорооны илтгэл, техникийн тайлан 659, ДЭМБ, Женев, 1981

## **MNS CAC 106:2007**

**2.3.2** Төхөөрөмж нь хүнсийг боловсруулах эрүүл ахуйн зохистой дадал болон аюулгүй байдал, үр ашигтай байх шаардлагыг хангасан байна.

**2.3.3** Төхөөрөмж дээр сайн бэлтгэгдсэн, эрх бүхий хангалттай тооны ажилтан ажиллана.

**2.3.4** Төхөөрөмжийн үйл ажиллагааны хяналт нь тун хэмжигчийн тоон үзүүлэлтийг агуулсан бүртгэлийг багтаана.

**2.3.5** Төхөөрөмж, холбогдох бичиг баримт болон тайлан нь тухайн улсын эрх бүхий байгууллагаас зохих журмын дагуу тавих хяналтад нээлттэй байна.

**2.3.6** Хяналтыг “Хүнсний бүтээгдэхүүнийг цацрагаар боловсруулах Олон улсын дадлын зөвлөмж стандарт” (CAC/RCP 19-1979, дахин хянасан 1-2003.)-ын шаардлагатай нийцүүлэн тавина.

### **3. Цацрагаар боловсруулсан хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй**

**3.1** Цацрагаар боловсруулсан хүнсний бүтээгдэхүүнийг “Хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуйн ерөнхий зарчим - Олон улсын дадлын зөвлөмж хууль” (Ишлэл № CAC/RCP 1-1969, дахин хянасан 2, 1985) олон улсын стандартын шаардлага болон хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зорилгоор хэрэглэдэг Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын систем (НАССР)-ийн үндсэн долоон зарчмын дагуу эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд боловсруулсан ба тээвэрлэсэн байна. Түүхий эд болон бэлэн бүтээгдэхүүн нь тухайн бүтээгдэхүүний стандарт, холбогдох эрүүл ахуй, тээвэрлэлтийн эрх зүйн баримт бичгийн техникийн шаардлагыг хангасан байна.

**3.2** Хүнсний бүтээгдэхүүнийг худалдан борлуулахдаа тухайн оронд мөрддөг микробиологийн аюулгүй байдал болон тэжээллэг чанарын шаардлагыг хөндсөн нийгмийн эрүүл мэндийн холбогдох шаардлагыг анхаарна.

### **4 Технологийн шаардлага**

#### **4.1 Ерөнхий шаардлага**

Хүнсний бүтээгдэхүүнийг цацрагаар боловсруулах аргыг зөвхөн технологийн шаардлагыг хангасан ба/эсвэл хэрэглэгчийн эрүүл мэндийг хамгаалахад ашигтай байх тохиолдолд зөвшөөрнө. Харин түүнийг үйлдвэрлэлийн эрүүл ахуйн болон хөдөө аж ахуйн зохистой дадлуудыг орлуулах зориулалтаар хэрэглэхгүй.

#### **4.2.Бүтээгдэхүүний чанар болон савлалтад тавих шаардлага**

Шингэсэн тунгийн хэмжээ нь зорьж буй технологийн болон нийгмийн эрүүл мэндийн зорилготой уялдаатайгаар, цацрагаар боловсруулах зохистой дадалд заасан хэмжээнд байвал зохино. Цацрагаар боловсруулах хүнсний бүтээгдэхүүн, тэдгээрийг савлах материал нь энэхүү зорилгод нийцсэн эрүүл ахуйн шаардлагад тохирохуйц чанартай байх бөгөөд шарлагын өмнө болон дараа нь үйл ажиллагааны онцгой шаардлагуудыг анхааралдаа авч, үйлдвэрлэлийн зохистой дадлын дагуу боловсруулалтыг хийнэ.

**5 Дахин боловсруулах**

**5.1** Хортон шавьжаар дахин халдварлуулахгүй зорилгоор цацрагаар боловсруулсан чийгийн агууламж багатай (үр тариа, буурцагт ургамал, хатаасан болон ийм төрлийн бусад бүтээгдэхүүн) бүтээгдэхүүнээс бусад энэ стандартын 2 ба 4–д заасны дагуу цацрагаар боловсруулсан бүтээгдэхүүнийг дахин боловсруулах шаардлагагүй.

**5.2** Энэхүү стандартын зорилгод нийцүүлэн дараах тохиолдолд бүтээгдэхүүнийг цацрагаар дахин боловсруулахгүй. Үүнд:

**5.2.1** цацрагаар боловсруулсан бүтээгдэхүүн нь хүнсний аюулгүй байдлыг хангахаас (жишээлбэл, үндэс, булцууны ургалтыг зогсоох, хорио цээрийн хяналт) бусад зорилгоор бага хэмжээний цацрагаар боловсруулсан түүхий эдээр үйлдвэрлэсэн;

**5.2.2** цацрагаар боловсруулсан бүтээгдэхүүний бүрэлдэхүүний 5-аас бага хувийг цацрагаар боловсруулсан;

**5.2.3** боловсруулалтын явцад хүнсний бүтээгдэхүүнд технологийн тодорхой чиглэлээр хүссэн үр дүнд хүрэхэд шаардагдах иончлогч цацрагийн бүрэн тунгаас илүү хэмжээгээр хэрэглэсэн.

**5.3** Технологийн тодорхой зорилгод хүрэхээс бусад нөхцөлд цацрагаар дахин боловсруулсан бүтээгдэхүүнд шингэсэн цацрагийн тунгийн хуримтлагдсан нийт хэмжээ нь 10 кГу-ээс ихгүй буюу хэрэглэгчийн эрүүл мэнд болон хүнсний аюулгүй байдлыг хангахуйц хэмжээнд байна.

**6 Шалгах**

Цацрагаар боловсруулсан хүнсний бүтээгдэхүүнд албан ёсны зөвшөөрөл олгох, шошгололтын шаардлагыг мөрдүүлэх шаардлагатай үед тохирох шинжилгээний аргуудыг ашиглана. Эдгээр шинжилгээний аргуудыг Хүнсний хууль эрх зүйн хорооноос хүлээн зөвшөөрсөн байна.

**7 Шошголох****7.1 Бүртгэлд тавих хяналт**

Цацрагаар боловсруулсан, савласан ба задгай хүнсний бүтээгдэхүүний дагалдах бичиг баримтад боловсруулалт хийсэн төхөөрөмжийн бүртгэлийн тодотгол, бүтээгдэхүүнийг боловсруулсан огноо (он, сар, өдөр), шарлагын тун, цувралын тодорхойлолтыг тусгасан байна.

**7.2 Шууд хэрэглэхэд зориулан савласан бүтээгдэхүүн**

Цацрагаар боловсруулсан, савласан хүнсний бүтээгдэхүүн нь “Савласан хүнсний бүтээгдэхүүнийг шошголох ерөнхий стандарт” (CAS 1-1985, нэмэлт өөрчлөлт орсон 1-1991)-ын шаардлагыг хангасан, цацрагаар боловсруулалт хийснийг илэрхийлсэн таних тэмдэг бүхий шошготой байна.

**7.3 Бөөнөөр савласан бүтээгдэхүүн**

Боловсруулалтын талаарх мэдээллийг дагалдах бичиг баримтад тодорхой тусгана. Хэрэв бөөнөөр савласан бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгчид шууд худалдахаар бол савны гадна талд шошгон дээр бүтээгдэхүүний нэрийн хамт зохих олон улсын тэмдгийг тавьсан буюу “цацрагаар боловсруулсан” эсвэл “иончлогч цацрагаар боловсруулсан” гэсэн үгийг бичнэ.

**ТӨГСӨВ.**

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 67.040

Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандарт	MNS CAC 193:2007
Codex General Standard for Contaminants and toxins in Food	CAC 193-1995 (Rev.2-2006)

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2007 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 37 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандартыг 2007 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

Энэ стандартын бүх шаардлагыг заавал мөрдөнө.

### 1 Удиртгал

#### 1.1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь хүнсний бүтээгдэхүүн, малын тэжээл зэрэгт агуулагдах бохирдуулагч ба хорт бодистой холбоотой Хүнсний Хууль эрхзүйн Хороо(ХХЭЗХ)-ноос зөвлөмж болгосон үндсэн зарчмууд болон журамд хамаарах бөгөөд Олон улсын худалдаанд нийлүүлэгдэж буй бараа бүтээгдэхүүнд баримтлахыг зөвлөсөн хүнсний бүтээгдэхүүн, малын тэжээл дэх бохирдуулагч ба байгалийн хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээний жагсаалтыг багтаана.

#### 1.2 Тодорхойлолт

##### 1.2.1 Ерөнхий зүйл

Хүнсний хууль эрхзүйн холбогдолтой тодорхойлолтуудын Хүнсэн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандарт (ХХББЕС)-д хэрэглэж болох бөгөөд хамгийн их ач холбогдолтой хэсгүүдийг нь энд давтан оруулав. Зохих тодруулга хийх шаардлагатай хэсэгт зарим шинэ тодорхойлолт оруулж байна. Хүнсэнд зөвлөсөн зүйлсийг шаардлагатай нөхцөлд малын тэжээлд ч нэгэн адил хамааруулна.

##### 1.2.2

##### бохирдуулагч

аж ахуйн ажиллагаа (газар тариалан, мал аж ахуй мал эмнэлэг зэрэг салбаруудад хийгддэг үйл ажиллагааг оролцуулаад), хүнс үйлдвэрлэх, боловсруулах, бэлтгэх, боох, савлах, тээвэрлэх, хадгалах явцад болон орчны бохирдлоос шалтгаалан хүнсэнд санамсаргүйгээр орсон ямар нэг бодис

Энэ нэр томъёонд шавьж хорхойн биеийн хэсгүүд, мэрэгчдийн үс хялгас болон бусад гадны зүйлс хамаарахгүй.

Энэ стандарт нь дор дурдсанаас бусад тохиолдолд хүнсний зориулалтаар үржүүлдэг малын тэжээл дэх бохирдуулагчдыг оруулаад бохирдуулагчийн талаарх Хууль эрхзүйн нэр томъёоны тодорхойлолтод орсон аливаа бодист хамаарна. Үүнд:

**1.2.2.1** Хүнсэн дэх нийгмийн эрүүл мэндэд нөлөөлөхөөргүй зөвхөн хүнсний чанарт нөлөөлдөг бохирдуулагчид

**1.2.2.2** Хууль эрхзүйн тодорхойлолтод тусгасан Пестицидийн үлдэгдлийн эрхзүйн хороо 4 (ПҮЭЗХ)-ны нэр томъёоны хүрээнд авч үзэх пестицидийн үлдэгдлүүд

## **MNS CAS 193:2007**

Хэрэв ПҮЭЗХ-оор пестицидийг хүнс үйлдвэрлэхтэй холбоогүйгээр хэрэглэснээс үүдэлтэй пестицидийн үлдэгдлийг авч үзээгүй бол ХХББЕС-д тусгаж болно.

**1.2.2.3** Хууль эрхзүйн тодорхойлолтод тусгасан Мал эмнэлгийн эм бэлдмэлийн үлдэгдлийн эрхзүйн хороо (МЭЭҮЭЗХ)-ны нэр томъёоны хүрээнд авч үзэх эм бэлдмэлийн үлдэгдэл

**1.2.2.4** Хүнсний Эрүүл Ахуйн Хууль Эрхзүйн Хороо (ХЭАХЭЗХ)-ны холбогдох нэр томъёонд тусгасан бичил биетнүүд болон ботулины хор, стафилококкын энтеротоксин зэрэг бичил биетний хорууд

**1.2.2.5** Туслах түүхий эдүүд (тодорхойлолтоор хүнсэнд зориудаар нэмсэн)

### **1.2.3 Энэ стандартад хамаарах байгалийн гаралтай хорууд (токсин)**

Хууль эрхзүйн тодорхойлолтод зааснаар хүнсэнд шууд бус хэлбэрийн бохирдуулагчид зориудаар нэмээгүй зарим бичил мөөгөнцрүүдийн задралын явцад ялгарах хорт бүтээгдэхүүнээс ялгарсан байгальд тохиолдох хор (микотоксин)-ыг оруулдаг.

Ногоон замгаас үүсдэг болон нялцгай биетэн мэтийн хүнсэнд хэрэглэдэг далайн амьтдын биед хуримтлагдаж буй болдог бичил биетнүүдийн ялгадаг хор (фикотоксин)-ууд ч энэхүү стандартад хамаарна. Микотоксин болон фикотоксин хоёулаа бохирдуулагчийн дэд ангиуд.

Энэ стандартын хүрээнд хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл, төрөл, зүйлээс шалтгаалан далдуур аюултай түвшинд хүрэхүйц хэмжээгээр задралын хорт бүтээгдэхүүн болох ургамлын гаралтай хор (фитотоксин)-ыг ялгаруулдаг байгалийн хордуулагч бодисыг авч үздэггүй. Тэдгээрийг Хүнсний бүтээгдэхүүн дэх бохирдуулагчийн эрхзүйн хороо (ХБЭЗХ)-ны зөвлөмжийн нэр томъёонд тусгасан байдаг тул тухай бүр харгалзан авч үзэхэд ашиглаж болно.

### **1.2.4 Дээд түвшин, холбогдох нэр томъёо**

#### **хүнс, малын тэжээл дэх бохирдуулагчийн дээд түвшин (ДТ)**

Хүнсний хууль эрх зүйн хорооноос зөвлөмж болгосон тухайн бараа бүтээгдэхүүнд байвал зохих бохирдуулагч бодисын дээд хэмжээ

#### **зөвлөмж болгосон түвшин**

Хүнсний хууль эрхзүйн хорооноос тухайн бараа бүтээгдэхүүнийг гадаад худалдаанд нийлүүлэхэд баримтлахаар тогтоосон хүнс болон малын тэжээлд байх бохирдуулагчийн дээд хэмжээ

Зөвлөмжид заасан хэмжээ хэтэрсэн тохиолдолд Засгийн газраас тухайн нутаг дэвсгэрт хүнсийг түгээх эсэх талаар хуулийн хүрээнд шийдвэр гаргана<sup>1</sup>.

## **1.3 Хүнсний бохирдуулагчтай холбогдох ерөнхий зарчмууд**

### **1.3.1 Ерөнхий зүйл**

Хүнс, тэжээлийн зүйлс нь янз бүрийн үйл ажиллагаа, учир шалтгааны улмаас бохирдож болох юм. Бохирдол нь ерөнхийдөө хүнс болон тэжээлийн чанарт сөрөг нөлөө үзүүлэхээс гадна хүн, малын эрүүл мэндэд аюул учруулж болно.

Хүнсэн дэх бохирдуулагчийн түвшин боломжит хамгийн бага хэмжээнд байвал зохино. Дараах арга хэмжээг авснаар хүнс, тэжээлийг бохирдлоос сэргийлж, эсвэл хэмжээг нь бууруулж чадна. Үүнд:

<sup>1</sup> Хэдийгээр хүнс, малын тэжээлийн талаарх Хууль эрхзүйн хорооны стандартын үндсэн жагсаалт нь дээд түвшин байдаг ч ХХЭЗХ-ноос одоогийн байгаа эсвэл санал болгохоор дэвшүүлсэн түвшингийн дээд хэмжээнд өөрчлөлт оруулах эсэхийг шийднэ.

**1.3.1.1** Эх үүсвэр дээр нь хүнсийг бохирдохоос урьдчилан сэргийлэх, тухайлбал, хүрээлэн буй орчны бохирдлыг багасгах;

**1.3.1.2** Хүнс үйлдвэрлэл, боловсруулалт, хадгалалт, савлагаанд оновчтой технологийг хэрэглэх;

**1.3.1.3** Бохирдсон хүнс, тэжээлийг бохирдолгүй болгох эсвэл хэрэглээнд нийлүүлэхээс сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг авах.

Хүнс, тэжээлийн бохирдлыг бууруулах талаар хангалттай арга хэмжээ авах нөхцлийг бүрдүүлэхийн тулд холбогдох дүрэм, журмын эмхтгэлийг эх үүсвэртэй холбоотой арга хэмжээ, тухайн бохирдлын асуудалд хамааралтай үйлдвэрлэлийн зохистой дадал, түүнчлэн ХАА-н үйлдвэрлэлийн зохистой дадал зэргээс оролцуулан боловсруулсан байна.

Хүнс, тэжээлийн бохирдлын зэрэг, бохирдлыг бууруулах арга хэмжээний үр нөлөөг хяналт, тандалтын болон шаардлагатай үед илүү нарийвчилсан судалгааны тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар үнэлнэ.

Бохирдсон хүнсийг хэрэглэсэнтэй холбоотой эрүүл мэндэд учирч болох аюулын шинж тэмдэг илэрсэн үед эрсдлийн үнэлгээг заавал хийх шаардлагатай. Эрүүл мэндэд аюултай болох нь батлагдвал тухайн нөхцөл байдлыг сайтар үнэлсэний үндсэн дээр эрсдлийг удирдах бодлогыг хэрэгжүүлнэ. Тухайн асуудал ба боломжийн шийдлийн үнэлгээнээс шалтгаалан дээд түвшин эсвэл хүнсний бүтээгдэхүүний бохирдлыг удирдах бусад арга хэмжээг тогтоох шаардлагатай байж болох юм. Онцгой тохиолдолд эрүүл мэндэд учирч болох аюулыг зайлуулах бусад арга хэмжээ нь хангалттай бус бол хооллолтын дэглэмтэй холбоотой зөвлөмжийг өгнө.

Хүнсний бохирдлын талаар авах үндэсний арга хэмжээ нь хүнс, тэжээлийн олон улсын худалдаанд саад бэрхшээл учрахаас аль болох зайлсхийсэн байна. Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандарт нь бохирдлын асуудлыг шийдвэрлэж болох арга замыг удирдлагаар хангах, худалдаанд саад тотгор үүсэхээс сэргийлэхэд туслах, зөвлөмжөөр дамжуулан олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой юм.

Нэг ба түүнээс олон бүтээгдэхүүнд байж болох бүх бохирдуулагчийн хувьд эрсдлийг үнэлэх болон дээд түвшинг тогтоох асуудлыг тусгасан арга хэмжээ, зөвлөмжийг боловсруулах ажлыг, уг асуудалд хамаарах бүхий л мэдээллийг анхааралтай авч үзэх замаар өргөн хүрээнд гүйцэтгэнэ.

### **1.3.2 Хүнсний бүтээгдэхүүн болон малын тэжээл дэх бохирдуулагчийн дээд түвшинг тогтоох зарчим**

Дээд түвшинг тухайн хэрэглэгчид сөрөг нөлөө үзүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээгээр илэрч болох хүнсний бүтээгдэхүүний хувьд л тогтооно. Ингэхдээ тухайн хэрэглэгчийг бүрэн хамгаалсан байх тийм аргаар тогтоох шаардлагатай. Үүнтэй нэгэн зэрэг дээд түвшинг хангах технологийн боломжуудыг ч харгалзан үзнэ. Үйлдвэрлэл, мал эмнэлэг, ХАА-н зохистой дадлын зарчмуудыг хэрэглэнэ. Дээд түвшин нь хүнсний олон улсын худалдааг хөнгөвчлөх талаар дэлхий нийтээр баримталж болохуйц шинжлэх ухааны бодит зарчимд үндэслэсэн байна. Тухайн



## **MNS CAS 193:2007**

бүтээгдэхүүний статус болон хэрэглээний зориулалттай нь холбогдуулан дээд түвшинг ойлгомжтой тодорхойлсон байвал зохино.

### **1.3.3 Тусгай шалгуур үзүүлэлтүүд**

Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандарттай холбоотой зөвлөмж боловсруулах, шийдвэр гаргахад дараах шалгуур үзүүлэлтүүдийг (өөр бусад шалгуур үзүүлэлтүүдийг хэрэглэхэд саад болохооргүй) авч үзнэ. Үүнд: (Эдгээр шалгуур үзүүлэлтүүдийн талаарх бусад дэлгэрэнгүйг А хавсралтаар үзүүлэв.)

#### **Хор судлалын мэдээлэл**

- Хорт бодис(ууд)ыг таньж тодорхойлох
- Хүн ба амьтны бие махбодийн бодисын солилцоо
- Хорт бодисын кинетик, хөдлөл зүй
- Цочмог болон архаг хордлого болон өөр бусад холбогдох хордлогын талаарх мэдээлэл
- Тухайн хорт бодист онцгой эмзэг хүн амын тодорхой бүлгийн талаарх мэдээллийг оролцуулаад, тухайн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшин, хэрэглээ болон аюулгүй байдалтай холбоотой хор судлалын мэргэжилтнүүдийн хамтарсан зөвлөгөө, мэдээлэл

#### **Шинжилгээний өгөгдлүүд**

- Төлөөлсөн дээжийн баталгаажсан чанарын болон тоон өгөгдлүүд;
- Дээж авах журам.

#### **Хэрэглээний талаарх өгөгдлүүд**

- Сувиллын зориулалттай хүнсэнд бохирдуулагчийн илрэх байдал;
- Өргөн хэрэглээний хүнсэнд бохирдуулагчийн илрэх байдал;
- Дундаж болон хамгийн их өртөмтгий хэрэглэгчдийн бүлгийн хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний хэмжээ;
- Хооллолтын дэглэмийн талаарх судалгааны дүн;
- Хүнсний хэрэглээний загваруудаар тооцсон бохирдуулагчийн орох хэмжээ
- Өртөмтгий бүлгийн хувьд бохирдуулагчийн бие организмд орох хэмжээ.

#### **Үзэсгэлэн, худалдааны асуудлууд**

- Олон улсын худалдаанд тохиолддог болон цаашид гарч болох асуудлууд;
- Олон улсын худалдаанд нийлүүлдэг бараа бүтээгдэхүүнүүд;
- Үндэсний дүрэм зааврууд, ялангуяа эдгээрийн үндэслэл болон суурь үзүүлэлтүүдийн талаарх мэдээлэл.

#### **Технологийн асуудлууд**

- Бохирдлын явц, технологийн боломжууд, үйлдвэрлэл болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, бохирдуулагчийн түвшинг удирдах, зохион байгуулах, хянахтай холбоотой эдийн засгийн асуудлуудын талаарх мэдээлэл

## Эрсдлийн үнэлгээ ба эрсдлийн удирдлагын асуудлууд

- эрсдлийн үнэлгээ;
- эрсдлийн зохицуулалтын сонголт, үзүүлэлтүүд;
- дээр дурдсан шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэн хүнсний бүтээгдэхүүнд байх боломжит дээд түвшинг авч үзэх;
- бусад хувилбаруудыг авч үзэх.

### 1.4 Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын стандартуудыг боловсруулах аргачлал

#### 1.4.1 Ерөнхий зүйл

Журмын гарын авлагад дурдсан ёсоор эрхзүйн стандартыг боловсруулах аргачлал нь хэрэглэж болохуйц байна. Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын стандартуудыг боловсруулах ажлыг хөнгөвчлөх, тодорхой болгохын тулд шийдвэр гаргах шалгуур үзүүлэлтүүд ба дагаж мөрдөх журамтай холбоотой дэлгэрэнгүйг энэхүү аргачлалд тусгасан болно.

#### 1.4.2 Хүнсний нэмэлт ба бохирдуулагчийн Эрхзүйн Хороо (ХНБЭЗХ)-нд бохирдуулагчийн талаар урьдчилан хэлэлцэх журам

ХНБЭЗХ-гоор урьдчилан хэлэлцүүлэх ХХББЕС-д оруулахаар зэхэж буй шинэ бохирдуулагчид эсвэл шинэ бохирдуулагч ба барааны хам нөлөөний шинэ хэлбэрийн талаарх саналыг төлөөлөгчид болон нарийн бичгийн дарга нарын газраас дэвшүүлэн тавьж болно. Эхний хэлэлцүүлгийг ярилцлагын хэлбэрээр явуулах боловч холбогдох мэдээллийг хангалттай хэмжээгээр агуулсан тайлбарт үндэслэсэн байвал зохино. Шаардлага хангахуйц урьдчилсан тойм гаргахад дараах мэдээ, мэдээлэл хамгийн чухал. Үүнд:

**1.4.2.1** Бохирдуулагчийг таньж тодорхойлох ба асуудлын үндэслэлийн талаарх мэдээллийн товч хураангуй;

**1.4.2.2** Зөвлөмжийг оролцуулаад хор судлал, шинжилгээний болон орох хэмжээний өгөгдлүүдийн талаарх нотолгоо;

**1.4.2.3** Эрүүл мэндийн холбоотой (байж болох) асуудлуудын талаарх баримтууд;

**1.4.2.4** Олон улсын худалдаанд байгаа болон гарч болох саад бэрхшээлүүдийн талаарх баримтууд;

**1.4.2.5** Хүнсний бүтээгдэхүүн дэх бохирдуулагчийн асуудлыг удирдах, зохион байгуулахтай холбоотой технологийн боломж ба эдийн засгийн асуудлаарх мэдээ, мэдээлэл;

**1.4.2.6** ХНБЭЗХ –оос хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх нухацтай санал.

ХБЭЗХ-нд тодорхой бохирдуулагчтай холбоотой үйл ажиллагаа явуулах талаар тавьсан төлөөлөгчдийн саналыг авч үзэхийг хүссэн тохиолдолд, энэхүү төлөөлөл нь дээр заасан мэдээллийг урьдчилан хэлэлцэхэд үндэслэл болохуйц хангалттай хэмжээнд гаргаж өгөх ба нарийн бичгийн дарга нарын газарт Хорооны дараагийн

## **MNS CAS 193:2007**

хуралдааны хэлэлцэх асуудлын хөтөлбөрт тухайн асуудлыг тусгуулах талаар хүсэлт гаргана.

### **1.4.3 ХНБЭЗХ-д бохирдуулагчтай холбоотой эрсдлийн удирдлагын шийдвэр гаргах журам**

Хүнсний Нэмэлтийн Шинжээчдийн Хороо (ХНШХ)-ноос хийсэн бохирдуулагчийн хор судлалын болон бусад асуудлуудын үнэлгээ, үүнийг дагалдан хүнсэнд байж болох хэмжээ болон дээд түвшинтэй холбоотой боловсруулсан зөвлөмжүүд нь ХНБЭЗХ-оор хэлэлцэх шийдвэрийн үндэслэл болно. ХНБЭЗХ-оос тухайн асуудлыг нэн даруй авч хэлэлцэх шаардлагатай гэж үзвэл ХНШХ-ны зөвлөмж байхгүй бол Хороонд бусад эх сурвалжуудаас хангалттай мэдээллийг өгсөн тохиолдолд шийдвэр гаргаж болно.

Эрсдлийн удирдлагын талаарх шийдвэрүүдийг гаргах ХНБЭЗХ-ны журмын талаар бичсэн болно. /B хавсралт/

### **1.5 Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандартын бүтэц**

Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандарт (ХХББЕС) нь 2 төрлийн жагсаалтаас бүрдэнэ. Үүнд: 1 дүгээр жагсаалтад стандартуудыг төрөл бүрийн хүнсний ангиллаар бохирдуулагч тус бүрээр нь жагсааж бичдэг бол 2 дугаар жагсаалтад хүнсний бүтээгдэхүүн тус бүрээр нь бохирдуулагчийн стандартыг гаргадаг.

Удиртгал хэсгийн жагсаалт нь Журмын гарын авлагад заасны дагуу байх бөгөөд одоогийн байдлаар хэрэглэж болохуйц байгаа. Маш тодорхой ойлгомжтой байлгахын тулд шаардлагатай газар нь зохих тайлбаруудыг нэмж оруулна. Стандартын бүтэц нь тухайн стандартуудын агуулга, үндэслэл, хэрэглээ, хамрах хүрээ зэргийн талаар бүрэн ойлголт өгөхөд шаардлагатай бүх элементүүдийг агуулдаг бөгөөд тухайн стандартын үндэслэл, шүүн хэлэлцсэн тайлан, холбогдох бичиг баримт, мэдээллүүдийн жагсаалтыг багтаана. Стандартын бүтцийн бүрэн тодорхойлолтыг оруулав. /C хавсралт/

ХНБЭЗХ-ны хуралдаан бүрт 1 дүгээр жагсаалтын хэлбэрээр хүнсний бохирдуулагчдын талаарх Хууль эрхзүйн стандартуудын(хүлээн зөвшөөрөгдсөн болон санал болгож буй) бүрэн жагсаалтыг харуулсан ажлын баримт бичгийг бэлтгэдэг.

Төрөл бүрийн бохирдуулагчдын Хууль эрхзүйн хорооны стандартуудын жагсаалтыг хүнсний ангиллын тоон системийн дагуу аль эсвэл хүнсний бүтээгдэхүүн тус бүрээр гаргаж болно. /D хавсралт/

### **1.6 Стандартыг хянах, сайжруулах**

Энэхүү стандартын бохирдуулагчийн талаарх заалтуудыг ХНШХ-ны хор судлалын талаарх зөвлөмжийн дагуу тодорхой хугацаанд тогтмол хянан үзэж, эрсдлийн удирдлага өөрчлөгдөх, үлдэгдлийг зохицуулах боломжууд, шинжлэх ухааны мэдлэг болон бусад холбогдох баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдлуудад зохих засваруудыг оруулна.

Тогтоосон дээд түвшин, санал болгосон түвшин, мөн тэдгээрийг боломжтой тохиолдолд дээд түвшинд оруулахад онцгой анхаарах шаардлагатай.

**ТӨГСӨВ.**

## А Хавсралт

### Хүнсний бүтээгдэхүүн дэх дээд түвшинг тогтоох шалгуур үзүүлэлтүүд

#### Өмнөх үг

Энэ хавсралтын шалгуур үзүүлэлтүүдэд хүнсний бүтээгдэхүүн дэх бохирдлын тулгамдсан асуудлыг дүгнэх болон дээд түвшинг тогтооход зайлшгүй хэрэгтэй мэдээллүүдийг тусгасан. Мэдээллүүдийг ХНШХ эсвэл ХБЭЗХ-нд хүргүүлсэн тохиолдолд эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг анхааралдаа авах нь чухал юм. Иймээс ХНШХ эсвэл ХБЭЗХ-нд мэдээлэхдээ эдгээр шалгууруудыг анхаарч үзэх хэрэгтэй.

Энд дурдсан шалгууруудыг оршлын 1.3.3 хэсэгт тусгаснаас илүү нарийвчлан боловсруулсан болно. Гэвч зөвхөн цаашид улам тодорхой болгох шаардлагатай асуудлуудыг тусгасан тул үнэлгээний үйл ажиллагаанаас энд дурдаагүй бусад шалгуур үзүүлэлтүүдийг орхигдуулж болохгүй.

#### Хоруу чанарын мэдээлэл

Хүнсний бүтээгдэхүүн дэх бохирдуулагчийн дээд түвшинтэй холбоотой шийдвэр гаргахад тэдгээрийн аюулгүйн тун хэмжээний талаарх ХНБШХ-ны санал зайлшгүй хэрэгтэй. Хүнсний бүтээгдэхүүн дэх бохирдлын дээд түвшингийн талаарх шийдвэр хэлэлцэгдэх үед бохирдлын аюулгүй/зөвшөөрөгдөх хэмжээг үнэлдэг ХНБШХ-ны зөвлөмж зайлшгүй хэрэгтэй. ХБЭЗХ-ноос гаргах шийдвэрийн гол үндэслэл нь бүрэн, үнэн зөв тодорхойлсон хор судлалын үзүүлэлтүүдийн үнэлгээнд тулгуурласан ХНБШХ-ны бохирдуулагчийн аюулгүйн тун хэмжээний талаарх зөвлөмж юм. Яаралтай тохиолдолд, ХНБШХ-ны гүйцэд боловсруулалт хийж амжаагүй үнэлгээ эсвэл бусад, олон улсын болон үндэсний холбогдох байгууллагын хор судлалын зөвлөлийн саналд найдаж болно

Хэрэв хүнсний бүтээгдэхүүн дэх бохирдуулагчийн дээд түвшний тухай дэвшүүлсэн саналтай холбогдуулан хорын мэдээллийг өгөхөөр бол дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:

- хорт бодис (ууд)-ыг таньж тодорхойлох;
- хүн ба амьтны бие махбодийн бодисын солилцоо;
- хорт бодисын кинетик, хөдлөл зүй;
- хүн, амьтны удаан хугацааны болон архаг хордлого, хүнд халдварлахыг оролцуулсан болон өөр бусад холбогдох хордлогын талаарх мэдээлэл;
- тухайн хорт бодист онцгой эмзэг хүний болон амьтны тодорхой бүлгийн талаарх мэдээллийг багтаасан хор судлалын шинжээчдийн дүгнэлт, зөвлөмж.

#### Шинжилгээний үзүүлэлтүүд

Төлөөлж буй дээжийн шинжилгээний чанарын болон тоон үзүүлэлтүүд нь хангалттай хэмжээнд баталгаатай байх хэрэгтэй. Мөн дээж авах болон шинжлэх арга, үр дүнгийн үнэмшил, баталгаажилтын талаарх ашигласан мэдээлэл чухал. Бүтээгдэхүүний бохирдлыг тодорхойлох дээжтэй холбоотой бүрэн (жишээ нь: үндэсний хэмжээнд) мэдээлэл байх шаардлагатай.

Бохирдуулагчийн агууламжийг тодорхойлох шинжилгээнд хамрагдсан бүтээгдэхүүний хэсэг нь тухайн бүтээгдэхүүнийг бүрэн төлөөлж чадах эсвэл үлдэгдлийг хянах зорилгод нийцэж буйг тодорхой мэдээлнэ. Дээж авах тохирсон аргыг хэрэглэнэ.

Бүтээгдэхүүнд жигд бусаар тархсан байж болох бохирдуулагч (жишээлбэл, зарим бүтээгдэхүүн дэх микотоксинууд)-ийн хувьд энэ асуудалд онцгойлон анхаарах нь чухал.

### **Хэрэглээний үзүүлэлтүүд**

Дундаж болон түлхүү хэрэглээтэй хэрэглэгчдийн аль алиных нь хувьд нийт хүнсний 50%-иас доошгүй, боломжтой бол 80%-д хамаарах бохирдуулагчтай холбоотой мэдээллийг авсан байна.

Өргөн хэрэглээний (үндсэн нэр төрлийн) хүнсний бүтээгдэхүүнд бохирдуулагч байгаа эсэх талаарх мэдээлэл нь хүнсний худалдаа, хэрэглээтэй холбоотой, бохирдуулагчаас үүсч болох эрсдлийн үнэлгээг хангалттай хийхэд зайлшгүй шаардлагатай.

Хэрэглээний үнэлгээнд эмзэг болон өртөмтгий бүлгийн хүн амын хүнсний бүтээгдэхүүний хэрэглээний тоон өгөгдлүүдийн дундаж үзүүлэлт хэрэгтэй. Гэвч энэ асуудлыг үндэсний болон олон улсын хэмжээнд өөр өөрөөр авч үзэх шаардлагатай. Иймд хүнсний бараа бүтээгдэхүүний олон төрлийг хамааруулан дундаж болон түлхүү хэрэглээтэй хүнсний талаарх мэдээлэл чухал бөгөөд ингэснээр өртөмтгий хүн амын бүлгийн хэрэглэгчдийн хувьд бохирдуулагч тус бүрээр ялган тодорхойлох боломж бүрдэнэ. Бүлгийг тогтоох шалгуур /жишээ нь: нас, хүйсийн ялгаа, цагаан хоолтон эсвэл хооллох заншилтай холбоотой орон нутгийн онцлог гэх мэт/ болон стастикийн асуудлын аль алинд хамаарахуйц, түлхүү хэрэглээтэй хэрэглэгчдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл байх хэрэгтэй.

### **Хоол хүнсээр дамжуулан авах бохирдуулагчийн хэмжээ**

ДЭМБ-аас гаргасан зөвлөмжид Химийн бохирдуулагчийн хэрэглээний хэмжээг судлах ерөнхий зарчмыг тогтоосон байна. Шаардлагатай бүх мэдээлэл (хувилбар буюу адилтгах хүнс, хүнсний нийт хэмжээ эсвэл зах зээлийн багтаамжийн судалгаа, сонгомол судалгаа), статистикийн тоо баримтуудаар хангасан байх нь чухал. Мөн хүнсний хэрэглээний загвар дээр бохирдлыг тооцоолж гаргасан ашигтай мэдээлэл болон гаргасан бохирдуулагч бодисын тооцоог ашиглаж болно. Хүнсний ангилал бүрээр тэдгээрийг бэлтгэх, боловсруулах үеийн үр нөлөөний тухай мэдээлэл байвал хавсаргана.

### **Шударга худалдааны хэлэлцүүлэг**

Олон улсын худалдаанд байгаа болон хүлээгдэж буй эсвэл боломжит асуудлууд: ХНБЭЗХ-оор хэлэлцүүлэхэд хэр зэрэг тулгамдсан асуудал болохыг үнэлэхийн тулд аюултай байдалд ороод буй сонирхогч талуудын эдийн засагт хүндрэл учруулахуйц хүнс, тэжээлийн эх сурвалж, цар хэмжээтэй холбоо бүхий одоо байгаа болон хүлээгдэж буй асуудлуудын тухай мэдээлэлтэй байх хэрэгтэй. Боломжит асуудлыг ч харгалзан үзвэл зохино.

### **Олон улсын худалдаанд нийлүүлэгдэж буй хүнс**

Асуудал үүсгэж болзошгүй эрсдэлтэй бараа бүтээгдэхүүнийг экспортлогч, импортлогч орнуудыг тодруулах, Хэлэлцүүлэгт хамрагдах бараа бүтээгдэхүүнээр

## **MNS CAS 193:2007**

тэргүүлэх экспортлогч, импортлогч орнуудыг тодруулах, гол экспортлогч орны бараа бүтээгдэхүүн дэх бохирдуулагч бодисын төвлөрлийн хэмжээний талаар тодорхой мэдээлэл зайлшгүй байх шаардлагатай.

### **Үндэсний зохицуулалтын талаарх мэдээлэл**

Үндэснийх нь дүрэм, журамд заасны дагуу асуудал үүсгэн буй бохирдуулагчтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг тухайн бүх (ялангуяа гол экспортлогч, импортлогч) орнуудаар гаргуулна.

Асуудлыг сайтар үнэлэхийн тулд зөвхөн өгөгдлийн үндэс төдийгүй мөн хүнсэн дэх зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтооход ашиглах эрсдлийг үнэлэх болон удирдан зохицуулах бодлого нь ч тодорхой байна.

### **Технологийн асуудлууд**

Бохирдуулагчийн эх үүсвэр ба түүгээр бохирдсон хүнсний талаар, хэрэв бололцоотой бол бүтээгдэхүүний бохирдсон тодорхой хэсгийн мэдээлэл нь бохирдлын үйл явцыг хянах боломжтой эсэхийг тогтоох, бүтээгдэхүүний чанарыг хүссэн хэмжээнд хангахад онцгой чухал ач холбогдолтой. Үүнд эх үүсвэртэй холбоотой боломжит хэмжилтүүдийг санал болгоно. Түүнчлэн бохирдлын асуудлыг хянах Үйлдвэрлэлийн зохистой дадал (ҮЗД) ба/эсвэл Хөдөө Аж Ахуйн зохистой дадал (ХААЗД)-ыг бий болгох шаардлагатай. Зөвшөөрөгдөх дээд хэмжээг ҮЗД эсвэл ХААЗД-д үндэслэн тогтоовол энэ нь тодорхой бодлоготойгоор хүрч болох хамгийн бага түвшин байх болно. Эрсдлийн үнэлгээний анхдагч загвар (онолын хувьд нэг өдрийн хэрэглээний дээд түвшин)-т тооцож, зөвлөмж болгосон хорт бодисын дээд хэмжээнээс хэтэрсэн үед бохирдлын асуудлыг удирдан зохицуулахад технологийн боломжийг тухайлбал угаалга, цэвэрлэгээг харгалзан үзнэ. Энэ тохиолдолд бохирдлын түвшинг харьцангуй бууруулах боломжийг нарийвчлан тогтоох хэрэгтэй. Үүний тулд санал болгосон стандартыг дагаж мөрдөхөд нийгмийн эрүүл мэндийн байдалд гарч болох маргаантай асуудлыг аль ч талаас нь тооцсон үнэлгээнд тулгуурлан зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтооход бүх асуудлыг нарийвчлан судалсан байх шаардлагатай.

### **Эрсдлийн үнэлгээ, эрсдлийг удирдах асуудлууд**

Хүнсэн дэх бохирдуулагчаас үүдэн нийгмийн эрүүл мэндэд учирч болох эрсдлийн талаар нэгдсэн бодлого боловсруулахад эрсдлийн үнэлгээ ба удирдах арга хэмжээг багтаасан шаталсан аргачлалыг зөвлөмж болгоно.

**Эрсдлийн үнэлгээ нь** хүн хүнснээс үүдэлтэй аюулд өртөснөөс эрүүл мэндэд нь учирсан болон учирч болзошгүй сөрөг нөлөөллийг шинжлэх ухааны үүднээс тодорхойлсон үр дүн.

Энэхүү ажиллагаа нь дараах үе шатаас бүрдэнэ. Үүнд: *аюулыг илрүүлэх, аюулыг тодорхойлох, өртөлтийг үнэлэх* ба эрсдлийг *тодорхойлох* (тодорхойлолт нь эрсдлийн тоон үзүүлэлтийг онцгойлон авч үзсэн эрсдлийн тоон үнэлгээ, эрсдлийн чанарын илэрхийлэл мөн оролцогчийн тодорхой бус байдлын заалтыг агуулдаг.

Аюулыг илрүүлэх ба аюулыг тодорхойлох эхний үе шатууд.

**Аюулыг илрүүлэх** нь тодорхой хүнс буюу хүнсний бүлэгт байж болох бохирдуулагч, хүний эрүүл мэндэд нөлөөлсөн эсвэл нөлөөлж болзошгүйг илрүүлэх ажиллагаа юм.

**Аюулыг тодорхойлох** шат нь хүнсэн дэх бохирдуулагчаас үүдэлтэй сөрөг нөлөөллийн шинжийг чанарын, боломжтой тохиолдолд тоо хэмжээг нь үнэлэх, үүнд авах тунгийн хэмжээ ба өөрчлөлтийг тодорхойлох, боломжтой үед бохирдуулагчийн хэрэглээний аюулгүйн түвшинг тогтоох (ХЗХ, ХАХ эсвэл хоруу чанарыг харьцуулж болох зөвлөмжүүд) зэрэг асуудлууд орно.

**Өртөлтийг үнэлэх** шатанд хүнсний бүтээгдэхүүн нь бусад эх үүсвэрээр дамжуулан авч болох хорт бодисын чанарын, хэрэв боломжтой бол тоон үнэлгээг тодорхойлно.

**Эрсдлийн тодорхойлолтын** шатанд аюулыг илрүүлэх, тодорхойлох, мөн өртөлтийн үнэлгээний шатуудыг нэгтгэн, тодорхой (оролцогчийн тодорхой бус байдлыг оруулаад) хүн амын бүлэгт илэрч болох мэдэгдэж буй болон гарч болзошгүй эрүүл мэндийн нөлөөлөл түүний хурц байдлыг үнэлнэ. Тодорхой бүлэг хэрэглэгчдийн тухайн бохирдуулагчийг авах тунгийн хэмжээ нь (удаан хугацааны туршид авах тунгийн хэмжээ нь зөвлөмжид зааснаас давсан болох нь нотлогдсон бол) хэтэрсэн тохиолдолд нийгмийн эрүүл мэндэд гарч болох эрсдлүүд бодитойгоор оршиж байна гэж үзнэ.

Бодит байдалд хорт бодисын хэрэглээ нь стандартаас хэтэрсэн, хялбар багасахааргүй бол илүү дэлгэрэнгүй эрсдлийн үнэлгээ, тодорхойлолт хэрэгтэй.

Бохирдуулагчийн аюулгүйн хэмжээг тогтоох бололцоогүй тохиолдолд ч энэ асуудал хамаатай.

**Эрсдлийн удирдлага** нь шаардлагатай үед хүнсэн дэх бохирдуулагчийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоох ба түүнийг дагаж мөрдүүлэхэд тохирох хяналтыг сонгох болон хэрэгжүүлэхийн тулд эрсдлийн үнэлгээнд хамаарах бодлогын хувилбарыг цэгнэж үзэх үйл явц юм.

Энэ нь эрсдлийн хангалттай үнэлгээ, бохирдлын асуудлыг авч үзэх стратеги, бодлогод үндэслэх бөгөөд эрсдлийн мэдээлэл солилцоог багтаадаг.

**Эрсдлийн мэдээлэл солилцоо** гэдэг нь эрсдлийг үнэлэгч, эрсдлийн менежер болон бусад сонирхогч талууд эрсдэлтэй холбоотой санал, бодол, мэдээллээ өөр хоорондоо харилцан солилцохыг хэлнэ. Эрсдлийн удирдлага нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой шинжилгээний өгөгдлүүд, бүтээгдэхүүний бохирдлыг хянах технологийн боломжууд, эдийн засгийн хүчин зүйлс болон олон улсын худалдааны шалгууруудыг тооцсон зөв нэгдсэн бодлогыг хэрэгжүүлнэ. Товчхондоо эрсдлийн үнэлгээ нь хичнээн хэрэглэгч, хорт бодисын хэмжээг стандартад зааснаас хэтрүүлэн ямар хугацаанд, хэр зэрэг хэмжээгээр хэрэглэсэн болох, энэ нь эрүүл мэндийн эрсдэлд бодитойгоор хэрхэн нөлөөлөхийг тогтооно. Эрсдлийн удирдлага нь бохирдлыг хянах, нийгмийн эрүүл мэндийг хангалттай хамгаалахын тулд ямар үйлдэл шийдвэрийг гаргах, тухайн байдалд юуг зөвшөөрөх, юуг эс зөвшөөрөх, бусад хүчин зүйлсийг ямар хэмжээнд авч үзэхийг бүхэлд нь шийднэ. Эрсдлийн удирдлагын шийдвэр нь хүнсэн дэх бохирдуулагчийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтооход хүргэж болно. Ийм шийдвэр гаргахдаа үйл явцад үр дагавар, өртөг, үр ашгийг бодлогын бусад хувилбаруудтай нь харьцуулан үнэлж үзүүлнэ.



**Бохирдуулагчийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоох**

Хүнсэн дэх бохирдуулагчийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтооход хэд хэдэн зарчмыг баримтлах бөгөөд заримыг өмнө дурдсан болно. Товчоор, тэмдэглэхэд энэ асуудалд баримтлах нэгдмэл бодлогод дараах шалгууруудыг ашиглана:

- Зөвшөөрөгдөх дээд хэмжээг (ДХ) зөвхөн эрүүл мэндэд онцгой эрсдэлтэй, олон улсын худалдаанд учирч байгаа болон учирч болох асуудал аль аль шинж чанарыг агуулсан бохирдуулагчдад тогтооно.
- Хэрэглэгч нь бохирдуулагчид бүрэн өртөж болох тийм хүнсэнд зөвшөөрөгдөх дээд хэмжээ(ДХ)-г тогтооно. Тодорхой төрлийн хүнсний бохирдуулагчид бүрэн өртөх хэмжээг тогтоохдоо ХНБЭЗХ-ны хүнс, буюу хүнсний бүлэг дэх хорт болон бохирдуулагч бодисын өртөлтийн үнэлгээнд баримтлах бодлогод тусгагдсан шалгууруудыг авч үзнэ. (Хүнсний хууль эрх зүйн хорооны журмын гарын авлага дахь ХНБЭЗХ-ны “Хүнсэн дэх хорт болон бохирдуулагч бодисын өртөлтийн үнэлгээнд баримтлах бодлого”-ын 11 дэх хэсгийг үзнэ үү)
- Зөвшөөрөгдөх дээд хэмжээг (ДХ) боломжит хамгийн бага хэмжээнд тогтооно. Хэрэв, хоруу чанарын хувьд боломжтой бол хүнсний үйлдвэрлэл, худалдаан дахь зүй бус доголдоос зайлсхийх үүднээс дээд хэмжээг орчин үеийн дэвшилтэт технологиор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн дэх бохирдуулагчийн дундаж хэмжээнээс ялимгүй дээгүүр тогтооно. Боллоцтой үед ДХ-г ҮЗД болон/буюу ХААЗД-д үндэслэн тогтооно. Энд бохирдуулагчийн хэмжээг боломжит хамгийн бага хэмжээнд байлгах удирдлагын зарчмаар эрүүл мэндийн асуудлыг хамтатган авч үздэг. Орон нутгийн байдал, боловсруулалтын нөхцлөөс хамаарч илэрхий бохирдсон боловч боломжит аргаар залруулга хийж болох хүнсийг энэ үнэлгээнд оруулахгүй. (зөвшөөрөгдөх дээд хэмжээг өндөр тогтоох нь нийгмийн эрүүл мэндийн хувьд хүлээн зөвшөөрч болох ч эдийн засгийн хохиролд оруулна).
- Бүтээгдэхүүн дэх зөвшөөрөгдөх дээд хэмжээ (ДХ)-ний талаарх саналыг гаргахдаа наад зах нь тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг/боловсруулдаг үндсэн салбарыг хамарсан, цаашилбал олон улсын худалдаанд оролцож буй тэдгээр орнуудын мэдээлэл, өгөгдөлд үндэслэсэн байна. Бохирдлын явц нь хангалттай ойлгомжтой бөгөөд дэлхий нийтийн хэмжээнд авч үзэхүйц бол товч өгөгдлүүд хангалттай байж болно.
- Тухайн хүнсний бүлгийн хувьд бохирдлын явцын мэдээлэл, цаашлаад тоо баримтыг түшиглэн урьдчилан тооцоолох хэрэгтэй гэж үзвэл тэрхүү хүнсний бүлэгт зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоож болно.
- Хэрэглэхэд хүндрэл үүсгэхээргүй бол зөвшөөрөгдөх дээд хэмжээний тоон илэрхийлэл нь геометрийн шатлалаар тогтмол тоонууд (0.01, 0.02, 0.05, 0.1, 0.2, 0.5, 1,2,5 гэх мэт) байхыг илүүд үзнэ.
- Зөвшөөрөгдөх дээд хэмжээг цуврал бүрийг төлөөлөх дээжинд хэрэглэнэ. Хэрэв шаардлагатай бол, тохирох дээж авах аргыг онцлон заана.
- Хэрэв нийгмийн эрүүл мэндийн болгоомжлол нь шинжилгээний илүү боловсронгуй аргаар л илрүүлж чадах, бага хэмжээтэй байхыг шаардаагүй бол зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь хяналтын энгийн лабораторид хэрэглэдэг шинжилгээний аргуудаар тодорхойлж болохуйц хэмжээнээс бага байх ёсгүй. Гэхдээ бүх тохиолдолд ДХ-г хянаж чадах, шинжилгээний баталгаатай арга байвал зохино.
- Зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоохоор шинжлэх гэж байгаа бохирдуулагчийн чанарыг нарийвчлан тодорхойлсон байна. Хоруу чанараас хамааралтай гэж үзвэл бодисын солилцооны задралын бүтээгдэхүүнүүдийг үүнд багтаана. Мөн энэ нь өөр хоорондоо холбоотой бохирдуулагчийн бүлгээс сонгосон танигч бодис байж болно.

- Зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоохоор шинжлэх гэж байгаа бохирдуулагчийн чанарыг нарийвчлан тодорхойлсон байна. Ерөнхийдөө зөвшөөрөгдөх дээд хэмжээг анхдагч бүтээгдэхүүнд тогтооно.
- Зөвшөөрөгдөх дээд хэмжээг бүтээгдэхүүний цэвэр жинд тооцон холбогдох бохирдуулагчийн түвшингээр илэрхийлнэ. Гэвч зарим тохиолдолд баталгаатай үндэслэл бий гэж үзвэл хуурай жинд нь тооцож илэрхийлж болно.
- Шинжилгээ хийх болон дээж бэлтгэх үйл явцыг алдагдуулж болох иддэггүй хэсгийг салгах шаардлагатай бүтээгдэхүүнийг худалдаанд нийлүүлэгдэх байдлаар нь тодорхойлно.
- ПҮЭЗХ-ны хүрээнд авч үздэг хүнс, тэжээлийн ангилалд багтсан бүтээгдэхүүний тодорхойлолтыг энд удирдамж болгоно. Бусад бүтээгдэхүүний тодорхойлолтыг зөвхөн тодорхой тохиолдолд хэрэглэнэ. Гэвч бохирдуулагчийг тодорхойлоход бүтээгдэхүүний иддэг хэсэгт шинжилгээ хийж, ДХ-г тогтооно. Амьтны гаралтай бүтээгдэхүүнд хуримтлагдах тосонд уусдаг бохирдуулагчийн хувьд янз бүрийн тосны найрлагатай бүтээгдэхүүнд ДХ тогтоох аргачлалыг (тосонд уусдаг пестицидүүдийн нөхцөлтэй харьцуулан) хэрэглэнэ.
- Анхдагч бүтээгдэхүүнд тогтоосон зөвшөөрөгдөх дээд хэмжээг боловсруулсан бүтээгдэхүүн болон нийлмэл найрлагатай бүтээгдэхүүнд ашиглах зөвлөмж байх шаардлагатай. Өтгөрүүлсэн, хатаасан, шингэрүүлсэн бүтээгдэхүүнд ашигласан өтгөрүүлэлт, шингэрүүлэлтийн хүчин зүйл нь эдгээр боловсруулсан бүтээгдэхүүн дэх бохирдуулагчийн хэмжээг анхны байдлаар үнэлэхэд дөхөм болдог. Мөн нийлмэл найрлагатай бүтээгдэхүүн дэх бохирдуулагчийн концентрацийн дээд хэмжээг тогтоохдоо бүрэлдэхүүнээс нь тооцож болно. Илүү хангалттай зөвлөмж өгөхөд боловсруулалтын явц (жишээ нь угаах, хальслах, хандлах, чанах, хатаах гэх мэт) дахь бохирдуулагчийн шинж чанарын мэдээлэл хэрэгтэй.
- Боловсруулсан бүтээгдэхүүн дэх бохирдуулагчийн хэмжээ нь тэдгээр бүтээгдэхүүнийг гарган авсан анхдагч бүтээгдэхүүн дэх бохирдуулагчийн хэмжээтэй нь харьцуулахад ялгаатай бөгөөд бохирдлын загварын мэдээлэл хангалттай байвал, тэдгээр боловсруулсан хүнсний бүтээгдэхүүнд зөвшөөрөгдөх дээд хэмжээг тусад нь тогтоож болох юм.
- Мөн боловсруулалтын явцад бохирдол үүсч байвал дээрх аргыг хэрэглэнэ. Ерөнхийдөө зөвшөөрөгдөх дээд хэмжээг хөдөө аж ахуйн анхдагч бүтээгдэхүүнд тогтоохыг чухалчлах бөгөөд тохиромжтой хүчин зүйлийг ашиглан үйлдвэрлэсэн олон-бүрэлдэхүүнт болон шинээр гарган авсан хүнсний бүтээгдэхүүнд хэрэглэж болно. Тэдгээр хүчин зүйлүүдийн талаар хангалттай мэдээлэл бий болсон үед бохирдуулагчийн тухай мэдээлэлд нэмж оруулах ба бүтээгдэхүүн дэх зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй холбоотойгоор дурдагдах ёстой. Зөвшөөрөгдөх дээд хэмжээг нийгмийн эрүүл мэндийн талаас авч үзсэн анхны баримжаа (онолоор тооцсон дээд хэмжээ, эрсдлийн үнэлгээ)-наас хэтрүүлэн тогтоож болохгүй. Энэ нь зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоох бусад шалгууруудтай холбоотой асуудал үүсгэж байвал, бохирдуулагчийн хэмжээг бууруулах дараагийн арга хэмжээ (жишээ нь: ХААЗД болон ҮЗД-н нөхцлийг сайжруулах) шаардлагатай. Ингэснээр хангалттай үр дүнд хүрч чадахгүй бол ДХ-г зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах дараагийн шатны сайтар боловсруулсан эрсдлийн үнэлгээ, бохирдуулагчийн эрсдлийн удирдлагын арга хэмжээг авах хэрэгтэй.

**Бохирдуулагчийн зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй (санал болгосон) холбогдох эрсдлийн үнэлгээний аргачлал**

Бохирдуулагч бодисыг агуулсан хүнсний бохирдлыг хянах нь хүнсний нэмэлт болон пестицидийн үлдэгдэлтэй хүнсний бүтээгдэхүүн дэх бохирдлыг хянахтай харьцуулахад илүү төвөгтэй нь тодорхой юм. Энэ байдал нь зөвшөөрөгдөх дээд хэмжээг санал болгоход нөлөөлдөг. Бохирдуулагчийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг хуулиар хүлээн зөвшөөрүүлэхийн тулд тэдгээр ДХ-г эрэмбэ дараатайгаар бодитой тогтоосон үнэлгээ чухал. Энэ аргачлалаар хоруу чанарын талаас авч болох хамгийн дээд хэмжээ ба одоо байгаа болон санал болгож буй ДХ-тэй уялдуулан хоногийн хэрэглээг тооцдог. Пестицидийн үлдэгдлийн хувьд хоногийн хэрэглээнээс авах үлдэгдлийн хэмжээг урьдчилан тогтоохын тулд зөвлөмж (ДЭМБ 1989, 1995 онд дахин хянасан)-ийг боловсруулсан бөгөөд үүндээ хэрэглээг бодитойгоор урьдчилан тооцох 2 шатлалт аргачлалыг багтаасан. Хамгийн үнэн зөв үнэлгээнд хэрэглэсэн хүнсэн дэх бохирдуулагчийн мэдэгдэж буй үлдэгдлийн хэмжээ, бүтээгдэхүүнийг бэлтгэх, тээвэрлэх, хадгалах явцад бохирдуулагчийн хэмжээнд орсон өөрчлөлтийг тооцох залруулга, хоол хүнсний үндэсний загварыг хамруулна Хүн амын тодорхой бүлэгт хамаарал бүхий хүнсний хэрэглээний дундаж үзүүлэлтийг хэрэглэх нь тохиромжтой гэж үздэг ч түүнээс бусад хэмжигдэхүүнийг болгоомжтой хэрэглэхийг зөвлөдөг. Дээрх аргачлалыг санал болгож буй үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг зөвшөөрөх эсэхийг шийдвэрлэх, зөвшөөрөгдсөн хэмжээг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлэхэд хэрэглэнэ. Мөн хүнсэн дэх байгалийн хорт бодис болон бохирдуулагчийн аль алинд нь энэ аргачлалыг хэрэглэнэ. Хорыг авах хэмжээг тооцоолоход, үндэсний болон олон улсын эрүүл мэндийн хамгаалал ба эрсдлийн удирдлагын бодлогод хүлээн зөвшөөрөгдсөн бол хорыг авах хэмжээ ихтэй аюултай хүнсний хэрэглээний загварыг хэрэглэж болно. Аль болох бодит байдалд тулгуурласан зохистой хэрэглээний үнэлгээний бодит загварыг ашиглах нэгдмэл аргачлал хэрэгтэй. Тооцож гаргасан үзүүлэлтийг бололцоотой тохиолдолд хэрэглээний бодит үзүүлэлтүүдтэй байнга харьцуулж байна. Санал болгож буй зөвшөөрөгдөх ДХ-нд хорыг авах хэмжээг тооцсон тооцоо, тэдгээрийг хэрэглэх болон хүлээн зөвшөөрөхөд хамаарах эрсдлийн үнэлгээний дүгнэлтийг дагалдуулна. Хорыг авах хэмжээг тооцоолохдоо ХНБЭЗХ-ны өртөлтийн үнэлгээний бодлогод заасан аргыг хэрэглэх ба хэрэв боломжтой гэж үзвэл хүнсний бүтээгдэхүүний тодорхой бүлэг дэх өтгөрүүлэлт/концентрац/-ийн тархалтын жиших муруйг ашиглана. (Хүнсний хууль эрх зүйн хорооны журмын гарын авлага дахь ХНБЭЗХ-ны “Хүнсэн дэх хорт болон бохирдуулагч бодисын өртөлтийн үнэлгээнд баримтлах бодлого”-ын 5-8, 12-14 дэх хэсгийг үзнэ үү )

(Санал болгож буй) ДХ-г хүлээн зөвшөөрөхгүй талаарх Засгийн Газрын мэдэгдэл нь тухайн байр суурийг тодорхойлсон эрсдлийн удирдлагын дүгнэлт болон тухайн хорыг авах хэмжээг тооцсон тооцоон дээр үндэслэсэн байна.

## В Хавсралт

### Эрсдлийг удирдан зохицуулах шийдвэрийн үйл ажиллагаа

#### Өмнөх үг

ХБЭЗХ дахь эрсдлийн удирдлагын зөвлөмж аргачлалуудыг Оршил 1.4.2-т дурдсан гол шалгуурууд дээр үндэслэсэн энгийн шийдвэрийн хүснэгт байдалтай үзүүллээ. Урьдчилсан нөхцөл болох шалгуур (1) буюу бохирдуулагч (асуудал)-ийн тухай үндсэн мэдээлэлгүйгээр ямар нэг аюулыг илрүүлэх, аюулыг тодорхойлох тухай яриа байж болохгүй учраас цаашид дурдахгүй. Шалгуур (5) буюу технологи, эдийн засгийн асуудал нь бохирдуулагчийн талаарх эрсдлийн удирдлагатай холбоотой зөвлөмж боловсруулах, дээд хэмжээг тогтооход чухал хэрэгсэл бөгөөд энэ мэдээлэл хангалтгүй үед өөр мэдээ баримт шаардагдах болно. Үүнийг санаж, доор үзүүлсэн шийдвэрийн хүснэгтэд дахин дурдах албагүй.

Шийдвэр нь дараах шалгууруудад мэдээлэл байгаа /(-),(+),(?) / эсэхэд үндэслэгдэж болно.

- |           |  |
|-----------|--|
| (2a) ХЧМ  | хоруу чанарын мэдээлэл                 |
| (3) ЭМА   | гарч болох эрүүл мэндийн асуудал       |
| (2b) Ш/ХӨ | шинжилгээний болон хэрэглээний өгөгдөл |
| (4) ОУХА  | олон улсын худалдааны асуудал          |

ЭМА баганад хэрэглэсэн асуултын тэмдэг(?) нь зөвхөн хортой чанарын мэдээ хангалттай байгаа эсвэл зөвхөн хэрэглээний өгөгдөл байгаа, тиймээс гарч болох эрүүл мэндийн асуудал байгаа эсэх талаар шийдвэр гаргах хангалттай үндэслэл болохгүйг заана. Мэдээжээр амьдрал дээр хүснэгтэд үзүүлсэн шиг тодорхой бус байдал олонтаа тохиолддог. Мэдээлэл заримд нь хангалттай, заримынх нь хувьд хангалтгүй байж болох юм. 1 дүгээр хавсралтад дурдсан шалгуурыг харгалзан тохиолдол тус бүрээр шийдвэр гаргана. Бодит байдалд үүнтэй холбоотой бэрхшээлтэй асуудал тулгарвал шийдвэр гаргахад хэрэгтэй үндсэн өгөгдлийн шалгууруудыг цаашид тоо хэмжээний хувьд тодорхойлох шаардлагатай байж болно.

### 1 дүгээр хүснэгт-Хүнсний бохирдуулагчийн Эрхзүйн Хороо (ХБЭЗХ)-ны эрсдлийг удирдан зохицуулах шийдвэр

	Шалгуур				ХБЭЗХ-ны үйл ажиллагааны нөхцөл
	(2a) ХЧМ	(2b) Ш/ХӨ	(3) ЭМА	(4) ОУХА	
1	-	+	?	-	ХНШХ-гоор хоруу чанарын үзүүлэлт/үнэлгээ тогтоолгох хүсэлт
2	-	+	?	+	ХНШХ-гоор хоруу чанарын үзүүлэлт/үнэлгээ ба үндэсний аюулын үнэлгээ тогтоолгох хүсэлт Яаралтай бол ХБЭЗХ-ны мэдэгдэл
3	+	-	?	-	Шинжилгээний болон хэрэглээний өгөгдлүүдийг тогтоолгох хүсэлт
4	+	+	-	-	Цаашид авах арга хэмжээ байхгүй
5	+	+	-	+	Үндэсний эрсдлийн үнэлгээний хүсэлт, үнэлгээний дараа (яаралтай үед, урьдчилсан үнэлгээний дараа) ХБЭЗХ-ны мэдэгдэл
6	+	+	+	-	ХБЭЗХ-ноос дээд түвшинг тогтоох
7	+	+	+	+	ХБЭЗХ-ноос дээд түвшинг (яаралтай үед, шаардлагатай гэж үзвэл, түр зуурын дээд түвшинг) анхлан тогтоох

(-) Хангалттай бус мэдээ

(+) Хангалттай мэдээ

(?) Зөвхөн хортой чанарын мэдээ хангалттай байгаа эсвэл зөвхөн хэрэглээний өгөгдөл байгаа, тиймээс гарч болох эрүүл мэндийн асуудал байгаа эсэх талаар шийдвэр гаргах хангалттай үндэслэл болж чадахгүй.

## С Хавсралт

### Хүнсэн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандартын (ХББЕС) -ын бүтэц

#### Өмнөх үг

1 дүгээр хүснэгтийн бүтэц нь дараах элементүүдийг агуулсан байна.

- **Бохирдуулагчийн нэр:** тэмдэг, ижил утгатай үг, товчилсон үг, шинжлэх ухааны тайлбар, ялган танихад гол төлөв хэрэглэдэг код зэргийг дурдсан байна.
- **Бохирдуулагчийн дугаар:** 1 дүгээр хүснэгтийн жагсаалтад бичсний дагуу
- **ХНШХ-ны лавлах баримтууд** (бохирдуулагчийг авч хэлэлцсэн)
- **ХЗХ (хоногийн зохистой хэрэглээ), ХАХ (хоногт авч болох хэмжээ), ДХТХ (долоо хоногийн түр зөвшөөрөгдөх хэмжээ) гэх зэрэг хорт бодисыг авах хэмжээний зөвлөмж** ээдрээтэй нөхцөл байдалд бага хэмжээний дүгнэлт, лавлагаа хэрэгтэй байж болно.
- **Үлдэгдэл бодис:** Дээд түвшинг зайлшгүй тодорхойлбол зохих бохирдуулагч бодис
- **Бохирдуулагчтай холбоотой стандартуудын жагсаалт, хүнсний бүтээгдэхүүний ангиллаар:** Энэхүү жагсаалт нь дараах элементүүдээс (хүснэгтэнд үзүүлснээр) бүрдэнэ.
  - Бохирдуулагчийн нэр
  - Зөвшөөрөгдөх дээд хэмжээний тоон үзүүлэлт
  - Эрх зүйн баримт бичиг боловсруулах үе шат (зөвхөн ХБЭЗХ –ны ажлын баримт бичиг)
  - Заалт, тэмдэглэгээ, тайлбар
- **Хүнсний дадлын хуулийн тодруулга** , тохиромжтой бол
- **Хүнсний бүтээгдэхүүн / төрлийн нэр**
- **Хүнсний бүтээгдэхүүн эсвэл хүнсний төрлийн ангиллын дугаар**  
Хүснэгт 2-ын бүтэц нь дараах элементүүдийг агуулна.
- **Хүнсний бүтээгдэхүүн / төрлийн нэр**
- **Хүнсний бүтээгдэхүүн эсвэл хүнсний төрлийн ангиллын дугаар**
- **Бохирдуулагчтай холбоотой стандартуудын жагсаалт, хүнсний бүтээгдэхүүний ангиллаар:** Энэхүү жагсаалт нь дараах элементүүдээс (хүснэгтэнд үзүүлснээр) бүрдэнэ.
  - Бохирдуулагчийн нэр
  - Зөвшөөрөгдөх дээд хэмжээний тоон үзүүлэлт
  - Эрх зүйн баримт бичиг боловсруулах үе шат (зөвхөн ХБЭЗХ –ны ажлын баримт бичиг)
  - Заалт, тэмдэглэгээ, тайлбар (1 дүгээр хүснэгтийнхээс бага)
- **Хүнсний дадлын хуулийн тодруулга** , тохиромжтой бол

## D Хавсралт

## Хүнсний ангиллын систем (ХХББЕС-ын)

## Өмнөх үг

Дараах үүргийг гүйцэтгүүлэхийн тулд ХХББЕС-ын хүнсний ангиллын системийг боловсруулсан. Зөвшөөрөгдөх дээд хэмжээ(ДХ) /санал болгож буй/-г тодорхой системтэйгээр үзүүлэх логик бүтэцтэй. Энэ нь ' дээд түвшинг зайлшгүй шинжлэх бүтээгдэхүүний хэсэг ба бүтээгдэхүүний тодорхойлолтыг агуулдаг. Мөн тоо, мэдээллийг хадгалж засахад хялбар байлгахын тулд төрөл бүрийн хүнс болон нэг хүнсний бүтээгдэхүүний кодыг багтаасан байдаг. Аль болох цогц байдлыг буй болгох үүднээс одоогийн хүлээн зөвшөөрөгдсөн ангиллын системийг хэрэглэнэ. ХХББЕС нь ПҮЭЗХ-ны хүрээнд боловсруулсан системийг хэрэглэсэн бөгөөд энэ нь мөн бохирдуулагчийн хувьд ч тохиромжтой юм. Үүнийг өргөн хэрэглээний төрөл бүрийн хүнсний бүтээгдэхүүний бүлэг болон ганцаарчилсан бүтээгдэхүүний шинж чанарыг тогтооход хуулбарлан авсан болно. Ялангуяа энэ систем нь хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдэд зориулан боловсруулагдсан учраас цаашид боловсруулсан хүнсний бүтээгдэхүүнд зориулан дэлгэрүүлэх хэрэгтэй. Шаардлагатай бол шинэ (дэд) бүлэг эсвэл бүтээгдэхүүний кодыг оруулж өгнө. Эдгээр нь D.1 хавсралтад тусгагдсан. Мөн D.1 хавсралт нь ПҮЭЗХ-оос боловсруулсан одоогийн системд тусгагдснаас ялгаатай бүтээгдэхүүний тодорхойлолтыг агуулсан байна. **Боломжтой болон шаардлагатай тохиолдолд хүнсний бүтээгдэхүүнд тухайн бүтээгдэхүүний анхдагч түүхий эдээс хамаарсан өтгөрүүлэлт болон шингэрүүлэлтийн хүчин зүйлийг тусгасан тодорхойлолтыг дагалдуулна.** Ингэснээр анхдагч түүхий эдээс эцсийн бүтээгдэхүүнд бохирдуулагч дамжих боломжийн эхний үнэлгээг хийж чадна. Гэвч анхдагч түүхий эд дэх бохирдуулагчийн өвөрмөц тархац, боловсруулалтын явц дахь түүний шинж чанар—эдрээтэй хүчин зүйл гэдгийг санах нь зүйтэй. Тэр тохиолдолд нэмэлт зөвлөмж хэрэгтэй. Тухайн бохирдуулагчтай холбоотой тодорхой мэдээллийг 1 дүгээр хавсралтад тусгасан ерөнхий шинж чанараас үзнэ үү.

## ХХББЕС-ын хүнсний ангиллын системийн тайлбар

Эхний хэсэг нь ПҮЭЗХ-ны боловсруулж, дэлгэрүүлсэн ангиллын системийг багтаана Ургамлын болон амьтны гаралтай анхдагч бүтээгдэхүүнүүд, анхдагч хүнсний бүтээгдэхүүнүүд, ургамлын болон амьтны гаралтай боловсруулсан бүтээгдэхүүнүүдийг багтаасан 5 бүлгээс тогтоно. Бүлэг нь цаашид кодын дугаар, үсгээр тэмдэглэгдэх 19 төрөл, 93 зүйлд хуваагдана.

D.1 хавсралт нь ХХББЕС-ын хүнсний ангиллын системийн нэг хэсэг нь юм. Үүнийг ХБЭЗХ боловсруулж, хянан шинэчилдэг ба энэ нь нэгдүгээр хэсэгт тусгасан системийн нэмэлт бүрдүүлэлт болно. Энэхүү ангилал нь голдуу боловсруулсан, салбарласан, олон - бүрэлдэхүүнт буюу нийлмэл найрлагатай хүнсэнд чиглэгдсэн бөгөөд одоо байгаа болон байж болох бохирдуулагчдад зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоож өгөхөд зайлшгүй шаардлагатай бүх төрөл, зүйлийн бүтээгдэхүүний тодорхойлолт, кодыг хамарсан байна.

## D.1 Хавсралт

ХХББЕС-д зориулсан хүнсний ангиллын системийн  
нэмэлт бүрдүүлэлт

## Танилцуулга

Хүнсний ангиллын системийг тусгасан энэхүү хавсралт дахь нэмэлтүүдийг энэ хавсралтад ороогүй бүтээгдэхүүнд хүнсний код-дугаар олгоход хэрэглэнэ. Эдгээр нь голдуу боловсруулсан, шинээр гарган авсан болон олон бүрэлдэхүүнт бүтээгдэхүүнүүд юм. Хүнсний ангиллын системийг цаашдын боломжит хэрэгцээг хангахуйцаар олон талыг хамарсан жагсаалт /ерөнхий түвшинд/ байдлаар боловсруулсан. Энэ шатанд ямар ч бүтээгдэхүүний тодорхойлолт, код тусдаа өгөгдөөгүй.

Системийг зөвшөөрөх эсэхийг хэлэлцэхэд төрөл, бүлгээс цааш илүү нарийвчилсан түвшинд хэлэлцэх шаардлагагүй гэж үзлээ. Хэрэгцээ гарвал ангиллыг илүү нарийвчлан боловсруулж болно. Хүнсний нэмэлтийн ерөнхий стандарт (ХНЕС)-ын хүнсний ангиллын системийг энэ хавсралтад тусгасан одоо байгаа ангиллын системтэй тохирч байгаа учир хэрэглэлээ. Санал болгож буй хүнсний шинэ ангиллуудыг үзнэ үү.

Санал болгож буй системийг илүү ойлгож мэдэхэд зориулан зарим тайлбар /хүснэгтэд үзүүлснээр/ болон хэрэглэж буй холбогдох хүнсний ангиллуудыг оруулав. Бүтээгдэхүүний тодорхойлолтыг одоогийн стандартаас иш татаж болно. Боломжтой болон шаардлагатай тохиолдолд анхдагч бүтээгдэхүүнээс дамжсан бохирдолттой холбоотой, өтгөрүүлэлт ба шингэрүүлэлтийн талаарх мэдээллүүдийг нэмж болно. Түүнчлэн шинжилгээ хийх мөн бохирдлын дээд түвшин тогтоогдох ёстой, энэ хавсралтад байгаа тодорхойлолтуудаас ялгаатай, бүтээгдэхүүний хэсэгт зориулсан тодорхойлолтуудыг нэмж тусгана.

Ангилал	Төрөл	Бүлэг	Үсгэн код	Хүнсний бүлгийн тодорхойлолт
D				УРГАМЛЫН ГАРАЛТАЙ БОЛОВСРУУЛСАН ХҮНС /байгаа/
D	01			Ургамлын гаралтай хоёрдогч бүтээгдэхүүн / 5 бүлэг байгаа /
D	01	06	TF	Жимсээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн /хальсалсан, зүссэн, хөлдөөсөн гэх мэт/ /санал болгох шинэ бүлэг, бүтээгдэхүүний кодыг одоо байгаа жимсний кодоос боловсруулна/
D	01	07	TV	Ногоогоор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн /угааж, цэвэрлэсэн, зүссэн, хөлдөөсөн гэх мэт/ /санал болгох шинэ бүлэг, бүтээгдэхүүний кодыг одоо байгаа жимсний кодоос боловсруулна/
D	02			Ургамлын гаралтай бүтээгдэхүүнүүд /одоо 7 бүлэг байгаа /
D	02	08	JV	Ногооны шүүс, нухаш /санал болгох шинэ бүлэг, бүтээгдэхүүний кодыг одоо байгаа ногооны кодоос боловсруулна/
D	02	09	SH	Сахар, сироп, зөгийн бал /санал болгох шинэ бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
D	03			Үйлдвэрийн аргаар боловсруулсан ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүн /олон бүрэлдэхүүнт буюу нийлмэл найрлагатай/ (1 бүлэг байгаа)
D	03	01	CF	Үйлдвэрийн аргаар боловсруулсан нийлмэл найрлагатай үр тариан бүтээгдэхүүн /жишээ

				нь: талх ба бусад үр тариагаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн/ (бүлэг байгаа)
D	03	02	CB	Үр тариагаар үйлдвэрлэсэн ундаа /жишээ нь: пиво / шаардлагатай гэж үзвэл шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
D	03	03	NF	Жимсний нектар / санал болгох шинэ бүлэг, бүтээгдэхүүний кодыг одоо байгаа жимсний кодоос боловсруулна/
D	03	04	FF	Ферментжүүлсэн жимсний ундаа /вино, алимны ундаа/ /шинээр санал болгож буй бүлгийн бүтээгдэхүүний кодыг сонирхож буй тухайн жимснийхээ одоо байгаа кодоос боловсруулна/
D	03	05	DA	Спиртлэг шингэн ундаа /шаардлага гарах тохиолдолд шинээр санал болгож буй бүлгийн бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
D	03	06	FJ	Жимс, жимсгэний чанамал джем, цэлцэгнүүртэй болон бүржмэл чихэр, гэх мэт. /шинээр санал болгох бүлгийн бүтээгдэхүүний кодыг одоо байгаа жимсний кодоос боловсруулна/
D	03	07	SF	Жимсний амтлагч, түүнтэй ижил төрлийн бүтээгдэхүүн /санал болгох шинэ бүлэг, бүтээгдэхүүний кодыг одоо байгаа ногооны кодоос боловсруулна/
D	03	08	SV	Хүнсний ногооны амтлагч, түүнтэй ижил бэлдмэлүүд /санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг одоо байгаа ногооны кодоос боловсруулна /
D	03	09	PS	Самар, тосны үр, бусад үрнээс гарган авсан бүтээгдэхүүн /санал болгож буй бүлэг, бүтээгдэхүүний кодыг одоо байгаа ногооны кодоос боловсруулна/
D	03	10	PP	Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн ургамлын гаралтай бусад бүтээгдэхүүн /шаардлагатай гэж үзвэл шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
E				АМЬТНЫ ГАРАЛТАЙ БОЛОВСРУУЛСАН ХҮНС / ангилал бий /
E	01			Амьтны гаралтай хоёрдогч бүтээгдэхүүн / 2 бүлэг бий /
E	01	03	MS	Боловсруулсан махан бүтээгдэхүүн (жишээ нь: чанасан мах) /санал болгох шинэ бүлэг, бүтээгдэхүүний кодыг одоо байгаа махны кодоос боловсруулна/
E	01	04	ES	Өндөгнөөс боловсруулсан бүтээгдэхүүн (өндөгний нунтаг гэх мэт) /санал болгох шинэ бүлэг, бүтээгдэхүүний кодыг одоо байгаа өндөгний кодоос уламжилна/
E	01	05	WS	Боловсруулсан загасан бүтээгдэхүүн (жишээ нь утсан загас) /санал болгох шинэ билэг, бүтээгдэхүүний кодыг одоо байгаа загасны кодоос боловсруулна/
E	02			Амьтны гаралтай бүтээгдэхүүн ( 4 бүлэг бий)
E	02	05	MC	Махан бүтээгдэхүүн (жишээ нь: махны экстракт) /санал болгох шинэ бүлэг, бүтээгдэхүүний кодыг одоо байгаа махны кодоос боловсруулна/
E	02	06	ED	Өндгөн бүтээгдэхүүн (жишээ нь: өндөгний цагаан, шар уураг ) /санал болгох шинэ



MNS CAC 193:2007

				бүлэг, бүтээгдэхүүний кодыг одоо байгаа өндөгний кодоос боловсруулна/
E	02	07	WD	Загасан бүтээгдэхүүн /санал болгох шинэ бүлэг, бүтээгдэхүүний кодыг одоо байгаа загасны кодоос боловсруулна/
E	03			Үйлдвэрийн аргаар боловсруулсан амьтны гаралтай хүнс (1 бүрэлдэхүүнт буюу дан найрлагатай), / 1 бүлэг байгаа /
E	03	01	LI	Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүн бүтээгдэхүүн (1 бүрэлдэхүүнт буюу дан найрлагатай), /1 бүлэг байгаа /
E	03	02	MT	Үйлдвэрийн аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүн (жишээ нь: нөөшилсөн мах) /санал болгох шинэ бүлэг, бүтээгдэхүүний кодыг одоо байгаа махны кодоос боловсруулна/
E	03	03	EM	Үйлдвэрийн аргаар боловсруулсан өндгөн бүтээгдэхүүн (жишээ нь: өндөгний цагаан уургийн нунтаг) /санал болгох шинэ бүлэг, бүтээгдэхүүний кодыг одоо байгаа өндөгний кодоос боловсруулна/
E	03	04	WP	Үйлдвэрийн аргаар боловсруулсан загасан бүтээгдэхүүн /санал болгох шинэ бүлэг, бүтээгдэхүүний кодыг одоо байгаа загасны кодоос боловсруулна/
E	04			Үйлдвэрийн аргаар боловсруулсан амьтны гаралтай (нийлмэл найрлагатай) бүтээгдэхүүн / 1 бүлэг бий /
E	04	01	LM	Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүн (нийлмэл найрлагатай) бүтээгдэхүүн / бүлэг байгаа /
E	04	02	MP	Үйлдвэрийн аргаар боловсруулсан махан (нийлмэл найрлагатай) бүтээгдэхүүн (жишээ нь: хиам) / санал болгох шинэ бүлэг, бүтээгдэхүүний кодыг тухайн бүтээгдэхүүний тодорхойлолттой уялдуулан боловсруулна/
E	04	03	EP	Үйлдвэрийн аргаар боловсруулсан өндгөн (нийлмэл найрлагатай) бүтээгдэхүүн /шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг тухайн бүтээгдэхүүний тодорхойлолттой уялдуулан боловсруулна/
E	04	04	WI	Үйлдвэрийн аргаар боловсруулсан загасан (нийлмэл найрлагатай) бүтээгдэхүүн /шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг одоо байгаа загасны кодоос боловсруулна/
F				ҮЙЛДВЭРИЙН АРГААР БОЛОВСРУУЛСАН НИЙЛМЭЛ НАЙРЛАГАТАЙ ХҮНС /шинээр санал болгож буй ангилал/
F	01			Ундаа (нийлмэл найрлагатай) /шинээр санал болгож буй ангилал/
F	01	01	BS	Ундаа (зөөлөн ундаа, түүнтэй адил төрлийн бэлдмэлүүд) / шаардлагатай гэж үзвэл шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F шаардлагатай гэж үзвэл шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна	01	02	BA	Нийлмэл найрлагатай спиртлэг ундаа /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/

F шаардлагатай гэж үзвэл шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/	02			Сүмс, салат амтлагч, шөл, тунгалаг шөл гэх мэт. /шинээр санал болгож буй төрөл/
F	02	01	SP	Амтлагч, амт оруулагч /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	02	02	PV	Цуу (нийлмэл найрлагатай) /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	02	03	PM	Гич /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	02	04	BS	Шөл, тунгалаг шөл /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	02	05	ME	Сүмс, түүнтэй төстэй бүтээгдэхүүн /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	02	06	BC	Салат, хавчмал талхны түрхлэг /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	03			Шоколад болон бусад чихэрлэг бүтээгдэхүүн /шинээр санал болгож буй төрөл/
F	03	01	CC	Шоколадан бүтээгдэхүүн /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	03	02	CS	Чихэрлэг бүтээгдэхүүн, самарт суурилсан болон ижил төрлийн нийлмэл найрлагатайг оруулаад /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	03	03	CG	Бохь /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	04			Маргарин, бусад нийлмэл найрлагатай тослог бүтээгдэхүүн /шинэ санал болгож буй төрөл/
F	04	01	HF	>80%-аас их тослогтой маргарин /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	04	02	LF	<80%-аас бага тослогтой маргарин /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	04	03	OF	Тосны эмульсэд суурилсан бусад бүтээгдэхүүн /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	05			Нийлмэл найрлагатай нарийн боов /шинэ санал болгож буй төрөл/
F	05	01	BF	Нарийн боов /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	05	02	BS	Амтлаг бус өглөөний хоол (төмс, буудай, цардуул суурьтай) /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	05	03	NS	Өнгөлсөн амтлаг бус самар, самартай өглөөний хуурай хоол, самрын холимог /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	06			Тусгай зориулалтын нийлмэл найрлагатай

				сувиллын хүнс (шинээр санал болгож буй төрөл)
F	06	01	ID	Хүүхдийн болон нэмэлт хоол тэжээл /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	06	02	CD	Хүүхдийг хөхнөөс гаргахад зориулсан бүтээгдэхүүн /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	06	03	HD	Эмчилгээний тусгай зориулалтын сувиллын хүнс /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	06	04	TD	Жин зохицуулах үйлчилгээтэй сувиллын хүнс /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	06	05	SD	Сувиллын зориулалттай нэмэлт хүнс /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
F	06	06	AD	Нэмэлт хүнс /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
G				БУСАД ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН /шинээр санал болгож буй ангилал/
G	01			Ус, эрдэс болон органик нэгдлүүд /шинээр санал болгож буй төрөл/
G	01	01	DW	Ундны ус, эрдэсжүүлсэн ус, савласан ус /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/
G	01	02	SW	Давс, давс орлуулагч, эрдсийн бэлдмэлүүд /шаардлага гарвал шинээр санал болгох бүлэг, бүтээгдэхүүний кодыг боловсруулна/

## 1 дүгээр хүснэгт – Хүнсэн дэх бохирдуулагч, бохирдуулагчдын зөвшөөрөгдөх дээд хэмжээ болон зөвлөмж хэмжээ

Бохирдуулагчдын индекс:

Нэр	Хуудас
<b>Микотоксинууд</b>	<b>21</b>
Афлатоксинууд, нийт	21
Афлатоксин М1	27
Патулин	28
<b>Хүнд металлууд</b>	<b>29</b>
Хүнцэл	29
Кадьми	30
Хар тугалга	31
Мөнгөн ус	34
Метилт мөнгөн ус	35
Цагаан тугалга	36
<b>Цацраг идэвхт бодисууд</b>	<b>38</b>
<b>Бусад</b>	<b>43</b>
Акрилнитрил	43
Диоксин	44
Хлортвинил мономер	45

Тайлбар тэмдэглэл

ХНШХ-ны лавлах баримт:	Бохирдуулагчийн зөвлөмж хэмжээг авч хэлэлцсэн ХНШХ-ны хурал, тухайн хурал болсон жилийн талаарх лавлах баримт
Хоруу чанарын зөвлөмж хэмжээ	Зөвлөмж гаргасан он болон нэмэлт тайлбарыг багтаасан, хүний биеийн авч болох бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээний талаарх хоруу чанарын зөвлөмж, биеийн жингийн кг тутамд

	миллиграмм (мг)-аар илэрхийлснээр
Үлдэгдэл бодис	Өргөн хэрэглээний бүтээгдэхүүнд дээд түвшинг зайлшгүй тодорхойлолбол зохих бохирдуулагч бодис
Ижил утгатай үгс	Тэмдэг, ижил утгатай үгсийн товчлол, шинжлэх ухааны тайлбар, бохирдуулагчдыг ялган танихад ашигласан код
Бүтээгдэхүүний код	Өргөн хэрэглээний бүтээгдэхүүн нь ХХЭЗХ-оос баталсан ХХББЕС-ын хавсралт IV-д тусгасан хүнсний ангиллын системийн дагуу кодтой байдаг. Хүнсний ангиллын систем нь дээд түвшинд зарим төрлийн бүтээгдэхүүний тодорхойлолтыг хавсаргаагүй байвал, бүтээгдэхүүний аль хэсэгт шинжилгээ хийж дээд түвшинг тодорхойлохыг зааж өгдөг. Бүтээгдэхүүний стандартад тусгасан дээд түвшингийн хувьд тухайн бүтээгдэхүүний кодын дугаар байхгүй бол харгалзаж үзэх стандартын дугаарыг тавина.
Нэмэлт тайлбар	Дээд түвшин болон Зөвлөмж хэмжээг дагалдах тайлбар Дээд түвшинг хэрэглэх эсэхийг тодорхойлох цаашид хянан үзэхэд ашиглагдана. Жишээ нь: тодорхой үлдэгдэл бодисыг хураангуй байдлаар дурдаж болно. Дээд түвшингийн ангиллыг үзнэ үү.
Төрөл	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ эсвэл зөвлөмж хэмжээний аль нь болохыг заана. ХХББЕС -ийн оршилд дурдсан нэр томъёоны тодорхойлолтыг үзнэ үү.

### Дээд түвшинд тавих шаардлага

Л:	Зөвхөн лаазалсан бүтээгдэхүүнд
----	--------------------------------

### Зарим хорт чанарын нэр томъёоны тодорхойлолт

<b>ХТДХ (PMTDI)</b>	(Хоногийн хэрэглээний түр зөвшөөрөгдөх дээд хэмжээ) Хуримтлагдах шинж чанаргүй бохирдуулагчдад эцсийн цэг болгон хэрэглэсэн. Үүний хэмжээ нь хүнсний бүтээгдэхүүн болон ундны усан дахь бодисын байгалийн үзэгдлийн үр дагавраар хүний өртөж болох зөвшөөрөгдөх хэмжээг харуулна. Өчүүхэн бага байдаг ч чухалд тооцогддог, хүнсний зайлшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг болох бичилэлементүүдийн хувьд, мөн чанарыг илэрхийлсэн доод хэмжээ болон ХТДХ-г илтгэх дээд хэмжээний хүрээгээр илэрхийлсэн.
<b>ДХТХ (PTWI)</b>	(Долоо хоногийн хэрэглээний түр зөвшөөрөгдөх хэмжээ) Хуримтлагдах шинж чанартай хүнд металл мэтийн бохирдуулагчдад эцсийн цэг болгон хэрэглэнэ. Үүний хэмжээ нь бүхэл хэлбэрээр хэрэглэгддэг, шимт тэжээлтэй хүнсийг хэрэглэхтэй зайлшгүй холбогддог бохирдуулагчдад хүний долоо хоногийн өртөж болох хэмжээг заана.
<b>СХТХ (PTMI)</b>	(Сарын хэрэглээний түр зөвшөөрөгдөх хэмжээ) Хүний биед удаан хугацаагаар хадгалагдаж, хуримтлагдах чанартай, хүнсний бохирдуулагчид эцсийн цэг болгон хэрэглэсэн. Үүний хэмжээ нь бүхэл хэлбэрээр хэрэглэгддэг, шимт тэжээлтэй хүнсийг хэрэглэхтэй зайлшгүй холбогддог бохирдуулагчдад хүний сарын хугацаанд өртөж болох хэмжээг заана.

### Афлатоксин, нийт

ХНШХ-ны лавлах баримт:

31(1987), 46(1996), 49(1997)

Хоруу чанарын зөвлөмж хэмжээ:

B,G,M афлатоксиныг хавдар үүсгэх чадвартай гэж үздэг. (1997, Хорыг авах хэмжээг боломжит хамгийн бага түвшинд байлгах)

Үлдэгдэл бодис

**Афлатоксин, нийт (B1+B2+G1+G2)**

Химийн тэмдэг:

**Товчлол, AFB, AFG**, дугаарын хамт (найрлагыг тодруулахад)

Холбогдох дадлын хууль:

Газрын самар дахь афлатоксины бохирдлоос хамгаалах болон сэргийлэх дадлын хууль (CAC/RCP 55-2004)

Модны самар дахь афлатоксины бохирдлоос

хамгаалах болон сэргийлэх дадлын хууль  
(CAC/RCP 59-2005)

Бүтээгдэхүүний		Хэмжээ мг/кг	Нэмэлт тайлбар	Төрөл	Ишлэл	ХЭЗХ-ны заалт/ тайлбар
код	нэр					
SO 0697	Газрын самар	15		ДХ		Цаашид боловсруулсан Газрын самарт ДХ тавигдана. Дээж авах төлөвлөгөөг доорх хавсралтаас үзнэ үү.

Афлатоксин нь *Aspergillus* төрлийн мөөгний үүсгэдэг хоруу чанар өндөртэй микотоксиний бүлэг юм. Бохирдсон ургамлын гаралтай бүтээгдэхүүнд гол төлөв В1, В2, G1, G2 гэсэн бүтцийн хувьд дифуранокумарины уламжлалуудтай холбоотой 4 афлатоксин өөр хоорондоо янз бүрийн харьцаатайгаар тохиолддог, афлатоксин В1 нь хамгийн чухал нь. Эдгээр нэгдлүүд нь хүн ба амьтны эрүүл мэндэд онцгой аюултай. Хавдар судлалын Олон Улсын Агентлаг (IARC, 1992)- аас афлатоксин В1-ийг 1 дүгээр бүлэгт (Хавдар үүсгэх шинж чанартай), афлатоксин М-ийг 2 дугаар бүлэгт (хүний биед хавдар үүсгэх бололцоотой) ангилсан. Гол өртдөг эрхтэн нь элэг юм.

## Боловсруулалтад орох газрын самарт нийт афлатоксины хэмжээг тодорхойлох дээж авах төлөвлөгөө

### Өмнөх үг

1. Дээж авах төлөвлөгөөнд бүтээгдэхүүний цувралаас лабораторийн сорьцонд зориулан 20 кг хальсалсан газрын самар (27 кг хальслаагүй газрын самар)-ыг авч, нийт афлатоксин зөвшөөрөгдөх дээд хэмжээнд (15мкг/кг) байгаа эсэхийг шалгана.

2. Энэхүү дээж авах төлөвлөгөөг экспортын зах зээлд бөөнөөр худалдаалж буй газрын самар дахь нийт афлатоксины хэмжээг хянах болон удирдан зохицуулах арга хэрэгсэл болгон ашиглахаар боловсруулсан юм. Гишүүн орнуудад дээж авах төлөвлөгөөг боловсруулах эрх зүйн стандартыг хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор бөөнөөр борлуулах газрын самрын цувралаас дээж сонгох, дээж бэлтгэх болон афлатоксины хэмжээг тодорхойлох аргуудыг энэ баримт бичигт тусгасан болно.

### А. Тодорхойлолт

#### цуврал

гарал үүсэл, шинж чанар, ангилал, савлагааны төрөл, шошгололт, тэмдэглэгээний хувьд ижил, нэг савлагч савласан, адил хугацаанд нийлүүлсэн болохыг эрх бүхий албан тушаалтан баталсан тодорхой тоо хэмжээний хүнсний бараа бүтээгдэхүүн

#### дэд цуврал

эх буюу анхдагч цувралаас дээж сонгох аргыг хэрэглэн авсан тодорхой (тусгай) хэсэг. Дэд цуврал бүр тусдаа биеэ даасан, хүлээн зөвшөөрөгдөхүйц байна.

#### дээж авах төлөвлөгөө

афлатоксин, зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг шинжилгээний аргачлалын дагуу тодорхойлно. Тодорхойлох үйл явц нь дээжийг сонгох, дээж бэлтгэх, афлатоксины хэмжээг тодорхойлох гэсэн 3 үе шатаас бүрдэнэ. Зөвшөөрөгдөх хэмжээ болон хэлбэлзэл нь эрх зүйн стандартад заасан дээд түвшинтэй адил хэмжээнд байна.

#### хэсэгчилсэн дээж

цуврал эсвэл дэд цувралын дурын нэг цэгээс тохиолдлоор авсан материалын тоо хэмжээ

#### нэгтгэсэн дээж

цуврал эсвэл дэд цувралаас авсан хэсэгчилсэн дээжүүдийг хольж бэлтгэсэн нийт хэмжээ. Нэгтгэсэн дээжийг лабораторийн 20 кг-аас доошгүй дээжээс бэлтгэнэ.

#### лабораторийн дээж

бутлагчийн тусламжтайгаар нунтагласан газрын самрын багахан хэсэг. Лабораторийн дээж нь нийт нэгтгэсэн дээж эсвэл түүний хэсэг нь байж болно. Нэгтгэсэн дээж нь 20 кг-аас илүү бол, нэгтгэсэн дээжээс тохиолдлын байдлаар 20 кг лабораторийн дээжийг авна. Дээжийг аль болох сайтар хольж, нунтаглан жигд нэгэн төрлийн болгосон байна.

#### Шинжилгээний сорьц

Нунтагласан лабораторийн дээжийн хэсэг.

## MNS CAS 193:2007

20 кг лабораторийн дээжийг бутлагчийн тусламжтайгаар нэгэн төрлийн болтол нунтагласан байна. Афлатоксины химийн шинжилгээний хандлалтад зориулж нунтагласан 20 кг дээжээс тохиолдлоор тодорхой сонгон авна. Хэрэв үр дүнг дундажлахаар бол бутлагчийн хэмжээнээс хамааруулан 20 кг дээжийг хэд хэдэн тэнцүү хэсэгт хувааж нунтаглана.

### Б. Дээж авах

#### Дээжинд авах материал

3. Шинжлэх цуврал бүрээс тус тусад нь дээж авна. Их хэмжээний цувралыг дэд цувралуудад хувааж тус бүрээс нь дээж авна. Хуваалтыг 1 дүгээр хүснэгтэд заасны дагуу хийнэ.

4. Цувралын жин нь ихэвчлэн дэд цувралуудын жингийн яг нийлбэр байж чаддаггүй бөгөөд дэд цувралын жин нь дурдсан жингээс дээд тал нь 20%-иар давж болно.

#### **1 дүгээр хүснэгт - Дээж авахаар эх цувралыг дэд цувралуудад хуваах нь**

Бүтээгдэхүүн	Цувралын жин (тонн)	Дэд цувралын жин, тоо	Хэсэгчилсэн дээжийн тоо	Лабораторийн дээжийн жин (кг)
Газрын самар	≥ 500	100 тонн	100	20
	>100 ба <500	5 дэд цуврал	100	20
	≥ 25 ба ≤ 100	25 тонн	100	20
	>15 ба ≤ 25	--1 дэд цуврал	100	20

#### **15 тонноос бага жинтэй цувралын хэсэгчилсэн дээжийн тоо**

5. Хэсэгчилсэн дээжийн тоо, цувралын жингээс хамаарч доод тал нь 10 дээд тал нь 100 байна. Авах хэсэгчилсэн дээжийн тоог тодорхойлоход 2 дугаар хүснэгтэд үзүүлсэн тоонуудыг хэрэглэж болно. Нийт дээжийн жин заавал 20 кг байх шаардлагатай.

#### **Хүснэгт 2: Цувралын жингээс хамааран авах хэсэгчилсэн дээжийн тоо**

Цувралын жин, тонн	Хэсэгчилсэн дээжийн тоо
$T \leq 1$	10
$1 < T \leq 5$	40
$5 < T \leq 10$	60
$10 < T < 15$	80

#### **Хэсэгчилсэн дээжийг сонгох**

6. Газрын самрын цувралаас хэсэгчилсэн дээж авах аргачлал маш чухал. Цувралд байгаа газрын самар нэг бүр сонгогдох адил боломжтой байна. Хэсэгчилсэн дээжийг сонгоход хэрэглэсэн аргачлал, багаж хэрэгсэл нь цуврал дахь ямар ч зүйлийг сонгогдохыг багасгах буюу хориглосон бол дээж сонгох аргад алдаа гарна.

7. Бохирдсон газрын самрын үр нь цуврал дотор жигд тархсан эсэхийг мэдэх аргагүй учраас нэгтгэсэн дээжийг цувралын янз бүрийн хэсгээс сонгосон хэсэгчилсэн дээжээс бүрдүүлэх нь чухал юм. Хэрэв нэггэсэн дээжийн хэмжээ их бол тодорхой хэсэгт хувааж түүнээс тодорхой хэмжээгээр таслан авч лабораторийн дээж бэлтгэнэ.

**Хөдөлгөөнгүй цуврал**

8. Хөдөлгөөнгүй цуврал нь галт тэрэг, ачааны машин гэх мэт нэг том эсвэл хайрцаг, уут гэх мэт олон жижиг саванд байгаа, дээж сонгох үед хөдөлгөөнгүй байх, их хэмжээний газрын самар. Агуулж буй сав нь газрын самрын бүх хэсэгт хүрэх боломжийг хязгаарлаж болох тул хөдөлгөөнгүй цувралаас тохиолдлын дээжийг бодитойгоор сонгоход хүндрэлтэй.

9. Хөдөлгөөнгүй цувралаас нэгтгэсэн дээж авахдаа дээж авах зориулалтын багаж ашиглахыг шаардана. Дээж авах зориулалтын багажнууд нь савныхаа төрөлд зохицсон байна. Дээж авах багаж нь (1) бүх бүтээгдэхүүнд хүрэхүйц урт (2) цуврал дахь дурын хэсгийг сонгоход саад учруулахааргүй (3) цуврал дахь хэсгүүд нь солигдохооргүй байна. Дээр дурдснаар нэгтгэсэн дээж нь цувралын янз бүрийн хэсгээс авсан хэсэгчилсэн дээжүүдээс бүрдсэн байна.

10. Жижиглэн савласан цувралын хувьд дээж авах давтамжийн тоо буюу хэсэгчилсэн дээж авсан уутны тоог дараах томъёогоор тооцно.

$$n_{\bar{a}} = \frac{(m_{\bar{o}} \times \dot{o}_{\bar{o}})}{(\dot{o}_{\bar{i}} \times \dot{o}_{\bar{a}})} \quad /1/$$

Энд:

$n_{\bar{a}}$  - дээж авах давтамжийн тоо;

$m_{\bar{o}}$  - цувралын жин, кг;

$\dot{o}_{\bar{o}}$  - хэсэгчилсэн дээжийн жин, кг;

$\dot{o}_{\bar{i}}$  - нэгтгэсэн дээжийн жин, кг;

$\dot{o}_{\bar{a}}$  - жижиглэн савласан дээжийн жин, кг.

**Хөдөлгөөнт цуврал**

11. Цувралыг хөдөлгөөнд байхад тухайлбал, урсгал шугам (туузан дамжуулагч)-аас нэгтгэсэн дээжийг сонгож авах нь тохиолдлын дээж авах бодит утгад дөхөж очно. Хөдөлж буй урсгал шугамаас дээж авахдаа урсгалын нийт уртаас хэсэгчилсэн дээжүүдийг авч, хооронд нь нийлүүлээд нэгтгэсэн дээжийг бэлтгэнэ.

Хэрэв нэгтгэсэн дээж нь шаардагдах лабораторийн дээжээс их байвал нэгтгэсэн дээжийг холиод дахин хувааж хүссэн хэмжээний лабораторийн дээжийг бэлтгэнэ.

12. Тодорхой хугацааны давтамжтайгаар дээжээс хутгаж авдаг зориулалтын автомат төхөөрөмж худалдаанд байдаг. Хэрэв ийм автомат төхөөрөмж байхгүй бол хөдөлгөөнт урсгал дундуур хутгагчийг тодорхой хугацааны давтамжтайгаар гар аргаар нэвтрүүлж, хэсэгчилсэн дээжийг авна. Автоматаар буюу гар аргаар дээж авсан аль ч тохиолдолд нийт хугацааны туршид газрын самрын тодорхой цэгийг дайран урсаж өнгөрөх явцад жигд давтамжтайгаар хэсэгчилсэн дээжийг цуглуулж авна.

13. Автомат дээж авагч нь дараах байдлаар суурилагдсан байна. Үүнд: (1) хутгагч савны амсар нь урсгалын чиглэлтэй перпендикуляр байх; (2) хутгагч сав нь урсгалын бүх талбайд хүрэхүйц байна; (3) хутгагч савны амсар нь цуврал дахь судлах зүйлийн хүссэн хэсгээс авч чадах өргөн байх. Нийтлэг дүрэм ёсоор хутгагч савны амсар нь цуврал дахь судлах зүйлийн хамгийн том биетийн хэмжээнээс ойролцоогоор 3 дахин том байх ёстой.

14. Цувралаас автомат дээж авагчаар авсан нэгтгэсэн дээжийн жинг дараах томъёогоор тодорхойлно.

$$\dot{o}_{\bar{i}} = \frac{(\tau_{\bar{a}} \times v_{\bar{a}})}{(\tau_{\bar{o}} \times v_{\bar{o}})} \quad /2/$$



## MNS CAS 193:2007

Энд:

$\delta_i$  - нэгтгэсэн дээжийн жин, кг;

$\sigma$  - хутгагч аяганы өргөн, см;

$\delta_\sigma$  - цувралын жин, кг;

$\tau_a$  - дээж авах давтамжийн хугацаа, с;

$v_a$  - аяганы хурд, см/с.

15. Хөдөлгөөнт урсгалын хурд нь мэдэгдэж байвал, дээж авах давтамж буюу автомат дээж авагчийн хутгагч савны хутгалтын тоог дараах томъёогоор тооцоолно.

$$n_a = \frac{(m_i \times v_a)}{(\sigma \times \delta_\sigma)} \quad /3/$$

Энд:

$v_a$  - хөдөлгөөнт урсгалын хурд, кг/с

16. 2 дугаар томъёог хутгалт хоорондын хугацаа буюу дээж авах давтамжийн хугацаа гэх мэт бусад хэмжигдэхүүнийг тооцоолоход мөн хэрэглэж болно. Жишээлбэл, 30000 кг цувралаас 20 кг нэгтгэсэн дээж гарган авахад шаардагдах хутгагч аяганы дээж авах давтамжийн хугацааг олъё. Энд аяганы өргөн 5.08 см (2 инч), урсгал дундуур нэвтрэх аяганы хурд 30 см/с бол 2 дугаар томъёо ёсоор:

$$\tau_a = \frac{(5,08\text{н} \times 30000\text{г} \times \delta_a)}{(20\text{г} \times 30\text{н} / \text{н})} = 254\text{н} \quad \text{болно.}$$

17. Хэрэв цуврал нь 500 кг/мин хурдтай урсаж байвал, нийт цуврал нь дээж авагчаар дайран 60 минутанд урсан өнгөрөх ба дөнгөж 14 хутгалт хийж 14 хэсэгчилсэн дээжийг авах болно. Урсгалын хурд хэт их байх нь хутгалтын тоог цөөрүүлэх ба ингэснээр авах хэсэгчилсэн дээжийн тоо цөөрнө.

### Хэсэгчилсэн дээжийн жин

18. Хэсэгчилсэн дээжийн жин нь 20 кг нэгтгэсэн дээж бэлтгэхийн тулд авах хэсэгчилсэн дээжийн нийт тооноос хамаарч ойролцоогоор 200 г ба түүнээс дээш байна.

### Дээжийг савлах, зөөвөрлөх

19. Лабораторийн дээжийг бохирдохоос бүрэн хамгаалсан, зөөх явцад гэмтэхээргүй, янз бүрийн урвалд орохооргүй, цэвэр саванд хийнэ. Зөөвөрлөлт, хадгалалтын үед үүсэж болох лабораторийн дээжийн найрлагын аливаа өөрчлөлтөөс сэргийлэх шаардлагатай бүх арга хэмжээг авна.

### Дээжийг лацдах, тэмдэглэх

20. Албан ёсоор авсан лабораторийн дээж бүрийг дээж авсан газар дээр нь лац тавьж, тусгайлсан тэмдэглэгээ тавина. Цуврал бүрийг тодорхой таних, дээж авах явц, дээж авах газар, огноог болон шинжээчдэд шаардлагатай холбогдох бусад мэдээллийн хамт тэмдэглэж, баримт үйлдэнэ.

**С. Дээж бэлтгэх****Урьдчилан сэргийлэх**

21. Афлатоксин нь хэт ягаан туяаны нөлөөгөөр аажим задардаг тул ажиллагааны явцад нарны гэрлээс аль болох зайлуулах хэрэгтэй.

**Жижиглэж, нэгэн төрлийн болгох**

22. Афлатоксин нь онцгой жигд бус тархалттай байдаг учраас дээж бэлтгэхдээ ялангуяа нэгэн төрлийн болгохдоо онцгой анхаарна. Нэгтгэсэн дээжээс авч бэлтгэсэн лабораторийн бүх дээж нь нэгэн төрлийн байна.

23. Дээжийг аль болох жигд нунтаглаж, сайтар хольсон байна.

24. Шигшүүр №14 (нүхний диаметр 3,1 мм)-ийг хэрэглэх нь үнэ өртөг болоод нарийвчлалын хувьд боломжтой нь батлагдсан. Илүү боловсронгуй багажаар улам нарийн ширхэгтэй дээжийг бэлтгэж болох бөгөөд үүний үр дүнд гарах дээжүүдийн хоорондын ялгаа багасна.

**Шинжилгээний сорьц**

25. Лабораторийн дээжээс доод тал нь 100 г хэмжээтэйг шинжилгээний сорьцонд авна.

**Д. Шинжилгээний аргууд****Үндэслэл**

26. Шинжилгээний аргад гүйцэтгэлийн шалгууруудын багц үзүүлэлтэд тулгуурласан чиг хандлагыг баримтлах нь чухал. Шалгуур үзүүлэлтэд тулгуурласан чиг хандлага нь хэрэглэгдэж буй аргыг нэг бүрчлэн нарийвчилж тэмдэглэхээс зайлсхийдэг, аргачлал дахь тусгайлсан аргыг өөрчлөн шинэчлэх болон дахин хянахгүйгээр гаргаж ирдэг зэрэг давуу талтай. Тухайн аргад зориулж бий болгосон шалгуурын гүйцэтгэл нь бүх параметруудийг багтаасан байна. Лаборатори бүрт шаардлагатай бүх параметрууд (илрүүлэлтийн хязгаар, таарц, тохирцын коэффициент ба янз бүрийн хууль ёсны хязгааруудад зориулсан нөхөгдөх хувь)-ийг агуулсан байна. Энэхүү хандлагыг баримтлан лабораториуд нь өөрсдийн тоног төхөөрөмжид тохируулан шинжилгээний аргыг чөлөөтэй сонгон хэрэглэнэ. Олон улсын аналитик химичдийн холбоо (ОУАХХ)-оос батлан гаргасан шинжилгээний аргуудыг хэрэглэж болно. Эдгээр аргуудыг технологиос хамааран байнга хянан, боловсронгуй болгоно.

**Шинжилгээний аргын гүйцэтгэлийн шалгуур****3 дугаар хүснэгт - Шинжилгээний аргуудын дагаж мөрдөх тодорхой шаардлагууд**

Шалгуур	Концентрацийн хязгаар	Санал болгож буй хэмжээ	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Хоосон	Бүгд	Авч үзэхгүй	-
ялгаж авсан -нийт афлатоксин	1-15мкг/кг	70-110% хүртэл	
	>15мкг/кг	80-110%	
Нарийвчлал RSDr	Бүгд	Хорвитцын тэгшитгэлээр гарган авсан	Хорвитцын тэгшитгэлээс гарган авсан хэмжээг 2-оор үржүүлэх
RSDr -ийн нарийвчлалыг судлах концентраци дах RSDr-ын нарийвчлалыг 0,66 –аар үржүүлэн тооцож болно.			

**MNS CAS 193:2007**

- Хэрэглэсэн аргын мэдрэмжийн хязгаар нь судалж буй концентраци дахь нарийвчлалын хэмжээ биш.

Нарийвчлалын хэмжээг Хорвитцын тэгшитгэлээр тооцоолно.

$$RSDR = 2 \times (1 - 0,5 \log \times C)$$

Энд:

*RSDR* - дахин үйлдвэрлэлийн нөхцөл дор гарсан үр дүнгээс тооцсон стандартын

харьцангуй хазайлт  $\left[ \left( \frac{s \times R}{x} \right) \times 100 \right]$

*C* - концентрацийн харьцаа (жишээ нь  $1 = \frac{100\tilde{a}}{100\tilde{a}}$ ,  $0,001 = 1.000\tilde{a} / \hat{e}\tilde{a}$ )

27. Энэ нь нийтлэг нарийвчлалын тэгшитгэл бөгөөд шинжилж буй бодис, зүйлээс хамаарахгүй, ихэнх түгээмэл шинжилгээний аргуудын хувьд зөвхөн концентрациас хамаардаг.

**Афлатоксин М1**

ХНШХ-ны лавлах баримт  
Хоруу чанарын зөвлөмж  
хэмжээ:

56 (2001)  
Үлдэгдэлийн тодорхой хэмжээ нь хавдар үүсгэх чадвартай гэж үздэг.(2001) Хамгийн муу тохиолдлыг ч тооцон зөвлөж буй афлатоксин М1-ийн дээд хэмжээ буюу 0.05 ба 0.5 мг/кг нь элэгний хавдар үүсгэх аюул маш багатай болохыг урьдчилан тогтоосон болно.  
Афлатоксин хавдар үүсгэх чадвар гепатит В вирусын гадаргуугийн антиген (HBsAG)-д маш бага байж болно. Гэвч одоогоор сүүн бүтээгдэхүүнийг их хэмжээгээр хэрэглэдэг хүмүүст үзүүлэх афлатоксин М1-ийн хавдар үүсгэх хоруу чанарын нөлөөллийг энэ төрлийн бүтээгдэхүүний хэрэглээ багатай хүмүүсийнхтэй харьцуулах боломжгүй байна. Хоол хүнсэнд афлатоксины концентраци бага байвал гепатит В вирус тээгчдэд ашигтай байж болох бөгөөд энэ нь зарим талаар гепатит С вирус тээгчдэд хаалт болдог

Үлдэгдэл бодис  
Химийн тэмдэг:

Афлатоксин М1  
**AFM1**

Бүтээгдэхүүний		Хэмжээ мг/кг	Нэмэлт	Төрөл	Ишлэл	ХЭЗХ-ийн заалт/ тайлбар
код	нэр					
ML 0106	Сүү	0,5		ДХ		

**Патулин**

ХНШХ-ны лавлах баримт:  
Хоруу чанарын зөвлөмж  
хэмжээ:

35 (1989), 44(1995)  
ХТДХ- 0.0004 мг/кг биеийн жинд (1995)

Үлдэгдэл бодис  
Холбогдох дадлын хууль:

Патулин  
Алимны шүүс болон найрлаганд нь алимны шүүс орсон бусад төрлийн ундаанд патулины бохирдлыг багасгах болон сэргийлэх дадлын хууль (CAC/RCP 50-2003)

Бүтээгдэхүүний		Хэмжээ мг/кг	Нэмэлт тайлбар	Төрөл	Ишлэл	ХЭЗХ-ны заалт/ тайлбар
код	нэр					
JF 0226	Алимны жүүс	50		ДХ		Бусад ундааны бүрэлдэхүүнд алимны жүүс орсон бол бас ДТ тавигдана

Патулин нь молекул жин багатай, гемиацетал лактон микотоксин бөгөөд Аспергиллус, Пенициллиум, Биссокламмузины төрөл зүйлээр үүсгэгддэг.

### Хүнцэл

ХНШХ-ны лавлах баримт:

Хоруу чанарын зөвлөмж  
хэмжээ:

Үлдэгдэл бодис:

Химийн тэмдэг:

Холбогдох дадлын хууль:

5 (1960), 10 (1967), 27 (1983), 33 (1988)

ДХТХ-0.015 мг/кг биеийн жинд (1988, Органик  
бус хүнцлийн хувьд)

Өөрөөр заагаагүй бол нийт хүнцлийн хэмжээ /  
As-ийн нийлбэр/, органик бус хүнцэл (As) болон  
бусад нарийвчилсан тусгай заалт

**As**

Хүнсний химийн бохирдлыг багасгах түүхий эдэд  
чиглэсэн арга хэмжээний дадлын хууль  
(CAS/RCP 49-2001)

Бүтээгдэхүүний		Хэм жээ мг/кг	Нэмэлт тайлбар	Төрөл	Ишлэл	ХЭЗХ- ны заалт/ тайлбар
код	нэр					
	Идэшний өөх тос, тос	0,1		ДХ	CAS 19-1981	Тусгайлсан стандартад хамрагдаагүй
	Маргарин	0,1		ДХ	CAS 32-1981	
	Минарин	0,1		ДХ	CAS 135-1981	
	Тодорхой нэрийн амьтны тос	0,1		ДХ	CAS 211-1999	Гахайн өөх, өөхөн тос ба хайлуулсан тос
OR 0305	Чидун жимсний тос, цэвэршүүлсэн	0,1		ДХ	CAS 33-1981	
OC 0305	Чидун жимсний тос, цэвэр	0,1		ДХ	CAS 33-1981	
OR 5330	Чидун жимс, үлдэгдэл тос	0,1		ДХ	CAS 33-1981	Чидун жимсний шахдасны тос
OC 0172	Ургамлын тос, түүхий	0,1		ДХ	CAS 210-1999	Газрын самар, наргил модны самар, баба- су, хөвөн, усан үзэм, усан үзмийн үр, эрдэнэшиш, гичийн үр, наранцэцэг, рапс, шар буурцаг, дал мод, дал модны үр, сафлор, дал модны олеин, стеарин болон дээд зэргийн олеины болон какаоны тос- ноос бусад тос
OR0172	Ургамлын тос, хүнсний	0,1		ДХ	CAS 210-1999	Газрын самар, наргил модны самар, бабасу, хөвөн, усан

						үзэм, усан үзмийн үр, эрдэнэшиш, гичийн үр, наранцэцэг, рапс, шар буурцаг, дал мод, дал модны үр, сафлор, дал модны олеин, стеарин болон дээд зэргийн олеины болон какаоны тосноос бусад тос
	Байгалийн эрдэст ус	0,01		ДХ	CAC108-1981	мг/л-ээр илэрхийлэгдсэн
	Хүнсний давс	0,5		ДХ	CAC150-1985	

**Хүнцэл** нь металл төст элемент, дэлхийн гадарга дээр эрдэстэй холбогдсон хэлбэрээр тохиолддог, галт уулын идэвхжил, эрдсийн элэгдэл болон хүний үйл ажиллагаатай холбоотой, тухайлбал металл хайлуулалт, нүүрсний шаталт, тусгай зориулалтын буюу хүнцэлд суурилсан ой хамгаалах, хүн ба мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл, пестицид байгаль орчинд тархах явцад үүсч бий болдог. Байгаль дээр аяндаа явагдах бодисын солилцооны үр дүнд төрөл бүрийн хүнсэнд органик, органик бус хэлбэрээр буй болно. Ялангуяа далай тэнгист хүнцэл органик хэлбэрээр их хэмжээтэй байдаг бөгөөд далайн ургамал, загас, хясаа, хавч хэлбэртэн зэрэг далайн гаралтай бүтээгдэхүүнд нойтон жинд шилжүүлэн тооцноор 50 мг/кг хүртэл хэмжээтэй агуулагдана. Цэнгэг ус болон газрын гадаргуу дээр харьцангуй бага буюу үр тариа, гэрийн тэжээмэл амьтанд ойролцоогоор 0-20 мкг/кг байна. Будаа, мөөг, зарим тохиолдолд хүнцэл агуулсан загасаар хооллосон шувууны маханд их хэмжээгээр илэрдэг. Хүнцлийн хамгийн хортой хэлбэр нь (III) ба (V) валенттай хүнцэл агуулсан органик бус нэгдлүүд. Тухайлбал, хүнцлийн гуравдагч исэл болох хулганы хор нь зарим тохиолдолд хүнийг үхүүлэх чадвартай. Метилжүүлсэн хэлбэрт хүнцэл нь хурц хэлбэрийн хоруу чанар багатай, загас ба хавч хэлбэртэнд агуулагддаг хүнцлийн гол хэлбэр болох хүнцэлтбетаин /arsenobetaine/-ийг хоргүйд тооцдог. Хясаа, нялаахай, далайн ургамал диметиларсенилрибосидын уламжлалууд (Arsenosugars) тохиолддог ба эдгээрийн хоруу чанарын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй байна. Загасанд агуулагдах хүнцлийн нийт хэмжээний цөөн хувь нь органик бус нэгдэл хэлбэрээр байдаг. Энэ нь ХНШХ-ноос долоо хоногийн хэрэглээнд түр баримтлах зөвшөөрөгдөх хэмжээ /ДХТЗХ, НРТWII/-г тооцсон цорын ганц хэлбэр юм. Энэхүү аюулын үнэлгээнд ашигласан хүний өвчлөлийн үзүүлэлтүүдийг ундны усан дахь органик бус хүнцлээс үүдэн гарч болох аюул дээр үндэслэсэн болно. Хавдар судлалын Олон Улсын Агентлаг (IARC)-аас хүнцлийг хүний биед хавдар үүсгэгчдийн ангилалд оруулсан бөгөөд ДЭМБ-аас тогтоосон ундны усанд байвал зохих хүнцлийн зөвлөмж хэмжээнээс хэтэрсэн бохирдол бүхий ундны уснаас үүсч болох арьсны хавдрын аюулын үйлчилгээг  $6 \times 10^{-4}$  гэж үнэлжээ.

### Кадьми

ХНШХ-ны лавлах баримт: (1972), 33 (1988), 41 (1993), 55 (2000), 61 (2003), 64 (2005)  
Хоруу чанарын зөвлөмж хэмжээ: ДХТЗХ 0.007 мг/кг биеийн жинд (1988 (2000, 2003 онд дахин хянасан), ХНШХ-ны 64 дүгээр хуралдаанаар кадмийн нийт хэрэглээнд янз бүрийн дээд түвшингийн үзүүлэх нөлөөлөл маш бага болохыг тогтоосон. Стандартад санал болгож буй дээд хэмжээ нь ДХТЗХ-нээс ойролцоогоор 1%-иар бага болно. Зөвшөөрөгдөх дээд хэмжээг нэг түвшин доогуур болгосноор ДХТЗХ-ний 6% (буудайн тариа, төмс)-аас ихгүй хэмжээний кадмийг хэрэглэх боломжийг

бүрдүүлж байгаа юм. Бүтээгдэхүүний 9%-аас илүүгүй хэсэгт стандартад санал болгож буй дээд хэмжээ зөрчигддөг. Дээд хэмжээг санал болгож буйгаас нэг түвшин бууруулахад нялаахай, төмс болон бусад хүнсний ногооны 25% нь зөрчилтэй гардаг.

Үлдэгдэл бодис:

Химийн тэмдэг

Холбогдох дадлын хууль:

**Кадьми, нийт**

**Cd**

Хүнсний химийн бохирдолыг багасгах түүхий эдэд чиглэсэн арга хэмжээний дадлын хууль (CAS/RCP 49-2001)

Бүтээгдэхүүний		Хэмжээ мг/кг	Нэмэлт тайлбар	Төрөл	Ишлэл	ХЭЗХ-ны заалт/ тайлбар
код	нэр					
VB 0040	Байцааны төрлийн ногоо	0,05		ДХ		
VA 0035	Булцуут ногоо	0,05		ДХ		
VC 0045	Үр жимст ногоо, хулуу	0,05		ДХ		
VO 0050	Хулуунаас бусад үр жимст ногоо	0,05		ДХ		Улаан лооль, идэшний мөөгийг оруулахгүй
VL 0053	Навчлаг ногоо	0,2		ДХ		
VP 0060	Үрт ногоо	0,1		ДХ		
VR 0589	Төмс	0,1		ДХ		Хальсалсан
VD 0070	Буурцаг	0,1		ДХ		Шар буурцгийг (хатаасан) оруулахгүй
VR 0075	Үндэс, үндэс үрт ногоо	0,1		ДХ		Төмс болон үндэст шанцайг оруулахгүй
VS 0078	Иш болон бутархаг ногоо	0,1		ДХ		
GC 0081	Үр тариа, хар /гурвалжин/ будаа, Псевдо	0,1		ДХ		Буудай, тутрага, хивэг болон үр хөврөлийг оруулахгүй
CM 0649	Цагаан будаа, өнгөлсөн	0,4		ДХ		
GC 0654	Буудай	0,2		ДХ		
IM 0151	Далайн хос хавтаст нялаахай	2		ДХ		Хясаа, цацагт нялаахайг оруулахгүй
IM 0152	Цефалоподууд; (наймаалж, кальмар каракатиц, гм)	2		ДХ		Гэдэсгүй
	Байгалийн эрдэст ус	0,003		ДХ	CAS108-1981	мг/л-ээр илэрхийлэгд- сэн
	Хүнсний давс	0,5		ДХ	CAS150-1985	

**Кадьми** нь харьцангуй ховор элемент бөгөөд агаар, газар, усанд хүний үйл ажиллагаагаар тархдаг. Ерөнхийдөө бохирдлын 2 гол эх үүсвэр нь кадмийн үйлдвэрлэл, хэрэглээ болон кадьми агуулсан хаягдлыг тараах явдал юм. Хөрсөн дэх кадмийн агууламж нэмэгдсэнээр ургамалд агуулагдах хэмжээ ч ихсэнэ. Энэ нь хүний, хөдөө аж ахуйн таримлаар дамжуулан авах кадмийн хэмжээг

## MNS CAC 193:2007

нэмэгдүүлэх замаар эрсдэл оруулах магадлалтай. рН багатай хөрснөөс ургамалд шилжих кадмийн хэмжээ илүү байдаг. Хавч хэлбэртэн, хясаа, мөөг . зэрэг амьд организмууд нь байгаль дахь кадми хуримтлуулагчид. Хүнийхтэй адилаар, адуу мэтийн хуурай газрын, зарим зэрлэг амьтдын элэг, бөөрөнд кадмийн хэмжээ өндөр байдаг. Эдгээр бүтээгдэхүүнийг байнга хэрэглэх нь аюулд өртөх боломжийг нэмэгдүүлнэ. Тамхичдын хувьд кадмийг авах гол үүсвэр нь тамхи юм. (Химийн бодисын олон улсын хөтөлбөр (IPCS), кадмийг хянах орчны эрүүл ахуйн шалгуур, 1992)

### Хар тугалга

ХНШХ-ны лавлах баримт: 10 (1966), 16 (1972), 22 (1978), 30 (1986), 41 (1993), 53 (1999)

Хоруу чанарын зөвлөмж хэмжээ: ДХТЗХ 0.025 мг/кг биеийн жинд (1987 онд нярай болон бага насны хүүхдэд, 1993 онд бүх насны бүлэгт зориулан дэлгэрүүлсэн, 1999 онд шинэчилсэн)

Үлдэгдэл бодис:

Химийн тэмдэг:

Холбогдох дадлын хууль:

### Хар тугалга, нийт

**Pb**

Хүнсэн дэх хар тугалганы бохирдлыг багасгах, түүнээс сэргийлэх дадлын код (CAC/RCP 56-2004), Хүнсний химийн бохирдлыг багасгах түүхий эдэд чиглэсэн арга хэмжээний дадлын хууль (CAC/RCP 49-2001)

Бүтээгдэхүүний		Хэм жээ мг/кг	Нэмэлт тайлбар	Төрөл	Ишлэл	ХЭЗХ-ны заалт/ тайлбар
код	нэр					
FT 0026	Халуун орны (тропик) төрөл бүрийн жимс, идэж болох хальсны хамт	0,1		ДХ		
FI 0030	Халуун орны (тропик) төрөл бүрийн жимс, идэж үл болох хальсны хамт	0,1		ДХ		
FB 0018	Жимсгэнэ болон бусад жижиг жимс	0,2		ДХ		
FC 0001	Цитрусын төрлийн жимс	0,1		ДХ		
FP 0009	Голдоо үр бүхий шүүслэг жимс /Анар, алим, лийр/	0,1		ДХ		
FS 0012	Ястай жимс	0,1		ДХ		
VB 0040	Байцааны төрлийн ногоо	0,3		ДХ		Хальсалснаас бусад
VA 0035	Булцуут ногоо	0,1		ДХ		
VC 0045	Үр жимст ногоо, хулуу	0,1		ДХ		
VO 0050	Хулуунаас бусад үр жимст ногоо	0,1		ДХ		Мөөгнөөс бусад
VL 0053	Навчит ногоо	0,3		ДХ		Бууцайнаас бусад навчит ногоог оруулаад
VP 0060	Үрт ногоо	0,2		ДХ		
VD 0070	Буурцаг	0,2		ДХ		
VR 0075	Үндэс, үндэс үрт ногоо	0,1		ДХ		Хальсалсан төмсийг оруулаад
	Нөөшилсөн жимсний коктейль	1		ДХ	CAC 78-1981	
	Нөөшилсөн	1		ДХ	CAC15-1981	

	грейпфрут					
	Нөөшилсөн жүрж, амтат жүрж	1		ДХ	CAC 68-1981	
	Нөөшилсөн манго	1		ДХ	CAC 159-1987	
	Нөөшилсөн хан боргоцой	1		ДХ	CAC 42-1981	
	Нөөшилсөн бөөрөлзгөнө	1		ДХ	CAC 60-1981	
	Нөөшилсөн гүзээлзгэнэ	1		ДХ	CAC 62-1981	
	Нөөшилсөн, халуун орны жимсний (тропик) салат	1		ДХ	CAC 99-1981	
	Жимсний чанамал'(жимс хадгалагч), цэлцэгнүүр	1		ДХ	CAC 79-1981	
	Хатаасан манго жимс	1		ДХ	CAC 160-1987	
	Савласан чидун жимс	1		ДХ	CAC 66-1981	
	Нөөшилсөн хэрээ нүдэн	1		ДХ	CAC 56-1981	
	Нөөшилсөн лууван	1		ДХ	CAC 116-1981	
	Нөөшилсөн ногоон болон давирхайлаг /лаван/шош	1		ДХ	CAC 16-1981	
	Нөөшилсөн ногоон вандуй	1		ДХ	CAC 58-1981	
	Нөөшилсөн гүйцэд боловсорсон вандуй	1		ДХ	CAC 81-1981	
	Нөөшилсөн мөөг	1		ДХ	CAC 55-1981	
	Нөөшилсөн дал модны жимс	1		ДХ	CAC 144-1985	
	Нөөшилсөн чихэрлэг эрдэнэ шиш	1		ДХ	CAC 18-1981	
	Нөөшилсөн улаан лооль	1		ДХ	CAC 13-1981	
	Дарсан өргөст хэмх	1		ДХ	CAC 115-1981	
	Боловсруулсан улаан лоолийн концентрат	1,5		ДХ	CAC 57-1981	
JF 0175	Жимсний шүүс	0,05		ДХ		Нектарыг оруулаад, шууд уух зориулалттай
GC 0081	Үр тариа, хар /гурвалжин/ будаа, кафийхуа болон кюино	0,2		ДХ		
	Нөөшилсөн туулайн бөөр ба туулайн бөөрний нухаш	1		ДХ	CAC 145-1985	
MM 0097	Бод мал, хонь, гахайны мах	0,1		ДХ		Мөн махны тосонд хэрэглэнэ.
PM 0110	Шувууны мах	0,1		ДХ		
MO 0812	Бод малын дайвар	0,5		ДХ		



**MNS CAC 193:2007**

	бүтээгдэхүүн					
MO 0818	Гахайны дайвар бүтээгдэхүүн	0,5		ДХ		
PO 0111	Шувууны дайвар бүтээгдэхүүн	0,5		ДХ		
	Идэшний өөх тос ба тос	0,1		ДХ	CAC 19-1981	Бие даасан стандартгүй өөх тос ба тос
	Загас	0,3		ДХ		
	Маргарин	0,1		ДХ	CAC 32-1981	
	Минарин	0,1		ДХ	CAC 135-1981	
	Тодорхой нэрийн амьтны тос	0,1		ДХ	CAC 211-1999	Гахайн өөх, өөхөн тос, хайлуулсан тос, хивэгч амьтны өөх тос
OR 0305	Чидун жимсний тос, цэвэршүүлсэн	0,1		ДХ	CAC 33-1981	
OC 0305	Чидун жимсний тос, цэвэр	0,1		ДХ	CAC 33-1981	
OR 5330	Чидун жимс, үлдэгдэл тос	0,1		ДХ	CAC 33-1981	Чидун жимсний шахдасны тос
PF 0111	Тэжээвэр шувууны тос	0,1		ДХ		
OC 0172	Ургамлын тос, түүхий	0,1		ДХ	CAC 210-1999	Газрын самар, наргил модны самар, бабасу, хөвөн, усан үзэм, усан үзмийн үр, эрдэнэшиш, гичийн үр, наранцэцэг, рапс, шар буурцаг, дал мод, дал модны үр, сафлор, дал модны олеин, стеарин болон дээд зэргийн олеины тос, какаоны тосноос бусад
OR 0172	Ургамлын тос, хүнсний	0,1		ДХ	CAC 210-1999	Газрын самар, наргил модны самар, бабасу, хөвөн, усан үзэм, усан үзмийн үр, эрдэнэшиш, гичийн үр, наранцэцэг, рапс, шар буурцаг, дал мод, дал модны үр, сафлор, дал модны олеин, стеарин болон дээд зэргийн олеины болон какаоны тосноос бусад тос
ML 0106	Сүү	0,02		ДХ		Энэ хэмжээг хагас тослогтой болон тослоггүй сүүнд баримтлана.
	Боловсруулсан сүүн бүтээгдэхүүн	0,02		ДХ		Хэрхэн хэрэглэхээс
	Байгалийн эрдэст ус	0,01		ДХ	CAC 108-1981	мг/л-ээр илэрхийлэгдсэн
	Хүүхдийн /нярайн/ хоол тэжээл	0,02		ДХ		Шууд хэрэглэх зориулалттай
	Хүнсний давс	2		ДХ	CAC 108-1981	
	Дарс	0,2		ДХ		

**Мөнгөн ус**

ХНШХ-ны лавлах баримт:  
Хоруу чанарын зөвлөмж  
хэмжээ:

Үлдэгдэл бодис:

Химийн тэмдэг:

Холбогдох дадлын хууль:

10 (1966), 14 (1970), 16 (1972), 22 (1978)  
ДХТХ 0.005 мг/кг биеийн жинд (1978)

**Мөнгөн ус, нийт****Hg**

Хүнсний химийн бохирдлыг багасгах түүхий эдэд чиглэсэн арга хэмжээний дадлын хууль (CAC/RCP 49-2001)

Бүтээгдэхүүний		Хэмжээ мг/кг	Нэмэлт тайлбар	Төрөл	Ишлэл	ХЭЗХ-ны заалт/ тайлбар
код	нэр					
	Байгалийн эрдэст ус	0,001		ДХ	CAC108-1981	мг/л-ээр илэрхийлэгдсэн
	Хүнсний давс	0,1		ДХ	CAC150-1985	

Мөнгөн ус нь байгаль дээр тохиолддог металл элемент бөгөөд байгалийн үзэгдлийн үр дагавраар хүнсэнд байж болно. Мөнгөн усыг үйлдвэрлэлийн болон бусад зориулалтаар хэрэглэснээс үүдэн хүрээлэн буй орчин бохирдоход мөнгөн усны хэмжээ нэмэгдэнэ. Нийт мөнгөн ус, метил мөнгөн усны хэмжээ нь хуурай газрын амьтан, ургамалд ерөнхийдөө маш бага байдаг боловч загасны гурилаар хооллосон амьтны гаралтай бүтээгдэхүүнд метил мөнгөн усны түвшин өндөр байж болно.

**Метил мөнгөн ус**

ХНШХ-ны лавлах баримт:  
Хоруу чанарын зөвлөмж  
хэмжээ:

Үлдэгдэл бодис:

Холбогдох дадлын хууль:

22 (1978), 33 (1988), 53 (1999), 61 (2003)  
ДХТХ 0.0016мг/кг биеийн жинд (2003)

**Метил мөнгөн ус**

Хүнсний химийн бохирдлыг багасгах түүхий эдэд чиглэсэн арга хэмжээний дадлын хууль (CAC/RCP 49-2001)

Бүтээгдэхүүний		Хэмжээ мг/кг	Нэмэлт тайлбар	Төрөл	Ишлэл	ХЭЗХ-ны заалт/ тайлбар
код	нэр					
	Загас	0,5		ЗХ		Махчин загаснаас бусад Энэхүү зөвлөмж хэмжээ нь Олон улсын худалдаанд нийлүүлэх шинэ болон боловсруулсан загас, загасан бүтээгдэхүүн дэх метил мөнгөн усанд зориулагдсан болно.
	Махчин загас	1,0		ЗХ		Аварга загас (WS 0131), сэлэм загас, тунец WS 0132), цурхай ба бусад (WF 0865) Энэхүү зөвлөмж хэмжээ нь Олон улсын худалдаанд нийлүүлэх шинэ болон боловсруулсан загас, загасан бүтээгдэхүүн дэх метил мөнгөн усанд зориулагдсан болно.

Цувралаас авсан, нэгтгэсэн дээжээс бэлтгэсэн шинжилгээний сорьцонд метил мөнгөн усны хэмжээ дээрх хэмжээнээс хэтрээгүй бол, тухайн цуврал зөвлөсөн хэмжээнд байна гэж үзнэ. Зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн нөхцөлд жирэмсэн эмэгтэйчүүд гэх мэт нийгмийн эмзэг бүлгийнхний хэрэглээнд тодорхой хязгаарлалт

## MNS CAC 193:2007

тогтоох шаардлагатай гэж үзвэл Засгийн газраас, өөрийн нутаг дэвсгэр, засаглалын хүрээнд ямар нөхцөлтэйгээр хүнсийг түгээх эсэх талаар шийдвэр гаргана. Метил мөнгөн ус нь мөнгөн усны хамгийн хортой хэлбэр бөгөөд усан орчинд бүрэлддэг. Иймээс голчлон усны амьтан, ургамалд илүүтэй байна. Хүнсний хэлхээнд хуримтлагдана. Загас нь хүний метил мөнгөн усыг авах гол эх үүсвэр бөгөөд махчин төрлийн том загасанд агуулагдах хэмжээ нь бусад төрлүүдээс өндөр байдаг. Метил мөнгөн ус болон нийт мөнгөн усны хэмжээ нь хуурай газрын амьтан, ургамалд ерөнхийдөө маш бага байдаг боловч загасны гурилаар хооллосон амьтны гаралтай бүтээгдэхүүнд метил мөнгөн усны түвшин өндөр байж болно.

### Цагаан тугалга

ХНШХ-ны лавлах баримт:	10 (1966), 14 (1970), 15 (1971), 19 (1975), 22 (1978), 26(1982), 33(1988), 55 (2000), 64 (2005)
Хоруу чанарын зөвлөмж хэмжээ:	ДХТХ 14мг/кг биеийн жинд (1988, Sn-аар илэрхийлсэн, хүнсний нэмэлтээр хэрэглэсэн цагаан тугалгыг оруулаад, 2000 онд шинэчилсэн)
Үлдэгдэл бодис:	<b>Цагаан тугалга</b> , өөр байдлаар дурдагдаагүй үед <b>нийт</b> цагаан тугалга, органик бус цагаан тугалга болон өвөрмөц онцлог бүхий бусад нэгдэл
Химийн тэмдэг:	<b>Sn</b>
Холбогдох дадлын хууль:	Лаазалсан хүнсэн дэх цагаан тугалганы бохирдлыг багасгах, түүнээс сэргийлэх дадлын хууль (CAC/RCP 60-2005), Хүнсний химийн бохирдлыг багасгах түүхий эдэд чиглэсэн арга хэмжээний дадлын хууль (CAC/RCP 49-2001)

код	Бүтээгдэхүүний нэр	Хэмжээ мг/кг	Нэмэлт тайлбар	Төрөл	Ишлэл	ХЭЗХ-ны заалт/ тайлбар
	Нөөшилсөн жимсний коктейль	250	Л	ДХ	CAC 78-1981	
	Нөөшилсөн грейпфрут	250	Л	ДХ	CAC15-1981	
	Нөөшилсөн жүрж, амтат жүрж	250	Л	ДХ	CAC 68-1981	
	Нөөшилсөн манго	250	Л	ДХ	CAC159-1987	
	Нөөшилсөн хан боргоцой	250	Л	ДХ	CAC 42-1981	
	Нөөшилсөн бөөрөлзгөнө	250	Л	ДХ	CAC 60-1981	
	Нөөшилсөн гүзээлзгэнэ	200	Л	ДХ	CAC 62-1981	
	Нөөшилсөн, халуун орны жимсний (тропик) салат	250	Л	ДХ	CAC 99-1981	
	Жимсний чанамал (жимс хадгалагч), цэлцэгнүүр	250	Л	ДХ	CAC 79-1981	
	Хатаасан манго жимс	250	Л	ДХ	CAC 160-1987	
	Савласан чидун жимс	250	Л	ДХ	CAC 66-1981	
	Нөөшилсөн хэрээ нүдэн	250	Л	ДХ	CAC 56-1981	
	Нөөшилсөн лууван	250	Л	ДХ	CAC 116-1981	
	Нөөшилсөн ногоон болон давирхайлаг /лаван/шош	250	Л	ДХ	CAC 16-1981	
	Нөөшилсөн ногоон вандуй	250	Л	ДХ	CAC 58-1981	
	Нөөшилсөн гүйцэд	250	Л	ДХ	CAC 81-1981	

	боловсорсон вандуй					
	Нөөшилсөн мөөг	250	Л	ДХ	CAC 55-1981	
	Нөөшилсөн дал модны жимс	250	Л	ДХ	CAC 144-1985	
	Нөөшилсөн чихэрлэг эрдэнэ шиш	250	Л	ДХ	CAC 18-1981	
	Нөөшилсөн улаан лооль	250	Л	ДХ	CAC 13-1981	
	Дарсан өргөст хэмх	250	Л	ДХ	CAC 115-1981	
	Боловсруулсан улаан лоолийн концентрат	250	Л	ДХ	CAC 57-1981	
	Нөөшилсөн туулайн бөөр ба туулайн бөөрний нухаш	250	Л	ДХ	CAC 145-1985	
	Болгож нөөшилсөн татсан мах	200	Л	ДХ	CAC 98-1981	лаазалсан бүтээгдэхүүнд
	Болгож нөөшилсөн татсан мах	50		ДХ	CAC 98-1981	бусад төрлийн савтай бүтээгдэхүүнд
	Болгож нөөшилсөн гахайн гуяны мах	50		ДХ	CAC 96-1981	бусад төрлийн савтай бүтээгдэхүүнд
	Болгож нөөшилсөн гахайн гуяны мах	200	Л	ДХ	CAC 96-1981	лаазалсан бүтээгдэхүүнд
	Болгож нөөшилсөн гахайн хааны мах	50	Л	ДХ	CAC 97-1981	бусад төрлийн савтай бүтээгдэхүүнд
	Болгож нөөшилсөн гахайн хааны мах	200	Л	ДХ	CAC 97-1981	лаазалсан бүтээгдэхүүнд
	Давсалсан үхрийн мах	50	Л	ДХ	CAC 88-1981	бусад төрлийн савтай бүтээгдэхүүнд
	Давсалсан үхрийн мах	200	Л	ДХ	CAC 88-1981	лаазалсан бүтээгдэхүүнд
	Зуушны мах	200	Л	ДХ	CAC 89-1981	бусад төрлийн савтай бүтээгдэхүүнд
	Зуушны мах	50		ДХ	CAC 89-1981	лаазалсан бүтээгдэхүүнд

Цагаан тугалгыг гол төлөв цагаан тугалган сав хийх, мөн шүдний эмнэлэгт чигжээс, хайлш хийх хольц бэлтгэхэд хэрэглэнэ. Цагаан тугалганы +2, +4 исэлдэлтийн зэрэгтэй, органик бус нэгдлүүдийг үйлдвэрлэлд шил бэхжүүлэх, будгийн суурь, катализатор, саван, үнэртэнд тогтворжуулагч болгон хэрэглэхээс гадна шүд хорхойтохоос сэргийлэгч бэлдмэлд ашиглана. Ерөнхийдөө, байгаль орчин цагаан тугалгаар бохирдох нь харьцангуй бага байдаг. Хүний цагаан тугалгыг авах гол эх үүсвэр нь хүнс юм. Шинэ мах, үр тариа, ногоонд бага хэмжээтэй байна. Лаазалсан хүнсэнд их хэмжээгээр байх бөгөөд цөөн тохиолдолд лакаар бүрсэн лаазанд хадгалсан хүнсэнд илэрч болно. Улаан лооль, хэрээ нүдэн жимс болон тэдгээрийн шүүсийг лакаар бүрээгүй лаазанд савласан нөхцөлд цагаан тугалгын хэмжээ өндөр байх магадлалтай. (Химийн бодисын олон улсын хөтөлбөр (IPCS), цагаан тугалгыг хянах орчны эрүүл ахуйн шалгуур, 1980) Хүнсэнд агуулагдах цагаан тугалганы органик бус нэгдлүүд нь +2 ба +4 гэсэн исэлдэлтийн зэрэгтэй байна. Энэ нь катион (цагаан тугалгат, цагаан тугалганы нэгдлүүд) буюу органик бус анион (станит, станат) байдлаар тохиолдож болно.

## Цацраг идэвхт бодисууд

Бүтээгдэхүүний		Цацраг идэвхт бодисын төлөөлөл	Нэгж хүчин зүйлд ноогдох тун Sv/бк	Хэмжээ Бк/кг	Төрөл	Ишлэл	ХЭЗХ-ны заалт/ тайлбар
код	нэр						
	Хүүхдийн хоол тэжээл	$^{238}\text{Pu}$ , $^{239}\text{Pu}$ , $^{240}\text{Pu}$ , $^{241}\text{Am}$		1	3X		
	Хүүхдийн хоол тэжээл	$^{90}\text{Sr}$ , $^{106}\text{Ru}$ , $^{129}\text{I}$ , $^{131}\text{I}$ , $^{235}\text{U}$		100	3X		
	Хүүхдийн хоол тэжээл	$^{35}\text{S}^{**}$ , $^{60}\text{Co}$ , $^{89}\text{Sr}$ , $^{103}\text{Ru}$ , $^{134}\text{Cs}$ , $^{137}\text{Cs}$ , $^{144}\text{Ce}$ , $^{192}\text{Ir}$		1000	3X		
	Хүүхдийн хоол тэжээл	$^3\text{H}^{***}$ , $^{14}\text{C}$ , $^{99}\text{Te}$		1000	3X		
	Хүүхдийн хоол тэжээлээс бусад хүнс	$^{238}\text{Pu}$ , $^{239}\text{Pu}$ , $^{240}\text{Pu}$ , $^{241}\text{Am}$		10	3X		
	Хүүхдийн хоол тэжээлээс бусад хүнс	$^{90}\text{Sr}$ , $^{106}\text{Ru}$ , $^{129}\text{I}$ , $^{131}\text{I}$ , $^{235}\text{U}$		100	3X		
	Хүүхдийн хоол тэжээлээс бусад хүнс	$^{35}\text{S}^{**}$ , $^{60}\text{Co}$ , $^{89}\text{Sr}$ , $^{103}\text{Ru}$ , $^{134}\text{Cs}$ , $^{137}\text{Cs}$ , $^{144}\text{Ce}$ , $^{192}\text{Ir}$		1000	3X		
	Хүүхдийн хоол тэжээлээс бусад хүнс	$^3\text{H}^{***}$ , $^{14}\text{C}$ , $^{99}\text{Te}$		10000	3X		

\* гэх мэт хэрэглээнд зориулсан бол,  
 \*\* органик холбоотой хүхрийн шинж чанарыг төлөөлнө,  
 \*\*\* органик холбоотой тритиум (H-ийн хүнд цөм)-ийн шинж чанарыг төлөөлнө.

**Хамрах хүрээ:** Зөвлөмж хэмжээ нь цөмийн болон цацрагийн онцгой нөхцлөөс <sup>1</sup> үүдэн бохирдсон, хүний хэрэглээ болон олон улсын худалдаанд нийлүүлэгдэж буй хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах цацраг идэвхт бодист хамаарна. Энэхүү зөвлөмж хэмжээ нь хатаасан эсвэл өтгөрүүлсэн хүнсэнд бус харин дахин боловсруулсан эсвэл шууд хэрэглэх хүнсний бүтээгдэхүүнд зориулагдсан бөгөөд нэг жилд чөлөөлөгдөх түвшин 1 mSv байхаар тооцсон болно.

**Хэрэглээ:** Хэрэглэгчдийг цацрагийн бохирдлоос хамгаалах асуудал тавигдах үед хүнсэн дэх цацраг идэвхт бодисын хэмжээ харгалзах зөвлөмж хэмжээнээс хэтрээгүй байвал тухайн хүнсийг хэрэглэхэд аюулгүй гэж үзнэ. Зөвлөмж хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд, Засгийн газраас, өөрийн нутаг дэвсгэр, засаглалын хүрээнд хүнсийг ямар нөхцөлтэйгээр түгээх эсэх талаар шийдвэр гаргана. Засгийн газар нь их хэмжээний цацрагийн бохирдлын үед хүнсний түгээлтэд зөвлөмж хэмжээг баримтлах боломжгүй бол нутаг дэвсгэрийнхээ хүрээнд дотооддоо мөрдөх хэмжээндээ зохицуулалт хийж болно. Халуун ногоо мэтийн бага хэмжээгээр хэрэглэдэг, нийт хоолны өчүүхэн бага хувийг эзэлдэг, улмаар нийт тунд багаар нэмэгдэх хүнсний бүтээгдэхүүнд зөвлөмж хэмжээг 10 гэсэн коэффициентээр нэмэгдүүлж болно.

**Цацраг идэвхт бодисууд:** Зөвлөмж хэмжээ нь бүх цацраг идэвхт бодист хамааралгүй. Энд тусгасан цацраг идэвхт бодисууд нь хүнсний хэлхээ (холбоо)нд чухал бөгөөд гол төлөв цацрагийн байгууламжид агуулагдах эсвэл хүнсний бүтээгдэхүүн дэх түвшинг бодитойгоор нэмэгдүүлэхэд хүрэлцэхүйц их хэмжээний цацрагийн эх үүсгүүр болгон хэрэглэх явцад хүрээлэн буй орчинд тохиолдлоор алдагдсан буюу хорлон сүйтгэх үйл ажиллагаанд ашигласан байж болно. Энэхүү баримт бичигт байгалийн гаралтай цацраг идэвхт бодисыг оруулаагүй.

Хүснэгтэд цацраг идэвхт бодисуудыг зөвлөмж хэмжээний дагуу логарифмчилж бүлэглээд, өсөх дарааллаар үзүүлэв.

Зөвлөмж хэмжээг “Хүүхдийн хоол тэжээл”, “Хүүхдийн хоол тэжээлээс бусад хүнс” гэсэн 2 ангиллаар тодорхойлов. Энэ нь цөөнгүй цацраг идэвхт бодист хүүхэд илүү эмзэг байдагтай холбоотой. Зөвлөмж хэмжээг “Олон улсын аюулгүй байдлын үндсэн шаардлага” стандартад дурдсан цацраг идэвхт бодис тус бүрийн нэгж хэрэглээн дэх бүрэн шингэх идэвхтэй тун, наснаас хамаарч хүний биед шингэх тунгийн коэффициентийг тодорхойлж, нягталсаны үндсэн дээр тогтоосон. (Олон Улсын Атомын Энергийн Агентлаг, ОУАЭА буюу IAEA, 1996)<sup>2</sup> Хүнсэн дэх хэд хэдэн цацраг идэвхт бодисуудын хувьд зөвлөмж хэмжээг боловсруулахдаа янз бүрийн бүлэг дэх цацраг идэвхт бодисын хуримтлалыг өөр хооронд нь нэмэх шаардлагагүй гэж үзсэн болно. Бүлэг бүрийг тус бүрд нь боловсруулна. Гэхдээ, тухайн нэг бүлгийн доторхи цацраг идэвхт бодис тус бүрийн идэвхжлийн концентрацийг нийлүүлж тооцвол зохино.

---

<sup>1</sup> Энэхүү баримт бичгийн зорилгод нийцүүлэн “онцгой нөхцөл” гэдэг нэр томъёонд гэнэтийн осол болон хорлон сүйтгэх үйл ажиллагаа аль алиныг нь ойлгоно.

<sup>2</sup> Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага. Олон улсын Атомын Энергийн Агентлаг. Олон улсын Хөдөлмөрийн алба. Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага, Цөмийн Энергийн Агентлаг. Пан Америкийн Эрүүл Мэндийн Байгууллага, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (1996), Ионжуулах цацрагаас сэргийлэх болон Цацраг идэвхт эх үүсвэрийн Олон улсын аюулгүйн байдлын ерөнхий шаардлагын стандарт, ОУАЭА, Вена

## 1 дүгээр хавсралт

**Цөмийн болон цацрагийн онцгой нөхцлийн улмаас бохирдсон хүнсэн дэх цацраг идэвхт бодисуудын хянаж сайжруулсан, санал болгож буй зөвлөмж хэмжээний шинжлэх ухааны тайлбар**

1 дүгээр хүснэгтэд тусгасан хүнсэн дэх цацраг идэвхт бодисуудын хянаж сайжруулсан, санал болгож буй зөвлөмж хэмжээ нь хүнсний бүтээгдэхүүн дэх цацраг идэвхт бодисыг хянахад ашиглаж буй олон улсын болон үндэсний стандартыг хэрэгжүүлсэн туршлага болон дараах цацрагийн ерөнхий асуудлууд дээр тулгуурласан болно. Хүнсний Хууль Эрх зүйн Хорооноос 1989 онд Зөвлөмжийн стандартыг<sup>4</sup> (CAC/GL.5-1989) боловсруулан гаргаснаар хүн цацраг идэвхт бодисыг хэрэглэснээс авах цацрагийн тунгийн үнэлгээнд тодорхой ахиц дэвшил гарсан.

**Хүүхэд болон насанд хүрэгчид:** 1 дүгээр хүснэгтэд тусгасан санал болгож буй зөвлөмж хэмжээгээр цацраг идэвхт бодисыг агуулсан хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэснээр авах түвшинг хүүхэд болон насанд хүрэгчдэд хоёуланд нь тодорхойлсон бөгөөд харгалзах тунгийн шалгуурт байгаа эсэхийг хянасан. Хүнсний бүтээгдэхүүн дэх цацраг идэвхт бодисыг хэрэглэснээс учирч болох эрүүл мэндийн аюул болон нийгмийн өртөлтийг үнэлэхийн тулд хүнсний бүтээгдэхүүний хэрэглээний зохистой хэмжээний үнэлгээ болон шингээлтийн тунгийн коэффициент зайлшгүй шаардлагатай. ДЭМБ -ийн 1988 оны тайланд насанд хүрсэн хүн нэг жилд 550 кг хүнс хэрэглэдэг гэсэн тооцоог гаргажээ. Хүүхдийн авах тунг орчин үеийн хүний дадал зуршлын үнэлгээ (F. Luukx, 1990; US DoH, 1998; NRPB, 2003)<sup>7</sup>-нд үндэслэн, нялх хүүхдийн амьдралын эхний 1 жилийн турш хэрэглэсэн сүүний хэрэглээ болон хүүхдийн хоол тэжээлийн хэмжээг ашиглан 200 кг гэж тооцоолсон. Цацраг идэвхт бодис болон насны онцлогоос хамаарсан шингээх тунгийн коэффициент өөрөөр хэлбэл, ихэвчлэн ходоод-гэдсээр шимэгдэж биеийн эдэд хуримтлагддаг, цацраг идэвхт бодисуудын химийн бүтэцтэй холбоотой, тогтвортой хэмжигдэхүүнийг Олон Улсын Атомын Энергийн Агентлаг (ОУАЭА буюу IAEA,1996)-аас баталсан.

**Цацраг идэвхийн шалгуур:** Дор дурдсан тунгийн үнэлгээний үзүүлэлттэй харьцуулахад ашигласан, тохирох цацраг идэвхийн шалгуур нь Цацрагаас хамгаалах Олон улсын Хороо (ICRP, 1999)<sup>8</sup> -оос зөвлөсөн өргөн хэрэглээний гол нэрийн бараа бүтээгдэхүүнд тухайлбал хүнсэнд агуулагдах цацраг идэвхт бодисоос 1 хүний 1 жилийн хугацаанд авах тунд харгалзах ерөнхий хэмжээ бөгөөд ойролцоогоор 1mSV- тэй тэнцүү болно.

<sup>3</sup> Жишээ нь, хэрэв хүнсэнд <sup>134</sup>Cs ба <sup>137</sup>Cs изотопууд нь агуулагдаж байвал 1000 бк/кг гэсэн зөвлөмж хэмжээ нь дээрх 2 цацраг идэвхт бодисын нийлбэрийг заана.

<sup>4</sup> Хүнсний Хууль Эрх зүйн Хорооны 18 дахь чуулганаар (Женев, 1989) цөмийн осол гарснаас хойш 1 жилийн хугацаанд 6 төрлийн цацраг идэвхт бодис (<sup>90</sup>Sr, <sup>131</sup>I, <sup>137</sup>Cs, <sup>134</sup>Cs, <sup>239</sup>Pu and <sup>241</sup>Am)-д хэрэглэх Олон улсын худалдаанд баримтлахыг зөвлөсөн тохиолдлын чанартай бохирдлын үеийн хүнсний бүтээгдэхүүн дэх цацраг идэвхт изотопын хэмжээний зөвлөмж стандарт (CAC/GL 5-1989)-ыг баталсан.

<sup>5</sup> F. Luukx, Чернобылийн ослын дараах хүрээлэн буй орчны бохирдолд Европын Нийгэмлэгээс хийсэн дүгнэлт, Их хэмжээний цөмийн ослын дараах хүрээлэн буй орчны бохирдол, ОУАЭА, Вена, 2 боть, 269-287. (1990).

<sup>6</sup> АНУ Хүний эрүүл мэндийн үйлчилгээний яам (1998) Хүний хоол хүнс болон амьтны тэжээл дэх тохиолдлын чанартай цацрагийн бохирдол; Муж, орон нутгийн салбаруудад зориулсан зөвлөмж, Хүнс, эм бэлдмэлийн Удирдах газар. Роквилл

<sup>7</sup> K. Smith, A. Jones (2003) Цацрагийн үнэлгээнд зориулсан дадал зуршлын ерөнхий үзүүлэлт

<sup>8</sup> Цацрагаас хамгаалах Олон Улсын Хороо 1999); Уртасгасан хугацаанд өртөх нөхцөлд хүн амыг хамгаалах бодлого, ЦХОУХ-ны хэвлэл 82, ЦХОУХ-ны он дарааллын бичиг

**Байгаль дээр тохиолдох цацраг идэвхт бодисууд:** Байгалийн гаралтай элбэг тохиолддог цацраг идэвхт бодисууд нь бүх төрлийн хүнсэнд янз бүрийн хэмжээтэй байна. Хүнсний хэрэглээнээс үүдэх цацрагийн тунгийн тархалтын хувь хэмжээ нь жилд хэдэн арваас хэдэн зуун микросиевер хүрдэг. Үнэнийг хэлэхэд, өдөр тутмын хоол хүнсэнд бодитойгоор агуулагддаг цацраг идэвхт бодисын хэмжээг хянах боломжгүй; өртөлтөд нөлөөлөхөд шаардагдах эх үүсгүүр, эрүүл мэндийн хувьд олж авсан ашиг тустай харьцах харьцаа алдагдана. Эдгээр цацраг идэвхт бодис нь онцгой нөхцөлд хамааралгүй учраас энэхүү баримт бичигт оруулаагүй.

**Нэг жилийн өртөлтийн үнэлгээ:** Хуучнаар, цөмийн болон цацрагийн онцгой нөхцөл байдлын улмаас хүрээлэн буй орчин цацраг идэвхт бодисоор бохирдсон дараачийн 1 жилийн хугацаанд бохирдолтой бүс нутгаас импортолсон хүнсний бүтээгдэхүүнийг бохирдоогүй газраас импортолсон хүнсээр орлуулах асуудал хялбар биш байв. ХХААБ-н статистик мэдээгээр дэлхий даяар бүх орноос импортолсон гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнд бохирдолтой хүнсний эзлэх хувь хэмжээ дунджаар 0,1 байна. 1 дүгээр хүснэгтэд үзүүлсэн хүүхэд болон нийт хүн амын хэрэглэсэн хүнсний хэмжээг, тухайн орон нь бохирдолтой бүс нутгаас гол нэрийн хүнсээ импортолсоор байгаа тохиолдолд, оршин суугчдынх нь жилд авах тунгийн хэмжээ ойролцоогоор 1 mSv –ээс хэтрэхгүй байхаар тооцсон. /2 дугаар хавсралт/ Энэ дүгнэлтийг бохирдсон хүнсний хэмжээ 0,1-ээс их нөхцөлд зарим цацраг идэвхт бодист ашиглахгүй бөгөөд энэ нь цөөн нэрийн сүүнд суурилсан хоолтой нялх хүүхдийн хувьд ч хамааралтай байж болно.

**Урт хугацааны өртөлтийн үнэлгээ:** Ослын дараах 1 жилээс цааш хугацаанд, үндэсний хориг (зах зээлээс эргүүлэн татах), бусад бүтээгдэхүүнээр орлуулах болон хөдөө аж ахуйн уналтын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд зах зээлд дээр байгаа бохирдсон хүнсний хэмжээ ерөнхийдөө багасна. Туршлагаас үзэхэд урт хугацаанд бохирдсон хүнсний импортын хэмжээ зуу түүнээс ч илүү хувиар буурдаг. Хүнсний бүтээгдэхүүний зарим тодорхой ангиллын жишээлбэл, байгалийн гаралтай бүтээгдэхүүнд бохирдлын хэмжээ тогтмол буюу бүр ихэссэн байж болно. Хүнсний бусад ангиллын бүтээгдэхүүний хувьд аажимдаа хяналтаас гардаг. Гэвч, бохирдсон хүнснээс үүдэлтэй хувь хүний нэрвэгдлийн хэмжээг тооцохгүй болтол нилээд олон жил шаардана.



## 2 дугаар хавсралт

## Хүний дотоод өртөлтийг зөвлөмж хэмжээг ашиглан үнэлэх

Цацраг идэвхт бодисын үлдэгдэлтэй гадаад орноос хүнсний бүтээгдэхүүн импортлосноос шалтгаалан тухайн оронд хүн амын өртөлтийг үнэлэх зорилгоор зөвлөмж хэмжээг хэрэглэхэд дараах үзүүлэлтүүдийг ашиглана. Үүнд: хүүхэд болон насанд хүрэгчдийн нэг жилийн хүнсний хэрэглээний хэмжээ, цацраг идэвхт бодис, наснаас хамаарсан хүнснээс авах тунгийн коэффициент, импорт болон үйлдвэрлэлийн хүчин зүйл Хүүхэд болон насанд хүрэгчдийн авах дотоод тунгийн дундаж үнэлгээнд хяналт, үнэлгээгээр импортын хүнсэн дэх цацраг идэвхт бодисын концентраци нь одоогийн зөвлөмж хэмжээнээс хэтрээгүй байхыг зөвлөдөг. Маш хянамгай хандаж үнэлэх байдлаар зөвлөмж хэмжээний түвшинд цацраг идэвхт бодисоор бохирдсон цацраг идэвхт бодисын үлдэгдэлтэй гадаад орноос импортлосон бүх хүнсний бүтээгдэхүүнийг авч үзнэ.

Цацраг идэвхт бодис агуулсан, импортын хүнсний жилийн хэрэглээнээс хүн амын авах дотоод тунгийн дундаж хэмжээ  $E$  (mSv)-г дараах томъёогоор тооцоолно.

$$E = \zeta \tilde{O}_{i\bar{o}} \times \dot{I}_{i\bar{o}} \times \emptyset \emptyset_{i\bar{o}} \times \dot{E}^- \tilde{O}$$

Энд:

$\zeta \tilde{O}_{i\bar{o}}$  - Зөвлөмж хэмжээ (Бк/кг)

$\dot{I}_{i\bar{o}}$  - наснаас хамаарсан, 1 жилд хэрэглэсэн хүнсний хэмжээ (кг)

$\emptyset \emptyset_{i\bar{o}}$  - наснаас хамаарсан шингэх тунгийн коэффициент (mSv/Бк)

$\dot{E}^- \tilde{O}$  - импорт/үйлдвэрлэлийн хүчин зүйл<sup>9</sup> (нэгжгүй).

2 дугаар хүснэгтэд үзүүлсэн хүүхэд, насанд хүрэгчдэд хоёуланд нь тооцсон, үнэлгээний үр дүн нь их хэмжээний цацрагийн бохирдлын дараагийн 1 жилд импортлосон хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэснээс авсан нийт 20 цацраг идэвхт бодисын тунгийн хувьд ерөнхий цацрагийн бохирдол 1mSv (миллисиевер)-ээс хэтрэхгүй байгааг харуулж байна.

Тунгийн хэмжээг ИҮХ-ийн үнэлгээнд тулгуурлан 0,1-тэй тэнцүү гэж тооцсон, гэвч цөөн төрөлтэй сүүнд суурилсан хоолтой хүүхдэд энэ үнэлгээг заавал хэрэглэх албагүйг тэмдэглэх хэрэгтэй.

<sup>239</sup>Pb болон бусад хэд хэдэн цацраг идэвхт бодисын хувьд тунгийн үнэлгээ бага байдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Үүний учир нь ходоод-гэдэсний зам дахь шингээлтийн хүчин зүйлийн өсөлт ба түүнтэй холбоотой шингээлтийн тунгийн коэффициентийг амьдралын эхний бүтэн 1 жилийн хугацаанд хэрэглэдэг гэж үздэг ч энэ нь ерөнхийдөө хөхөөр хооллох үед хүчинтэй буюу сүүлийн үед (ЦХОУХ, 2005<sup>10</sup>)-оос тооцоолсноор дунджаар амьдралын эхний 6 сар байна. Амьдралын эхний жилийн дараагийн 6 сард нарийн гэдэсний шингээлтийн хүчин зүйл нилээд доогуур байдаг.

<sup>9</sup> Импорт/ үйлдвэрлэлийн хүчин зүйл(ИҮХ) нь цацраг идэвхт бодисоор бохирдсон бүс нутгаас 1 жилд импортлож буй хүнсний хэмжээг тухайн орны буюу бүс нутгийн 1 жилд импортлосон, үйлдвэрлэсэн нийт хэмжээнд харьцуулсан харьцаагаар тодорхойлогдоно.

<sup>10</sup> Цацрагаас хамгаалах Олон Улсын Хороо (2005) Эхийн сүүнд шингэсэн цацраг идэхит бодисоос хүүхэд авах тунгийн хэмжээ (Хэвлэлтэнд)

Гэхдээ энэ нь  $^3\text{H}$ ,  $^{14}\text{C}$ ,  $^{35}\text{S}$ , иод болон цезийн изотопид хамаарахгүй.

Жишээ нь: хүнсэн дэх  $^{137}\text{Cs}$ -ийн тунгийн үнэлгээ нь тухайн бүс нутаг энэхүү цацраг идэвхт бодисоор бохирдсоны дараачийн 1 жилд бага байдаг.

Насанд хүрэгчдийн :  $E = 1000 \text{ Бк/кг} \times 550 \text{ кг} \times 1,3 \cdot 10^{-5} \text{ мSv/Бк} \times 0,1 = 0,7 \text{ мSv}$ ;

Хүүхдийн хувьд:  $E = 1000 \text{ Бк/кг} \times 200 \text{ кг} \times 2,1 \cdot 10^{-5} \text{ мSv/Бк} \times 0,1 = 0,4 \text{ мSv}$

### Хүүхэд болон насанд хүрэгчдийн импортын хүнснээс 1 жилд авах идэвхтэй тунгийн үнэлгээ

Цацраг идэвхт бодис (радионуклид)	Зөвлөмж хэмжээ (бк/кг)		Идэвхтэй тунгийн хэмжээ (mSv)	
	Хүүхдийн хоол тэжээл	Бусад хүнс	Бохирдлын дараагийн 1 жилд	
			Хүүхэд	Насанд хүрэгчид
$^{238}\text{Pu}$	1	10	0.08	0.1
$^{239}\text{Pu}$			0.08	0.1
$^{240}\text{Pu}$			0.08	0.1
$^{241}\text{Am}$			0.07	0.1
$^{90}\text{Sr}$	100	100	0.5	0.2
$^{106}\text{Ru}$			0.2	0.04
$^{129}\text{I}$			0.4	0.6
$^{131}\text{I}$			0.4	0.1
$^{235}\text{U}$			0.7	0.3
$^{35}\text{S}^*$	1000	1000	0.2	0.04
$^{60}\text{Co}$			1	0.2
$^{89}\text{Sr}$			0.7	0.1
$^{103}\text{Ru}$			0.1	0.04
$^{134}\text{Cs}$			0.5	1
$^{137}\text{Cs}$			0.4	0.7
$^{144}\text{Ce}$			1	0.3
$^{192}\text{Ir}$			0.3	0.08
$^3\text{H}^{**}$	1000	10000	0.002	0.02
$^{14}\text{C}$			0.03	0.3
$^{99}\text{Tc}$			0.2	0.4

\*Органик холбоотой хүхрийн хэмжээ,  
\*\* Органик холбоотой тритий ( $^3\text{H}$ )-н хэмжээ

“Зөвлөмж хэмжээний шинжлэх ухааны тайлбар” (1 дүгээр хавсралт) болон  
“Зөвлөмж хэмжээг хэрэглэн хүний дотоод өртөлтийн хэмжээг тодорхойлох” (2 дугаар хавсралт)-г үзнэ үү.

#### Акрилнитрил

ХНШХ-ны лавлах баримт:

28 (1984)

Хоруу чанарын зөвлөмж хэмжээ:

Түр зөвшөөрсөн (1984, хүнстэй хүрэлцсэнээс акрилнитрил шилжиж болох материалыг хэрэглэснээр хүнсэнд шилжих бодисын хэмжээг технологийн хувьд боломжит хамгийн бага түвшинд хүртэл бууруулах нөхцөлтэйгээр түр зөвшөөрсөн.)

Үлдэгдэл бодис:

**Акрилнитрил (мономер)**

Химийн тэмдэг:

**2-пропененитрил; циантвинил(VCN); циантэтилен; товчлол, AN, CAN.**

Холбогдох дадлын хууль:

Хүнсний химийн бохирдлыг багасгах түүхий эдэд чиглэсэн арга хэмжээний дадлын хууль (CAC/RCP 49-2001)

Бүтээгдэхүүний код		Хэмжээ мг/кг	Нэмэлт тайлбар	Төрөл	Ишлэл	ХЭЗХ-ны заалт / тайлбар
нэр	Хүнс					
	Хүнс	0,02		ЗХ		

## MNS CAC 193:2007

Акрилнитрил мономер нь мяндас, давирхай, резин, хүнсний сав баглаа, боодлын материал болгон хэрэглэдэг полимерийн үйлдвэрлэлийн анхдагч бодис юм. Байгалийн бүтээгдэхүүн байдлаар акрилнитрил тохиолдож байсан тухай мэдээлэл алга байна. Хавдар Судлалын Олон Улсын Агенлаг (ХСОУА буюу IARC )-аас акрилнитрилийг хүний биед хавдар үүсгэх боломжтой гэж ангилсан. (2Б бүлэг) Акрилонитрилээс гарган авсан полимерүүд нь чөлөөт мономерийг бага хэмжээгээр агуулж болно

### Диоксин

ХНШХ-ны лавлах баримт: :57 (2001)  
Хоруу чанарын зөвлөмж хэмжээ: ДХТХ 70 pg(пикограмм=10<sup>-12</sup>гр) TEQ/кг биеийн жинд (2001, ижил хавтгай дахь (PCB)-г оруулаад)  
Химийн тэмдэг: Полихлоржуулсан дибензо-диоксинууд ба фуранууд  
Холбогдох дадлын хууль: Хүнс, тэжээл дэх диоксин ба диоксин төст полихлортбифенилийн бохирдлыг багасгах болон түүнээс сэргийлэх дадлын хууль (CAC/RCP 62-2006);  
Хүнсний химийн бохирдлыг багасгах түүхий эдэд чиглэсэн арга хэмжээний дадлын хууль (CAC/RCP 49-2001)

Бүтээгдэхүүний		Хэмжээ мг/кг	Нэмэлт тайлбар	Төрөл	Ишлэл	ХЭЗХ-ны заалт/ тайлбар
код	нэр					
NO	ML					

### Хлорт винилийн мономер

ХНШХ-ны лавлах баримт: 28 (1984)  
Хоруу чанарын зөвлөмж хэмжээ: Түр зөвшөөрсөн (1984, хүнстэй хүрэлцснээс хлортвинил шилжиж болох материалыг хэрэглэснээр хүнсэнд шилжих бодисын хэмжээг технологийн хувьд боломжит хамгийн бага түвшинд хүртэл бууруулах нөхцөлтэйгээр түр зөвшөөрсөн.)

Үлдэгдэл бодис:

Химийн тэмдэг:

### Хлорт винилийн мономер

**Монохлорэтен, хлортэтилен; товчлол ХВ эсвэл ХВМ**

Холбогдох дадлын хууль: Хүнсний химийн бохирдлыг багасгах түүхий эдэд чиглэсэн арга хэмжээний дадлын хууль (CAC/RCP 49-2001)

Бүтээгдэхүүний		Хэмжээ мг/кг	Нэмэлт тайлбар	Төрөл	Ишлэл	ХЭЗХ-ны заалт/ тайлбар
код	нэр					
	Хүнс	0,01		ЗХ		Хүнс савлах материалд байх зөвшөөрөгдөх хэмжээ 1,0 мг/кг

Хлортвинилийн мономер нь хүнсний баглаа, боодлын материал, давирхай болгон хэрэглэдэг полимерийн үйлдвэрлэлийн анхдагч бодис юм. Байгалийн бүтээгдэхүүн байдлаар хлортвинил тохиолдож байсан тухай мэдээлэл алга байна. Хлортвинилийн мономерийн үлдэгдэл нь полимертээ байж болно. Хавдар Судлалын Олон Улсын Агентлаг (ХСОУА буюу IARC)-аас хлорт винилийг хүний биед хавдар үүсгэх шинж чанартай бодис гэж тогтоосон.(ажлаас хамаарч өртөх байдлаар)

**ЖАГСААЛТ 2- Хүнсэн дэх бохирдуулагч болон хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ болон зөвлөмж хэмжээ** (Хүнсний ангиллын системийг дуусгасны дараа боловсруулна)

## ТӨГСӨВ.